

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны салбар
Социологи, Нийгмийн ажлын тэнхим

Оюуны БААСАНТОГТОХ

МАЛЧДЫН ДОТООД ЯЛГАРАЛ

Социологийн ухааны
докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл

УЛААНБААТАР 2022 он

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны салбар
Социологи, Нийгмийн ажлын тэнхим

Оюуны БААСАНТОГТОХ

МАЛЧДЫН ДОТООД ЯЛГАРАЛ

Мэргэжлийн индекс: Социологи F31800

Социологийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

..... Т.Бүрэнжаргал, Социологийн ухааны доктор
(Ph.D), профессор
..... [Ц.Уртнасан] Социологийн ухааны доктор
(Ph.D), профессор

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх профессор:

..... Ц.Пүрэв, Социологийн ухааны доктор (Ph.D),
профессор

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

..... С.Түмэндэлгэр, Социологийн ухааны доктор
(Ph.D), профессор
..... Б.Бат-Өлзий, Социологийн ухааны доктор
(Ph.D), дэд профессор

УЛААНБААТАР 2022 он

Зохиогчийн эрхийн хуудас

©2021

ОЮУНЫ БААСАНТОГТОХ

Талархал

Уламжлалт нийгмийн харилцааны мөн чанарыг танин мэдэх тухай судалгааны ажлын сэдэв, санааг өгч чиглүүлсэн, хүндэт багш доктор [Ц.Уртнасан], судлаач Д.Ганхуяг, судалгааны ажлыг эмхлэхэд бүхий л талаар зөвлөж ажилласан удирдагч багш, доктор, Т.Бүрэнжаргал, зөвлөх, доктор Ц.Пүрэв, “Малчдын аж байдал” сэдэвт суурь судалгааны ажилд оролцуулж, хуримтлагдсан анхдагч мэдээллийг бүрэн эхээр нь ашиглах боломж олгосон “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт”-ийн хамт олон, захирал асан, мэргэжил нэгт ах М.Алтансүх, судалгааны ажлаа амжилттай гүйцэтгэх боломж, хугацаа олгосон Философийн хүрээлэнгийн Захиргаа, Социологийн салбарын хамт олонд гүн талархал илэрхийлье.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн нэгдсэн улс
БНМАУ	Бүгд найрамдах Монгол ард улс
БОХААЭЗХ	Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн
ЗГ	Засгийн газар
ИС	Институт социологии
ИСПИ РАН	Институт социально-политических исследований
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
МАА	Мал аж ахуй
МБТХ	Монголын бэлчээрийн менежментийн холбоо
МУ	Монгол улс
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
МУИС	Монгол улсын их сургууль
МУИХ	Монгол улсын их хурал
МХААХҮХ	Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо
МХЗЭ	Монголын хувьсгалт залуучуудын эвлэл
МЭӨ	Манай эриний өмнөх
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ННФ	Нээлттэй нийгэм форум
НСИСОУХ	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ОХУ	Оросын холбооны улс
РАН	Российская академия наук
САА	Сангийн аж ахуй
УБДС	Улсын багшийн дээд сургууль
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ФСЭХ	Философи, социологи эрхийн хүрээлэн
ФХ	Философийн хүрээлэн
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ХААН	Хөдөө аж ахуйн нэгдэл
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүн, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ШУА	Шинжлэх ухааны академи
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ММCG	Mongolian Marketing Consulting Group
CAPI	Computer Assisted Personal Interview
UNDP	United Nations Development
WHO	World Health Organization

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мэдээлэл цуглуулсан аймаг, сум ба түүврийн харьцаа.....	94
Хүснэгт 2. Малчид, малчин өрхийн тоо: бүс нутгаар (малын тоогоор).....	101
Хүснэгт 3. Тухайн жилд тоологдсон малаас зүй бус хорогдлын хэмжээг тооцсон үр дүн (тухайн бүсд тоологдсон нийт малын тооноос хувь тооцсон үр дүн).....	103
Хүснэгт 4. Нэг өрхийн сүргийн бүтцийг илэрхийлэх дундаж: бүсээр.....	104
Хүснэгт 5. Зах зээл дэх малын дундаж үнэ ханш: бүсээр (mean: төгрөгөөр).....	106
Хүснэгт 6. Малын мах, түүхий эд борлуулснаас орж буй орлогын харьцаа (хувиар)....	106
Хүснэгт 7. Малын түүхий эдээс олох орлогын дундаж (төгрөгөөр).....	107
Хүснэгт 8. Мал, мах борлуулсны орлого: малын төрөл зүйл, бүсээр (төгрөгөөр).....	107
Хүснэгт 9. Төсөл, хөтөлбөрт хамрагдалт (хувиар).....	110
Хүснэгт 10. Хөтөлбөрүүд дэх нийгмийн бүлгүүдэд чиглэсэн зорилт.....	119
Хүснэгт 11. Даатгалын үйлчилгээний хамрагдалт (хувиар).....	125
Хүснэгт 12. Эрсдэл бууруулах арга: малын тоо, арга ажиллагааны хамааралт шинж (Пирсоны корреляцийн коэффициент).....	129
Хүснэгт 13. Үр ашгийг нэмэгдүүлэх арга зам (Пирсоны корреляцийн коэффициент)	130
Хүснэгт 14. Малчдын туршлага (Пирсоны корреляцын коэффициент).....	133
Хүснэгт 15. Малчдын гарал, үе залгамжлал (хувиар).....	134
Хүснэгт 16. Гэр бүлийн хэв маяг ба насны бүлэг (хувь).....	136
Хүснэгт 17. Гэр бүлийн хэв маяг ба ам бүлийн тоо (хувь).....	136
Хүснэгт 18. Боловсролын түвшин (хувь).....	137
Хүснэгт 19. Гэр бүлийн хэв маяг боловсролын түвшин (хувь).....	138
Хүснэгт 20. Нас ба малын тоо, орлогын ялгаа (дундаж үзүүлэлт, төгрөгөөр).....	140
Хүснэгт 21. Боловсролын түвшин: өөрийн эзэмшлийн малын тоо, орлого (дундаж үзүүлэлт, төгрөгөөр).....	141
Хүснэгт 22. Малчдын хөдөлмөрийн үйл ажиллагааны хэлбэр ба ялгаа (хувиар).....	142
Хүснэгт 23. Дундаж малын тоо ба өмч, хэрэгслийн хангамж, зөрүү (хувь, Пирсоны коррелцийн хамаарал).....	146
Хүснэгт 24. Гэр бүлийн хэв маяг ба өмч (хувь, Пирсоны коррелцийн хамаарал).....	147
Хүснэгт 25. Ажиллаж буй хэлбэр ба нас, хүйс, боловсролын ялгаа (хувиар).....	148
Хүснэгт 26. Ажиллаж буй хэлбэр ба гэр бүлийн хэв маяг (хувиар).....	149
Хүснэгт 27. Үйлдвэрлэл эрхлэх аргаас хамаарах ялгаа (хувиар).....	153
Хүснэгт 28. Үйлдвэрлэлийн арга ба боловсролын түвшин (дундаж үзүүлэлт болон төгрөгөөр).....	155
Хүснэгт 29. Суурьшил ба нас, хүйс (хувиар).....	156
Хүснэгт 30. Суурьшил ба боловсрол, гэр бүлийн хэв маяг (хувиар).....	157
Хүснэгт 31. Орлогын бүтэц харьцаа: суурьшлаар (хувиар).....	157
Хүснэгт 32. Малчдын зарлагын бүтэц: суурьшлаар (хувиар болон зарлагын дунджаар).....	158
Хүснэгт 33. Хамаарал: суурьшил, мал маллагааны арга хэлбэр ба орлого, зарлага (Пирсоны корреляцийн коэффициент).....	159
Хүснэгт 34. Нийгмийн хэв шинж ба индекс (дундаж үзүүлэлтээр).....	164

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Малтай өрхийн тоо ба малын тоо (малчдын тоо)	100
Зураг 2. Малчдын өөрийн эзэмшлийн малын зах зээлийн үнэлгээ: бүсийн ханшаар (төгрөгөөр)	105
Зураг 3. Мал сүргийн бүтэц (тоон үзүүлэлт)	110
Зураг 4. ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байгуулах байрлал	117
Зураг 5. Даатгалд хамрагдсан малчид, малын тоо	122
Зураг 6. Даатгалд хамрагдалт (хувиар).....	124
Зураг 7. Өмч хувьчлал ба малчдын өсөлт (мянгачилсан үр дүн).....	131
Зураг 8. Малчдын насны бүтэц, өөрчлөлт (хувиар)	135
Зураг 9. Өрхийн сарын дундаж орлого (хувь)	139
Зураг 10. Орлогын эх үүсвэрийн тоо, орлогын хэмжээ (төгрөгөөр).....	140
Зураг 11. Судлагдсан малчдын өөрийн эзэмшлийн малын тоо толгой (хувиар)	144
Зураг 12. Өмчилж буй малын зах зээлийн үнэлгээний дундаж	144
Зураг 13. Малын тоо толгой ба өрхийн сарын дундаж орлого (төгрөгөөр).....	145
Зураг 14. Малчдын нийгмийн бүтэц, ялгаа (малын тоо, өмч, орлого, зарлагаар).....	163

БҮДҮҮВЧИЙН ЖАГСААЛТ

Бүдүүвч 1. Мал аж ахуйн үйлдвэрлэл.....	71
Бүдүүвч 2. Боломжийг тодорхойлох нь.....	76

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУРААНГУЙ

Хөдөлмөр, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь мал аж ахуйд суурилж, түүнээс амьжиргааны гол эх үүсвэрээ бүрдүүлдэг, нүүдлийн болон хагас суурьшмал, суурин (өрх, хувь хүн) байдлаар аж ахуй эрхэлдэг хүмүүсийг малчид гэж ойлгоно. Орчин үеийн хөдөлмөрийн харилцаанд ажилтан өөрийн эрхэлж буй ажлыг орхиод явсан ч тухайн ажилтнаас хамаарахгүйгээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь үргэлжилсээр (ажил олгогч өөр хүнээр гүйцэтгүүлэх байдлаар) байх боломжтой бол мал аж ахуйн үйлдвэрлэл нь малчны оролцоогүйгээр үргэлжлэх боломж хязгаарлагдмалонцлогтой билээ. Нийгмийн бусад бүлгээс ялгарч буй онцлог нь, малтай болсон арга (удам дагасан, эсвэл худалдаж авсан г.м)-аас нь үл хамааран өдөр тутмын ажиллах, амрах, баярлах цэнгэх үйл нь үйлдвэрлэлийнхээ дотор өрнөж, өргөн утгаар амьдралын хэмнэл нь үйлдвэрлэлээс шууд хамаардагт оршино. Хувь судлаачийн зүгээс “Малчдын дотоод ялгарал” сэдвийн хүрээнд үйлдвэрлэлийн онцлогоос хамааралтай ялгарч буй дүр зургийг тодруулан судлахыг зорилоо.

Онолын талаас 1980-аад оны үед боловсрон хөгжсөн зарим онол (жендерийн, угсаатны г.м)-ын урсгалыг үл тооцвол сонгодог болон орчин үеийн онолын төлөөлөгчид хөдөлмөр, үйлдвэрлэлийн харилцааг үндэс болгон нийгмийн ялгарлыг судалсаар ирсэн. Хөгжлийн эхэн үед макро түвшний онолууд нийгмийг бүхэлд нь судлан тодорхойлох хандлагатай байсан бол хожуу үед тодорхой байгууллага, институтийн түвшинд нийгмийн бүлгүүдийн ялгарах шалтгаан, нөхцлийг судлах болсон юм. Малчдын нийгмийн ялгарлыг тодорхойлох эл судалгаанд бүтцийн онолын чиглэлийг баримжаа болгон өмнө судлагдсан баримт материал хийгээд эмпирик судалгааны мэдээлэл, баримтад үндэслэн үйлдвэрлэлийн онцлог, социаль ялгарал, бүтцийг тодорхойлох үзүүлэлтүүдийг шинжилсэн болно. Ийн судлах явцад зөрчлийн, эсвэл үүргийн шинжтэй, орчин үеийн онолын хандлагуудад үндэслэн тайлбарлавал зохих баримтууд гарч байсанч малчид дотооддоо хэрхэн бүтэцжиж, ялгарч байгаад судлаачийн зүгээс анхаарч ажиллалаа. Учир нь бүтэцжиж, ялгаран буй хэв маягуудыг тодорхойлон судалсны ард бүхэл бүлэг хийгээд дэд бүлгийн ялгааг онолын бусад хандлагад үндэслэн нарийвчлан шинжилж, тайлбарлах нь илүү сонирхолтой, үр дүнтэй ажил болох талтай. Тухайлбал, үйлдвэрлэлийн явц дахь хувь хүн хийгээд гишүүдийн оролцоо, нийгэм-

эдийн засагт гүйцэтгэх үүрэг, онцлог бүхий харилцаа хэрхэн хэлбэржин тогтож буйг феноменологи, эсвэл бихевиорист хандлагаар ойлгож тайлбарлах нь сонирхолтой.

МАН-н үйлдвэрлэл, малчдын онцлогийг тал бүрээс нь судлан тодорхойлсон баримт олон ч тэдгээрийг нэгтгэн боловсруулсан үр дүн хязгаарлагдмал бөгөөд ихэвчлэн салангид шинжтэй үр дүн байх нь элбэг. Эл судалгааны ажилд социологийн хандлагад үндэслэн МАН-н үйлдвэрлэлийн онцлог, бүтцийг зураглан, түүнд үндэслэн шинжилгээ хийлээ.

МАН-н үйлдвэрлэл нь нэг талаасбайгаль цаг уурын, бодлогын, эдийн засгийн орчныг нөхцөл болгон, нөгөө талаас хувь хүний бие эрхтний чадамж, мэдлэг ухаан, сэтгэл зүйн төлвийг боломж болгон харилцан хамаардаг. Боломж нь социаль хүчин зүйлсийг тухайлбал, судалгаанд нас, хүйс, гэр бүлийн хэв маяг, ам бүлийн тоо, туршлага-боловсрол, хөдөлмөр, эрүүл мэндийн байдал, өмч-өмчийн хэлбэр, орлого-орлогын бүтэц, өмч захирах эрх, үйлдвэрлэл эрхлэх арга, суурьшлын хэв маяг зэрэг олон үзүүлэлтүүдийг багтаах бөгөөд судалгааны ажлын хүрээнд дурдан буй үзүүлэлтүүдээр үр дүнг шинжилсэн болно. Суурь буюу социаль боломж нь өөр бусад боломжийн эх үүсвэр болдог.

Субъектийн үйлдэл, үйлдлийн сонголт, үнэлэмж, байр суурь, хандлага нь хувь хүний болон социаль хүчин зүйлсийн үйлчлэлээр төлөвшин тогтдог бөгөөд өгөгдсөн боломжоос хамаарч нөхцөл байдалд тохируулан үйлдэх зарчим үйлчилнэ.

Нөхцөл. Судалгааны үр дүнгээс харахад газар зүйн бүсд хамаарч малчдын эзэмшиж буй малын тоо хэмжээ харилцан адилгүйгээс гадна цаг уурын эрсдэл, түүний үр нөлөө бүсүүдэд өөр өөр байна. Үйлдвэрлэлийн өсөлт бууралтад байгалийн хүчин зүйлээс гадна хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөр хүчтэй нөлөө үзүүлдэг. Тухайлбал, 2008 оноос малчдад ноос ноолуур, арьс ширний урамшуулал өгч эхэлснээс хойш сүргийн бүтэц дэх хонь, ямаан сүргийн тоо огцом өсч мал сүргийн 80 гаруй хувийг эзлэх болсон юм. Энэ нь эргээд бэлчээрт нөлөөлж мал аж ахуйн үйлдвэрлэл эрсдэлд ороход нөлөөлж байна. Эдийн засгийн талаас МАН нь хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эдийн гол эх үүсвэр болдог ч үйлдвэрлэл хөгжөөгүйн улмаас түүхий эд үнэгүйдэж, ашиглагдахгүй хаягдаж байна. Үйлдвэрлэл хөгжүүлснээр малчдын орлогын эх үүсвэрийн тоо нэмэгдэх боломжтой ч өнөөдөр судлагдсан малчдын дийлэнхийнх нь орлого мал мах, ноолуураас шууд хамаарч байгаа юм.

Боломж. Судлагдсан малчдын тухайд үр ашгийг нь нэмэгдүүлэх буюу шууд утгаар тэсвэртэй, таваарлаг чанартай малын тоог нэмэгдүүлэхийн тулд малын эрүүл ахуйг сайжруулах, шилмэл үүлдрийн малтай болох, МАА-г эрчимжүүлэх зэрэг аж ахуй эрхлэлттэй холбоотой арга ажиллагаануудыг хэрэглэдэг. Холбогдох шинжилгээний үр дүнгээс хүчтэй бус боловч эерэг үр дүн илэрч байгаа юм. Үйлдвэрлэлийн арга хэлбэрээс хамаарч тухайлбал, уламжлалт үйлдвэрлэлд малын эрүүл ахуй, шилмэл үүлдэртэй болох, таваарлаг чанарын аль алиныг нь харгалзан орлого нэмэгдүүлэх санаачлага, ажиллагаа зэрэгцэн өрнөх зүй тогтол ажиглагдаж байгаа бол фермерийн аж ахуйд бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх байдлаар орлого нэмэгдүүлэх ($p = 0.404^*$), үйлдвэрлэлийн аргыг хослуулан хэрэглэж буй аж ахуй шууд орлого гэхээс илүүтэй малын таваарлаг чанарыг сайжруулах, эрчимжүүлэх зэрэг ажиллагаа нь дэд бүтцээс хамааралтай ($p = 0.474^{**}$) буюу дам үр дүнг эрэлхийлсэн шинжтэй болох нь хамаарал тооцсон үр дүнгүүдээс харагдаж байгаа юм.

Дотоод ялгарал ба бүтэцжилт. “Малчдын нийгмийн ялгарал” судалгаанд ашигласан “ам бүлийн тоо, эрүүл мэндийн байдал, өрхийн тэргүүлэгчийн нийгэм хүн ам зүйн байдал, боловсрол, сууц, өмч (хөдлөх болон үл хөдлөх), газар зүйн байршил, хадгаламж” зэрэг үзүүлэлт нь “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал” дахь шалгуур үзүүлэлттэй таарч байгаа бол “гэр бүлийн хэв маяг, хөдөлмөр эрхлэлт, туршлага, өмч захирах эрх, үйлвэрлэл эрхэлж буй арга, суурьшлын хэв маяг” гэсэн үзүүлэлтүүдийг ашиглаж үр дүнг шинжлэхэд 9 хэв маяг үүсч буй юм. Нийгмийн хэв шинжийн хувьд 0.3-0.59 хүртэл насны дунджаас доош насныхан давамгайлах хандлагатай бол энэ үзүүлэлтээс дээш, доош чиглэлд ахмад малчид давамгайлах хандлага ажиглагдаж байгаа юм. Хүйсийн хувьд эрэгтэй тэргүүлэгчтэй өрх, боловсролын хувьд түвшин дээшлэх тусам, гэр бүлийн хэв маягаар дан гэр бүл, ам бүлийн тоогоор дунджаас бага тооны гишүүдтэй өрх индексийн оройд байрлаж байна. Малчдын нийгмийн ялгаатай байдал нь өрхийн тэргүүлэгчийн хүйс, боловсролын түвшнээс, нарийн тодорхойлбол ялгаа нь гэр бүлийн хэв маяг, бүтэц бүрэлдэхүүнээс хамаарч байгаа нь судалгааны үр дүнгээр баталгаажиж байна.

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	10
Судалгааны үндэслэл	10
Судалгааны зорилго, зорилт	15
Таамаглал	16
Судалгааны ажлын бүтэц.....	16
БҮЛЭГ 1. МАЛЧДЫН ЯЛГАРЛЫГ СУДЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ЧИГЛЭЛ.....	18
1.1. Социологи дахь ялгарлын тухай ойлголт, үзэл баримтлал	18
1.2. Малчдын судалсан дүр зураг ба шалгуур үзүүлэлтийн нарийвчлал	52
БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ	86
2.1. Судлагдсан байдлын тойм	86
2.2. Судалгааны талбар, түүвэр	94
2.3. Өгөгдөл цуглуулах арга	95
2.4. Өгөгдлийн шинжилгээ	96
2.5. Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол.....	96
2.6. Судалгааны ажлын хязгаарлагдмал тал	98
БҮЛЭГ 3. МАЛЧДЫН ЯЛГАРЧ БҮЙ ДҮР ЗУРАГ.....	100
3.1. Үйлдвэрлэлийн онцлогоос хамаарах ялгаа	100
3.2. Малчдын ялгааг илэрхийлэх хүчин зүйлсийн шинжилгээ	131
ДҮГНЭЛТ.....	165
Санал, зөвлөмж	169
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	175
ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН НОТОЛГОО.....	194
Хавсралт-1. Сүргийн бүтэц, харьцаа: эзэмшлийн хэлбэр, бүсээр	195
Хавсралт-2. Эзэмшиж буй малын төрөл зүйлийн харьцаа, олж буй орлогын хэмжээ.....	196
Хавсралт-3. Сүргийн бүтэц, малын тоо, өрхийн орлогын хамаарал (Пирсоны коэффициент).....	197
Хавсралт-4. Өрхийн орлогын хэмжээ: суурьшлаар	198
Хавсралт-5. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх арга зам ба үйлдвэрлэл эрхэлж буй арга хооронд хамаарал тооцсон үр дүн.....	199
Хавсралт-6. Мал төрөл болон хонин толгойд шилжүүлж харьцуулсан үр дүн	200
Хавсралт-7. Малчдын ялгарал, дүр зураг.....	201
Хавсралт-8. Түүхий эд борлуулсны орлого: малын төрөл зүйл, бүсээр	202

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Малчдын нийгмийн асуудлаар, бүтэц ялгааг тодорхойлох чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлын түвшинд салбар бүрийн эрдэмтэд сэдэвтэйгээ уялдуулан тал бүрээс нь судлаж, олон бүтээл хэвлүүлсэн. Гэхдээ тэдгээр нь хоорондоо уялдаагүй салангид шахуу, зарим талаар нэгнээ хуулбарлаж, өмнөхөө давтсан шинжтэй санаа агуулсан байх нь олон. Судлан буй сэдэвтэй холбоотой баримтыг социаль хандлагаар нэгтгэн боловсруулах ажил орхигдож гэх дүр зураг ойлгогдож буй тул судлаачийн зүгээс мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогийг тодруулах, малчдын ялгааг тодорхойлж буй хүчин зүйлсийг шинжлэхийг эрмэлзэж судалгааны ажлаа гүйцэтгэлээ. Судлаж буй бүлгийн онцлог, хувь судлаачийн сонирхон буй тал өнцгийг харгалзан сэдвийн хэрэгцээг дараах байдлаар үндэслэлээ.

Нэг. Малчид, мал аж ахуй нь Монгол улсын нэн тэргүүнд анхаарч байх үйлдвэрлэлийн суурь салбар юм. Дундад зуунаас өмнө болон түүнээс хойш (Гомбосүрэн.Ц, Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү, 1995, pp. 10-11; Железняков.С) Богд хаант Монгол улсыг хүртэл малчид нийгмийн бүтцийн зонхилох хэсгийг бүрдүүлж, мал аж ахуйн дагнасан хөдөлмөр давамгайлж, энэ нь эдийн засаг-үйлдвэрлэлийн гол хэрэгсэл болж байв (Майский.И, 2001, p. 130; Насанбалжир.С, 1978, p. 7). Уламжлалт хэв маяг, бүтэц социалист нийгэм байгуулах эхлэл¹ тавигдсанаас хойш 1952-1953 он (НСИСОУХ, 2017, p. 78), 1957 оноос эхлэн тооцох (Отхон.Ц, 2000, p. 115) тухай ялгаатай тэмдэглэдэг ч 1960-аад оны эх хүртэл хадгалагдаж хувьсгалын социалист шатны дундаас нэгдэлжүүлэх ажил бүрэн хэрэгжиж эхэлснээр малчид, мал аж ахуйн салбарын нийгэм-эдийн засагт гүйцэтгэх үүрэг, үр өгөөж шинэ түвшинд хүрсэн. Энэ үед нийгмийн бүлгүүдийн болон бүлгийн доторх ялгаа, заагийг арилгахад чиглэсэн бодлого хөтөлбөр хэрэгжиж нийгмийн, соёлын зэрэг үйлчилгээнд хамрагдах

¹ Нэг: Социализмаас өмнөх үе: хамжлага ард (ШУА-ийн Түүхийн хүрээлэн, 1976, p. 13), малчин ард (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, p. 77), *Хоёр*: Социализмын үе (Ред: Түмэндэлгэр.Ч, Цэрэннадмид.А, 1985, pp. 50-51), 1). Хувьсгалын ардчилсан шат: 1921-1940. Сангийн аж ахуй байгуулж эхэлсэн нь энэ үед хамаарна (Отхон.Ц, 2000, p. 100), 2). Хувьсгалын социалист шат: 1. Аж төрөх ёс нь социалист агуулга, хэлбэртэй болж өөрчлөгдсөн үе буюу социалист аж төрөх ёсны материалын ба нийгэм-эдийн засаг, улс төр, нийгмийн ба оюун санааны үндэс бүрэлдсэн үе: 1940-1960 он. 2. Социалист үйлдвэрлэлийн харилцаа тогтвортой бүрэлдсэн үе: 1980-аад оны сүүл гэж ангилдаг.

боломж бүрдсэн бол зах зээлийн нийгэмд шилжсэн үеэс эдгээр үйлчилгээ тасалдаж, өнөөдөр зарим зүйлсийг технологи орлох (ШУА-ийн ФХ, 2018, pp. 126-128) болжээ.

Нийгэм-эдийн засгийн бодит үр ашгийн хувьд социализмын өмнөх үед Монгол улсын хүнсний хэрэгцээ, хэрэглээний гол эх үүсвэр бүрдүүлэх, социализмын үед үйлдвэрлэлийн түүхий эд бэлтгэх, ажилчин анги бий болоход, зах зээлийн үед үйлдвэрлэлийн болон эдийн засгийн үр өгөөж буурсан ч хүнд үеийг даван туулахад малчид голлох үүрэг гүйцэтгэсэн юм. Шилжилтийн он жилүүдэд, мөн өдгөө 16 болон түүнээс дээш насны нийт хүн ам (2.215.679)-ын 12.9 хувь нь мал аж ахуйн салбарт хөдөлмөр² эрхэлж байгаагаас үзвэл монгол улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийн үйл явцыг малчид, мал аж ахуйд суурилсан хөдөлмөрөөс салгах бололцоогүй. Олон салбарын эрдэмтэд үүнийг дуу нэгтэй хүлээн зөвшөөрдөг. "Малчин гэгдэх эдгээр хүмүүс ардын хувьсгал ялахаас өмнө хамжлага, албат, хувьсгалын дараа үед ардын аж ахуйтан, малаа нийгэмчилж нэгдэлд элссэнээс хойш нэгдлийн гишүүн, малчин гэж янз бүрээр нэрлэгдэж байсан ч цаг цагийн аясад тохируулан малаа маллаж, ахуй амьдралаа залгуулсаар ирсэн билээ." (Бат-Эрдэнэ.Ц, 2004, р. Оршил) гэж тэмдэглэсэн байдаг.

Монголчуудын туулж өнгөрүүлсэн түүх, хөгжлийн явцад нийгмийн бүтцэд голлох байр суурийг эзлэж, хөгжил өөрчлөлтийн явцад ч нийгэм эдийн засагт ирэх их бага цохилт, сорилтыг малчид нуруун дээрээ үүрч байсан энэ үүрэг, ач холбогдол, үнэ цэнийг нь ойлгож, уламжлалт нийгмийн харилцааг “тээгч”, Монголын нийгмийн бүтэц дэх голлох бүлэг болохын хувьд судлах практик ач холбогдол нь үүгээр тодорхойлогдоно.

Хоёр. Малчдын ялгарлыг социаль аспектаар судалсан эсэх тухайд доктор Х.Гүндсамбуу "... монголын нийгэм бол хэзээнээс янагш нүүдэлчдийн нийгэм байсаар, үе улиран хөгжсөөр ирсэн жамтай, түүхэн замналтай. Энэ нь нийгмийн шинжлэх ухааны арга зүйн тавил, ойлголтуудыг нэгэн бодлын эргэлзээтэй, нөгөө бодлын сонирхол татам болгодог юм. орчин үеийн америкийн нэрт социологич Н.Смелзер ... ертөнцийн нөгөө талд монгол нийгмийн агуулга, мөн чанар, бодит давхраажилтыг тодорхой судалгаагүйгээр ойлгоно гэдэг юу л бол” гэж онолын шинжтэй тавил, үүнтэй уялдаатай үнэн чанартаа бид малчдаа нарийвчлан судлаагүй, судлах хэрэгцээтэй

² Малчид гэж жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны мал аж ахуй эрхлэгчдийг ойлгоно (Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар, 2016, р. 8).

болохыг хүлээн зөвшөөрсөн юм (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, pp. 26, 103, 112). Уг баримт нь малчдын бүтэц, ялгааг судлаагүйг харуулах ба судлаач "... хөдөөнийхний давхраажил нь ... намхан, хавтгайдуу, тэгшдүү, зэрэгцмэлдүү, жирэлзэх төдий долгиолог ... мал сүрэг, өмч хөрөнгө, ажил төрөл, нутагшил байршил зэргээрээ ямар нэгэн хэмжээгээр давхраажиж буй нь эргэлзээгүй." (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, pp. 112, 539) гэж таамаг дэвшүүлсэн. Уг санаанаас нэгд малчдын социаль ялгарал, түүний шалтгаан, онцлогийг нарийвчлан судлах бодит хэрэгцээ буйг, хоёрт малчид социаль шинж байдлын хувьд хоорондоо хүчтэй ялгардаггүй юу, эсвэл харилцааны хувьд дээр доор гэж ялгардаггүй нь эрдэмтний ажиглалтад өртөв үү, гуравт уламжлалт нийгмийн гол төлөөлөл болох малчдын ялгарч байгаа гол гол шинжүүд нь юу вэ, дөрөвт үйлдвэрлэл хийгээд соёлын онцлогоос үүдэлтэй малчдыг ямар үзэл онол, арга зүйгээр судлах вэ гэсэн асуултуудад хариулт олох тухай давхар санаа агуулагдаж байгаа юм.

Судалгааны арга зүй, шалгуур үзүүлэлтийн тухайд ч эрдэмтэн, судлаачид олон янзын байр суурь, санал дэвшүүлдэг. Академич, түүхч Ш.Нацагдорж "... нүүдэлчдийн нийгмийн хөгжлийн асуудлыг түүх, нийгмийн шалтгааны зэрэгцээгээр газар зүйн орчин, байгалийн нөхцлийн үүднээс, тэгэхдээ газар зүйн детерменизмд хальтран орчихгүйгээр тайлбарлаж чадвал бид нүүдлийн нийгмийн олон асуудалд хариу олж чадах юм." (Нацагдорж.Ш, Монголын феодализмын үндсэн замнал, 1978, р. 18) гэж нэгд уламжлалаа хэрхэн таних хэрэгцээ, хоёрт онол, арга зүйн хувьд тодорхой үр дүнд хүрээгүй болохыг дам байдлаар илэрхийлж, чигүүлдэг.

Малчдыг судалсан баримтуудыг нэгтгэн харвал мал нь гол объект болж, өмчийг удирдан зохицуулж буй субъект болох малчдыг хоёрт эрэмбэлэх явдал гардаг (төрийн бодлогод ч ийм байдлаар тусдаг О.Б). Үүнээс уламжлалт нийгмийн харилцааны онцлог шинжийг илрүүлэн судлах талын ажил, мөн малчид дотооддоо хэрхэн ялгарч буй асуудлыг орхих, нийгмийн талын асуудлыг үйлдвэрлэлтэй нь хольж хутгаснаар арга зүйн болоод шийдлийн төөрөгдөлд орох, зөрчилтэй байдал бий болоход хүргэдэг.

Малчдын ялгааг илэрхийлэхдээ малын тоо хэмжээг шалгуур болгох нь түгээмэл. Мал нь малчдын амьжиргааг тодорхойлох шинжтэй, бусад зүйлсийн эх үүсвэр болох ч нийгмийн ялгааг илэрхийлэх өмчид хамаарах нэг л үзүүлэлт, хэмжүүр юм. Нийтлэг тохиолдолд судлаач эрдэмтэд үүнд илүүтэй анхаарч, байгаль цаг уурын өөрчлөлт

хувирлаас хэт хамааралтай гэх байдлаар судлан малчдын ялгааг илэрхийлж, малчны үүрэг оролцоог орхигдуулдаг. Ийм байдлаар нийгмийн талын тухайлбал, уламжлалт харилцааны тухай асуудлыг хөндөх үед мухардалд ордог тул үйлдвэрлэлийн нөхцөлтэй нь уялдуулан судлаж энэ зангилаа асуудлыг ойлгож, үүнээс ургуулан уламжлалт харилцааны төлөвшил, түүний учир зүйг тайлах боломж бүрдэнэ. Судалгаа эрдэм шинжилгээний ажлын түвшинд ч, бодит хэрэглээний хувьд ч мал аж ахуйн үйлдвэрлэлийн явц дахь малчны байр суурь, түүнээс үүдэн ялгарч буй дүр зургийг танихад чиглэсэн эрэл хайгуулыг ул суурьтай, өргөн хүрээнд үргэлжлүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Гурав. Монгол улс зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш тулгуур гэж болох урт хугацааны 7 хөтөлбөр³ баталснаас одоо “Ногоон хөгжлийн бодлого: 2014-2030” (УИХ, 2014), “Алсын хараа-2050” (УИХ, 2020) хөтөлбөр хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Сүүлд батлагдсан “Алсын хараа-2050” хөтөлбөрт “Амьдралын чанар ба дундаж давхарга” гэсэн зургаан дэд бүлэг бүхий зорилт дэвшүүлсэн бөгөөд зорилтод хамаарах сэдвээр Монгол улсад Ц.Уртнасан (Уртнасан.Ц, БНМАУ-ын ажилчин ангийн нийгмийн бүтцийн социологийн асуудал, 1989; Уртнасан.Ц, Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ, 2017), Х.Гүндсамбуу (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002), О.Мөнхбат (Мөнхбат.О, 2000), Т.Бүрэнжаргал (Бүрэнжаргал.Т, 2001), Т.Нарантуяа “Монголын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн амьжиргааны чадавхийн судалгаа” (Нарантуяа.Т, 2006) зэрэг эрдэмтэд судалж эрдмийн зэрэг хамгаалж, сүүлд нийтлэлч Б.Энхмандах, Э.Энхчимэг нар “Дундчуудыг түшин хөгжих хөгжлийн хандлага ба Монгол орон” (Энхмандах.Б, Э.Энхчимэг, 2017) нэг сэдэвт бүтээл хэвлүүлсэн.

Эрдэмтэн, судлаачдийн бүтээлээс Монгол улсын нийгмийн бүтэц, давхрааг ямар онол, арга зүй, шалгуурыг удирдлага болгож тодруулах вэ? гэсэн нийтлэг нэг зүйл ажиглагддаг. Асуудал нь суурин болон нүүдлийн гэх амьдралын ялгаатай хэв маяг бүхий бүлгүүдийг хэрхэн судлах (Тихонова.Н.Е, Модель социальной стратификации

³ “Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал: 1996-2015” (МУИХ, 1996), “Монгол улсын ХХI зууны тогтвортой хөгжлийн стратеги хөтөлбөр: 1998-2021” (МУ-ын Засгийн газар, 1998), “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтууд: 2005-2015” (Должинсүрэн.Ж, 2017), “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого: 2008-2021” (МУИХ, 2008), “Ногоон хөгжлийн бодлого: 2014-2030” (МУИХ, 2014), “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (МУИХ, 2016), “Алсын хараа-2050” (МУИХ, 2020).

российского общества: эвристические возможности различных теоретических подходов, 2007), практик түвшинд Монголын нийгмийн бүтцийг ямар хэмжээнд судалсан, бүтцийн хувьд одоо ямар дүр зурагтай байгаа, түүнийг ямар түвшинд хүргэх, эсвэл хүрч болох тухай асуултаар дамжин гардаг. Малчдын ялгаралд нөлөөлж буй учир шалтгааны асуудлыг тодруулахын зэрэгцээ суурин хийгээд нүүдлийн амьдрал бүхий малчид бүхэл нийгмийг бүрдүүлэгч болохын хувьд интеграль бүтэц (нийгмийн бүтцийг бодитой зураглах интеграль загвар)-ийг дүрслэх арга замыг эрэн хайх, гарц чигийг тодорхойлох, наанадаж ийм байх болов уу гэсэн суурийг тавих, хэлэлцүүлж болохуйц санаа дэвшүүлэх бодит хэрэгцээ бий.

Дөрөв. Сонгодог онолын түвшинд тухайлбал, К.Марксын “Азийн үйлдвэрлэлийн арга” гэх ойлголтод юуг, хэрхэн багтаан хэлсэн нь хязгаарлагдмал бөгөөд эрдэмтэд үүнд олон янзын тайлбарыг өгдөг. Оноон буй бүс, газар зүйн байршлын хувьд уг тодорхойлолт нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлд ямар нэг байдлаар хамаарах боловч оросын эрдэмтэн Кагарлицкий "Азийн үйлдвэрлэлийн арга нь тодорхойлолтоороо бол газар тариалан эрхлэлт юм." (Кагарлицкий, 2018, р. 271) гэж тэмдэглэсэн. Энэ нь азийн, тэр дундаа бэлчээрийн мал аж ахуйд суурилсан үйлдвэрлэлийн арга, түүнээс үүдэлтэй нийгмийн онцлогийг ойлгох, тодруулах чиглэлээр тусгайлан судлах хэрэгцээтэй болохыг шууд илэрхийлдэг.

Нийгэм, хүмүүнлэгийн чиглэлээр судлаж буй Монголын эрдэмтэд уламжлалаа таних чиглэлд нэлээд анхаарах болсон нь их сэтгэгчийн орхисон асуулт, уламжлал соёлын онцлогтой ямар нэг байдлаар холбогддог. Үүний илрэл гэж болохоор, доктор Б.Даш-Ёндон үндэсний шинжийг онцолсон үзэл, доктор Ц.Гомбосүрэн “нийгмийн философийн интеграль загвар”, доктор Н.Хавх “квадратын дагуу сэтгэх”, академич Г.Чулуунбаатар “азийн үйлдвэрлэлийн арга”-ын үзэл баримтлалд тулгуурлан суурин болон нүүдлийн гэх соёлын хэв шинжийг цогц байдлаар судлах (Чулуунбаатар.Г, 2008, рр. 233-240), О.Дашпүрэв “Монгол оршихуй” (Дашпүрэв.О, 2017), Л.Дашням “Язгуураа танихуй” (Дашням.Л, 2020) гэж өөр өөрийнхөөрөө тодорхойлон судлаж байна.

Санаа зорилго нь ийн уламжлалаа танихад чиглэн буй боловч уламжлалт нийгмийн харилцааны онцлог, мөн чанарыг нь таньж чадсан уу? Ингэж танин мэдэхэд дэмтэй, тустай социаль баримт сэлт, тэдгээрийг нэгтгэн боловсруулж үр дүнд хүрсэн үү? Эл асуулт хийгээд филосочдын судалгааны ажилд үндэслэхэд: философи

сэтгэлгээний түвшинд баримтуудаас хийсвэрлэлд шилжих нь үр дүнтэй юу, эсвэл хийсвэрлэн буй түвшнийг үндэслэн социаль баримт, үзэгдлийн өөрчлөлтийг тодорхойлох нь үр дүнтэй юу гэсэн зарчмын асуулт тавигдана. Хувь судлаачийн зүгээс бодит баримтаас хийсвэрлэлд шилжих буюу юуны түрүүнд нүүдэлчдийн гэх эмх цэгцтэй, бүтэцлэгдсэн санаа, хандлага боловсрон хөгжсөн үү гэх гол асуултад хариулах байдлаар судлах нь илүү үр дүнтэй. Бодит байдал хийгээд уг үндсээ ухаарч өөрийгөө таних гэсэн эрэл хайгуулыг нийгмийн өөрийнх нь онцлогоос ургуулан харж, судалснаар илүү бодитой, тодорхой үр дүнд хүрэх бололцоотой.

Малчдын дотоод ялгарал гэх эл сэдвийн хүрээнд ялгарал, түүнд нөлөөлж буй суурь хүчин зүйлсийг онцлон судлаж, дам байдлаар дээр дурдсан онолын болон практик түвшний асуултуудад хариулах сэжмийг эрэлхийлсэн хүсэл, сонирхолдоо хөтлөгдсөн нь эл судалгааны ажлыг гүйцэтгэх үндэслэл болсон.

Судалгааны зорилго, зорилт

Өөрийн онцлог бүхий бие даасан бүлэг болохын хувьд малчдын нийгмийн ялгарал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийн харилцаа хамаарлыг тодруулан судлана. Судалгааны зорилгод үндэслэн дараах зорилтуудыг дэвшүүлээ:

- Сонгодог болон орчин үеийн онолуудад хэрэглэж буй ялгарал гэх ойлголтын агуулга, хүрээ, өөрчлөлт, хувирал зэргийг тодруулан судлаж малчдын ялгарлыг судлах онолын чиглэлийг тодорхойлох.
- Социологийн онолуудад нийтлэг тохиолдолд нийгмийн ялгарлыг үйлдвэрлэлийн онцлог, хөдөлмөрийн хуваариас хамааралтай болохыг онцлон тэмдэглэдэг учир мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогийг тодорхойлох.
- Малчдын нийгмийн асуудлаар судалсан эрдэмтэн судлаачдын бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг шинжлэн судлаж малчдын нийгмийн ялгаралд нөлөөлөх шалгуур үзүүлэлтүүдийг тодруулах.
- Үйлдвэрлэлийн онцлог хийгээд нийгмийн үзүүлэлтүүдэд үндэслэн малчдын ялгаралд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэх.
- Малчдын ялгарлыг судалсан үр дүнд үндэслэн цаашид энэ чиглэлээр хийх судалгаа, эрдэм шинжилгээний ажлын түвшинд, хэрэглээний шинжтэй зөвлөмж, санал боловсруулна.

- Нүүдлийн болон суурин амьдралтай иргэдийн нийгмийн ялгааг илэрхийлэн судлах арга зүйн санал дэвшүүлэх.

Таамаглал

Нэг. Малчдын ялгаа нь “нөхцөл”, “боломж”-ийн харилцан үйлчлэлийн үр дүн. Нөхцөл нь өөр хоорондоо ялгарах суурь хүчин зүйл болох бол үйлдвэрлэлийн талаас боломж нь шийдвэрлэгч үүрэгтэй.

Хоёр. Боломж гэдэг нь мөн социаль шинжүүд (гэр бүлийн хэв маяг, үйлдвэрлэл явуулж буй арга, туршлага, боловсрол, гэр бүлийн хэв маяг, бүтэц, өмч, өмчийн хэлбэр, орлого)-ийг илэрхийлэх бөгөөд малчдын дотоод дахь ялгарч, бүтэцжихэд нийгмийн шинжүүд голлох үүрэг гүйцэтгэнэ.

Судалгааны ажлын бүтэц

Судалгааны ажил нь удиртгал, хоёр бүлэг, зургаан зүйл, хавсралтаас бүрдэнэ. Удиртгал хэсэгт судалгааны үндэслэл, зорилго, зорилт, судалгааны ажлын шинэлэг тал, судалгааны ажлын бүтцийн тайлбарлалыг орууллаа.

Нэгдүгээр бүлгийн нэгдүгээр зүйлд сонгодог болон орчин үеийн социологид ялгарал гэх ойлголтын үүссэн нөхцөл, сэтгэгчдийн үзэл хандлага, түүнийг өргөжүүлж, хөгжүүлсэн байдал, хэрхэн тайлбарлаж буйг үйл явцын хувьд ойлгож, малчдын ялгарлыг судлах онолын чигийг тодорхойлох, хоёрдугаар зүйлд монгол болон монголч эрдэмтдийн малчдыг судалсан онолын болон арга зүйн хандлага, үр нөлөө, тэдгээрийн үр дүн, МАА-н үйлдвэрлэл дэх малчдын үүрэг, оролцоог тодорхойлохыг оролдсон. Мөн малчид хоорондоо ялгарахад нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийвчлан, тодруулбал социологийн онолын сэтгэгчид болоод малчдыг судалсан тодорхой судалгааны баримт үр дүнд үндэслэн бүтцийн хандлагаар судлан тодорхойлох зохих шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан гаргалаа.

Хоёрдугаар бүлэгт судалгааны судлагдсан байдлын тойм, өгөгдөл цуглуулах арга, өгөгдөл боловсруулах арга зүй, аргачлалыг, гуравдугаар бүлгийн нэгдүгээр зүйлд үйлдвэрлэл, аж ахуйн онцлогоос үүдэлтэй ялгаатай байдал үүсч буйг, хоёрдугаар зүйлд нийгмийн хүчин зүйлсээс хамааралтай ялгаралд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжилж, малчдын дотоод бүтэц хийгээд дэд бүлгүүд хоорондоо хэрхэн ялгарч буй байдлыг тодруулан гаргасан.

Эцэст нь таамаглалын дагуу судалгааны ажлын гол үр дүнг шалгасан дүгнэлт, судалгааны үр дүнтэй холбоотой санал зөвлөмж боловсруулан гаргалаа.

БҮЛЭГ 1. МАЛЧДЫН ЯЛГАРЛЫГ СУДЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ЧИГЛЭЛ

1.1. Социологи дахь ялгарлын тухай ойлголт, үзэл баримтлал

Хүн биологийн төрөл зүйл болохын хувьд нас, хүйс, хувь хүний зан байдал, биеийн өндөр, жин, үсний өнгө, оюуны чадамж гээд олон шинжээрээ ялгаатай ба нэг хэсэг нь онцгой чадвартай, нөгөө хэсэг нь хүч чадалтай, өөр нэг хэсэг нь гоо үзэсгэлэнтэй, эсвэл төрөлхийн сул дорой, хөгжлийн бэрхшээлтэй төрдөг. Эдгээр шинжээр ялгарч эхэлдэг ч тодорхой нөхцөлүүдээс хамаарч нийгмийн ялгааг тодорхойлох хүчин зүйл болох нь бий. Нийгэмд амьдралын хэв маяг (хот, хөдөө), хөдөлмөрийн хуваарь (оюуны болон биеийн хөдөлмөр), гүйцэтгэж буй үүрэг (судлаач, эмч, багш г.м), эд хөрөнгө, орлого, эрх мэдэл, нэр хүнд, боловсрол, мэргэжил зэрэг нийгмийн хүчин зүйлсээр илрэн гарч, хэрэгжих бөгөөд улс орны хөгжлийн түвшин, соёлын онцлогоос, бүр гэр бүлийн дотор, байгууллага, янз бүрийн хэмжээ бүхий бүлэгт ч харилцан адилгүй илэрч, үйлчилж байдаг.

Социологийн шинжлэх ухаанд нийгмийн бүтэц, шинж чанарыг тодорхойлох илүү өргөн утга, агуулга бүхий суурь ойлголтод тооцогддог. Уг үзэгдэл нь (латин *differentia*; англи *differentiation*; герман *differenzierung*; франц *differentiation*; чех *diferenciace*) феминист, колончлолын онол зэргээр дамжин хүчтэй илэрхийлэгдэж, нийтлэг тохиолдолд хүйсийн ялгаатай байдлын талаарх хэвийн гэж тооцогддог үзэл хандлагыг шүүмжлэн гарч ирсэн гэж үздэг. Нийгэмд эрэгтэйчүүдийн үүрэг, оролцоог хүлээн зөвшөөрч эмэгтэйчүүдийг үл хайхрах, тусгаарлах (*exclusion*) хандлагын эсрэг тэгш оролцоог хангах (*inclusion*) зарчимд үндэслэдэг (Edited by Austin Harrington, Barbara I. Marshall, Hans-Peter Muller, 2006, pp. 139-140). Агуулгын хувьд ялгарал гэх ойлголтоор дамжуулан нийгмийн бүтцийг бүхэлд нь эсвэл гүйцэтгэж буй үүргээс нь хамааран дэд бүлгүүдэд хуваан тэдгээрийн хамааралт шинж, нийгмийн оршин тогтнол, тогтвортой байдлыг хангахад гүйцэтгэж буй үүргийг судалдаг (ИСПИ РАН, ИС РАН, 1998, р. 74). Төрөлхийн ялгаатай шинж, цаашлаад социаль ялгаа, ялгарал нь хүмүүс хооронд тэгш бус харилцаа үүсэх, нийгмийн байр суурь (статус)-ийг тодорхойлох суурь болох бөгөөд илүү өргөн утгаар нийгмийн давхраажлын үндэс болдог.

Нийгмийн бүтцийн судалгаанд ялгарлыг тэгш бус байдал (орос неравенство, англи inequality) гэсэн ойлголттой зэрэгцүүлэн, эсвэл нэг зүйлийн хоёр тал мэтээр ойлгож хэрэглэх (Батсугар.Ц, 2015) нь бий боловч социаль ялгаа нь нийгмийн бүлгүүдийн тухайн төлөвийг, тэгш бус байдал нь ялгаатай байдлын үр дагавар (Мөнхнасан.Б, 2004) болох баялгаас хүртэх тэгш бус боломж гэсэн утгыг заан тэмдэглэдэг. Дурдан буй хоёр ойлголт нь тодорхой нөхцлүүдэд нэг нь нөгөөгөөсөө хамаарч гүнзгийрэн бэхжих юм уу, эсвэл тэгш боломж руу ойртож байдаг ч ойлголтын агуулга багтаамжийн хувьд нийгмийн ялгаатай байдал нь тэгш бус байдлын, илүү өргөн утгаар давхраажлын үндэс суурь болдог. Өөрөөр, тэгш бус байдал нь ялгарлын нийгэмд мэдрэгдэж, хүртэгдэж буй үр дүн бөгөөд давхраа гэх ойлголтын хувьд бүлгүүдийн боломж, эрсдэлийг илрүүлэх байдлаар илүү хэлбэржсэн байдлаар илэрхийлэгдэж, хэрэглэгддэг.

Ялгарал, давхраажил гэх ойлголтуудын нийлэмж, зааг: ялгарал нь хэвтээ тэнхлэгийн дагуу хувь болон нийгмийн бүлгүүдийг биологи, физиологи, нийгэм-соёлын хүчин зүйл, шалгуураар бүлгийн шинж чанар, үүргийг шинжилдэг бол давхраажил нь босоо тэнхлэгийн дагуу нийгмийг бүхэлд нь юмуу, томоохон бүлгүүдийн эрх, эрх мэдлийн хуваарилалт, боловсрол, нэр төр, эд хөрөнгө г.м янз бүрийн шалгуураар нийгэмд эзлэх байр суурь, статусаар нь эрэмбэлэж, зэрэглэдэг. Онолын түвшинд ойлголтуудын заагийг ийн тодорхойлдог ч уг зарчим бүрэн хэрэгжинэ гэсэн үг биш юм.

Босоо тэнхлэгийн дагуух хүмүүсийн шаталсан эрэмбэ нь ялгаралд үндэслэдэг (Umanailo, M. Chairul Basrun; Umanailo, Annisa Retrofilia; Umanailo, Askar Daffa Sophia, 2020; Chris Livesey & Tony Lawson, 2006). Малчдын гэх бүлэг нь бие даасан статус бүхий босоо тэнхлэгийн дагуу бүтэцлэгдсэн бүлэг бөгөөд дан ганц хэвтээ тэнхлэгийн дагуу судалж, шинжлэх нь учир дутагдалтай. Иймд социологийн ерөнхий онолын шалгуур үзүүлэлтүүдээс судлан буй бүлгийн онцлогт тохирохуйц тодорхой шинжүүдийг шалгуур болгон зарчмын хувьд бүлгийн дотоод дахь бүлгүүдийн ялгарч буй дүр зургийг тодруулах бололцоотой гэж үзэж болно.

Түүхэн нөхцлийн хувьд нийгмийн ялгарал, тэгш бус байдлыг хэлбэржүүлэн судалсан нь хожуу боловч эртний Грек, Ромын сэтгэгчид (Платон МЭӨ 428/427-348/347, Аристотель МЭӨ 384-322)-ээс эхлээд (Даш-Ёндон.Б, Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. I боть, 2011, pp. 384-388, 495) дундад зуунд

Никколо Макиавелли (1469-1527) Д.Локк (1632-1704), И.Бентам (1748-1832), Ж.Ж.Руссо (1712-1778), Г.Гегель (1770-1831) зэрэг сэтгэгчид олдмол болон жам ёсны аль нэг шинжээр, эсвэл дурдан буй хоёр шинжийн хоёулангаар нь үүсэх анги, давхарга нь зайлшгүй бэрхшээлийг дагуулж болзошгүй тухай, мөн үүсч болох бэрхшээлийг даван туулахад засаглалын ямар бүтэц хамгийн үр дүнтэй (Болд-Эрдэнэ.Д, 2015, pp. 285-287) талаар өөр өөрийн үзэл хандлагыг дэвшүүлэн судлаж байв. Нийгмийн тэгш бус байдал, түүний шалтгаан, үр дагаврын тухай эртний болон сэргэн мандалтын үеийн сэтгэгчид дээрх байдлаар бичиж тэмдэглэж байсан бол Европ дахь нийгэм-соёл, эдийн засаг-аж үйлдвэрийн хувьсгалын үр дүнд ноёрхох байр сууриа хадгалахад чиглэсэн байгалийн хууль, өөрөөр жам ёсны гэгдэх үзэл хандлагыг шүтэн бий болсон анги, давхраа нь эд баялаг, эрх мэдлээр ялгарах нийгмийн анги, давхраагаар солигдсон үеэс социологийн шинжлэх ухааны голлох судлагдахуун болж, хэлбэржсэн. Тодруулбал, Францын хувьсгалаас өмнө баялагийн ихэнх хэсэг язгууртнууд, сүм хийдэд төвлөрч, тэд хүн амын 10 орчим хувийг бүрдүүлж байсан бол өмч хөрөнгөгүй гэгдэх дундчууд, ажилчин анги, тариачид хүн амын 90 гаруй хувийг бүрдүүлж байсан нь нийгэм-соёлын хувьсгал гарахад нөлөөлсөн гэж үздэг. Аж үйлдвэрийн хувьсгалын эхлэл 1700-аад оны сүүлээр нэхмэл, төмөрлөг, уул уурхайн үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх замаар Их Британид, улмаар Баруун Европ, АНУ-д тархаж уламжлалт үйлдвэрлэлийн технологийг механикжуулснаар хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, эдийн засгийн өсөлт хурдасч, энэ нь эргээд шинжлэх ухаан, технологийн тасралтгүй шинэчлэлийн эхлэл болж үйлдвэрлэлийн арга, технологи улам бүр сайжирч байв. Өөрчлөлт нь дан ганц бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлтөөр хязгаарлагдаагүй юм. Уламжлалт амьдралын хэв маяг, бүхэл нийгмийн зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэрт ч нөлөөлж байв. Тухайлбал, хөдөө аж ахуйд суурилсан гэр бүлийн хөдөлмөрөөс үйлдвэрлэл төвлөрсөн хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрчимжиж шинэ хотууд үүсэх, хуучин хотууд өргөжин тэлэх замаар хэт төвлөрлийн үр дүнд хотжилтын сөрөг үр дагаврууд гарах болжээ. Энэ үед технологи нийгмийн амьдралд гарч буй өөрчлөлт, бэрхшээлээс үнэ цэнтэйд тооцогдож, энэ хэрээр иргэдийн амьдрал уналтад орж байв (Royce, 2015, pp. 2-9; Энгельс.Ф, 1973, pp. 10-31). Хувьсгалын үр нөлөө ийнхүү нийгмийн бүхий л давхаргад хүчтэй нөлөөлсөн нь социологи шинжлэх ухаан болж төлөвшихөд ихээхэн түлхэц өгч (Wes W.Sharrock, John A.Hughes, Peter J.Martin, 2003, pp. 1-2), цаашид

нийгмийн үзэгдэл, үйл явцыг тайлбарлан судлах онолын бие даасан урсгал чиглэлүүд хөгжиж, өргөжих суурь болов.

Нийгмийн үзэгдэл, үйл явцыг тайлбарлаж буй байдлаар нь Т.Кун (1922-1996) парагдигмын хандлагад үндэслэн социологийн онолуудыг баримт сэлтийн (Э.Дюркгейм үндэслэн, бүтэц-үүргийн шинжилгээ, системийн, зөрчилдөөний онолуудыг багтаан үздэг), марксист (К.Маркс, Ф.Энгельс нар болон шинэ марксист үзэл баримтлалын төлөөлөгчид), дефиницын (М.Вебер үндэслэж, нийгмийн үйлдлийн онол, символик интеракционизм, феноменологи социологи, этнометодологи, нийгмийн бихевиоризм зэрэг онолууд) парадигм гэж (Мөнхбат.О, 2000, р. 18) ангилсан байдаг. Урсгал чиглэлээр нь сонгодог буюу материалист (К.Маркс 1818-1883, Ф.Энгельс 1820-1895), позитивист (биологийн чиглэл Г.Спенсер 1820-1903, газар зүйн чиглэл Г.Бокль 1820-1903), антипозитивист (В.Дильтей 1833-1911, М.Вебер 1864-1920, антропологийн чиглэл М.Шелер 1874-1929), сэтгэл зүйн хандлага (сэтгэл судлалын хувьслын, зөн билэг “инстинктивизм”, олон нийтийн сэтгэл зүй, бихевиоризм) гэж ангилдаг. Онолын урсгал чиглэлүүд аж үйлдвэрийн хувьсгалын үеийн барууны нийгмийн тусгал болж хөгжсөн. Орчин үеийн гэгдэх бүтэц үүргийн (А.Радклифф Браун 1881-1955, Т.Парсонс 1902-1972, Р.Мертон 1910-2003), бэлэг тэмдгийн (Ч.Х.Кули 1864-1929, Ж.Г.Мид 1863-1931), феноменологи социологи (А.Шюц 1899-1959, П.Бергер 1929, Т.Лукман 1927), бүтээлч структурализм (П.Бурдьё 1930-2002), бихевиоризм солилцооны онол (теории обмена) (Б.Скиннер 1904-1990, Ж.Хоманс 1910-1989), шинэ марксизмын Франкфуртын сургаал (Т.Адорно 1803-1969, Э.Фромм 1900-1980), интеграл синтезийн онол (Ю.Хабермас 1929) гэсэн онолын урсгал чиглэл (Токарев.В.В, 2012, рр. Лекц №9, №12)-үүд бий болсны зарим нь сонгодог онолын суурь зарчмыг хадгалж, эсвэл тухайн онолын аль нэг тал шинжийг гүнзгийрүүлэн судлах байдлаар хөгжүүлсний үр дүн юм. Эл судалгааны ажлын хүрээнд социологийн онолууд дахь ялгарлын тухай ойлголт тайлбар, түүнийг судлах аргачлал, шалгуур зэргийг тодруулж малчдын ялгааг судлах онолын чиглэл, арга зүйг дараах байдлаар тодруулан гаргалаа. Үүнд:

Ангийн тэгш бус байдлын талаар Адам Смит (1723-1790) (Смит, 2015, рр. 82-119), Этьен Кондильяк (1715-1780), Клод Сен-Симон (1760-1825), Франсуа Гизо (1787-1874), Огюст Минье (1796-1884) зэрэг эдийн засагчид, түүхчид, гүн ухаантан (Рафисович.М.С, 2014, рр. 170-179)-ууд судлаж байсан ч К.Маркс (1818-1883) ул

суурьтай, өргөн хүрээнд судлаж нийгэм дэх өмч, түүний хуваарилалт нийгмийн тэгш бус байдлын үндэс суурь болж буй тухай шүүмжлэлийг дэвшүүлснээрээ үнэ цэнтэй, нөлөө бүхий онолын үндэслэгч гэгдэх болсон юм. Түүхийн тодорхой үед үзэл суртлаас үүдэлтэй онолын нөлөө, байр суурь буурсан ч нийгмийн ялгарал, тэгш бус байдал, давхраажлын талаар судлаж буй марксизмын талыг баримтлагчид төдийгүй эсрэг байр суурь бүхий урсгал, чиглэлийн төлөөлөгчид ч түүний боловсруулсан ангийн онолыг шинжлэн судалдаг бөгөөд дэлхий нийт уг онолын асуудлыг бүхэлд нь эргээд (Кагарлицкий, 2018) шүүн хэлэлцэх болжээ.

Тэрээр нийгмийн тэгш бус байдлын үндсийг "Ангийн эдийн засгийн уг чанар ямар ч л гэсэн үйлдвэрлэлийн арга, хөдөлмөрийн нийгмийн хуваариар тодорхойлогдоно." (Кагарлицкий, 2018, р. 35) гэж үзсэн. Газар, үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл, машин механизм, түүхий эд зэрэг "үйлдвэрлэлийн хэрэгсэл"-ийг хэн эзэмшиж байгаагаас хамаарч 1) газар, үйлдвэр, үйлдвэрийн хэрэгслийг өмчлөгч капиталист анги (санхүүгийн, аж үйлдвэрийн, худалдааны, жижиг хөрөнгөтөн), 2) нийгмийн болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг гардан гүйцэтгэдэг ажилчин анги (пролетари, люмпен пролетари), 3) газар өмчлөгч (газрын эзэн, жижиг тариачид) ангиас бүрдэнэ. Анги нь сонирхол, амьдралын хэв маяг, арга барил, хүсэл зорилгоо ойлгож ухаарсан харилцаанд тулгуурладаг бөгөөд ямар нэгэн ангийн эсрэг тэмцэл явуулах үед тусгаар бодгалиуд ангийг буй болгож байдаг.

Үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөгч капиталист анги ажиллагсдын хөдөлмөрийг мөлжсөний үндсэн дээр капиталыг улам бүр хуримтлуулах бол үүний үр дүнд эсрэг талд ажилчин анги бие махбод, оюун санааны хувьд мөлжлөгт өртөж, хөдөлмөрөөс хүнийсдэг (1. Өөрийнхөө хөдөлмөрийн бүтээгдэхүүнээс хагацдаг, 2. Албадлагын шинжтэй хөдөлмөр нь сэтгэл ханамж өгдөггүй учир ажилчин үйлдвэрлэлийн үйл явцаас хүнийсдэг, 3. Өөрийн уг чанар буюу төрөлхтний ахуйгаасаа хүнийсдэг, 4. Зах зээлд эзэлж байгаа байр сууриар нь үнэлдэг учир бусад хүмүүсээс хүнийсдэг). Ангиудын хоорондох эдийн засгийн ашиг сонирхлын зөрчил нь эцсийн дүндээ ангийн тэмцэлд хүргэдэг (Royce, 2015, pp. 24-25, 136-137; Kathy S. Stolly, 2005, pp. 139-140).

Марксист хандлага. Нийгмийн ялгарал, тэгш бус байдлын үндэс нь өмчөөс хамаардаг (Маркс.К, Капитал I, 1999, р. 859) гэсэн нь К.Марксын онолын гол санаа юм. Хожуу түүний сургаалийг залгамжлагчид анги ба өмчийн харилцаа, захирах захирагдах

харилцааг гүнзгийрүүлэн судлаж онолын дэд чиглэлүүдийг хөгжүүлсэн юм. XX зуунд ленинизмын чиг шугамыг баримталсан сталнизм, маосизм, социаль демократ үзэл дэлгэрч, Д.Лукач (1885-1971), А.Грамши (1891-1937) зэрэг нэр хүндтэй эрдэмтэд төрөн гарсан. Сүүлд Франкфуртын (М.Хоркмайер 1895-1973, Т.Адорно 1903-1969, Г.Маркузе 1898-1979, Э.Фромм 1900-1980), Франц дахь экзистенциаль марксизм (Ж.П.Сартр 1905-1980, М.Мерло-Понти 1908-1961)-ын гэх хоёр том урсгал сургууль салбарлан хөгжиж нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн онолын түвшинд хүрчээ.

Нийгмийг өөрчилж чөлөөлөх хүч, боломж нь ажилчин ангид бий гэх Марксын энэхүү үзэл баримтлалыг Ленин бодит үйл хэрэг болгон өөрчилсөн (S.Turner, 2003, pp. 7, 45) бөгөөд түүхэн үйл явдлаар баталгаажсан ангийн хүч, боломжийн талаарх энэхүү баримт, нотолгоог Г.Лукач (1855-1971) дахин бататгасан. Тэрээр Марксын гүн ухааны арга, хэлбэр нь марксист диалектикт бий гэж үздэг. Марксизм нь түүхэн бодит байдлыг онолын түвшинд зөв танин мэдэх боломжийг олгодог гээд ажилчин анги нь мөн чанарын хувьд хүн төрөлхтнийг аврагч оюун санааны хүч гэж үзэж байв (Лукач.Г, 2003, р. 29). Ангийн ухамсар нь “шинээр гарч ирж буй ухамсар” болж “өөртөө буй” ангиас “өөрийнхөө төлөө анги” болдог. Анги нь өөрийн материаллаг нөхцөл, байр сууринаас ертөнцийг танин мэдсэн үед өөрчлөлтийг хийж чаддаг (Лукач.Г, 2003, pp. 32, 64) ба эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд бизнес эрхлэгчид, эрдэмтэд, эдийн засагчид, хуульч, техникийн мэргэжилтэн г.м сэхээтний хэд хэдэн давхаргыг өөртөө багтаадаг (Грамши.А, 2020, pp. 311-312).

Марксизмын талыг баримтлагч хожуу үеийн эрдэмтэд ангийн харилцаа, тэгш бус байдлыг нийгмийн ерөнхий түвшнээс үйлдвэр, корпорацийн түвшинд буулгаж, шалтгааныг нь технологийн хөгжилтэй холбон судлах болсноор онцлогтой. XX зууны барууны эдийн засаг дахь өмчийн бүтэц, хөдөлмөрийн зохион байгуулалт, түүгээр зогсохгүй ажилчин ангийн бүрэлдэхүүн, сэтгэл зүйн байдал ч өөрчлөгдсөн гэж үзэж байв. Тэрээр корпораци хоорондын, корпораци болон банкны хоорондын институтжсэн харилцааг нарийвчлан шинжилж корпорациуд капиталист өмчлөгч ангийн үр дүнтэй хяналтыг сулруулдаггүй, харин удирдлагын чиг үүргийг хэд хэдэн хэсэгт дахин хуваарилж байна гээд “Өмч ба хяналт”-ын үзэл баримтлал (Моррис Цейтлин), бүтээмж өндөртэй техникийн болон лабораторийн, мэргэшсэн, ур чадвар бүхий ажилтнуудаас бүрдэх “Шинэ ажилчин анги” өөртөө “өөрчлөлтийн хүч”-ийг тээж байдаг тухай (Серж

Малле), технологийн хөгжлийн үр дүнд ажилчид хөдөлмөрөөс чөлөөлөгдөхөд хүрч байгаа тул хөдөлмөр, үйлдвэрлэлээс нийгэм соёлын илүү өргөн асуудалтай тулгарч байна (Андре Горц 1923-2007) гэх үзэл хандлага (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 110-112)-ыг дэвшүүлсэн. Мөн капитализмын заналхийлэл орчин үед шинжлэх ухаан, инженерчлэлийн бүхий л нөөц баялагт тулгуурлан хэрэгжиж буй тухай Харри Браверман (1920-1976) үйлдвэрлэлийн материал, хэрэгсэл дээр “ажиллах хүч”, “үйлдвэрлэлийн хүчин зүйл”, мөн цорын ганц субъектив элемент болох менежмент нэмэгддэг. Гол нь энэ нөхцөлд ажиллах хүч нь үйлдвэр эрхлэгчийн хувьд “капитал”-д тооцогдож, үйлдвэрлэлийн процесст объект болж хувирах бөгөөд үйлдвэрлэлд ашиглаж буй машин механизмын нэг хэсэг гэж тооцогддог. Капиталын монопольлол нь шинжлэх ухаан, технологийн ололтоор улам бүр баталгаажиж буй бөгөөд үүгээр дамжин аж үйлдвэрийн өмнөх болон дараах ангийн бүтэц хадгалагдаж байгаа юм (Braverman, 1998, pp. 169-173, 377) гэжээ.

Тодорхой институт хийгээд технологитой холбоотой ялгарал, тэгш бус байдлаас гадна ангийн харилцаа нь уламжлагдах шинжтэй, мөн олон талын харилцааг багтаадаг гэх үзэл хандлагыг дэвшүүлж байв. Тухайлбал, Никос Пуланцас (1936-1979) ангийн бүтэц нь зөвхөн эдийн засгийн харилцаагаар хязгаарлагдахгүй бөгөөд энэ нь улс төр, үзэл суртлын ноёрхох болон захирагдах харилцааг багтаана (Poulantzas, 1975, pp. 13-20), Эдвард Томпсон (1924-1993) эрх баригч болон дарлагдсан ангиудын аль алиных нь түүхэн хийгээд үйл ажиллагааны олон янз байдал, мөн тэдгээр нь уламжлагдан үлдсэн элементүүдтэй болохыг тэмдэглээд анги нь хийсвэр, эсвэл салангид байдлаар тодорхойлогдох боломжгүй нийгэм, соёлын цогц, институтчилэгдсэн бүтэц бөгөөд нийтлэг ашиг сонирхол, туршлага, уламжлалт, үнэт зүйлсийн тогтолцоо бүхий бүлэг хүмүүс ба өөрсдийн хандлага, үйлдэл, ухамсраараа ангийг тодорхойлох хандлагатай (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 114-115) гэсэн санааг дэвшүүлдэг.

Марксизмын төлөөлөгчдөөс Эрик Олин Райтын “Ангийн онол” нэлээд нарийн бүтэцлэгдсэн. Тэрээр ангийн талаарх марксист тодорхойлолтуудыг шинжилж нэгд, ангиудыг дээд, эсвэл доод гэж ойлгохоос илүүтэй харилцааных нь хувьд “капиталистууд” ба “ажилчид”, “феодалууд” ба “хамжлагууд” гэж тодорхойлдог. Хоёрдугаарт, ангийн харилцааг дан технологи, үйлдвэржилт, хөдөлмөрийн хуваарь гэх мэт эдийн засаг, техникийн зохион байгуулалтад эзлэх байр сууриар бус нийгмийн

талаас нь шинжилдэг. Гол нь эдийн засгийн, ингэхдээ үйлдвэрлэлийн харилцаанд үндэслэн нийгмийг системтэйгээр судлаж, шинжилдэг. Гуравдугаарт, үйлдвэрлэлийн үйл явцад үндэслэн ангийн харилцааг тодорхойлдог. Энэ нь Веберийн үзэл хандлагаас ялгаж өгдөг. Үйлдвэрлэлийн харилцаа нь ангийн харилцааг тодорхойлдог.

Орчин үед ямар ангиуд оршин буй талаар тогтсон ойлголт бүрдээгүй. Ихэвчлэн “дунд анги”-д анхаарал хандуулж шинжилдэг. Нийтлэг тохиолдолд биеийн хүчний хөдөлмөр эрхлэгсэд ажилчин ангид, гэр бүлийн бизнес эрхлэгчид капиталист ангид багтдаг гэдэгтэй хэн ч маргадаггүй ч мэргэшсэн инженер, менежрүүд гэхчлэн албан тушаалтай холбогдоод ирэхээр маргаан үүсдэг. Тэрээр асуудлыг шийдэх гарцыг: 1). Бодит өмч буюу эзэмшиж буй хөрөнгөөр ялгагдах цөөн тооны менежер, захирлуудыг эс тооцвол бүх ажилчид ажилчин ангид хамаарна. Энэ хандлагаар авч үзвэл хүн амын 80-90 хувийг эзлэх ажилчин анги, 8-10 хувийг эзлэх хөрөнгөтнүүдээс бүрдэнэ. 2). Цалин хөлсөөр ажилладаг хүмүүсийн тодорхой хэсгийг жижиг хөрөнгөтөнд оруулдаг уламжлалт жижиг хөрөнгөтнүүд болох гар урчууд, худалдаачид, хувиараа үйлдвэрлэл эрхлэгчдээс ялгахын тулд “шинэ жижиг хөрөнгөтөн” гэж нэрлэдэг. Жижиг хөрөнгөтөн жижиг капиталист ангид хуваагдана гэсэн үг юм. 3). “Мэргэжлийн болон удирдлагын” гэх завсрын анги байх бөгөөд ангийн нөхөн үйлдвэрлэлийг хангаж байгаагаар үүрэг нь тодорхойлогддог. 4). Үйлдвэрлэлийн үйл явцад оролцож буй албан тушаал бүрийг нэг ангид багтаах нь өрөөсгөл гэж үздэг.

Ангийн бүтцэд хандах энэ хандлага нь нэг талаас үйлдвэрлэлийн үйл явц дахь ялгаатай чиг үүрэг гүйцэтгэхтэй холбоотой, нөгөө талаас үйлдвэрлэл дэх захирах, захирагдах харилцааг өөртөө багтаадагтай холбоотой. Үйлдвэрлэл харилцаа нь мөнгөн капитал, биет капитал буюу үйлдвэрлэлийн хэрэгсэл, хөдөлмөр гэх харилцан уялдаатай гурван нөөцөөр тодорхойлогдох бөгөөд эхнийх нь эдийн засгийн “бодит өмчлөл”, хоёр болон гурав дахь хэсэг нь “эзэмшил” болно. Эдгээр хүчин зүйлс нь капиталист үйлдвэрлэлийн зайлшгүй нөхцөл юм. Түрээслэгчид биет капитал хийгээд хөдөлмөрийг шууд хянадаггүй боловч капиталист ангид багтдаг (Райт.Э.О, 2000, pp. 36-39).

Мөнгөний капитал, биет капитал, хөдөлмөрийг хянах нийгмийн харилцааны хувьд капиталист анги захирах, ажилчин анги захирагдах шинжтэй бөгөөд хийсвэрлэлийн өндөр түвшинд энэ хоёр ангийг ялгаж үздэг. Хийсвэрлэлээс тодорхой шинжилгээний түвшинд буухад бусад ангиуд тодрон гардаг. Тухайлбал, үйлдвэрлэлийн

өмнөх буюу уламжлалт үйлдвэрлэл нь капиталист үйлдвэрлэлтэй зэрэгцэн оршдог ч мөнгө, биет капиталд л хяналт тавьдаг. Менежер болон мастеруудыг ажилчин, эсвэл капиталист ангид оруулахад төвөгтэй бөгөөд тэд мөнгөний капиталаас хөндий байх боловч үйлдвэрлэлийн бодит хэрэгсэл, хөдөлмөрт хяналт тавьдаг.

Жижиг ажил олгогчид хөлсний хөдөлмөр ашигладаг ч капиталистуудтай харьцуулахад тэд ажилчидтайгаа хамт үйлдвэрлэлийн үйл явцад оролцож, их хэмжээний хөрөнгө хуримтлуулах хөдөлмөр зарцуулдаггүй. Энэ нь тэднийг жижиг хөрөнгөтөн, эсвэл капиталист ангид оруулахад төвөгтэй болгодог. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид мөнгөний капитал хийгээд хөдөлмөрт хяналт тавихаас хөндий бөгөөд биет капиталд хяналт тавьж байгаагаараа жижиг хөрөнгөтний адил юм. Нөөцийг эзэмшиж, ашиглаж байгаагаас хамааран дурдан буй хэв маягуудыг капиталист өмчлөгч, эсвэл ажилчин ангид шууд хамааруулахад төвөгтэй ийм нөхцлийг Эрик Олин Райт ангийн байр суурийн зөрчил гэж нэрлэсэн.

Үүргийн хандлага. Маркстай нэгэн зэрэг түүний ангийн үзэл баримтлалыг сэргүүлэн Г.Спенсер (1820-1903) нийгмийн тэгш бус байдлын үзэл баримтлалаа боловсруулсан юм. О.Конт (1798-1857)-ын позитивизмыг залгамжлагч, Английн социологийг, мөн функционализмын чиглэлийг үндэслэгчдийн нэг гэгдэх тэрээр угсаатны зүйн материалд суурилсан “Социологийн зарчмууд” зохиолдоо социологийн ухааныг системчилсэн. Түүнийхээр хөгжлийн аливаа үйл явц нэгдэл ба ялгарал гэсэн хоёр талтай ба энэ үйл явц энгийн тооны өсөлт, эзлэхүүн юм уу бүрэлдүүлэгч элементүүдийн тооны ихсэлтээс эхэлдэг. Хувьслын үр дүнд нийгэм нь нэгэн төрлийн байдлаас олон янз байдалд шилжих, улмаар нийгмийн үүргийн ба бүтцийн дотоод ялгаа улам бүр нэмэгдэнэ. Энгийн нийгмийн организмуудад тусгай хэсэг, үүргүүд нь сул ялгарсан, бие биетэйгээ төсөөтэй байдаг. Тусгай нэг бүтэц нь энд нийгмийн өөр хэд хэдэн үүргийг биелүүлж болно. Мөн нэг үүргийг хэд хэдэн өөр бүтэц биелүүлж байдаг. Нийгэм өсөхийн хэрээр түүний хэсгүүд нь бие биетэйгээ улам төсөөгүй болж, тэдгээр нь зохицуулалтыг шаардсан улам төрөлжсөн өөр өөр үүргүүдийг биелүүлж эхэлдэг. Хувь хүмүүс нийгэмд бүхэлдээ захирагддаг бол нийгэм нь социаль организм (Offer, 2010, pp. 197-198) болохын хувьд бүрэлдэхүүн хэсгүүддээ үйлчилдэг. Хөгжингүй нийгэм бүр хэрэгцээт бүтээгдэхүүнээр хангах дэмжин тэтгэгч систем, хөдөлмөрийн хуваарьд суурилсан организмын уялдаа холбоог хангах хуваарилалтын систем, хэсгүүд

бүхэлдээ захирагдах боломжийг хангадаг зохицуулалтын систем гэсэн эрхтэн тогтолцоотой.

Ангийн ялгарах шинж нь байлдан дагуулалтын үр дүн бөгөөд ялагчид нь эрх баригч ангийг, ялагдагсад нь боол, эсвэл хамжлага болдог гээд ангийн гурван хэв маягийг ялган тэмдэглэсэн. Доод анги нь хүнсний болон үйлдвэрлэлийн зориулалттай түүхий эд, материал цуглуулах зэргээр нийгмийн амьдралын тогтвортой байдлыг хангадаг. Дунд анги түүхий эд боловсруулах, түгээх, хүргэх, худалдах зэргээр илүү идэвхтэй бөгөөд амьтдын адил цусны эргэлтийн, дээд анги нь удирдах, чиглүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Организм үндсэн эрхтэн тогтолцоогүйгээр оршин тогтнох боломжгүйтэй адил хүн төрөлхтөн ч захирах, захирагдах ёсноос гажиж чадахгүй. Шалгарлын хуулиар ноёрхох байр суурь луу хүчирхэг хэсгийг нь хөтөлж, сул дорой нь доод шатандаа үлддэг (Offer, 2010, p. 201; Mingardi, 2011, p. 75).

Үүргийн ялгаралт хэдий чинээ их болох тусам тусгаар бүтцүүдийн зохицуулсан үйлдлийг хангаж чадах ямар нэг удирдагч, зохицуулагч оньс байх явдал төдий чинээ чухал болдог. Ингэж удирдлагын үйл явц өөрөө нарийсч, ялгарч байдаг учиртай. Нийгмийн хувьслын бүр эртний үе шатанд ч эрх баригчид ба удирдуулагчдын хоорондын ялгарал үүсч, аажмаар улам хурц болдог. Эрх баригчийн засаг нь түүнтэй нэгэн зэрэг үүссэн шашны засаг, тэр хоёроос аажмаар салан тугаарласан зан үйлдлийн болоод ёс заншлын нийтээр дагадаг дүрмүүдийн засгаар давхар дэмжүүлж байдаг (ШУА-ийн ФСЭХ, 2006, pp. 86-87).

Тэгш бус байдлын онол боловсруулахад Австрийн социологич Людвиг Гумплович (1838-1909) чухал хувь нэмэр оруулсан. Тэрээр нийгмийн амьдралыг танин мэдэхийн тулд хамгийн энгийн бүрдэл болох нийгмийн бүлгийн үүрэг, ач холбогдлыг мэдэх хэрэгтэй гэж үзсэнээрээ социологийн мэдлэгийн субъект нь хувь хүн бус харин нийгмийн бүлгүүд гээд тэдний харилцаа (захирах ба захирагдах харилцаа, материаллаг ба оюун санааны ашиг сонирхол, хүсэл эрмэлзэл г.м)-г мэдэхийг чухалчилсан. Түүнийхээр анхны бүлгүүд антропологи, угсаатны шинжээрээ нэгдэж, хоорондоо дайсагналцаж бие биенээ устгаж байсан бол хувьслын явцад ялагчид ялагдсан хэсгээ боолчлох болсон. Төр мөн ийм байдлаар үүссэн гэж үздэг. Тэмцлийн үр дүнд хүчтэй нь сул доройгоо хэрэгцээгээ хангах хэрэгсэл болгох зорилгоо хэрэгжүүлэхийн тулд захирахыг эрмэлздэг. Тэгэхлээр ангийн хуваагдал нь захирах ба захирагдах харилцаа,

мөн эдийн засаг дахь хөдөлмөрийн ялгаатай байдлаар тодорхойлогддог. Тэрээр орчин үеийн Европт язгууртнууд, хөрөнгөтнүүд болон тариачид гэсэн харьцангуй хаалттай ангийн гурван хэв маяг байна гээд тэдгээр нь эд хөрөнгө, ажил мэргэжил, статусын өв залгамжлагдах шинжээрээ ялгарч, шатлан байрладаг. Ангийн шатлал нь хөгжлийг өдөөх хөшүүрэг болдог бөгөөд хүн бүр дээд шатлалд хүрэхийг эрмэлздэг.

Гумпловичийн бүтээл хэвлэгдэж байх үеийн Герман улсад хөдөлмөрийн хуваарь, мэргэжлийн боловсролыг үндэс болгосон ангич онол өргөн тархсан. Густав Шмолер (1838-1917) энэ чиглэлийн томоохон төлөөлөгчид тооцогдоно. Анги (мэргэжил, хөдөлмөрийн үйл ажиллагаа, өмч, боловсрол, улс төрийн эрх, сэтгэл зүйн байдал, арьс өнгөг.м)-ийн тухай олон шалгуурт онолыг дэвшүүлсэн бөгөөд хөдөлмөрийн хуваарь, мэргэжил боловсролд шууд ач холбогдол өгч өмч болон орлогын тэгш бус байдал, зөрчил нь хөдөлмөрийн хуваарь, боловсрол мэргэжлийн үр дүн гэж үзэж байв. Хөдөлмөрийн хуваарь нь өөртөө үндэсний онцлог бүхий бие даасан хэв маягуудыг багтаадаг учир үе улиран уламжлагддаг. Үүнээс хөдөлмөрийн нөхцөл, амьдралын маягийн ялгаа үүсдэг. Үүнтэй төсөөтэй санааг Вернер Зомбарт (1863-1941) дэвшүүлсэн. Тэрээр анги бүр өнөөгийн эдийн засаг өнгөрсөн үеийн эдийн засгийн тогтолцоог өөртөө тээн агуулж байдаг бөгөөд өвлөж авсан ажил мэргэжлээр дамжин ангийн ухамсар, амьдралын хэв маяг залуучуудад өвлөгдөж байдаг. Ангийн талаарх түүхэн хандлагын учир шалтгаан нь үүнд оршино. Давхраажлын хандлагад суурилсан ангийн онолч гэгдэх Рене Вормс (1869—1926) нэг ижил мэргэжил бүхий хүмүүс нэг ангид хамаарах боловч үзэл бодлоороо өөр ангид харъяалагдаж, эсвэл өөр өөр мэргэжилтэй хүмүүсийн байр суурь адил байж болно. Тэрээр ижил байр суурь, ижил хүсэл эрмэлзэл, ижил сэтгэлгээтэй, ижил амьдралын хэв маяг бүхий хүмүүсийг анги гэж ойлгоно гээд анги нь нэгд нийтлэг зорилгод чиглэсэн хувь хүмүүсийн хамтын ажиллагааны үр дүн, хоёрт баялагийн хувьд ойролцоо хүмүүс юм гэж тодорхойлсон (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 76-78).

XX зууны дунд үеэс давхраажлын үзэл баримтлалд функционалистуудын байр суурь нэмэгдэж ирсэн бөгөөд Т.Парсонс (1902-1978) (Парсонс.Т, 2000), Л.Уорнер (1898-1970), Б.Барбер болон бусад төлөөлөгчид “систем дэх харилцан хамаарал бүхий хэсгүүд нь нийгмийн тэнцвэртэй байдлыг хадгалах чиг үүрэгтэй” гэж тайлбарлаж байв. Эдгээрээс Т.Парсонс давхраажлын асуудлыг тусгайлж авч үзээгүй боловч нийгмийн янз

бүрийн нэгжийг үнэлэх ёс суртахууны үнэлэмж (моральная оценка), үнэт зүйлсийн систем гэж үзсэн. Парсонс нийгмийн бүтцийг тодорхойлох урьдач нөхцөл нь 1) Дүрийн зан үйл (behavior)-ийг сэдэлжүүлэх нөөц, 2) Нөхцөл ба нөхцөл байдлын нөөц, 3) Соёлын хуримтлал (мэдлэг, эд өлгийн зүйл “artifacts” г.м)-аас бүрдэнэ (Parsons, 2005, p. 92). Тэрээр бүтэц дэх “организмууд, бие хүний төрөлх чанар (эго), бие хүний өөрчлөлт, нэгдэл, биет, соёлын объект” гэсэн объектын хэлбэрүүдийг заан эдгээр нь нийгмийн системд тодорхой, бүтэц дараалал бүхий үүрэг гүйцэтгэх ба хүлээгдэж буй үүргийн хувьд олон талт болон онцгой “Particularism”, тодорхой болон амжилттай, өвөрмөц болон төвийг сахисан, өөртөө чиг барижаа олгох болон хамтын ажиллагааг хангах, чиглүүлэх гэсэн үүргийг гүйцэтгэдэг. Америкийн социологич М.Эдвард, С.Прейс нар нийгмийн бүтэц, тэгш бус байдал нь системийн онцлогоос хамааралтай өөр өөр болохыг тус тусдаа судалсан бол О.Д.Данкен “нийгэм-эдийн засгийн индекс”-ийн аргачлал боловсруулж, Д.Фитерман, Р.Хаузер нар Данкений аргачлалыг ашиглан өндөр мэргэшсэн 17 бүлгийг тодорхойлсон (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 89, 100-101).

Функционалистуудаас Л.Уорнер “Янки сити” (Уорнер.Л, 1999) гэх бүтээлээрээ нийгмийн давхраажлын судалгаанд нэрээ үлдээсэн бөгөөд арга зүйн хувьд бусдаар үнэлүүлэх байдлаар нийгмийн статус, бүтэц (дээд, дээд дунд, дээд доод, дээд дунд, дунд дунд, доод дунд, доод дээд, доод дунд, доод ёроолын хэсэг)-ийг тодорхойлон судалсан нь түүний ажлын гол үр дүн юм. Хэрэв тодорхой нэг хүний боловсрол, мэргэжил, хөрөнгө чинээ, орлого, гэр бүл, найз нөхөд, харилцааны хүрээлэл, биеэ авч явж буй байдлыг бусад хүмүүс мэддэг бол статусыг нь нэлээд бодитой, ойролцоо түвшний хүмүүстэй нэг түвшинд тодорхойлох боломжтой гэж үзсэн юм. Тэрээр үүнийгээ тухайн орон нутаг дахь Хилл стрит, Ривербүүк гэх байр зүйн нэршлийг 1. Хэнд хамааралтай хэрэглэж байгаа, 2. Бүлгийг тодорхойлохдоо үндэс болгож буй шинж чанарууд, 3. Нэршлүүдийг бүхэлд нь, эсвэл зарим утга санааг хэн хэрэглэж байгааг тодорхойлох байдлаар судалгааны ажилдаа ашигласан. Зарим үр дүнгээс тодруулахад, үе дамжин амьдарсан эсэхээс хамаарч зарим нэг ялгаа ажиглагдсан ч энэ нь нийтлэг бус дүр зургийг илэрхийлж байсан юм. Гэхдээ ангич шинжтэй байр суурь нь буяны байгууллага, тодорхой клуб, нийгэмлэгүүдэд харъяалагддаг эсэх, эсвэл тэнд харъяалагдах боломж, гишүүнээр элсэх дур сонирхлоор тодорхойлогдох шинжтэй байж.

Мөн гэрлэлт нь нас, угсаатны бүлгүүдэд харилцан адилгүй болохыг тэмдэглэсэн (Уорнер.Л, 1999, pp. 48-49, 55-57).

Уорнерийн зэрэгцээ К.Дэвис, У.Мур нарын “Давхраажлын зарчмууд” (Kingsly Davis, Wilbert E. Moore, 1945) бүтээлийг судлаач, эрдэмтэд онцолдог. Тэд нийгмийн давхраажилд хувь хүмүүсийн эзлэж буй байр суурь, тэдгээрийг урамшуулж сэдэлжүүлэх хэрэгцээтэй болохыг тайлбарлан, засаглал (эрх мэдэл), эд баялаг-хөрөнгө-хөдөлмөр, техникийн мэдлэг гэсэн үзүүлэлтүүдээр нийгэм давхрааждаг гэж үзсэн. Энэхүү тэгш бус хуваарилалт нь тухайн байрлал дахь функциональ ач холбогдлоор тодорхойлогддог. Нийгмийн тэгш бус байдал бий болоход а) нийгмийн ач холбогдлын түвшин, б) хамгийн их бэлтгэл, чадвар шаарддаг ажил албан тушаал гэсэн хоёр хүчин зүйл нөлөөлдөг. Эхний хүчин зүйл нь нийгмийн үүрэгтэй холбоотой харьцангуй ач холбогдолтой асуудал бол хоёр дахь нь хомсдолтой холбоотой юм. Үүнтэй холбоотой тэд ажил, албан тушаалын урамшууллыг; Үүргийн ялгаа: хэрэв тодорхой албан тушаалд ажиллах сонирхолтой хүмүүс их байгаа тохиолдолд урамшуулал өндөр байх шаардлагагүй. Эсрэгээр тодорхой албан тушаалд тэнцэх хэмжээний ажиллах хүчин хомс тохиолдолд түүнд тохирох ажилтныг олох хүртэл өндөр урамшуулал олгох хэрэгтэй. Боловсон хүчний ялгаа: яаж олж авснаас үл хамааран бүх төрлийн албан тушаал зарим төрлийн ур чадвар, гүйцэтгэлийн чадавх шаарддаг. Харин чадвар нь төрөлхийн, эсвэл сургалтаар дамжуулан бий болгож болдог. Үүргийн болон боловсон хүчний ялгаатай байдал нь нийгмийн хэв маяг, хөгжлөөс хамааран ялгаатай байдлаар илэрч болох аж.

Бүтцийн хандлага. Социологийн шинжлэх ухааны сонгодог онолд К.Маркс, Г.Спенсер болон М.Вебер (1864-1920)-ийн онолыг зүй ёсоор оруулан тооцдог бөгөөд түүний үзэл хандлага төлөвшихөд Марксын капиталын үүсэл, хөгжлийн тухай сургааль ихээхэн нөлөөлсөн (ШУА-ийн ФСЭХ, 2006, pp. 191-195). Тэрээр нийгмийн тэгш бус байдлын мөн чанар, хэлбэр, үүргийн тухай орчин үеийн үзэл санааг төлөвшүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн.

Нийгмийн давхраажлын судалгаанд эдийн засгийн хүчин зүйлээс гадна эрх мэдэл, нэр хүнд (Вебер.М, 2016) гэх үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн бөгөөд харилцан уялдаа бүхий гурван хүчин зүйл нь нийгэмд шатлалыг бий болгодог. Нэг зүйлд тэгш бус байвал энэ нь бид бүх зүйлд тэгш бус гэсэн хэрэг биш; гурван хэмжүүр тохирч байх

албагүй; тэдгээр нь бие биедээ хамаардаггүй, тэдгээрийн аль нь ч детерминизм утгаараа шийдвэрлэгч байдаггүй; давхраажил ямагт гурван хэмжээстэй гэж үздэг (ОХУ-ын ШУА-ийн Социологийн институт, Шихихутуг ХЗДС-ийн Шихихутуг судалгааны төв, 2012, р. 14).

Өмчийн ялгаатай байдал нь эдийн засгийн ангиудыг, эрх мэдэл нь улс төрийн намуудыг, нэр хүндийн ялгаа нь статусын бүлэг, эсвэл давхарга үүсгэдэг. Тухайлбал, энэ нь амьдралын боломж, байр суурийн ялгаа руу хөтөлдөг бөгөөд амьдралын хэв маяг, зан байдал, амьдралын зарчмаар ялгарахад нөлөөлдөг. Амьдралын хэв маягийг бүлгийн нийтлэг “дэд соёл”-оор тодорхойлж “байр суурийн нэр хүнд”-ээр хэмждэг. Байр суурь (статус бүлэг)-ийн бүлэг нь тухайн дэд соёлд агуулагдах нэлээд ухамсартай, зан үйлийн стандартаар дамжуулан гишүүдээ удирддаг (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, р. 85). Эрх мэдлийн тухайд, ардчилал гэх халхавч дор улс төрийн эрх мэдэл нь эдийн засгийн давуу эрхэт ангийг бий болгох бөгөөд тэд үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмшиж, хянасан хэвээр байгаа тухай тэмдэглэсэн. Түүнийхээр “ангийн байр суурь”, “анги” гэсэн ойлголтууд нь хувь хүмүүсийн ижил, эсвэл ойролцоо ашиг сонирхлыг илэрхийлдэг. Зарчмын хувьд бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хэрэгсэл, эзэмшиж буй өмч баялаг, орлого олж буй арга хэрэгсэл, ур чадвараа захиран зарцуулах боломжууд нь ангийн байр суурийг тодорхойлдог. Мэргэшээгүй, үл хөдлөх хөрөнгөгүй, зөвхөн хөдөлмөрийн хөлсөөр амьдардаг хүмүүс нэг ангид багтана. Капиталист нийгэмд ангийн бүтэц тогтворгүй шнжтэй тул тэдгээрийг судлаачид янз бүрээр илэрхийлэн бичих нь бий.

Ангийн байр суурь бол энгийн боломж бөгөөд 1). Өөртөө ашиг тустай, 2). Тодорхой байр суурь бүхий. 3). Хувь хүмүүсийн эзэмшин буй бараа, ур чадвар, эдийн засгийн хүрээнд орлого олоход чиглэсэн эрх, хэмжээгээр ангийн байр суурь тодорхойлогдоно. Ангийн байр суурь бүхий бүлэг хүмүүсийг анги гэж тодорхойлсон. Харин анги нь а). Эзэмшиж буй өмчийн шинж чанараар, б). Зах зээл дэх бараа, үйлчилгээнээс хүртэх, ашиглах боломжоор, в). Нийгмийн анги нь ангийг тодорхойлох хүчин зүйлүүдийн цогц бөгөөд нэг ангиас нөгөөд дангаар, эсвэл үеийн дагуу шилжих боломжтой байдаг. Дурдан буй гурван хүчин зүйлийн үндсэн дээр ангийн ашиг сонирхол бүхий хүмүүсийн хооронд холбоо (ангийн холбоо) үүсч болох ч гарцаагүй байгуулагдах ёстой гэсэн үг биш юм.

Өмчлөгч анги нь 1. Өндөр үнэ бүхий өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг монопольлох, 2. Давуу байдлаа хадгалахын тулд үүнтэй холбоотой бодлого хэрэгжүүлэх, 3. Хэрэглээнд ашиглагдаагүй илүүдлээр бусад боломжийг монопольлох, 4. Хуримтлал үүсгэх замаар капиталыг монопольлох, улмаар төрийн байр суурийг зээлдэгч болгон хувиргаж хөрөнгө оруулалт хийх, үүнээс үүдэн төр бизнес эрхлэгчдийн байр суурийг дагаж мөрдөх, 5. Боловсрол (үл хөдлөх хөрөнгө)-ыг монопольчилдог.

Өмчлөгч, эрх бүхий анги хэрхэн тогтож байгаагаас үл хамааран үр тариа, мал, мөнгө, үнэт цаас гэх зайлшгүй хэрэгцээт зүйлсийг өөртөө төвлөрүүлдэг бол эсрэг талд нь өмчлөх зүйлгүй, ангийн байр суурьгүй, өртэй, ядуусаас бүрдэх ердийн ангиуд байрладаг. Эдгээрийн дунд өөрийн гэсэн эд хөрөнгө өмчтэй, боловсрол, ур чадвартай, түүгээрээ орлого олдог янз бүрийн давхаргаас бүрдэх дунд анги байрладаг. Дунд ангийг орлогоор нь бизнес эрхлэгчид, эсвэл пролетари, сөрөг давуу эрх бүхий пролетари анги гэж хувааж болох ч тариачид, гар урчуудын олонх нь уг ангилалд багтдаггүй (Вебер.М, 2016, pp. 334-336).

М.Веберийн сургаал номлолыг түүхийн тодорхой үед Марксын үзэл сургаалыг үгүйсгэж няцаах хэрэгсэл болгож ашиглаж байсан бол сэтгэлгээний хувьд өөр өнцгөөр харах боломжийг олгосон гэж хүлээн зөвшөөрдөг. Түүний үзэл баримтлалыг нэрд гарсан олон сэтгэгч (Ральф Дарендорф 1929-2009, Фрэнк Паркин 1931-2011, Энтони Гидденс 1938, У.Г.Рансимен, Дэвид Локвуд 1929-2014, Джон Голдторп нар 1935, Франк Бичхофер нар, Ховард Ньюби нар, Сэнди Стюарт нар, Гордон Маршалл нар г.м) үргэлжлүүлэн судалж, хөгжүүлсэн юм. Ральф Дарендорф эрх мэдэл, авторитет ба мөргөлдөгч бүлгийн талаар өөрийн үзэл баримтлалаа боловсруулсан. Онолын хувьд түүнийг аль урсгал чиглэлд хамааруулах нь эргэлзээтэй бөгөөд “эрх мэдэл” гэх ойлголтод үндэслэн тодорхой нөхцөл дэх бүлгүүдийн үйлдлийг шинжлэхэд ашигласныг нь үндэслэвэл Веберийн (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996), бүлгүүд өөрсдийн төлөөх ашиг сонирхлыг хэрэгжүүлсний үр дүнд зөрчил, мөргөлдөөн үүсч, тэр нь нийгмийн өөрчлөлтөд хүргэдэг гэх хандлагыг харгалзвал Марксын үзэл баримтлалыг хөгжүүлэгч (Болд.Р, 2007; Смелзер.Н, 2001) гэж үзэх нь бий. Тэрээр өмч болон эрх мэдлийг нэг түвшинд авч үздэг ч орчин үеийн нийгэм дэх өмч болон хяналтын үүргийг менежерүүдэд шилжүүлэх болсноор ач холбогдол нь буурч байгаа гэж үзсэн. Корпорацийн менежерийн эрх мэдэл нь боловсролын түвшин, тасралтгүй үргэлжлэх

хичээл зүтгэлийн үнэ цэнэ, хариуцлагын шатлал дахь (бюрократической) албан тушаалын зэрэглэлээс хамаардаг. Түүнийхээр эрх мэдэл нь зайлшгүй, ховор нөөцөд тооцогдох бөгөөд үүний төлөөх зөрчил нь ангиудыг үүсгэдэг. Ангийг энэ үндсэн дээр “эрх мэдлийн ялгавартай хуваарилалтын үр дүнд үүссэн зөрчилдөөнт бүлгүүд” гэж тодорхойлжээ.

“Ангийн тогтолцооны үндэс нь үйлдвэрлэлийн хэрэгсэл дээр тулгуурласан хувийн өмч хөрөнгө юм” гээд өмч нь нийгмийн цөөнх хэсэг монопольчилж, эрх мэдэлд хүрэхдээ ашигладаг социаль саадын нэг гэх санааг Фрэнк Паркин дэвшүүлсэн. Түүнийхээр социаль саад гэдэг нь “... нөөц баялгийг зөвхөн өөрөө хянах, бусдын боломжийг хязгаарлах гэж оролддог” гэсэн утгаар тайлбарлагддаг бөгөөд М.Вебер социаль саад бий болгоход угсаатны хамаарал, хэл, шашин зэрэг статусын ялгааг ашиглаж болдог. Энэ нь нэгд гадуурхах, хоёрт булаан авах замаар хэрэгждэг бөгөөд хоёр дахь арга зам нь гадуурхал, тусгаарлалтаас үүдэлтэй хариу үйлдэл байдлаар илэрч болдог бөгөөд үүнийгээ түрүү үеийн бүтээллүүддээ солдаризм гэж томъёолж байсан.

Бүлгийн давуу байдлыг хадгалахтай холбоотой давхар саад гэх ойлголтыг мөн хэрэглэсэн (Гидденс.А, 2006, р. 170). Тухайлбал, өнгөт арьстнууд, католик шашинтан, эмэгтэйчүүдийг үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхийг хязгаарлах нь тодорхой нэг бүлэг эрх ашгаа хамгаалж үлдэхийн тулд бусад бүлэгт зориудаар саад учруулж байгаагийн жишээ юм. Нийгмийн бүтэц нь давуу байдлаа хадгалж үлдэх, хамгаалах стратеги боловсруулах, хэрэгжүүлэх үйв явц гэж ойлгож болно.

Неовеберийн урсгал чиглэлийг хөгжүүлэхэд Энтони Гидденс ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үздэг. Тэрээр ангийг “... адилавар материаллаг нөөцтэй, энэ нь эргээд өөрсдийнх нь аж төрөх ёсыг нь тодорхойлж байдаг хүмүүсийн томоохон бүлэг” хэмээн тодорхойлоод өрнөдийн нийгэмд дээд анги (баячууд, үйлдвэрийн эзэд, худалдаачид, мөн түүнчлэн үйлдвэрийн хэрэгслийг эзэмшдэг эвсэл шууд хянадаг удирдлагын дээд хэсгийнхэн), дунд анги (цагаан захтнууд болон мэргэжилтнүүд), мөн ажилчин анги (хөх захтнууд буюу биеийн хүчний ажил эрхэлдэг хүмүүс)-иас, зарим аж үйлдвэржсэн орнуудад ... дөрөв дэх анги буюу тариачид чухал үүрэгтэй (Гидденс.А, 2006, pp. 164-165) болохыг тэмдэглэсэн. Ажилчин ангийг дотоодод нь пролетарийн уламжлалт (ижил нөхцөлд ажиллаж, амьдардаг өөриймсөх мэдрэмж өндөр хүмүүс), хүндэтгэлт уламжлалт (легитимт, зайлшгүй шинжтэй), өмчтөн ажилчид (ангийн эрхэмлэлгүй, бие даасан

амьдралын тойрог бүхий бүлэг) гэж ангилсан (Гидденс.А, 2006, р. 179). Бүтцийн онолын үндэслэлээ тэрээр үйлдэл нь хүний зан үйлийн талаарх ойлголтыг агуулсан байх ёстой; нийгмийн институт болон нийгмийн тогтолцооны бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүдэд анхаарал хандуулахдаа ийм ойлголтыг хослуулах хэрэгтэй; эрх мэдэл, ноёрхол гэсэн ойлголтууд нь нийгмийн үйлдэл болон бүтцийн тухай ойлголттой санамсаргүй байдлаар бус логик учир шалтгаанаар холбогдоно (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, р. 126) гэж тайлбарладаг.

Орчин үед “Баячуудын эсрэг чиглэсэн татварыг ядуу болон хөдөлмөрийн чадваргүй хүмүүст олгох тэтгэмжтэй хослуулснаар дээдэс доодсын ялгааг багасгажээ. Түүнээс гадна боловсрол нийтэд хүртээмжтэй болсноор авъяас чадвартай хэн бүхний өмнө нийгмийн болон эдийн засийн шатлалын оргилд хүрэх зам нээлттэй болсон” гэж тэмдэглэсэн байна. Цааш нь “Бие бялдын ялгаа хүртэл ангийн хамааралтай уялддаг. Ажилчин ангийн төлөөлөгчид дээд ангийн төлөөлөгчдийг бодвол төрөх үеийн дундаж жин багатай, нялхсын эндэгдэл их, өсөлт удаан, цаашилбал харьцангуй залуудаа өвчилдөг, эрт нас бардаг байна. Зүрх судасны өвчин, хорт хавдар, шижин хатгалгаа, сүрьеэ зэрэг хурц өвчин тусах нь ангийн тогтолцооны доод давхрынханд илүү түгээмэл байдаг”-ийг баримтаар нотлон харуулсан. Харин нийгмийн давхраажлыг “хүмүүсийн хоорондын бүтэцжсэн ялгаа” гэж тодорхойлоод баялаг (зарж болох бүх зүйл), орлого (цалин, хөрөнгө оруулалт ашиг) (Гидденс.А, 2006, р. 171), жендер гэсэн шалгуурыг ашиглан анги болон давхрааг тодорхойлохын хамт байр суурийн өөрчлөлт, хувирал, чиглэлийг “зиндаачлал” гэх ойлголтоор дамжуулан гаргасан (Гидденс.А, 2006, pp. 183-192).

Вебер анги, статус, эрх мэдэл гэх хүчин зүйлсийг тус тусад нь нийгмийн шатлалыг тодорхойлох хүчин зүйл гэж үзэж байсан бол америкийн Дж.Ленский (1924-2015) нийгэм янз бүрийн анги, давхарга болон ялгарч байгаа нь чухал эрх мэдэл, онцгой эрх дарх, нэр төрийн тэгш бус хуваарилалтаар тайлбарлагддаг (ОХУ-ын ШУА-ийн Социологийн институт, Шихихутуг ХЗДС-ийн Шихихутуг судалгааны төв, 2012, р. 15). Гээд эрх мэдэл тэргүүн байранд тавигддаг. Харин У.Г.Рансимен эдгээр нь харьцангуй бие даасан давхаргыг илэрхийлэх шинжтэй ч хоорондоо нягт уялдаатай, бие биетэйгээ давхцаж, нэгдмэл байдлаар үйлчилж байдаг гэж үзсэн. Шалгуур үзүүлэлт, хүчин зүйлүүд бие даасан байдлаар бус нэгдмэл байдлаар үйлчилдэг гэсэн санааг дэвшүүлсэн

нь илүү үнэ цэнэтэйд тооцогдоно. Тодруулбал, нийгмийг цогцод нь, гэхдээ шалгуур үзүүлэлтүүдийн харьцаа нөлөөллийн хэр зэргэмж, харьцааг анхаарах шаардлагатай болох нь үүнээс ойлгогдоно. Түүнийхээр ялгарал, тэгш бус байдлын хэмжүүр үзүүлэлтүүдээс эрх мэдлийг “нам-улс төрийн” гэж явцууруулахаас илүүтэй социологийн ерөнхий ойлголтын түвшинд ашигладаг бол боловсрол, анги, байр суурь, нам зэрэг нь бүтцийн үндэс болдог. Ажил мэргэжлийн, эсвэл орлогын хэмжээг үндэс болгон нийгмийг ангид хуваах нэг хэмжээст аргачлалыг үгүйсгэн эдийн засгийн боломж байгаа эсэхээс үл хамааран ангийг: хяналт (эдийн нөөцийг захиран зарцуулах), өмчийн хэмжээ (нөөцийн хууль ёсны өмчлөл), зах зээлд нэвтрэх чадвар (зохих ур чадвар, мэргэжил-мэргэшил эзэших) гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлохыг санал болгосон юм. Том компаний ажилтан, бизнес эрхлэгч, хараат бус зөвлөх хийдэг мэргэжлийн хувьд нэг ангилалд хамаарах гурван инженер орлогын түвшнээр, ажиллаж буй салбараар ялгарах боловч ангийн байр сууриар адил юм. Үүргийн тэнцвэрт байдал гэх шалгуураар эхнийх нь хяналтын, хоёр дахь нь өмчийн, гурав дахь нь зах зээлд нэвтрэх чадвараараа ялгарна (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 128-129) гэж үзэж байв.

Дэвид Локвуд 1950-иад оны сүүлээр бичиг хэргийн ажилтнуудыг судалснаараа Веберийн урсгал чиглэлд хамаардаг. Бүлгийн нийгмийн байр суурь нь зах зээл (рыночной), хөдөлмөр, байр суурь гэсэн шинж чанараар илрэн гардаг. Өөрийн ухамсар, адилсаж буй бүлгийн байр суурийг тодорхойлохдоо эдгээр шалгуурыг цогцод нь ашигладаг. Зах зээлийн нөхцөл өмчийн харилцааг агуулдаг бөгөөд ортодокс марксистуудаас ялгаатай нь ангийг үл хөдлөх хөрөнгөтэй эсэхийг үндэслэж таньж мэдэхийг чухалчилдаг. Зарим хүмүүс тухайлбал, ижил түвшний ажилтнууд өөрсдийн “объектив” ашиг сонирхлыг мэддэггүй бол энэ нь “хуурамч ухамсар”-ын үр дүн юм. Нөгөө талаар зах зээлийн нөхцөл нь өмч хөрөнгө, орлогын хэмжээ зэргээс гадна нийгмийн хамгаалал, өсөн дэвших боломж нь ажилчдын мэргэшлийн түвшнээс ихээхэн хамаардаг.

Өмчгүй, хөдөлмөрийн хөлсөөр амьдардаг гэх ангилалд хамаарах хүмүүс ижил нөхцөлд байхыг чухалчилдаг. Уламжлалт бичиг хэргийн ажилтнуудыг биеийн хүчний хөдөлмөр эрхлэгсэдтэй харьцуулахад санхүүгийн боломж, албан тушаалын хамгаалагдсан байдлаараа давуу. Гэхдээ энэ ялгаа одоо үгүй болсон ч тэднийг ажилчин ангид хамааруулж болохгүй. Энэ нь нэгдүгээрт, бага тушаалын ажиллагсад мэргэжлийн

чиг баримжаагаа хадгалсаар байдаг тул албан тушаал ахих магадлал хамгийн өндөр байдаг (тэдний гуравны нэг нь албан тушаалд очдог). Хоёрдугаарт, нөхцөл байдлыг тодорхойлоход дан ганц зах зээлийн нөхцөл хангалтгүй бөгөөд хөдөлмөрийн хуваарь дахь албан тушаал, байгууллага доторх эрх мэдлийн ялгаа чухал нөлөөтэй. Тэрээр орчин үеийн аж үйлдвэрийн нийгэмд хувь хүний сэтгэл зүйг бүрдүүлж буй нийгмийн хамгийн чухал нөхцөл бол үйлдвэрлэл, удирдлага, түгээлтийн гэсэн ажлын зохион байгуулалт, нөхцөл байдал чухал болохыг онцолж байв. Ажлын орчин нөхцөл сайжирсан ч ажлын байранд “хүзүүвч хана”-аар тусгаарлагдах бөгөөд энэ нь ажиллагсдын хооронд болон нийгмийн салангад байдлыг хадгалж үлддэг.

Бичиг хэргийн ажилтнуудыг судалсантай төстэй буюу “Цагаан, цэнхэр таславч” гэх сэдвийг Кембриджийнхэн үргэлжлүүлэн судлаж байна (Ж.Голдторп, Д.Локвуд, Ф.Бичхофер, Ж.Платт). Тэд ажилчин ангийн “хөрөнгөжилт”-ийн асуудлыг орлогын түвшин, хөдөлмөрийн хуваарь дахь байр суурь, соёлын хэм хэмжээ, баримжааллыг эмпирик баримтаар баталгаажуулан судалсан. Д.Локвуд Льютоны үйлдвэр дэх хөдөлмөрийн нөхцөл байдлын талаарх нөхцөл байдалд шинжилгээ хийж “хөдөлмөрийн нөхцөл, үр ашиг, албан тушаал ахих боломж, орлогын өсөлтийн хувьд биеийн хүчний хөдөлмөр эрхэлдэг ажилчдаас давуу юм. Ижил түвшний цалин хөлстэй хүмүүстэй харьцуулахад илүү цагаар (ажлын цаг 25 хувиар нэмэгдсэн), ажлын бус цагт ч ажиллах шаардлагатай болсон. Энэ нь тэдний ажилдаа хандах хандлагад тусгалаа олдог. Ажил, ажлаас гадуурх амьдрал нь эрс ялгаатай болсон бөгөөд ажилтан найз нөхөд, хамаатан садны хүрээлэлд “ажиллангаа амьдрах” тойргоос чөлөөлөгддөг. Ажлын бус цагт цэнхэр захтнууд өөрийн гэр бүлийн дунд ихэнх цагийг өнгөрүүлдэг бол цагаан захтнууд нийгэм-соёлын үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцдог. Цагаан захтнууд мөн гэр бүлийнхээ хэмжээг урьдчилан төлөвлөж, хязгаарладаг гэж тэмдэглэсэн байдаг.

Ангийн бүтцийн талаарх ажилчдын санаа бодол энгийн, хялбар бөгөөд “бид”, “тэд” (өөрсдөө илүү эрх мэдэлтэй хүмүүс) гэж хуваагддаг. Тэдний дунд нийгмийн нэр хүнд, дунд давхаргын онцлог шинжид суурилсан илүү боловсронгуй (развитых) шатлалын талаарх төсөөлөл хязгаарлагдмал байгаа юм. Талаас илүү нь материаллаг хүчин зүйлийг илүүд үздэг. Ажилчдын хувьд эдийн засаг, соёлын хүрээг өргөжүүлэхээс илүүтэй одоогийн амьдралын түвшнээ удаан хугацаанд хадгалахыг илүүд үздэг. Ажиллагсадтай харьцуулахад хуримтлалаа хэрхэн зарцуулах талаар урт хугацааны

төлөвлөлт хийдэггүй. Ажил мэргэжлийн хувьд хүлээлт багатай тул албан тушаал дэвших магадлал бага байдаг. Мөн хүмүүс өөрсдийн ажил хэргийн талаар төлөвлөж ярьдаг боловч таван хүнээс нэг нь л бодит оролдлого хийдэг. Франк Бичхофер (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 133-135) болон түүний хамтрагчид нийгмийн бүлэгт шинжилгээ хийхэд ангийн схемийг ашиглахад тохиромжгүй болохыг хүлээн зөвшөөрч дэлгүүрийн эздийн жишээн дээр энэ санаагаа батлан харуулсан. Тэднийхээр “Тохиромжгүй давхарга” гэсэн тодорхойлолтод “дэлгүүрийн эзэд”-ийг оруулсан бөгөөд тэд жижиг хөрөнгөтний адил өмч хөрөнгөө эзэмшиж, бага ч гэсэн хөлсөөр хүн ажиллуулдаг. Хөдөлмөрийн үйл явцын хувьд бие даасан шинжтэй, ажлын зохион байгуулалтын хувьд гар урчуудтай ижил, орлого удаан эдэлгээтэй бараа бүтээгдэхүүний хангамжаар мэргэшсэн мэргэжилтнүүдтэй ойр, ажилчин анги шиг өөрсдийн төлөө ажилладаг. Боловсролын түвшнээр доод давхаргад ойрхон боловч улс төрийн сонирхлоор дээд давхаргад ойр юм. Энэ давхаргын ертөнцийг үзэх үзэл нь өөрийн гэсэн бэлгэдлийн шинжтэй “эдийн засгийн уламжлал”-аар тодорхойлогддог. “статус кво”-г хадгалах буюу одоогийн амьдралын нөхцлөө хадгалах, томоохон өөрчлөлтөд дургүйлхэх, бизнесийн огцом өөрчлөлт хийх эрмэлзэлгүй байх хандлагаар ялгардаг. “Жижиг хөрөнгөтнүүд” өөрийн хүч, хөдөлмөрт найдах нь тэдний онцлог шинж, бие даасан тусгаар байдлаа хадгалахыг эрмэлздэг нь үнэт зүйлсийнх нь бүтцэд голлох байр эзэлдэг. Тэдний байр суурь нь маш олон давхаргыг хамарсан мэргэжлийн шилжилт хөдөлгөөнийг бий болгодог ч нийгэмд хүчтэй нөлөөлдөггүй. Ховард Ньюби (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 135-136) хөдөөгийн болон фермер эрхлэгчдийн давхаргыг веберийн судалгааны арга зүйд үндэслэн судалсан. Фермерүүдэд олон зүйлээрээ хотынхонтой төстэй бөгөөд том том капиталын тээрэм, төрийн хүнд сурталын хооронд хавчуулагдан байрладаг. Ингэхдээ судлаачид нөөцийн тэгш бус хуваарилалтын тухай бус харин ангийн харилцаа хэрхэн хөгжиж буй тухай асуудлыг хөндсөн юм. Энэ нь өөр өөр түвшинд байрлаж буй бүлгүүд хийгээд тодорхой нөхцлүүдээс ихээхэн хамаарна.

Хөдөө аж ахуйн фермүүд дэх ийм тодорхой нөхцөл гэвэл тэд гэр бүлийн бизнес давамгайлсан газар тариалангийн ажил эрхэлдэг. Эзэд нь “үл таних хүмүүс”, “шинээр эхлэгчид”, “харь газраас ирэгсэд” тухайн газар нутагт эвлэлдэн нэгдэх замаар бий болдог. Үүний уг үндэс нь тэдэнд өөрсдөд нь буй бөгөөд газрын өмчлөл, ёс суртахуунд

суурилсан нэр хүндийн харилцаагаар дамжин давхраажлын системийг бий болгодог. Энэ нөхцөл нь тэгш бус байдлыг хуульчилсан шинжтэй болгож, эсрэг тэсрэг бүлгүүдийг нэг гэр бүл болгон хувиргадаг учир ангиудыг хуваахын зэрэгцээ холбож өгдөг. Уг холбоо нь ноёрхол, захирагдах харилцаагаар бус харин эцгийн эрх ёсны илүү нарийн төвөгтэй харилцаагаар тайлбарлагдана. Эцгийн эрхэт харилцаа нь тусгаарлагдмал зүйл бус хөрөнгө, өөрийн эдийн засгийн эх үүсвэрт үндэслэсэн давхраажлын тодорхой системд үндэслэдэг. Тэгш бус байдалд суурилсан харилцааг тогтворжуулах, ёс суртахууны хувьд зөвтгөх шаардлагаас урган гардаг бөгөөд эргээд ангийн харилцааг батлах аргачлал болдог.

Орчин үеийн шинэ хандлага. Зах зээлд оролцогчдын онцлогийг илэрхийлсэн сонгодог эдийн засгийн онолын үзэл баримтлал нь удаан хугацааны турш хөдөлмөрийн зах зээлийн онолд тусгалаа олж ирсэн ч энд давхраажлын асуудал орхигдсон гэж үздэг. Питер Дерингер, Майкл Пайор нар 1970-аад оны эхээр хөдөлмөрийн зах ба нийгмийн давхраажлын харилцаа хамаарлын тухай, Ч.Лидбитер хөдөлмөрийн зах зээлийг сегментчилэх зэрэг үзэл хандлагыг дэвшүүлсэн. Тухайлбал, Ч.Лидбитер хөдөлмөрийн зах зээл нь 1. Цөм, 2. Захын эхний ба хоёр дахь бүлэг, 3. Гадаад зах гэж гурван тойрогт хуваагддаг гээд цөм нь хөдөлмөрийн зах зээлийн анхдагч бүлэг юм гэсэн тайлбарыг өгч байв. Уг бүлэгт байнгын болон эдийн засгийн таагүй нөхцөл байдлын үед ажиллагсдыг удирдах арга ухаан эзэмшсэн хүмүүс багтдаг. Хөдөлмөрийн зах зээлийг сегментчилэх энэ хандлага 1970-1980-аад оны үеийн хоёрдогч тэлэлт, захын давхаргын өргөжилт зэргээс үүдэлтэй хөдөлмөрийн зах зээлд уян хатан байдал нэмэгдэх болсоны үр дүн болж хөгжсөн. Энд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн тухай бус нийгмийн бүлгүүдийн санхүүгийн байдлыг ч хөнддөг. Ажиллах хэлбэр нь чөлөөт цагийн хэмжээ, амьдралын хэв маяг хэвшил, нийгмийн байр суур, хүсэл эрмэлзэл, хувь хүний сэтгэл зүйн төлөв байдалд нөлөөлдөг (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 140-144) гэж үздэг. Эл үед буюу 80-аад оны үеэс мөн угсаатны ялгарлын тухай асуудал яригдаж эхэлсэн бөгөөд гуравдагч ертөнцийн гэгдэх орнуудаас барууны орнуудыг чиглэсэн цагаачлал нэмэгдэж, засгийн газрууд ч дэмжиж байв. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн үр дүнд орон нутгийн ажилчид сонирхолгүй, бохир, байнгын ажлаас улам бүр холдсоор байсан нь шинэ ажилчдын тэр дундаа гадаадын ажилчдын хэрэгцээг өсгөсөн юм. Цагаачдад тулгарч буй саад бэрхшээлтэй холбоотой нийгмийн ялгарал дахь угсаатны хүчин

зүйлийн нөлөө улам бүр анхаарал татах болж угсаатны бүлгүүд шатлалын доод, дунд түвшинд байрлаж, тэднийг тойрсон олон зөрчил үүсч байв. Тэд ихэвчлэн технологийн болон санхүүгийн бус салбарт хагас мэргэшсэн, биеийн хүчний үйл ажил эрхэлж, мэргэжлийн ялгаварлал нь үндэстний цөөнхийг илүү тодорхой, эсвэл бага орон зай-талбар луу шахаж байсан юм. Үүний үр дүнд цөөнхүүдийн олонх нь жижиг, эсвэл дунд бизнес (худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ)-ийн салбарт орж уугуул иргэдийг энэ салбараас шахаж, өөрсдийн суурьшлын бүсийг бий болгож байв. Ийм байдлаар угсаатны тусгаарлах үйл явц нь нутаг дэвсгэрийн тусгаарлалт болж хувирч байв. Гол төлөөлөгчдийн нэг Роберт Майлс угсаа нь ангиудтай утга дүйх хэмжээний бие даасан давхаргыг бүрдүүлж чадахгүй бөгөөд барууны орнуудад цагаачлах нь ажилчин ангийн бүрэлдэхүүний нэг төрлийн “дэд пролетариат”-аас өөр зүйл биш юм. Угсаатны ялгаварлал, гадуурхал нь тэдний үл итгэх хандлагыг л гүнзгийрүүлдэг гэж үздэг. Марксистуудын өөр нэг хэсэг нь дан ганц нэгдмэл байр суурин дахь “хуваагдал” ажилчин ангийн хуваагдал бус харин үндэстний угсаатны бүлгүүд байр сууриараа тусгай давхарга үүсгэдэг гэж үздэг. Веберийн талыг баримтлагчид угсаатны гадуурхалт нь ажилчин ангийн байр сууриас ангийн тусгай байр суурийг бий болгох үндэс болно гээд үүсэн буй хэв маягийг “доод анги – underclass”, эсвэл “дэд анги – subclass” гэсэн ойлголтоор илэрхийлж байв.

Арьсны өнгө, угсаатны шинж чанар нь ангийн ялгаагаар далдлагддаг гэж үзэх хүмүүс бас бий боловч нь эдийн засгийн анги, нийгэм-мэргэжлийн бүлгүүдийг шахаж чадахгүй гэсэн байр суурь, хандлага давамгайлж байв (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 144-146). Радаев энэ тухайд “Үндэстэн, угсаатны ялгааг судлах асуудал нь тодорхой хэмжээгээр барууны судлаачдын болгоомжлол, уг сэдвийн өөрийнх нь мэдрэмтгий шинж (арьс өнгөний ялгарварлалаас тахал шиг айдаг)-ээр хязгаарлагддаг.” гэж тэмдэглэсэн.

Хүйсийн ялгаатай байдал (Сергеева.З.Х, 2011, pp. 167-187)-ыг мөн 80-аад оны эхэн үеийг хүртэл үл тоомсорлож ирсэн. Өнөөгийн түвшинд эмэгтэйчүүдийн идэвхтэй хөдөлмөр эрхлэлтийн түвшин-оролцоо, холимог гэр бүлийн хэв маяг зэргийг харгалзвал уг онолыг зөвтгөхөд бэрхшээлтэй боловч эмэгтэйчүүдийг эрчүүдийн хамтаар ажилчин, эсвэл дунд ангид хамаруулах, эсвэл нийгэм, мэргэжлийн байдлыг гэр бүлийн байр сууриар буюу далд утгаар нөхрийн байр сууриар илэрхийлж байв.

Феминист хөдөлгөөнүүд үүнд идэвхтэй үүрэг гүйцэтгэж байсан. Их Британид 1980-аад оны эхээр эцгүүдийн нийгмийн шилжилт хөдөлгөөнийг судлахдаа эмэгтэйчүүдийн шилжилт хөдөлгөөнийг хараат бус хүчин зүйл болгон харьцуулан судалж эхэлсэн юм. Э.Хит жендерийн бүлгүүдийн өсөн дэвших боломжийг харьцуулан судлаад зах зээлийн боломжийг ашиглан биеийн болон оюуны хөдөлмөр эрхэлдэг доод албан тушаалаас дээш ахих боломж эмэгтэйчүүдэд сул, эрэгтэйчүүдтэй харьцуулахад гэрлэлт нь босоо чиглэлд хөдөлгөөн хийх боломжийг олгодог гэж дүгнэсэн. Эрэгтэйчүүдийн хувьд дотоод ялгаа, шилдэг байр суурийн төлөөх өрсөлдөөн илүү өндөр байдаг. Үзэл бодол, байр суурийн хувьд мөн ийм ялгаа байдаг гэх хандлагыг Г.Маршалл дэвшүүлсэн. Тэрээр нийгмийн шилжилт хөдөлгөөнийг судлахдаа нэгэн төрлийн гэр бүл (гомогенной семьи) гэх ойлголтыг эсэргүүцэж байв. Хэдийгээр салангид тусдаа зүйл боловч сонгуулийн зан үйлийн хувьд эмэгтэйчүүд бүхэлдээ эрчүүдийг дагах, тэдний нийгмийн байр суурийг баримтлах хандлагатай байдгийг тогтоосон. Нийгэм мэргэжлийн хувьд хүйсийн ялгаа хамгийн их ажиглагддаг. Байр суурь доогуур ихэнх нь хязгаарлагдмал хүрээнд буюу хагас ур чадвартай, бичиг хэргийн болон үйлчилгээний ажил хийдэг.

Эмэгтэйчүүд нийгмийн ангийн масст уусдаггүй учир хэвтээ ба босоо тусгаарлалт (сегрегаци)-ын объект болдог. Хэвтээ тусгаарлалт нь эмэгтэйчүүдийг ажил мэргэжил, үйл ажиллагааны зарим хэсгээс хасч тодорхой мэргэжил, үйл ажиллагааны хүрээнд төвлөрүүлэхийг хэлдэг. Тухайлбал, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлийн мэргэшсэн ажлын дийлэнх хэсгийг эзэлдэг. Оффисын, борлуулалтын, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний ажилд ноёрхох шинжтэй байдаг. Зарим ажлын байрыг “эмэгтэйчүүдийн”-х гэж тодорхойлсон нь доромжилсон утгатай зүйл биш. Хэвтээ тэнхлэгийн тусгаарлалт нь босоо тэнхлэгийн тусгаарлалттай нягт уялдаатай. Эмэгтэйчүүдийн дундаж цалингийн хэмжээ нь ижил төстэй ажил эрхэлж буй эрэгтэйчүүдийнхээс доогуур. Мөн эмэгтэйчүүд хөдөлмөрийн хоёрдогч зах зээлд түр, эсвэл цагийн ажил хийлгэх магадлал өндөр. Энэ нь үр хүүхдээ өсгөх гол ачааг үүрдгийнх нь хувьд чөлөөт сонголтод тулгуурладаг.

Эрэгтэйчүүд манлайлах байр суурь, өсөн дэвших боломжоо эмэгтэйчүүдээс илүү сайн хадгалж чаддаг бол эмэгтэйчүүдийн хувьд албан тушаал ахих магадлал харьцангуй бага. Нийгмийн идэвхийн хувьд ч тэр эмэгтэйчүүд тухайлбал, үйлдвэрчний эвлэлийн

гишүүнчлэлийн хэмжээгээр харьцагуй доогуур. Хүйсийн ялгаатай байдал хамгийн тод илэрдэг талбар бол гэр бүл дэх хөдөлмөрт эрэгтэйчүүдийн оролцоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа ч эмэгтэйчүүд гол үүрэг гүйцэтгэсэн хэвээр байгаа юм. Ийм дүр зураг нөхөр нь ажилгүй үед ч адил. Жендерийн чиг хандлагыг дэмждэг хүмүүсийн хувьд “хөдөлмөр дэх хүйсийн ялгаатай байдал нь ангийн хуваагдалтай нэгэн адил чухалд тооцогддог” гэх боломжийг олгодог.

Нийгмийн тэгш бус байдлыг арилгахад төрийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх тухай онолын хандлагууд мөн энэ үеэс бий болов. Эдгээрээс Г.Эспин-Андерсен (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 150-152) төр аливаа нийгмийн бүтцийг өөрчлөхөд асар их үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд татварын бодлогоор дамжуулж үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус аргаар хуримтлагдсан орлогыг дахин хуваарилах замаар өмчийн ялгаатай байдлыг зохицуулдаг. Төр нь хөдөлмөрийн гэрээ байгуулахаас эхлээд анги хоорондын зөрчилдөөнд маргаан таслагч, ажлаас халах, ажилд авах нөхцөлийг зохицуулах, олон нийтийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, ажилгүйдлийн болон хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжийн хэмжээ, нөхцөлийг зохицуулах зэргээр хөдөлмөр эрхлэлтийн бүтцийн өөрчлөлтийг өдөөгч үүрэгтэй оролцдог. Үүний үр дүнд төрийн сектор өөрөө өргөжиж, мөн анги бүрт олон давхарга үүсдэг. Эдгээр давхаргынхан хувийн хэвшлийнхнээс эрс ялгарах ба зарим тохиолдолд төрийн болон хувийн хэвшилд ажиллагсдын хоорондын ялгаа нь нийгмийн болон мэргэжлийн ялгаанаас багагүй ач холбогдолтой болж хувирдаг. Тэрээр “Халамжит төр”-ийн тухай “... зүгээр нэг механизм биш, хөдлөнгөөс оролцох, боломжтой бол тэгш бус байдлыг засах, энэ бол давхраажлын бие даасан систем, нийгмийн харилцааг зохицуулах идэвхтэй хүч юм” гэж онцолсон байдаг. Гэхдээ нийгмийн халамж-дэмжлэг (выплата), тэтгэмж (льгот)-д суурилсан үр дүнтэй давхраажлын системийн талаар судлаачид 1950-иод оны сүүлээр тэмдэглэж байсан юм.

Нийгмийн халамж, тэтгэмжийн ерөнхий дүн нь хэд байх?, Засгийн газрын шууд татаас, эсвэл төсвийн сан, корпорацийн сан зэрэг сувгийн алинаар зохион байгуулах вэ?, Ядуусыг дэмжих, нийгмийн болон мэргэжлийн зарим бүлгийг идэвхжүүлэх, нийт хүн амд тэг хүртээмжтэй байх зэрэг бодлогын ямар зарчимд үндэслэн бий болгох?, Мөнгөн дэмжлэг үзүүлэх, татварын хөнгөлөлт үзүүлэх, үнэгүй нийгмийн үйлчилгээ үзүүлэхийн аль хэлбэр давамгайлах?, Тусламж дэмжлэг нь хэрэглээг нэмэгдүүлэхэд, эсвэл хүсэл

зоригийг (стимул) идэвхжүүлэхэд чиглэдэг үү?, Нийгмийн дэмжлэг нь энэрэн нигүүлсэх үйлс үү, эсвэл хуримтлалын дахин хуваарилалт уу?, Хүн амын аль хэсэг, ямар үндэслэлээр халамжид хамрагдах боломжтой вэ? гэсэн асуулт бүрийг давхраажлын төлөвлөлтийн үндсэн хэсэг гэж үзэж болно. Харин эдгээрийг шийдвэрлэхэд туйлширсан үзэл баримтлал (эрх баригч ангийн тухай марксист үзэл, төвийг сахигч байгууллын тухай либералууд)-уудаас оновчтой хувилбарыг олох нь чухал. Тэрээр либерал, консерватив, нийгмийн ардчиллын (Түмэннаст.Г, Монголын нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоонд хийсэн социологийн шинжилгээ (диссертаци), 2017, pp. 12, 24-29) гэх гурван зарчим санал болгосон. Зарим улс орнууд тодорхой загваруудыг бий болгосон ч ихэнхдээ эдгээрийг хослуулан хэрэглэдэг бөгөөд өмнө дурдсан асуултууд, тэдгээрийн сонголтоос хамааралтай зөрчилдөөн үүсдэг.

Дээрхээс гадна Т.Маршалл 1950 онд хэвлүүлсэн “Иргэншил ба нийгмийн анги” бүтээлдээ (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 153-154) нийгмийн бодлого, давхраажлын хамаарлыг судлан гаргасан. Иргэний нийгмийн онолчид халамжит төр нь ангийн давхаргын ялгааг гүнзгийрүүлж, улам дордуулдаг гэх үзлээр марксистуудаас ялгарна. Нийгмийн байр суурийн тэгшитгэлийг эсэргүүцээд зогсохгүй энэ нь ангийн тэгш байдлын галыг “унтрааж”, эсвэл ангийн харилцааны байр суурийг ноцтойгоор “өөрчлөх” чадвартай юм. Тухайн тохиолдолд орлогыг тэгшитгэх нь чухал бус. Харин эрсдлийг бууруулах, хүн амын доод давхаргын байр суурийн тодорхой бус байдал, нийгмийн баталгааны ерөнхий өсөлтийг хангахыг чухалчилдаг. Иргэншил нь нийгмийн ёс суртахууны зэрэгцээ амьдралын тодорхой түвшин, бас өмчлөх эрхээс хамаарах ба энд үл хөдлөх хөрөнгийг шууд эзэмшүүлэхгүй боловч түүнийг эзэмших боломжийг нь нээж өгдөг. Гэхдээ иргэний эрхийн хэрэгжилт нь өөрөө онцгой, басхүү давхраажлын зарчим болдог. Тухайлбал, иргэний статусгүй, эсвэл бүрэн бус эрх бүхий бүлгүүд ажилд орох, эд хөрөнгө олж авах, тодорхой үйл ажиллагаа эрх нь хязгаарлагддаг.

Питер Саундерс болон түүний хамтрагчид өрхийн өмч хуримтлагдсанаар өмчийн ялгааг нэмэгдүүлдэг, орон сууц зэрэг үл хөдлөх хөрөнгө өмчийн зөрүүтэй байдал нь ажил мэргэжлийн болон хөдөлмөрийн ялгаанаас илүү ач холбогдолтой гэжээ. Газар ашиглалт, татвар татаас, зээлийн хуваарилалт зэрэг материаллаг ашиг сонирхлоос үүдэх зөрчилдөөний объект болж хувирдаг. Тухайлбал, ирээдүйг харж орон сууцны үнийн өсөлтөөс баялаг хуримтлуулах нь нийгмийн бүлгүүдийг амьдралын боломжоор нь ялгах

бие даасан үндэс, суурийг бий болгодог. Мөн цаашлаад энэ нь дахин давхраажих үйл явцын талаар ярих боломжийг олгодог. Тэрээр энэ тухайд “Орон сууц өмчлөх нь хэрэглээний салбарын ялгааг тодорхойлоход хамгийн чухал хүчин зүйл болдог. Ийм ялгаа нь зарчмын хувьд орчин үеийн давхраажлыг ойлгоход ангийн ялгаанаас багагүй ач холбогдолтой. Орон сууцны нөхцөл байдал нь амьдралын боломж, эдийн засгийн тэгш бус байдал хийгээд нөөцийг хэрхэн хуваарилагдаж байгаагаас хамаарч нийгмийн адилсал болон өөрчлөлтийг тодорхойлоход, нийгмийн ялгарал, улс төрийн мөргөлдөөнийг шинжлэхийн тулд өмчлөлийн асуудлыг төвд нь тавих ёстой гэсэн үг юм” гэж тэмдэглэсэн.

Францын шинэ сургуулийнхан. Мишель Фуко (1926-1984), Пьер Бурдьё (1930), Ален Турейн (1925) зэрэг францын шинэ үеийн сургуулийнхны боловсруулсан үзэл баримтлал функционалистуудаас гадна позитивизм, европын ортодокс марксизмын аль алианаас өөр байр суурь илэрхийлдэг. Шинэ гэгдэх үзэл хандлага бий болоход зүүний чигийн намуудын үзэл хандлагын ялгаа, Франц дахь 1968 оны 5 дугаар сард болсон их үймээн, ажил хаялт (Wolin, 2015) зэрэг үйл явдлуудаас хамааралтай өөрсдийн байр суурийг дэвшүүлж, мөн марксист арга зүйн хэд хэдэн зарчмыг эргэн харах шаардлагатай болсон юм. Ерөнхий дүр зургийн хувьд нийгмийн үйл ажиллагаа, харилцаанд шинжилгээ хийн эдийн засгийн детерменизмийг шинэчлэх, мэдлэгийн болон соёлын асуудалд анхаарал хандуулах байдлаар социологийн уламжлалыг даван туулдаг. Мөн судалгааны объект болон субъектийн тухай позитивист арга зүйг эсэргүүцэж байв. Судлаачдын оролцоо нь мэдлэгийг бий болгоно гэж үздэг. Эдгээр эрдэмтдийн үзэл хандлагад уламжлалт ангийн онолууд дахь тэмцлийн асуудал орхигдоогүй ч тэдгээрт сорилт болдог гэж үздэг.

Мишель Фуко Европ дахь хөрөнгөтнүүдийн хэрэгжүүлсэн ашиг сонирхол нь шууд ангийн дарангуйлал, эдийн засгийн мөлжлөгтэй холбоогүй бөгөөд хүмүүсийн өдөр тутмын амьдралын хэв маягийг сахин хамгаалах, дэг журмыг тогтооход чиглэж байсан гэх үндэслэлийг дэвшүүлдэг. Тэрээр үүний тулд шийтгэлийн тогтолцоог хөгжүүлэх замаар гэмт хэргийг хянах, бэлгийн үйлд хяналт тавих замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэц заслыг хөгжүүлэх замаар сэтгэцийн өвчлөл, эмгэгийг хянах зэрэг зохицуулалтын аргыг нэвтрүүлсэн. Эдгээр нь зөвхөн гажуудсан бүлгүүд

гэлтгүй сургууль, эмнэлэг, үйлдвэр, арми нь бүгд сахилга тогтоох байгууллагууд болж хувирдаг.

“Хяналтын аппарат, бэлгийн хандлагыг анагаах, сэтгэцийн эмгэгийг хянах, гэмт хэргийг хянах нь чухамдаа тусгаарлах механизмууд хэрэгтэй боловч эдгээр нь жижиг зүйлс тодорхой нэг цэгээс, тухайлан хөрөнгөтнүүдийн ашиг сонирхлын илэрхийлэл болж үүссэн.” гэж үзэж, ийм зүйлсийг нэвтрүүлэх нь доод давхаргад эсрэг тэсрэг байдлыг үүсгэх, илүү тэсрэлттэй бүлгүүдийг доод давхаргаас салгах, пролетаруудыг “бүрэн пролетаржаагүй” хэсгээс салгах, ажилчдыг “доод хэсгийнхэн – плебса”-ээс салгах гэсэн давхраажлын зорилготой. Жишээлбэл, мэргэшсэн гэмт хэрэгтнүүдийг ажилчин ангийн байнгын заналхийлэл болгож ашиглах явдал юм. Нийгмийн доод хэсгийнхэнд плебса буюу “Хөрөнгөтнүүд энэ хэсгийнхэнд шоронд эсвэл армид, шоронд эсвэл колонид, шоронд эсвэл цагдаагийн алба хаах сонголтыг санал болгодог.”.

Хөрөнгөтнүүдийн ашиг сонирхолд нийцсэн эдгээр төлөвлөгөө хэрхэн хэрэгжиж буйг эрх мэдлийн тусгай ойлголтоор дамжуулан шинжилсэн. Гэхдээ түүний бүтээлд эрх мэдлийн талаар ерөнхий, тогтсон шинжтэй бүтэцлэг зүйл байдаггүй ч энэ нь мөлжлөг, дарангуйллын шинжтэй харилцаа бус харин хувь хүмүүсийн хоорондох мэдлэг, мэдээлэл үйлдвэрлэх харилцаа юм. Илүү нарийвчилж, оновчилсон хэлэлцүүлгийн явц дахь үнэн, эсвэл худал гэж үзэх, худлыг үнэнээс салгах дүрмийн төлөөх тэмцэлт харилцааны үр дүн юм. Эрх мэдлийг эд бараа шиг тодорхой хувь хүн, эсвэл анги эзэмшдэггүйн зэрэгцээ хэн ч эрх мэдлээс ангид байдаггүй. Энэ нь нийгмийн харилцаан дахь тасралтгүй (гинжин), сүлжээгээр холбогддог.

Фуко амьдралын тодорхой нөхцөл, орон нутгийн түвшин дэх эрх мэдлийн жижиг хэсгүүд (капиляр)-д илүү анхаарал хандуулдаг. Эрх мэдэл хэрэгжүүлэхэд дээрээс доош чиглэсэн пирамид хэлбэртэй байхыг үгүйсгэдэггүй. Гэхдээ эрх мэдэл хэрэгжүүлэх нь доороос дээш чиглэсэн хөдөлгөөнгүйгээр байх боломжгүй. Янз бүрийн орон зай, бие махбод үүнийг хэрэгжүүлдэг.

Дэлхийд нэг анги дангаар ноёрхох дүр зураг байхгүйтэй адил урьдчилан тогтоосон бүтцийн сүлжээ гэж байхгүй. Харин энэ нь өдөр тутмын сүлжилдсэн харилцаа, орон нутгийн хөтөлбөр төлөвлөгөөний үр дүнд бий болдог. “Давамгайлагч анги гэдэг нь хийсвэрлэл төдийгүй урьдчилан таамаглах аргагүй нийгэмлэг юм. Эрх баригч анги болох, эсвэл эрх баригч ангийн байр суурийг дахин олж авах нь уридаас

төлөвлөсөн бодлого, төлөвлөлтийн үр дүн байх ёстой юм. Гэвч үйлдвэрлэлийн харилцаа, өөрийгөө эрх баригч байр сууринд тавих гэсэн оршин буй ангийн болон хүчний харилцаанд анхаарч, сэлбэж нөхөх, засварлах хамаарал л байдаг.”. Тэрээр “дайн”, “тэмцэл”, “тулааны талбар” гэх үгсийг нэлээд хэрэглэдэг ч ангийн тэмцэл нь өвөрмөц агуулгатайгаар өрнөдөг. Орон нутгийн ажил, амьдралын нөхцлөөс үүдэлтэй олон тооны жижиг зөрчил, тэмцэл (схваток) нь том биш боловч ангиас гадуур өрнөж буй зүйл биш юм. Үндсэндээ бүхний эсрэг бүх нийтийн тэмцэл юм. Энэ тэмцэлд сэхээтний байр суурь нь ажлын нөхцлөөр, тухайн нийгэм дэх амьдрал болон боломжийн талаарх мэдлэгийн үйлдвэрлэл горимоор тодорхойлогдоно. Сэхээтний үүрэг нь тулааны талбарыг байнга судлах явдал юм (Радаев.В.В, Шкаратан.О.И, 1996, pp. 158-160).

М.Фукогийн шавь нарын нэг гэгдэх Пьер Бурдьё (Бурдьё, 2007) ангийг нийгмийн орон зай дахь ижил төстэй байр суурь бүхий төлөөлөгчид гэж тодорхойлдог. Түүнийхээр яг ижил нийгмийн орон зайд улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, бэлгэдлийн гэсэн ялгаатай хүчний талбарууд бүрэлдэн бий болдог. Эдгээр талбар бүр биет болон нэгтгэгдсэн (инкорпорированном состояниях) капиталтай. Эдийн засгийн талбар нь бусад талбаруудад өөрийн бүтцийг ногдуулах хандлагатай байдаг. Капиталын эзэмшлээс хамаарч бүлгүүдийн эрх мэдэл тодорхой нэг, эсвэл өөр өөр талбарт янз бүрээр илэрдэг. Ялгаа бүхий өөр өөр талбаруудыг хольж хутгах нь зарчмын хувьд зохисгүй боловч талбарууд дахь ижил төрлийн албан тушаал бүхий давуу эрхэт, хараат бүлгүүдийн хооронд их, бага аль нь боловч тогтвортой холбоо тогтоож болно.

Нийгмийн орон зайд үүссэн бүлгүүдийг “жинхэнэ анги” гэж үздэггүйгээрээ тэр марксистуудаас ялгардаг. Түүнийхээр эдгээр нь “боломжит анги” төдий зүйл биш юм. Ангийг дайчлах буюу “өөртөө зориулсан анги” бий болгох боломж нь нийгмийн орон зай дахь төлөөллүүдийн хоорондын зай, уг орон зайг хэрхэн ойлгож байгаагаас хамаарна. Сүүлийнх нь өөрийн ээлжинд нийгмийн институтүүдийн бүтээгдэхүүн, өмнө тогтсон бэлгэдлийн тэмцлийн үр дүн болно. Угтаа “ойлголтын дархлагдсан (легитимной) хэв маяг” гэх нийтлэг мэдрэмж төлөвшүүлэхийн төлөөх тэмцэл л үргэлжилж байгаа юм. Энэхүү тэмцлийн үр дүн нь бүлгүүдийг давхраажуулах аймшигтай, бараг ид шийдийн гэмээр хүчийг өгдөг. Тиймээс “ойлголт” нь бодит байдлын энгийн тусгал бус харин нийгмийн хил хязгаарыг хөгжүүлэх бүтээлч үйл болдог.

Албан тушаал, зэрэг дэвээр эрэмблэхэд бэлгэдлийн капитал онцгой үүрэг гүйцэтгэдэг. Тэрээр төрөл бүрийн цол, диплом зэрэг албан ёсоор институтчилэгдсэн бэлгэдлийн капиталыг ашиглах нь найдвартай бөгөөд төрийн хууль ёсны хүчийг оролцуулан тооцох нь хүчийг нь байнга нэмэгдүүлдэг гэж үздэг. Тухайлбал, улс төрийн талбар дахь бүлгийн тодорхойлогдох шинж, эрх мэдэл нь ихэвчлэн албан ёсны төлөөлөгчдөөр дамжин хэрэгждэг. “хүсэл эрмэлзэл ба төлөөлөл”-ийн, “цаасан дээрх анги” боломжит бүлэг (идеаль, эсвэл төсөөллийн О.Б)-ийг анги болгон нэгтгэхийг Марксист онолчид ихэнхдээ дайчлагдсан бүлэг болгон дэвшүүлдэг.

Бурдые хувь хүний мэдлэг, туршлагаас үүдэлтэй өвөрмөц сэтгэлгээ, үйл хөдлөлийн тогтолцоог хабитус (хэвшил, зуршил-habitus) гэх ойлголтоор илэрхийлж, хамтач байдлыг танин мэдэхийн тулд зуучлагч элементүүдийг ойлгож, ангилах матрицыг ашигладаг. Энэ нь ангийн ангийн бүтцийг илэрхийлэх энгийн үр дүн биш. Харин бүтцийг илэрхийлэх идэвхтэй эхлэл гээд үр дүнд нь хабитус бол “нэгтгэгдсэн анги” гэсэн дүгнэлтийг хийсэн. Эдгээр ангиудын амьдралын болон хэрэглээний хэвшмэл байдал нь ангиудын улс төрийн үзэл бодол, зан төлөвт нөлөөлдөг.

Учир шалтгааны тайллыг: амьдралын хэв маягийг бүрдүүлдэг дадал зуршлаас өмнө олон төрлийн мэдрэмж (tastes) хүлээн авах, ойлгох бүдүүвчийг оруулсан. Мэдрэмж нь эргээд хэвшил дээр суурилдаг бөгөөд үүнд нийгмийн гарал, боловсрол зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Оршихуйн бодит байдал нь зуршил буюу хабитус, мэдрэмж, дадал, амьдралын хэв маяг гэсэн гинжин хэлхээгээр үүсдэг. Үүнд тулгуурлан ангиудын ялгааг тайлбарласан бөгөөд урлагийн тухайд гэхэд ажилчин ангийн хүмүүс дүр төрхийг ёс суртахууны талаас илүү мэдрэх, нийгмийн чиг үүргийн гүйцэтгэлийг урлагт илүү хамааруулах хандлагатай байдаг. Энэ мэдрэмж нь тэдний хамтран ажиллах хэрэгцээ, шаардлагаас үүдэлтэй хэлбэрждэг. Сэхээтнүүд урлагийн бүтээлээс цэвэр гоо зүйн ойлголтыг чухалчилдаг. Үүгээрээ Бурдыегийн анги болон зуршлын тухай ойлголт нь нийгмийн бүтцийн түлхүүр ойлголт болж хувирдаг. Ангийн байрлал, бүтэц хооронд, тэдгээрийн зуршилд агуулагдах бичвэр (анги, бүлгүүдэд байх өөрсдийгөө ойлгох ухамсар О.Б)-үүд нь үл нийцэл, зөрчлийг үүсгэж болзошгүй бөгөөд үүнээс нийгмийн бүтэц дэх тогтворгүй байдлын бүсүүд бий болдог (Anadolu University, 2019, p. 251).

Ален Турейн “эдийн засгийн шийдвэр, тэмцэл нь өмнөх нийгэмд байсан шигээр хараат, голлох байр суурьтай байхаа больсон”. Эрх мэдэл нь мөн чанарын хувьд

нийгмийн харилцаан дахь зөрчилдөөний цөм болсоор байна. Гэхдээ эрх мэдэл нь түүнийхээр эзэмшлийн зүйл бус харин давуу байдал, “тодорхойгүй байдал”-ыг хянах чадвар юм. Эрх мэдэл сарнихын хэрээр зөрчилдөөн олон талт шинжтэй болж байна. Ажилчид зөвхөн ажилчид гэх утгаар бус хэрэглэгч, тодорхой бүс, нутаг дэвсгэр дэх оршин суугчийн хувьд оролцогч болдог. Гэхдээ нийгмийн бүтцийн асуудлаас ангийн шинжилгээг хатуу тусгаарладаг. Тэрээр “Ангиуд нийгмийн, соёлын жинхэнэ давхарга болж алга болсныг бид харж байна. Үүний хамт ангийн нийгмийн харилцаан дахь зөрчилдөөнийг нээн илрүүлэх, ангийн харилцааг ойлгох аналитик зарчмын үнэ цэнэ өсөж байна. Нийгмийн ангиудын тухай яриа нь ямар нэг бүлгийг тодорхойлохоос илүүтэй ангийн асуудлыг зааж өгөх хэрэгтэй юм.” гэж тэмдэглэсэн.

Үйлдвэрлэлийн дараах нийгэм дэх эрх барих хэлбэр нь мэдлэг, боловсролд суурилдаг бөгөөд технологийн чиглэлийнхэн эрх баригчид болж хувирч байна. Тэрээр “Шинэ эрх баригч анги ... мэдлэг, боловсролын түвшнээр тодорхойлогддог”, “Эрх баригч анги бол давуу байдлаа хэрэгжүүлж буй шинийг санаачлагчдын бүлэг юм.” гэх зэргээр тодорхойлсон. Өдгөө мөлжигч ангиуд байхаа больсон ч эдгээрийг ерөнхий системд нэгтгэж удирдах болсон. Тиймээс гол асуудал нь өөрсдийгөө тодорхойлохын төлөө тэмцэх болсон. Энэ тэмцлийн тэргүүн эгнээд үйлдвэрчний эвлэлүүд, ажилчин ангийн уламжлалт давхаргынхан бус харин боловсролтой мэргэжилтнүүд, техникчид, оюутнууд явж байгаа юм. Их дээд сургуулиуд нийгэм соёлын эсэргүүцлийн төв болсон.

Онолын чиглэл, хандлагууд ийн хөгжиж байгаагийн зэрэгцээ эмпирик судалгааны түвшинд нийгмийн бүтцийг зураглаж, дүрслэх аргачлал орхигдож ирсэн. Ялангуяа бүтцийн онолын хандлагад нийгмийн бүтцийг хэрхэн судлах онол хандлага, шалгуурууд тодорхой боловч тэдгээрийг нэгтгэн зураглах аргачлал хангалтгүй. Энэ чиглэлээр оросын эрдэмтэн Н.Е.Тихонова олон жилийн турш ажиллаж, хэд хэдэн эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэн гаргасан юм. Тэрээр нийгмийн бүтэц давхраажлын онолыг удирдлага болгон нийгмийн бүтцийг дүрслэж, зураглах аргачлалыг хөгжүүлэх чиглэлээр нэлээд ахиц гарган хэд хэдэн эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэн гаргасан юм. Нийгмийн бүтцийг зураглах ажлын онолын үндэс нь неовеберийн хандлагад үндэслэн боловсруулсан нийгмийн статусыг тодорхойлох ESOMAR аргачлалд үндэслэлсэдэг. Уг аргачлалыг Оросын нөхцөлд байдалд тохируулан хэрэглэсэн бөгөөд арга зүйн хувьд 1) өрхийн үндсэн орлого олдог гишүүний мэргэжлийн болон албан ёсны

статусыг харгалзах: манлайллын үүрэг гүйцэтгэдэг эсэх, түүнд захирагдан ажилладаг хүмүүсийн тоо (5-аас бага, 6-аас их), үл хөдлөх хөрөнгө (бизнес эрхлэгч, хөлсний ажилчин), хөдөлмөрийн шинж чанар (биеийн болон оюуны хөдөлмөр), 2) үндсэн орлого олдог гишүүний боловсрол, 3) удаан эдэлгээтэй эд хөрөнгөтэй эсэхийг харгалзан тооцдог (Тихонова.Н.Е, Модель социальной стратификации российского общества: эвристические возможности различных теоретических подходов, 2007, р. 11). Нийгмийн бүтцийн судалгаанд төдийгүй, онолын асуудлаар судалгаа хийж байгаа хэн боловч социологийн онолын мэдлэгийг практик хэрэглээ болгох, эсвэл хэрэглээнд нэвтрүүлсэн онол нь нийгмийн бодит байдлыг зураглаж чадахуйц байх нөхцөлийг уг аргачлалаар хангаж өгсөн бөгөөд наад зах нь бүтцийн өөрчлөлтийг энгийнээр дүрслэн илэрхийлэх боломж олгодог. Уг аргачлалд үндэслэн оросын нийгмийн бүтцийн өөрчлөлтийг тодорхой давтамжтайгаар (1992, 1998, 2003, 2006) дүрслэн харуулсан нь (Тихонова.Н.Е, Социальная структура России: теории и реальность, 2014, р. 56; Тихонова.Н.Е, Социальная стратификация в современной России; опыт эмпирического анализа, 2007, р. 254) нэг талаас макро болон микро түвшний судлагдахууныг уялдуулах (зөрчлийг шийдэх) гэсэн бодит оролдлого, нөгөө талаас нийгмийн бүтэц давхраажлыг тодорхойлох хэрэглээний шинжтэй судалгааны ажил онолоос түрүүлэх шинжтэй болсон гэж үзэж болно. Учир нь дэлхий нийтэд энд дурдсанаас гадна нийгмийн давхраажлын судалгааны зарим нэг талыг үндэслэсэн шинжтэй судалгаанд ихээхэн анхаарч улс орнуудыг бүхэлд нь эрэмбэлэж, дэслэх болсон юм.

Нийгмийн ялгарлын тухай суурь ойлголт, нийгэмд ялгарал үүсэн бий болох шалтгаан, үр дагаврыг тайлбарлаж буй онолын үзэл хандлагуудыг нэгтгэн харвал:

Нэг. Марксистуудын үздэгээр нийгмийн харилцааны үндэс нь үйлдвэрлэлийн харилцаагаар буюу үйлдвэрлэлийн хэрэгслийг хэн өмчилж, хяналт тавьж байгаагаас хамаарч захирах, захирагдах, эсвэл хөрөнгөтөн, пролетари ангийн харилцаа үүсдэг бөгөөд өмчийн ялгаатай байдлаас үүдэлтэй нийгэмд зөрчил үүсдэг. Маркс хийгээд түүний залгамжлагчдын бүтээлийг шүүн харахад зөрчилдөөний шалтгаан, хүч нь нийгмийн хөгжлийн түвшнээс хамаардаг гэж болохоор байна. Тухайлбал, эхэн үед өмч эзэмшигч өмчгүй пролетарийн харилцаанд анхаарч байсан бол дараагийн түвшинд анги болон анги доторх давхарга (үйлдвэрлэлийн эзэд, захирал, менежер, дунд тушаалын албан хаагчид, технологийн болон бусад чиглэлийн мэргэшсэн ажилчид, гүйцэтгэх

түвшний ажилчид, хувиараа бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчид г.м), удирдлагын чиг үүргийн хуваарилалт, технологийн хөгжлийн үр дагавар зэрэг асуудалд анхаарах болсон. Нийгмийн ялгаатай байдал, бүтцийг ийнхүү ангич байр суурь, хандлагаар судалж байгаа ч орчин үед өмч, эрх мэдлийн ялгаатай байдлаас үүдэлтэй хувьсгалч, өөрчлөгч хүч нь сарнисан гэж үзэх болсон. Тэгэхлээр уг онолын хандлагад үндэслэвэл хожуу үеийн сэтгэгчдийн тодорхой институтцлэгдсэн харилцааг орхиод өмч хийгээд эрх мэдэлтэй холбоотой дараах асуултыг тавьж болохоор байна. Үүнд: нэгд малчдыг бие даасан ангийн статустай гэж үзэж болох уу?, хоёрт бүхэл нийгэмд, мөн бүлгийн дотоодод зөрчилдөөнт харилцаа, түүний уг шалтгаан нь юу вэ? Өөрөөр, нөлөөлөл тогтоох юм уу, хянах харилцаа бий юу гэсэн асуулт урган гарч байна.

Хоёр. Функционалистуудын үзэл баримтлалаас судлаж буй асуудлын тайлбар, судалгааны талбар, бүтэцтэй холбоотой нэгдүгээрт, анги болон ангийн нийгэмд гүйцэтгэх үүргийн тухайд Г.Спенсер ангийн гурван түвшнийг ялгаж эхнийх нь нийгмийн тогтвортой байдлыг хангах, хоёр дахь нь эргэлтийн, гурав дахь нь чиглүүлэх үүрэг гүйцэтгэдэг гэж тайлбарладаг бол Л.Гумплович анги нь хөгжлийг өдөөгч болдог гэж, Т.Парсонс тэнцвэртэй байдлыг хадгалах чиг үүрэгтэй гэж үздэг онолын ерөнхий хандлага. Хоёрдугаарт, ангийн ухамсар, түүний уламжлагдах шинж хийгээд уг шалтгааны тухай асуудал (Г.Шмолер, В.Зомбарт)-ыг хөнддөг. Гуравдугаарт, нийгмийг анги болон давхарга болгож ангилан судалсан (Г.Шмолер, М.Эдвард, С.Прейс, Д.Фитерман, Р.Хаузер, Л.Уорнер, К.Дэвис, У.Мур). Эл онолын хандлагад үндэслэвэл судлан буй нийгмийн бүлэг, сэдэвтэй хоёр зүйлийг тодруулан хэлэх хэрэгцээ үүсч байна. Нэгд Монголын гэх нийгмийн хувьд малчдын нийгэмд гүйцэтгэж буй үүрэг нь юу болох, хоёрт малчид гэх нийгмийн бүлгийг бүрдүүлэгч дэд хэсгүүд ямар шинж, үүргээр (өмчтэй нь өмч багатайдаа, хүчтэй нь хүч султайдаа г.м) холбогддог тухай асуулт урган гарна.

Гурав. Веберийн үзэл хандлагыг үргэлжлүүлэн судалсан эрдэмтдийн үзэл хандлагаас харахад бүтцийн шинжилгээ нь үйл ажиллагааны хэв маяг, шинэ бүтцүүдэд илүү анхаарч, марксистуудын үздэгчлэн эрх мэдэл нь дан ганц өмчөөр тодорхойлогдохгүй (функционалистуудаас ялгаатай нь зөрчилдөөний илэрхий элементүүдийг агуулдаг) боловсрол, мэргэжлийн нэр хүнд, амьдралын хэв маяг, зан үйлийн хэм хэмжээ г.м олон хүчин зүйлээс хамаардаг гэх хандлагад төвлөрдөг.

М.Веберийн орлого, өмч хөрөнгө, эрх мэдлийн хуваарилалт, Дж.Ленскийн чухал эрх мэдэл, онцгой эрх дарх, нэр төр, Ф.Паркиний угсаатны хамаарал, хэл, шашин, Э.Гидденсийн баялаг, орлого, жендер Ж.Голдторп, Д.Локвуд, Ф.Бичхофер, Ж.Платт зэрэг эрдэмтдийн тодорхой институт дэх ажилчдын статус, эрхэлж буй хөдөлмөр, орлогын хуваарилалт зэргийг харгалзан үзэхийг санал болгодог. Үүгээрээ эмпирик түвшинд функционалистуудын ашигладаг үзүүлэлт, чиглэлтэй давхцах ч гол санаа нь нийгмийн бүтэц, бүлгүүдийн ялгарч буй шинжийг олон хүчин зүйлийн нөлөөллийн үр дүн гэж тодруулан судалдагт оршино. Гэхдээ энэ чиглэлийн төлөөлөгчид нийгмийн бүтэц, ялгааг тодорхойлох шалгуур, хэмжүүрүүдийг тодорхойлон, хэрхэн судлах арга зүйг тэмдэглэсэн хэдий ч хэрхэн тодорхойлж харуулах тал дээр учир дутагдалтай гэж шүүмжлэлд өртөх нь бий. Оросын эрдэмтэн Н.Е.Тихонова нийгмийн ялгарлыг хэмжих аргачлал, шалгуур үзүүлэлтүүдийг нэлээд нарийвчлан боловсруулж Оросын нийгмийн бүтцийг дүрслэн илэрхийлэх болсон юм. Нийгмийн бүтцийн судалгаанд ялгаатай байдлыг ийм байдлаар дүрслэн илэрхийлэх нь илүү үр дүнтэй байж болох талтай. Онолын энэ хандлагад үндэслэвэл малчдын бүтэц, ялгааг ямар үзүүлэлтүүдээр илэрхийлж, хэмжих вэ?, одоо бүтцийн хувьд ямар хэв маягтай байна вэ? гэх асуултуудад хариулах бодит хэрэгцээ бий.

Дөрөв. Ялгарлын тухай ерөнхий онол, үзэл баримтлалуудын зэрэгцээ ХХ зууны 80-аад оноос хөдөлмөрийн зах зээлийг сегментчилэх (Питер Дерингер, Майкл Пайор, Ч.Лидбитер), угсаатны, жендерийн (Э.Хит, Г.Маршалл), нийгмийн хамгааллын (Г.Эспин-Андерсен, Т.Маршалл), үл хөдлөх хөрөнгийн өмчлөл (Питер Саундерс нар), францын шинэ сургуулийнхан (М.Фуко өөрийгөө эрх баригч байр сууринд тавих гэсэн оршин буй ангийн болон хүчний харилцаанд анхаарч, сэлбэж нөхөх, засварлах хамаарал, П.Бурдые нийтлэг мэдрэмж төлөвшүүлэхийн төлөөх тэмцэл, А.Турейн ангийн нийгмийн харилцаан дахь зөрчилдөөнийг нээн илрүүлэх, ангийн харилцааг ойлгох аналитик зарчмын үнэ цэн өсөж байна), элитийн гэх онолын хандлагууд төлөвшин хөгжсөн. Шинэ гэгдэх эдгээр хандлагуудад үндэслэн малчдын ялгарлыг судлан шинжлэх боломжтой ч эдгээрийн шалгуур болгож буй үзүүлэлт нь ерөнхий онолд ямар нэг байдлаар тусгалаа олсон, нөгөө талаар ялангуяа францын шинэ сургуулийнхны үзэл хандлагад үндэслэн судлахад дурдан буй нөхцлийг гарган илэрхийлэх шалгуур үзүүлэлт, аргачлалын тал дээр бэрхшээл үүсэх талтай.

Онолын гол гол асуудал, тавилууд нь суурин соёл бүхий улс орны хөрснөөс соёолж, нийтлэг тохиолдолд шинээр олж авч, эзэмших шаардлагатай “боломж”-уудаар нийгмийн бүтэц, ялгаа нь тодорхойлогддог болох нь харагдана. Онолын тайлбаруудыг нэгтгэн харахад эхэн үеийн төлөөлөгчид нийгмийн ялгарлыг ангийн хандлагаар судлаж ирсэн бөгөөд зарим шинэ хандлага (1980-аас оноос бий болсон)-ыг эс тооцвол социаль ялгааг дээд, дунд, доод ангийг бүрдүүлэгч давхраанд хувааж, үйлдвэр корпораци дахь ажил үүрэг, эрх мэдлийн хуваарилалт, хангамж үйлчилгээний боломж, гэр бүл, гарал үүсэлтэй нь холбох байдлаар судлагдахуун нь ерөнхийгөөс тодорхой руу шилжих байдлаар улам бүр нарийсан хөгжсөн.

Судлаачийн зүгээс малчдын ялгарлыг бүтцийн онолын хандлагад үндэслэн тодруулна. Бүлгийн дотоод дахь бүтэц, ялгааг нь тодорхойлсны дараа бүлгийн дотоод дахь, мөн дэд бүлгүүдэд илэрч буй асуудлуудыг өөр онолын хандлага, тайлбараар гүнзгийрүүлэн судлах нь үр дүнтэй. Үйлдвэрлэлийн онцлог хийгээд өмч бүрэлдэж буй үйл явц, харилцааг марксист хандлагаар, үйлдвэрлэлийн явц дахь хувь хүн хийгээд гишүүдийн оролцоо, нийгэм-эдийн засагт гүйцэтгэх үүрэг, онцлог бүхий харилцаа хэрхэн хэлбэржин тогтож буйг үүргийн хандлагаар ойлгож тайлбарлах бололцоотой. Үүний өмнө малчдыг судалсан байдал хийгээд үзэл баримтлал, МАА-н үйлдвэрлэлийн онцлогийг тодруулж, ялгаралд нөлөөлж буй хүчин зүйлс буюу шалгуур үзүүлэлтүүдийг тодрууя.

1.2. Малчдын судалсан дүр зураг ба шалгуур үзүүлэлтийн нарийвчлал

Нийгмийн байгууламжийн тухайд Германы эрдэмтэн Фердинанд Тённис (1855-1936)-ийн геменшафт, гезельшафт (Tönnies, 2001, pp. 22-91; Foster, 2018) гэсэн ойлголтуудын хүрээнд нийгмийн байгууллын онцлог, мөн чанарыг ялгасан байдаг. Гезельшафт нь орчин үеийн аж үйлдвэржсэн нийгмийн дүр төрхийг илэрхийлэх бөгөөд хөдөлмөрийн хуваарь илүү нарийсан, хүмүүс хоорондын харилцаан дахь шашин, зан заншлын нөлөө суларч, үүний оронд зохистой тооцоо, хувийн өмч, чөлөөт солилцоонд тулгуурласан харилцаа давамгайлдаг (ШУА-ийн ФСЭХ, 2006, р. 71; Tönnies, 2001, р. 57). Нийгмийн давхраажил, тэгш бус байдлын талаарх барууны онол, урсгал чиглэлд нийгмийн байгууллын энэ талыг илүүтэй анхаарч, уламжлалт гэгдэх нийгмийн байгууллын тал шинж нь зарим талаар орхигдох талтай явж ирсэн.

Малчдын амьдрал, ялгарал, нийгмийн харилцааны онцлог, хэв маяг нь геменшафт гэх ойлголтод бүрэн хамаарах ба уг ойлголт нь уламжлалт нийгмийн хэв маяг буюу газар тариалан, хөдөө аж ахуй давамгайлсан уламжлалт үйлдвэрлэлийн арга хэрэгсэл бүхий нийгмийн зохион байгуулалтыг илэрхийлдэг. Хүмүүс хоорондын харилцаа нь зан заншил, шашны зан үйлээр зохицуулагдах ба энгийн, сэтгэл хөдлөлийн шинж давамгайлдаг гэж үздэг. Уламжлалт нийгмийн байгууллын ерөнхий зүй тогтлыг илэрхийлж байгаагийн хувьд малчдын харилцаа, дотоод бүтэц энэ зүй тогтлоос гажихгүй. Гэхдээ засварлаж, баяжуулах шаардлагатай зүйлс бий. Тухайлахад, хөдөө аж ахуй гэх ойлголтыг тодруулах шаардлагатай.

Бид нийтлэг тохиолдолд мал аж ахуй тэргүүтэй, газар тариалан, бусад салбарыг хөдөө аж ахуй гэх ерөнхий томъёололд багтаан ойлгож, хэрэглэдэг (ҮСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл-2018, 2019, р. 489). Ф.Тённис газар тариаланг онцолж үзсэн ч хөдөө аж ахуй гэх ойлголтод мал аж ахуй болон бусад салбарыг хамааруулан хэрэглэсэн ойлголт гэж үзэж болох талтай. Ийм байдлаар ойлгож, цаашилбал уламжлалт нийгмийн гэх үндэслэл, утгаар газар тариалан, мал аж ахуйг ерөнхийлсөн томъёолол ч үйлдвэрлэлийн аргын хувьд нэн ялгаатай.

Монголчуудын хувьд малчид уламжлалт нийгмийн хэв шинжийг тээгч болно. Тээгч субъектын тухайд мөн олон янзаар ойлгож, тодорхойлдог. Малчин, малчид (англиар herder, оросоор скотоводов), мал аж ахуй, мал гэх ойлголтууд нь монгол хүн бүрийн нарийн сайн мэддэг сэдэв гэж үзэж болох ч шинжлэх ухааны судлагдахуун

болохын хувьд нэгд ойлголтын агуулга, хүрээг нарийвчлан тодорхойлох, хоёрт уг ойлголттой шууд болон дам байдлаар холбогдох бусад ойлголттой хэрхэн холбогдох, ямар харьцаатай болохыг нь ялгах шаардлагатай юм. Үүнд юуны өмнө “nomad” буюу нүүдэлчид гэх ойлголт хамаарна. Ойлголтын уг сурвалж, хамрах хүрээг судлаач Д.Мөнхтөр “Бэлчээр хөөн нүүх” (roaming about for pasture) гэсэн үндсэн утга бүхий Грек нэр томъёо болох “nomasados” нь угтаа малчин нүүдэлчид ба засвар гар урлал эсвэл худалдаачид гэсэн 3 үндсэн төрөл бүхий бүх л нүүдэлч хэрмэл улсуудыг өөртөө хамааруулдаг аж.” (Мөнхтөр.Д, Нүүдлийн соёлоос улбаатай Монголын нийгмийн бүтцийн зарим онцлогийн тухайд, 2020, р. 34) гэж тэмдэглэсэн. Оксфордын тайлбар тольд “... нэг газраа байнга амьдрахаас илүү нэг газраас нөгөө рүү нүүн амьдардаг бүлэг, хүн” гэж хэн, ямар зорилго чиглэлтэй нь тодорхой бус хэт ерөнхийлсөн байдлаар, Лехико (Oxford Lexico) тайлбар тольд “... шинэ бэлчээр хайн нэг газраас нөгөө рүү аялдаг, орон гэргүй хүмүүс” гэж монголын нүүдэлчдээс ондоо хэв маягийг үндэслэн тодорхойлжээ. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд “1. Ус, бэлчээр даган малаа маллан аж төрдөг хүмүүс, 2. Нүүдэллэн явдаг хүн” (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, 2008, р. 1417), Я.Цэвэлийн тайлбар тольд “Нүүдэллэн яваа айл хүмүүс: нүүдэлчин аймаг, нүүдэлчин айл” (Я.Цэвэл) гэж монголын гэх тодотголтой нүүдэлчдийн хэв маягийг онцолсон. Үйлдвэрлэлийнх нь арга, үр дүнг онцлон "Нүүдлийн сонгодог мал аж ахуй бол байгалийн ба зориудын шалгарлаар бий болсон таван төрөл малыг бэлчээрээр адгуулж, өгөөжийг нь хаягдалгүй, орчинд сөрөг нөлөөгүйгээр боловсруулдаг, экологийн цэвэр бүтээгдэхүүний цогц үйлдвэрлэл мөн" (Баянжаргал.Ч, 2011, р. 13) гэж ончтой бөгөөд өргөн агуулгатайгаар тодорхойлсон.

Логикийн хувьд бүх малчдыг нүүдэлчид, эсвэл бүх нүүдэлчдийг малчид гэж ойлгож болохгүй, зөрчилтэй боловч академич Б.Энхтүвшин “Монголын нүүдэлчид гэдэг нь юуны урьд бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч малчид мөн.” (Энхтүвшин.Б, 2014, р. 42) гэж тэмдэглэсэн нь бий. Хэрэв эдгээр тодорхойлолтод үндэслэн судалгааны сэдвийг “нүүдэлчид”-ийн ялгарал гэж томъёолон судлах бол чиглэл, зорилго нь тодорхой бус олз хайгчид, хэрмэл⁴-үүд, олон улсад утгын хувьд ойролцоо 20 гаруй⁵

⁴ Тайлбар: хэрмэл гэсэн үг нь “сул чөлөөтэй” гэх утгыг агуулдаг (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, 2021).

ойлголтыг нарийвчлан шинжилж, Монголд байгаа хэлбэр тус бүрийг хайн судлах шаардлагатай болно. Тодорхойлолтуудын агуулга нь нэгд, суурин амьдрал бүхий хэв маягаас ялгаж буй соёлын шинжтэй томъёолол (ингэж ч үздэг), хоёр амьдралын хэв маяг, хэмнэлийг илэрхийлж буй тул зөвхөн нүүдэлчид гэх томъёоллоор “нэг газар удаан суурьшихгүйгээр, бэлчээр ус дагаж, эсвэл улирлын онцлогоос хамаарч амьдралын хэмнэл нь зохицуулагддаг хүмүүс” гэж ойлгон судлаж болох ч агуулгын хүрээ нь судалгааны зорилгоос хэтийднэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “... мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэн”-ийг ойлгохоор (УИХ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, 2011) тодорхойлсон бөгөөд НДЕГ-аас “... түүнчлэн аж ахуй нэгж, байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр мал маллаж байсан малчин, цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан мөн сайн дурын даатгалд даатгуулж шимтгэл төлсөн малчин...”-ийг гэж нэмж тодруулсан тодорхойлолтыг хэрэглэдэг (НДЕГ, 2021). ҮСХ-ны ажил мэргэжлийн тодорхойлолтод “Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа иргэдийг хэлнэ” (ҮСХ, Малчдын тоо (улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр), 2021) гэжээ. Хувь судлаачийн зүгээс малчдын гэх томъёололд хөдөлмөр, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь мал аж ахуйд суурилж, түүнээс амьжиргааны гол эх үүсвэрээ бүрдүүлдэг, нүүдлийн болон хагас суурьшмал, суурин байдлаар аж ахуй эрхэлдэг хүмүүсийг оруулан ойлгоно. Нийгмийн байр суурь, ялгаа нь өрхийн статусын түвшнээр тодорхойлогддог.

Орчин үеийн хөдөлмөрийн харилцаанд ажилтан өөрийн эрхэлж буй ажлыг орхиод явсан ч тухайн ажилтнаас хамаарахгүйгээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь үргэлжилсээр (ажил олгогч өөр хүнээр гүйцэтгүүлэх байдлаар) байх боломжтой бол мал аж ахуйн үйлдвэрлэл нь малчин хүний оролцоогүйгээр байх боломж хязгаарлагдмал. Нийгмийн бусад бүлгээс ялгаж буй үйлдвэрлэлийн онцлог, тал шинжийг нь судлаач эрдэмтэд тал бүрээс нь шинжлэн тодорхойлсон байдаг бол нийгмийн талаас малтай болсон арга (удам дагасан, эсвэл худалдаж авсан г.м)-аас нь үл хамааран малчдын ажиллах, амрах, баярлах цэнгэх үйл нь үйлдвэрлэлийнхээ дотор

⁵ Ойролцоо утга: rancher, herdsman, breeder, cowboy, wrangler, vaquero, gaucho, goatherd, shepherd, buckaroo, cowpuncher, cowhand, cattleman, shepherd, drover, granger, stockman // <https://www.definitions.net/> 2020.11.18

өрнөж, өргөн утгаар амьдралын хэмнэл нь үйлдвэрлэлээс нь хамаардаг онцлогтой. Нүүдлийн, хагас суурин, суурин аж ахуй эрхэлж буй малчдын аль алинаас ийм дүр зураг ажиглагдана. Энгийнээр, бусад салбарт ажилдаа өмсөх болон өдөр тутмын хэрглээний гэж, эсвэл зориулалтын хувцас хэрэглэл өмсөж ажлаа хийдэг бол малчдын хувьд буяр ёслолоос бусад үед буюу ажиллах даа ч, амрахдаа ч байнгын өмсдөг хувцастайгаа үйлдвэрлэлээ эрхэлдэг.

Малчдын нийгмийн асуудлаар судлаж буй монгол эрдэмтдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил дахь онол, арга зүйн хэрэглээний дүр зургийг шалгуур болгон тэдгээрийг нэгтгэн харахад: 1). Нэгэнт бий болсон онол, үзэл хандлагыг баримтлан судлах, 2). Өөрийн нийгмийн онцлогийг тодруулж чадахуйц онол үзэл баримтлал боловсруулах тухай хувилбарыг ялгаж болно. Эрдэмтэн, судлаачдын санал таамаглал ихэвчлэн энэ хүрээнд өрнөж байна. Нийтлэг тохиолдолд эдгээр хувилбарын аль аль нь тодорхой шийдэлд хүрэхгүй (санаа уралдуулах байдлаар О.Б), зарим тохиолдолд үзэл баримтлалын мухардалд орох, эсвэл өөрийн онцлогийг тодруулах тухай санаагаа дэвшүүлэн орхих байдлаар хязгаарлагдсан байх нь бий. 3). Ямар нэг онолын баримжаа гэхгүй үзэгдлийг баримтын түвшинд бүртгэн судлах, эсвэл үзэгдэл, үйл явцын хувирлыг өөрт нь даатган нь орхих хандлага ажиглагддаг.

Эхний хандлага буюу барууны суурин иргэншил бүхий улс орнууд хөгжлийнхөө явцад үүссэн бэрхшээлээ даван туулах арга замыг хайж, янз бүрийн хувилбар бүхий гаргалгааг хийж байсан нь дэлхийн сонгодог гэх онолууд бий болох үндэс болсон. Монгол улс хөгжингүй улсуудын онол, сэтгэлгээний хөгжлийн суурь нөхцлийг харгалзалгүйгээр хуулбарлах, нутагшуулах тухай их ярих болсон нь шүүмжилбэл зохих бодит асуудал юм. Угтаа бодит байдлаа судалсан (практик, эмпирик) үр дүнд үндэслэн шийдлийн хувилбар тодорхойлох нь илүү өгөөжтэй.

Нийгмийн ялгарал, түүнийг судалсан, хөгжсөн онолын сэтгэлгээний үндэс, суурь нь бодит байдал дахь бэрхшээлээс үүдэлтэй болох нь өмнөх бүлгээс тодорхой харагдана. Тэдний онолын гаргалгаа, үндэслэл нь амьдралын хэв маяг, үйлдвэрлэлийн аргатай нь холбогдож оюун сэтгэлгээний түвшинд хэлбэржин бүтэцжиж байв. Ийм онол, үзэл баримтлалыг мал аж ахуйд суурилсан үйлдвэрлэл бүхий Монголын хөрсөнд шууд буулгаж хэрэглэх нь тохиромжтой юу? гэсэн асуулт урган гардаг. Доктор Х.Гүндсамбуу (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага,

2002, р. 26), академич Г.Чулуунбаатар (Чулуунбаатар.Г, 2008, р. 193), доктор О.Дашпүрэв “Монгол нийгэм (философийн анализ)” (Дашпүрэв.О, 2017) өөрийн уг үндсийг судлаж, ухаарахгүйгээр үүсэн буй асуудлыг зөв өнцгөөс харж, бэрхшээлийг үр дүнтэй шийдвэрлэх бололцоогүй болохыг тэмдэглэж, асуудалд эргэлзээ бүхий байр сууринаас хандахыг сануулсан. Сүүлийн үед судлаачдын дунд гарч буй үзэл хандлагын өөрчлөлтийг эс тооцвол нэгэнт бий болсон онол, үзэл хандлагыг шууд хэрэглэх байдал давамгайлж байсан, одоо ч ийм хандлага ажиглагдсаар байгаа юм. Үүний үр нөлөө нь асар их хортой!

Малчдын нийгмийн асуудлаар хийсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажилд өөрийн онцлог, уламжлалыг урьд (хайгуулын судалгааны түвшинд)-аас судлан тодорхойлох ажлыг хагас дутуу хийх, энэ хэрээр баруунжсан онолд тавих шүүмж, шүүлт хангалттай бус, тодорхой судалгааны түвшинд онолыг бараг бүрэн хуулбарлах, түүнийгээ төгс шийдэл гарц мэтээр хандах дүр зураг илэрхий ажиглагддаг. Оросын эрдэмтэн А.В.Чаянов тариалан эрхлэгчдийг судлаад “ ... тариачны аж ахуйн үйл ажиллагааны араншин, зорилго нь бизнесийн аж ахуй эрхлэгчийнхтэй ижил бус, өөрөөр хэлбэл ашиг олох асуудал биш, харин тариачин цаг хугацаа, ажлын ачааллаа өөрөө тодорхойлж, “өөрөө өөрийгөө дайчлан ажилладаг” гэжээ. Уг санаагаа “... бүтээгдэхүүний үнэ өсөх үед ч фермер ... үйлдвэрлэлээ бууруулах тохиолдол байх боломжтой” (Бакей.А, Хөдөө аж ахуйн эдийн засаг, 2014, р. 11) гэж үндэслэн тайлбарласан нь энэ. Үүнийг ХААИС-д малчид, мал аж ахуйн хөдөлмөрийн асуудлаар доктор (Нямсүрэн.Г, 2016), магистр (Тунгалаг.В, 2018; Наранцэцэг.Б, 2016; Баярчимэг.Г, 2008)-ын зэрэг хамгаалах эрдмийн ажилд нэлээд өргөн ашигладаг жишиг тогтсон аж. Мөн японы эрдэмтэн Ч.Накаймагийн тариачны аж ахуйн субъектив тэнцвэрт байдлын суурь загвар (Нямсүрэн.Г, 2016)-ыг ашигладаг.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын түвшинд тодорхой тал шинжийг нь тухайлбал, “цаг хугацаа, ажлын ачааллаа өөрөө тодорхойлж”, “бүтээгдэхүүний үнэ өсөх үед ч фермер ... үйлдвэрлэлээ бууруулах тохиолдол байх боломжтой” гэхчилэн үйлдвэрлэлийн онцлогтой холбогдох мөн чанарыг нь, гаргаж ирсэн арга зүй, аргачлалыг нь ойлгох буюу “мал аж ахуйн үйлдвэрлэлийн мөн чанар нь юунд оршиж байна вэ?” гэх байдлаар ойлгож ашиглавал зөв болмоор. Ухаандаа, мал аж ахуйн үйлдвэрлэлд малчин цаг хугацаа, ажлын ачааллаа өөрөө зохицуулна гээд малаа хаших юм уу, бэлчээрт зөнд

нь хаяад байж болох уу, байгалийн гэнэтийн үзэгдэл тохиогоогүй л бол түүхий эдийн үнэ өссөн ч, буурсан ч үйлвэрлэл тогтвортой үргэлжилдэг г.м тал шинжийг ойлгож түүнд үндэслэн судалбал онол, арга зүйн хувьд өөрсдөд илүү наалдацтай ажил болох юм. Малчид, мал аж ахуйн хөдөлмөрийн хүрээнд анхаарч үзвэл зохих олон асуудлыг хөнддөг ч ийм байдлаар “гол” асуултаа үл хэрэгсэн (магистр, докторын зэрэгтэй болох нь л гол зорилго) бүс нутаг, улирлын онцлог шинж гэсэн нийтлэг үзүүлэлтүүдээр судалгааны ажил нь хязгаарлагддаг.

Нийтлэг тохиолдолд бусад (барууныхан, газар тариалан эрхлэгчид)-ын боловсруулсан онол үзэл баримтлалыг “эрдмийн зэрэг горилсон ажлын бүтцэд байх ёстой зүйл” мэтээр оруулах, эсвэл тухайн онолын хүрээнд “илэрхийлсэн бүтэц”-ийн дагуу үр дүн гаргах төдийгөөр хязгаарлах, онол дахь яг таг оноосон шалгуур үзүүлэлтийг гөрдөж хэрэглэх, эцсийн дүгнэлтэд “өөрийн онцлогийг харгалзан үзэх” гэх мэтээр онолын тулгалтаас гарч чадахгүй байх нь түгээмэл. Бэлэнчлэх гэх үү, эсвэл энэ талын сургалт хоцрогдсных уу бүтээлч эрэл хайгуул нь ийм байдлаар гээгддэг. Ялангуяа, уламжлалаа танихад чиглэсэн судалгааны ажилд ийм байдал ихээхэн анзаарагддаг бөгөөд дээр дурдсан баримт (тодорхой судалгааны ажлуудаас мөн ийм жишээ олныг харж болно)-ууд үүний жишээ болно.

Монголчуудын түүх, соёл, сэтгэлгээ, үзэл хандлагын хувьд суурин иргэншил бүхий ард түмнээс өөр гээд уламжлалаа танихад чиглэсэн эрэл, хайгуул хийж, үзэл санаагаа уралдуулсаар байгаа нь **хоёр дахь хувилбар** болно. Монголын нийгмийн бүтэц, хөгжлийн тухай хэлэлцүүлгийн явцад өрнөж буй маргаан нь малчид, мал аж ахуйн хөдөлмөртэй холбогдох үед үүсэх нь түгээмэл. К.Марксын “азийн үйлдвэрлэл”-ийн арга гэх томъёолол үүний сонгодог жишээ, баримт юм. Үүгээр их сэтгэгч формацийн өөр хэлбэрийг тэмдэглэх гэсэн үү, томъёоллын шинжтэй ойлголтод яг юуг хамааруулж үзэх вэ гэх байдлаар маргадаг. Зөвлөлт холбоот улсад 1964-1965 онд “Үйлдвэрлэлийн Азийн арга” гэх ойлголтын талаар маргаан дэгдэж “... эрдэмтэд дорно зүгийн ард түмний үйлдвэрлэлийн арга нь бусад орныхоос маш өөр тул түүнийг нийгэм эдийн засгийн VI тусгай шинэ хэлбэршил гэж нэрлэх нь зүйтэй гэдэг саналыг дэвшүүлсэн байна. Ер нь дорно зүгийн орнуудад феодализм зохих ёсоор хөгжөөгүй бөгөөд ялангуяа нүүдэлчдийн дунд феодалын харилцаа хөгжсөн гэх нь нэн ч эргэлзээтэй ... ” (Нацагдорж.Ш, Сум, хамжлага, шавь ард (түүхэн найруулал) , 1972, р.

7) гэж маш сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлсэн ч үйлдвэрлэлийн аргын хувьд нэгэнт батлагдсан аргаас өөр шинэ хэлбэрийг хараахан нээгээгүй гээд орхисон байдаг.

Ойлголтын агуулга, тайлбарын тухайд олон эрдэмтэн байр сууриа илэрхийлдэг ч эдгээрээс зөвхөн хоёрыг жишээ татахад, академич Г.Чулуунбаатар “Маркс, Лениний хэн нь ч гэсэн орон зай, цаг хугацааны учир шалтгаан, судалгааны сурвалж материалын хүрэлцээний улмаас Ази тивийн соёл иргэншлийн онцлогийг нарийн судалж чадаагүй. ... Монголын нийгэм өнө эртнээс Азийн өвөрмөц соёл иргэншилд тулгуурлан оршиж, нийгмийн амьдралын үйлдвэрлэлийн аргын бие даасан хэлбэрийг бий болгон бататгасан нь тухайн үед Маркс, Ленин нарын "Азийн үйлдвэрлэлийн арга" гэж нэрлэсэн зүйлтэй агуулгын хувьд тохирч байгаа юм.” (Чулуунбаатар.Г, 2008, pp. 290-291) гэж нэлээд зоримог дүгнэлт хийсэн байдаг. Б.Ю.Кагарлицкий “газар тариалан эрхлэлт юм” (Кагарлицкий, 2018, p. 271) гэж азийн гэх үйлдвэрлэлийн арга гэсэн томъёоллоо Маркс хэт нэг талыг барьсан өнцгөөр харсан гэж ойлгогдохоор гаргалгааг хийдэг. Зарчмын хувьд К.Маркс энэ ойлголтоо судалсан судлаагүй, газар тариаланг дангаар, эсвэл мал аж ахуйг хамааруулсан, хамааруулаагүй гэх асуудлыг өнөөдөр хэлэлцүүлгийн сэдэв болгож маргахаас илүүтэй “мал аж ахуй болон газар тариалан” гэх үйлдвэрлэлийн, цаашлаад амьдрах арга барилаар ялгаатай хоёр том хэв маяг байгаа тул эдгээрийн мөн чанарыг нь илрүүлэн судлах нь ач холбогдолтой.

Азийн гэх үйлдвэрлэлийн аргад хамааруулах үйлдвэрлэлийн аргын тодорхой бус байдал нь өөрийгөө судлан тодорхойлох, ингэхдээ мал аж ахуйн үйлдвэрлэлийн аргыг газар тариалан эрхлэгчдийн үйлдвэрлэлээс ялгаж өгөх шаардлагатай гэсэн чигийг зааж өгдөг. Академич М.Төмөржав нар “Нүүдэлчдийн адгуусан амьтан гаршуулан гэршүүлэх ур ухаан нь ургамлыг гаршуулсныг бодвол их нарийн, чухамдаа энэ бол дуулгавар муутай, гарын дор биш материалыг хүний ухаан, тэвчээрээр эзэмшсэн үйл ажиллагаа. Харин газар тариалан эрхлэгчид хот барьж байгуулахдаа чадварлагаас гадна тэнд шинжлэх ухаан, улс төрийн төвүүд байгуулагдаж, хүн ам ихээр нягтрах нь хүмүүсийн хоорондын ялгаат харьцаа бий болгоход хүргэдэг.” (Төмөржав.М, Хүрэлбаатар.Н, 2017, pp. 489-490) гээд үйлдвэрлэлийн арга нь уг сууриараа ялгаатай болохыг, тэр нь соёлд нь хэрхэн нөлөөлдөг тухай шалтгаан, үр дагаврыг нь ийнхүү ойлгомжтой илэрхийлсэн.

Өнөөгийн түвшинд Монголчууд суурин болон нүүдлийн амьдралтай гэж ялгарах болсон ч “... олон зуун жилийн турш уламжлан ирж өнөө болтол хадгалагдаж буй

нүүдэлчдийн амьдралын хэв маяг, соёл, сэтгэл зүйтэй холбогдоно. Энэ утгаараа монголын нийгмийн бүтэц угаасаа бараг нэгэн төрлийнх буюу малчдын нийгэм байсан...” гэсэн нь туйлаас үнэн (Уртнасан.Ц, Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ, 2017, р. 157). Монголчуудын соёл, сэтгэлгээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөлөө нэвт шувт шингэсэн нь баттай бөгөөд үүний ул мөр нь ямар ч тохиолдолд устаж үгүй болохгүй. Иймийн учир өөрийгөө хэрхэн ойлгох, таних асуудалтай нүүр тулсаар байх болно.

Нийгэм, хүмүүнлэгийн чиглэлээр судлаж буй эрдэмтэд эл асуудалд ихээхэн ач холбогдол өгч, анхааран судлах болжээ. Доктор Б.Даш-Ёндон "... Монгол өөрийгөө оюуны хувьд оношлоход одоо ихээхэн анхаарах цаг болоод байна. Эл оношлохуй гэдэг нь улс төрийн болон гол нь нийгмийнхээ сэтгэл зүйг нарийвчлан судална гэсэн үг." (Даш-Ёндон.Б, Нийгмийг танихуй: түүх-хөгжлийн философи, 2014, р. 225), доктор Ц.Гомбосүрэн “нийгмийн философийн интеграль загвар” (Гомбосүрэн.Ц, Нийгмийн философийн интеграль (нэгдэгч) хувилбарыг боловсруулах эхлэл, 1999), доктор Н.Хавх “квадратын дагуу сэтгэх”, академич Г.Чулуунбаатар “азийн үйлдвэрлэлийн арга”-ын үзэл баримтлалд тулгуурлан судлах тухай (Чулуунбаатар.Г, 2008, pp. 233-240), О.Дашпүрэв “Монгол оршихуй” (Дашпүрэв.О, 2017), Л.Дашням “Язгуураа танихуй” (Дашням.Л, 2020) тухай. Мөн Д.Урианхай "Бодь сэтгэл, эв хамт ёс" - Ганцаарчилсан хөдөлгөөний улс төрийн үзэл онолын "Очир" - Үнэнээс цогцолсон Зэндмэнэ (Урианхай.Д, 2000, р. 5), Ч.Эрдэнэ “Их гурвалжин” (Эрдэнэбаяр.Г, 2000), П.Давааням “Суваргын онол” (Давааням.П, 1996) зэргийг дурдаж болно.

“Нүүдлийн болон суурин соёл”-ын нэгдэлд өөрийгөө шинжлэх, нийгмээ таних эерэг хандлагад суурилсан эрэл хайгуул ийнхүү өрнөж байгаа ч хүлээн зөвшөөрөгдөхүйц, тодорхой бүтэцлэгдсэн үр дүнд хүрэхгүй, яг тийм гэх бодитой дүр зураг, дүрслэл, бүтэц буухгүй байгаагаас харвал үр нөлөө багатай хүүрнэл үү гэмээр зүйл ажиглагдах нь ч бий. Учир нь социаль үзэгдэл, баримтыг нэгтгэн боловсруулж, оюуны боловсруулалт хийсний үр дүнд (барууны их сэтгэгчдийн онолын үндэс нь ихэнхдээ социаль баримтуудад үндэслэдэг болохыг өмнөх бүлэгт тэмдэглэсэн) хүлээн зөвшөөрөгдөхүйц тулхтай онол, үзэл хандлага бий болох бүрэн үндэстэй ч Монголын эрдэмтэн, судлаачид философийн ерөнхий урсгал чиглэлүүд дэх хандлага, арга зүйг ашиглан өөрсдийн ажиглалт, баримт (өөрсдийгөө хэт өргөмжилж, социаль баримтаар

баталгаажсан баримт ашиглах нь ховор бөгөөд илт үгүйсгэх хандлага гаргадаг. Тухайлбал, Б.ДЁ)-ыг шинжлэх, түүнээсээ санаагаа дэвшүүлэн гаргах байдлаар үр дүнгээ гаргаж байгаа юм. Магадгүй онолын хийгээд арга зүйн ийм чигийг баримтлан дүр зургийг тоймлох, чиглүүлэх нь тэдний үүрэг, гол үр дүн гэх байдлаар хүлээн зөвшөөрч болох талтай ч онол, сэтгэлгээний тодорхой үр дүн нь бодит байдлын зүй тогтолт шинжийг илэрхийлж, эргээд бодит байдлаа өөрчлөн хувиргах шинжтэй байх (Аюурзана.Г, 2010, р. 25) ёстой гэсэн санаа, гаргалгаанд үндэслэхэд хувь судлаачийн дэвшүүлж буй “хүүрнэл” гэх шүүмжлэлт байр суурь үнэний ортой болж ирнэ.

Онолын ямар ч хийсвэрлэл, байгууламж нь социаль баримтаар баталгаажиж, оюуны шүүлтүүрээр орсон нөхцөлд илүү үнэ цэнтэй, хүлээн зөвшөөрөгдөх шинжтэй болох ч тодорхой баримтуудыг нэгтгэж түүнд үндэслэн яг тийм гэх цэгцэрсэн баримт, үр дүнд хүрсэн нь нэн ховор. Ялангуяа уламжлал, нийгмийн “суурь онцлог”-ыг илрүүлэхүйц байдлаар шинжилсэн тодорхой судалгааны үр дүн хязгаарлагдмал, хуримтлагдсан баримтыг социаль хандлагаар онол, үзэл баримтлалын түвшинд нэгтгэн боловсруулсан үр дүн хомс, энэ талын ажил бүхэлдээ орхигдсон шинжтэй (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, р. 112) байгаа нь философи сэтгэлгээний түвшинд яг ийм гэх барьцтай үр дүнд хүрэхгүй байгаагийн шалтгаан гэж үзэх үндэс бас бий.

Доктор Н.Хавх, Х.Гүндсамбуу нарын эрдэмтэд уламжлалаа таних асуудалд бүтээлчээр хандан сэтгэж, социаль баримтуудад үндэслэн өөрсдийн үзэл хандлагыг гаргасан ч Н.Хавх мөн л хийсвэрлэлийн түвшинд үзэл санаагаа хэт туйлшруулах байдлаар (Хавх.Н, Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан, 1995; Хавх.Н, Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан, 2000), Х.Гүндсамбуу социаль баримтуудад үндэслэн судалсан ч таамаг дэвшүүлээд орхисон (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, рр. 26, 121) нь онол, арга зүйн бие даасан үзэл, хандлага дэвшүүлэх хэрэгцээ бий гэсэн санааг давхар илэрхийлдэг. Шүүмжлэлтэй, мөн онцлууштай зүйлүүд байгаа ч эрдэмтэн, судлаачдын үзэл хандлага бүхэлдээ уламжлалт хэв маяг, түүний социаль тал шинжийг нь илэрхийлж чадахуйц хэмжээнд судлах чигийг зааж байгаагаараа, зарим талаар арга зүйн хувьд анхаарвал зохих чухал санаа, гаргалгааг тэмдэглэн үлдээсэнд хийсэн ажлынх нь үнэ цэнэ оршино.

Бүтэцлэгдэж, цэгцэрсэн онол, арга зүй байгаа тохиолдолд асуудал, нөхцлийг өөрөөр тухайлахад, Кагарлицкийн тэмдэглэсэн лугаа "Хэрэв онолын аль нэг эд эс нь нийцэхгүй болсон бол үүнийг нь зүгээр л нийцэхээ больжээ гээд хэлчих нь хангалтгүй. Яагаад? гэж учрыг нь олох хэрэгтэй. Эндээс онолын бусад тал чиглэлд холбогдуулж ямар дүгнэлт хийж болох вэ? Яагаад энэ эх, адаг хоорондоо авцалдахгүй байна, энэ бүхнийг авцалдуулахын тулд ямар ажиллавар хийх ёстой вэ?" (Кагарлицкий, 2018, р. 50) гэх мэт онол, арга зүйн шинжтэй асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх боломж нээгдэнэ. Соёл, уламжлалын хувьд барууныхан болон газар тариалан эрхлэгчдээс өөр, мөн өөрийн онцлог дүр зургийг илэрхийлж чадахуйц онол, арга зүйн байгууламж бүрдээгүй нөхцөлд бид асуудлыг эхнээс нь, ул суурьтай судлах зайлшгүй шаардлагатай тулгарч байгаа юм.

Малчид, мал аж ахуйн салбар өөрийн дотоод инерцээр урагшилж, дэвшиг гэх байдлаар өөрийнх нь хүч бололцоонд найдан орхиж буй өнөөгийн хандлага (дэмжлэг байлаа гэхэд тэр нь маш хортой), шинжлэх ухааны талаас үйл явцыг баримт (тодорхой судалгааны болон бусад баримт материал)-ын түвшинд буулгаж, тэмдэглэн буй дүр зураг **гурав дахь нөхцөл болно**. Нөхцөл байдлыг баримт (баримтуудыг дахин боловсруулах байдлаар)-д үндэслэн судлаж, тогтоохоос мөн чанарын хайгуулыг эхлэх нь асуудал шийдвэрлэх боломж, чадамжийн хувьд илүү. Ийм байдлаар судлаж тодорхой шийдэлд хүрч болох дүр зураг ч харагдаж байгаа юм. Баримтуудыг дахин боловсруулах гэсэн уг санаанд "... аж ахуйн соёл иргэншил, түүний монгол гэсэн хэв шинжийг судалж ойлгохын тулд олон шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааг нэгтгэж зангидах хэрэгтэй байна" (Батцэнгэл.Х, 1992, р. 7) гэсэн утга, агуулга бий.

Социологийн тодорхой судалгааны түвшинд суурин, нүүдлийн амьдрал бүхий иргэдийг дан дангаар нь судалж, бүтэц, дүр зургийг нь баримжаалсан (ихэвчлэн сонгодог онол, үзэл баримтлалыг үндэс болгож) шинжтэй судалгааны ажил цөөнгүй. Бусад шинжлэх ухааны хандлагаар малчдын социаль дүр зургийг тодруулан судалсан үр дүн, баримтуудыг мөн ийм өнцгөөр харж, үүнд хамааруулан ойлгож болно. Гол нь тэдгээрийг социологийн шинжлэх ухааны хандлагаар нэгтгэн боловсруулж, нэгтгэсэн ажил ховор байгаа юм. Доктор Ч.Баянжаргал "Манай орны мал аж ахуйн зүтгэлтэн, биологич эрдэмтэн зарим хүмүүс, энд бидний тавьж буй асуудлуудыг хөндөхдөө тэдгээрийн тухай шинжлэх ухааны үндэслэл, тайлбар сэлт, онолын гаргалгааны талаар

уншихмаар зүйл тааралдсангүй, өрнөдийн их сэтгэгчдийн бүтээлд ч юм үгүй хэмээн шууд тэмдэглэсэн нь нэг биш үзэгдэнэ. ... монголчууд, тэр тусмаа нүүдэлч-малчин удмынхан л судлан шинжилж, нэгтгэн дүгнэж дэлхийн шинжлэх ухаанд энэ чиглэлээр бодитой хувь нэмэр оруулж чадах буйзаа." (Баянжаргал.Ч, 2011, pp. 4-5), нийтлэлч Б.Энхмандах "Монголын нийгмийн бүтцийн нэг өвөрмөц бүлэг болох малчдын хөдөлмөр эрхлэлтийн онцлог, МАА-н салбарын хөгжлийн өнөөгийн түвшин, хөдөөгийн хүн амын орлогын төрөл, хэмжээ, түвшинг тогтооход оршиж буй хүндрэл бэрхшээл...зэрэг Монголын өөрийн гэсэн онцлогтой цөөнгүй хүчин зүйлүүдийг тооцох шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Үүнтэй уялдуулан дундаж давхаргыг тодорхойлох аргачлалаа боловсронгуй болгох нь судлаачдын ээлжит зорилт байх ... болно." (Энхмандах.Б, Э.Энхчимэг, 2017, р. 29) гэж тэмдэглэсэн нь онол, сэтгэлгээний түвшинд, мөн арга зүйн тал дээр ахицтай үр дүнд хүрээгүй болохыг илэрхийлж байгаа юм. Магадгүй бага сага судалсан, тархай бутархай баримтууд (социаль хандлагыг онцолж байна)-ыг цэгцэлж, эсвэл гүнзгийрүүлэн судлаж гэмээ нь үзэл санааны хувьд батлагдах, эсвэл няцаагдахын аль нь боловч шийдэл бүхий үр дүнд хүрэх нь чухал. Цаг хугацааны хувьд ийм тулгалт ирэх нь зайлшгүй. Одоогийн нөхцөлд гадны эрдэмтдийн боловсруулсан онол, арга зүйн үндэслэл, гаргалгаа зэргээс суралцаж, тэдгээрийн боловсруулсан аргачлалыг баримжаалан, ядаж өөрийн онцлогийг танин мэдэхэд чиглэсэн бүтэцлэгдсэн арга зүй, аргачлал (бүтэцлэгдсэн загвар) боловсруулах зарчмыг баримтлах нь зөв чиг байж болох талтай.

Хоёр болон гурав дахь баримжааллын тухайд социологийн сонгодог болон орчин үеийн онолын сэтгэгчдийн боловсруулсан үзэл хандлагад үндэслэн зарчмын хувьд нийгмийн бүхэл дүр зургийг илэрхийлэх боломжтой гэж үзэж болох ч яг малчдын онцлогийг судлахад энэ бүхэн бүрэн нийцнэ гэхэд эргэлзээтэй, арга зүй хийгээд ойлголтын тайлбарлалын түвшинд бүрэн үгүйсгэгдэх шинжтэй үр дүн ч бий. Наанадаж онол, үзэл баримтлалууд боловсрон гарсан орчин буюу аж үйлдвэржсэн, суурин амьдрал бүхий орнуудад суурь нь тавигдаж, хөдөлмөрийн хуваарь нарийссан нөхцөл (Энгельс.Ф, 1973; Маркс.К, Капитал I, 1999, pp. 777-784, 840-844, 853)-тэй уялддаг зэргийг нь харгалзан үзэхэд л шүүн тунгаах зүйл бага биш.

Марксист чиглэлд хамаарах төлөөлөгчид Грамши, М.Цейтлин, С.Малле, А.Горц, Х.Браверман, Р.Микельс, Э.О.Райт нар нийгмийн ялгааг тодорхой институт, корпораци

дахь эрх мэдэл, байр сууриас хамааралтай болохыг, позивистуудаас Г.Шмолер, В.Зомбарт, Р.Вормс нар веберийн урсгал чиглэлийг баримтлагчдаас Р.Дарендорф, Д.Локвуд, Ж.Голдторп бусад, С.Стюарт нар, функционалистуудаас М.Эдвард, С.Прейс нар, шинэ хандлага баримтлагчдаас П.Дерингер, М.Пайор нар хөдөлмөрийн хуваарь, тодорхой ажил, мэргэжлийг үндэслэн нийгмийн ялгааг тодорхойлсон. Хэрэв мал аж ахуйн салбар бүхэлдээ барууныхтай адил фермержиж, зах зээлийн ихэнх хууль сонгодог утгаараа үйлчилж (Бакей.А, Хөдөө аж ахуйн эдийн засаг, 2014, р. 3), тэнд хуулиар зохицуулагдах (ийм нөхцөл бүрдэж байгаа) хөдөлмөрийн нарийн харилцаа үүссэн тохиолдолд “мэргэшсэн, чадварлаг” ажиллагч, ажил олгогчийн тухай ярьж, мөн мал сүргийг төрөл, насаар нь ялгаж, мал аж ахуйтай холбогдох хөдөлмөрийн бусад хэлбэрийг задлаж тус бүрт нь бие даасан статустай болгосон тохиолдолд дурдан буй эрдэмтдийн үзэл баримтлал, шалгуурыг ашиглаж шинжилгээ хийх бололцоотой. Зах зээлийн нийгэмд шилжихээс өмнө малчдыг дотор нь мэргэжлийн гэмээр хэсгүүдэд хувааж, энэ нь судалгаа шинжилгээний баримтад “Социализмын үеийн малчид бүрэлдэхүүний хувьд хоньчин, ямаачин, адуучин гэх мэт мэргэжлийн гэж болох бүлгээс тогтож байсан нь мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалттай холбоотой. Эдгээр нь маллагааны өвөрмөц арга барил шаарддаг боловч малчны мэргэжлээс онцгой ялгарч байсан гэхэд хэцүү” (ШУА-ийн ФСЭХ, 2001, рр. 153-154) гэж шүүмжлэлд өртөж байв. Мөн "... хоршоолсон ардын дотор орлогын буюу эдийн засгийн давхраажил бүдэгхэн ч, мэргэжил-мэргэжлийн ялгарал мэдэгдэм тодорч, давхраа, бүлгүүд үүсгэсэн гэж хэлж болно." гээд үүнд хөдөлмөрийн хөлс, бүс нутгийн ялгаа, газар зүйн байршил, ам бүлийн тоо, ястан угсаатны гарвал, нас хүйс (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, рр. 100-103) зэрэг хүчин зүйлс ялгаралд нөлөөлж байгаа тухай тэмдэглэсэн. Өнөөгийн түвшинд аж ахуй эрхлэх арга хийгээд, өмч захирах эрх зэргийг үндэслэвэл сэтгэгчдийн үзэл хандлага, арга зүйг ашиглаж болох талтай. Л.Уорнерийн онол, аргачлал ялангуяа малчдыг өөрөөр нь, эсвэл нөгөөгөөр нь үнэлүүлэн хэрэглэхэд ихээхэн төвөгтэй. Үнэлэмж, баримжааллын хувьд монголчууд “амны билгээс ашдын бэлэг, хоёр идэхгүй хоосон хонохгүй амьдрах, бусдын жишгээр” гэхчилэн өөрийн амь амьдралтай холбоотой асуудлыг муу, эсвэл сайн, гоц гойд гэж бусдаас хэт дөвийлгөж, ялгарахаас татгалзах хандлага давамгайлдаг. Цөөн малтай малчин өөрийгөө ядуу, эсвэл муу гэхгүй, хэдэн зуу, мянган малтай байлаа ч баян, бусдаас дээгүүр гэхгүй амьдрал,

амьжиргаагаа адил “дунд” гэж үнэлэх, өөрөө хэдий цөөн малтай байгаад олон малтай нэгнийгээ, эсрэгээр олон малтай нэг нь цөөн малтай бусдыгаа уг шинжээр нь дээр доор гэж үнэлэхээс зайлсхийдэг учир энэ аргачлалыг хэрэглэхдээ ихээхэн болгоомжтой, болвол объектив үзүүлэлтээр шалган хэрэглэх шаардлагатай болдог.

Нийгмийн хөгжлийн явцад гарсан зарим өөрчлөлтийг эс тооцвол малчид үйлдвэрлэлийн уламжлалт шинж, харилцааг бараг бүрэн хадгалж үлдсэн. Тэднийг "... эдийн засгийн талаар: малчныг мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн гол ажиллах хүч, малыг хувьдаа өмчлөгч, өсгөн үржүүлэгч, арчлан маллаж, хайрлан хамгаалагч, үр хүүхэддээ өвлүүлэгч, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, зах зээлд нийлүүлэгч, өөрөө хэрэглэгч ... иргэншлийн хувьд Монголын нүүдлийн соёл иргэншлийн гол эзэн субъект, түүнтэй холбоотой дэвшилттэй бүхнийг бүтээлцэгчид" (Чагдаа.Х, Монголын малчдын үе залгамжлалын нийгмийн асуудал: өнгөрсөн, одоо цаашид (диссертаци), 1997, р. 14) гэж тодорхойлсон. Малчдын ихэнх хэсэг нь нүүдэллэн амьдарч, хөдөлмөрийн нарийн хуваарьт захирагдалгүй, уламжлалт үйлдвэрлэлийн арга давамгайлсан хөдөлмөр эрхэлдэг зэргээрээ суурин амьдрал бүхий хүмүүс, зах зээлжсэн харилцаанаас өөр, малчин гэдгийг тодорхой мэргэжил гэж харвал үл ялгарах бүхэллэг шинжтэй (янз бүрийн мэргэжил эзэмшиж, давхар өөр бусад ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүс бас бий) тул малчдын ялгааг судлан тодорхойлохдоо дээр дурдсан сэтгэгчдийн үзэл баримтлалыг шинжилгээний гадна үлдээлээ.

Бидний өөрсдийн тохиолдолд "... малчны ажил хөдөлмөр, мэргэжилд зөвхөн нэг талаас нь өрөөсгөлөөр хандаж болохгүй." (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, р. 540) гэж тэмдэглэсэнчлэн зөвхөн мэргэжил гэх өнцгөөр хязгаарлаж, эсвэл социаль ялгааг нь зөвхөн малын тоо хэмжээг баримжаалан ойлгож, тогтоох нь хэт хялбарчилсан ажил болж, үүний ард зүй тогтолт шинж, шалтгаант чанарыг илрүүлэхэд чиглэсэн ажил орхигдсоор байх болно.

Хөдөлмөр, үйл ажиллагааны нэгэн төрөл байдал, өмчийн хэв маяг, эрх хэмжээ, орлогын эх үүсвэр (өөрт нь төвлөрдөг учир бие даасан анги гэж үзэхэд эргэлзээтэй), шийдвэр гаргахад оролцож буй байдал нь “анги”-ийн (Эдвард Томпсон) статустай⁶ (ШУА-ийн ФСЭХ, 2001, р. 150) бие даасан бүлэг болохыг нь илэрхийлнэ. Э.Томпсоноос

⁶ "... монголын нийгмийн хөгжлийн зурвас үед хоёр найрамдалт анги (ажилчин, малчин), сэхээтний давхраа тэдгээрийн амьдралын хэв маяг оршин байсан нь одоогийн зах зээлийн нийгэмд ч ул мөрөө үлдээсэн хэвээр байгааг мартаж болохгүй." (ШУА-ийн ФСЭХ, 2001, р. 150)

гадна анги, түүний ялгах шалгуур үзүүлэлтийг үнэс болгосон ч малчид бие даасан анги болох нь батлагддаг. Учир нь ангийн шинжийг нь үйлдвэрлэлийн арга нь дангаар шахуу илэрхийлж, нийгмийн бусад бүлгээс ялгарах социаль ялгааг нь тодорхойлно. Эрхэлж буй үйлдвэрлэлийн аргын хувьд “мал, малчин, бэлчээр” гэх гурван хүчин зүйлийн аль нэг тал шинжгүйгээр оршин байх бололцоогүй төгс зохицол бүхий үйлдвэрлэл бөгөөд үүнийг Б.Сумъяа “битүү цагирган холбоонд тулгуурласан соёл иргэншлийн бие даасан хэв маяг мөн” (Сумъяа.Б, 2005, р. 32). Нийгмийн ялгааг тодруулан судлахад энэ онцлог, шинжийг орхигдуулж үл болно.

Төгс зохицол бүхий үйлдвэрлэл гэдэг нь нэг тохиолдолд бие биеийн оршин байхуйг тэтгэх, эргээд нөгөөхийнхөө оршихуйг нь дэмнэх байдлаар харилцан үйлчилж, тогтвортой оршдог. Энэ үйлчлэл бодитой, тогтвортой оршин байхад маш нарийн холбоо, зохицуулалт шаардагддаг бөгөөд нийгэм-эдийн засгийн зохион байгуулалтын хэлбэр, бодлого зохицуулалтаас хамаарч хаягдаж гээгдэх, эсвэл үйлдвэрлэлийн зарим хэсгийг шууд үгүйсгэх юм уу, хэт дөвийлгөх байдлаар зохицуулалтын чанартай алдаа гаргах нь бий.

Үйлдвэрлэлийн гол хэрэгсэл нь бэлчээр, малчдын амьдралын гол үүсвэр нь мал боловч малчны оролцоотой ийн тодорхойлогдож, нэрлэгдэх бололцоотой болдог. Малчин, мал хоёр нь бэлчээрийг бодитой болгож буй бөгөөд ийм харилцаа үгүй бол “газар” нь хувийн үйлдвэрлэл, өмч (Маркс.К, Капитал III, 2001)-ийн шинжтэй таваарлаг капитал болж хувирна. Бүхэллэг байдлаар үйлдвэрлэлийг бүрдүүлж буй гурван хүчин зүйлийн аль нэг тал шинжийг нь тухайлбал, үйлдвэрлэлийн хэрэгсэл болох мал үгүй бол “малчин”, “бэлчээр”-ийн тухай ярьж, судлах боломжгүй. Мал аж ахуйд суурилсан үйлдвэрлэлийн онцлог шинжийг ийн ойлгож, тооцолгүйгээр малчдын социаль ялгарлын тухай ярих нь өрөөсгөл юм.

Үйлдвэрлэлийн тасралтгүй шинж нь нийтлэг тохиолдолд бэлчээр (байгалийн давагдашгүй хүчин зүйлс)-ээс, цаашлаад газар зүйн байршлаас хамаарах ба үүгээр малчдын амьдралын хэв маяг, хэмнэл нь зохицуулагдаж, нийгэмшдэг (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, р. 548). Хэрэв бэлчээрийг нь хязгаарлаад, эсвэл нөхөн сэргэх чанар нь алдагдаад эхэлбэл бэлчээрийн гэх тодотгол бүхий мал аж ахуйн үйлдвэрлэл бүхэлдээ, газар нутгийн бүрэн бүтэн байдал (Батхишиг.Б, 2018, р. 219) тэр чигтээ эрсдэлд орох, малчдын гэх бие даасан хэв маяг,

бүтэц үгүй болох аюултай. Бэлчээрийг хэт шүтсэнээр мал аж ахуйн үйлдвэрлэл эрсдэлд орох, эсвэл мал аж ахуйн үйлдвэрлэлийг хэт шүтсэнээр бэлчээр нь эрсдэлд орж үйлдвэрлэлийн энэ хэлбэр устах эрсдэлтэй (Гантөмөр.Б, 1997, р. 19).

Түүхийн талаас Монголчууд дургүйлхэж, үгүйсгэсэн байр сууринаас хүлээн авдаг ч Манжийн эрхшээлийн үед ийм бодит эрсдэл үүсэхээс болгоомжилж "Бэлчээрийг хамгаалах арга хэмжээг нилээд тууштай явуулж атар газар хагалбарлаж тарих буюу хятадын нүүдэлчин тариачдыг олон олноор оруулж монголчуудын малын бэлчээрийг эзлүүлэхийг цаазлан хоригложээ." (Нацагдорж.Ш, Сум, хамжлага, шавь ард (түүхэн найруулал) , 1972, р. 56) гэж тэмдэглэсэн байдаг. Үүнийг хувь судлаачийн зүгээс юуны түрүүнд МАА-н үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг сэргөлдөгч соёлын тээгчдээс хамгаалахад чиглэсэн шууд утга бүхий, хоёр дугаарт үйлдвэрлэлийн тэтгэгч тал шинж (бэлчээр)-ийг нь бүрэн бүтэн авч үлдэх гэсэн санаа гэж ойлгож байгаа юм. Хоёр хүчин зүйлийн аль нэгийг онцгойлж үзсэнээр бэлчээрийн аж ахуй орших боломжгүйг харуулсан чухал баримт юм. Уламжлалт үйлдвэрлэлийн энэхүү нарийн холбоос сэмжийг ойлгосон тохиолдолд (Хавх.Н, Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан, 2000, р. 125; Дашпүрэв.О, 2017, р. 32) бэлчээр хувьчлах, эзэмшүүлэх, түрээслэх тухай ярьж байгаа нь соёл, түүх, газар нутгийн бүрэн байдал руу чичилсэн үйлдэл, гэмт хэрэгт тооцогдож ч болох талтай.

Нягт хамаарал бүхий хоёр хүчин зүйлийн аль нэг талыг хэт шүтэлгүй, зохицуулж ирсэн нь малчдын мэдлэг, ухаантай салшгүй холбоотой (асар их соёлын өв уламжлал бий болж хөгжснийг салбар бүрт анхааран судлаж ил гаргавал зохино). Ийм хамааралт шинж малчныг бие даасан статустай, бас соёл, түүхийн талаас үнэ цэнэтэй субъект болгон хувиргадаг. Энэ нь өөрийнхөө түвшинд ч олон шинжээр батлан харуулдаг.

Бэлчээрийн гарц дорой, ус ундаа, хужир шүү хүрэлцээгүй тохиолдолд бэлчээр даган нүүж суухаас өөр гарцгүй (Сумъяа.Б, 2012, р. 160) бөгөөд “Нүүдэлчид нь газартай шууд харилцдаггүй, харин малчид хахир цагт нөмөр нөөлөг, халуун цагт дэнж бараадан, өвсний сөл хөөж, хүн малын усны ойрыг бодон нутагладаг, түүнийгээ цагийн аяс, жилийн дөрвөн улирал, ургамлын гарц, тэнгэрийн хуртай таацуулан сэлгэдэг, нүүдэл хийдэг.” (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, р. 548) бэлчээр тохируулах шинжтэй үйлдэгдэж буй мэт боловч малчны мэдлэг, туршлагатай холбогдох асуудлууд юм. Энэ тухайд Б.Сумъяа "Бэлчээрийн мал аж ахуй

нь хүмүүсээс зөвхөн биеийн хөдөлмөрийг шаардаад зогсохгүй оюуны идвэхитэй үйл ажиллагаа, ажиглалт, эрэл хайгуул, бодол бясалгал, сорилт туршилтын ажлыг шаардах бөгөөд үүний үр дүнд нүүдэлчдийн аж ахуйн нарийн ухаан төлөвшиж хөгждөг билээ." (Сумьяа.Б, 2005, р. 57), Д.Шомбодон "Бэлчээрийн мал аж ахуйг байгаль, цаг уур, малын биологийн өргөн мэдлэгт тулгуурлан үйлдвэрлэлийн хязгаарлагдмал, хувьсамтгай нөөцөд бодитой үнэлэлт өгч оновчтой хувилбарыг сонгох замаар эрхэлдэг учраас түүнийг оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл гэж үзэх үндэстэй." гэж тодорхойлоод үйлдвэрлэл эрхлэн явуулахын тулд "Малчид ажиллах хүчний нөөц, мал сүргийн тоо, бэлчээр усны хангамжийг харьцуулан үйлдвэрлэлийн нөөцөө тооцож малын бэлчээрийг сонгон, нүүдэллэж үйлдвэрлэлээ явуулдаг. Тэгэхдээ өрхийн хүн амын бүтэц, хөдөлмөрийн чадвар, малын төрөл, тооноос шалтгаалан, хот айлын хэмжээ, малчдын хөдөлмөрийн зохион байгуулалт, ажлын хуваарь харилцан адилгүй." (Шомбодон.Д, 1993, рр. Зөвлөмж, 47).

Сүргийн хэмжээ, бүтцийг тогтвортой хадгалахад нарийн ажиллагаа шаардах ба наад зах нь бууц хэвтрийг нь хэрхэн засах, цагийн өнгийг харгалзан ямар төрлийн тарга тэвээрэг авахуулах, ямар хэмжээний, ямар төрлийн малтай байх, бэлчээрийн болон цаг уурын эрсдлийг бууруулахаар отор нүүдэл хийх, өвс тэжээл бэлтгэх, сульдаж дордсон малыг хэрхэн тэнхрүүлэх гээд олон талын мэдлэг ухаан шаарддаг бөгөөд Х.Чагдаа "Туршлагатай сайн малчин хүн малынхаа өнгө зүс, үс ноос, байр байдлаас нь аль хэр таргалсан, нутаг бэлчээр, хужир-шүү, тохирч байгаа эсэх, эрүүл мэнд, өлсөж даарч байгааг нь гярхай ажиглан тэр бүхнийг тохируулж байдаг." (Чагдаа.Х, Монгол малчны амьдрахуйн ухаан, 2002, р. 31) мэдлэг, ухааны онцлог тал шинжийг ийн тэмдэглэн хэлжээ. Мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбогдох мэдлэг ухаан зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Олон талын ухааныг шингээсэн мэдлэгийн цогц бүтэц юм.

Мал аж ахуйн үйлдвэрлэл нь малчнаас үйлдвэрлэлээ тогтвортой үргэлжлүүлэхэд чиглэсэн, мөн ахуй амьдралаа хөтлөн явахад тустай олон талын мэдлэг, ухааныг шаардах ба мал аж ахуйн үйлдвэрлэлийн явцад бий болсон мэдлэгийн бүтэц (хөдөлмөр, аж ахуйн арга ухаан, технологи, мэдлэг ухаан, соёл урлаг, эрчим хүч, экологийн мэдлэг, социаль харилцаа, төр ёсон, зан заншил, нийгмийн сэтгэл зүйн)-ийг 8 бүлэг болгосноос үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, онцлог, үр дүнтэй холбоотой хөдөлмөр (их төлөв амьд байгаль, амьтан ургамалтай харьцдаг хийгээд хөдөлмөр эрхлэгчдийн бичил хамтлаг,

нийгмийн бүлгийн хоршсон хамтын үйл ажиллагаа байдагт оршино), аж ахуйн арга ухаан (сонгодог маягийн фермерийн аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд илүү анхаарвал Монгол улсын үндэсний хөгжилд бишгүй хувь нэмэр оруулах боломжтой), технологи (арьс шир, идээ цагаа, мах шүүс, мал аж ахуйн тоноглол, малчдын ахуйн хэрэглээний үйлдвэрлэл зэрэг хүний материаллаг үйл ажиллагааны олон талыг багтаан хамарсан), мэдлэг ухаан, соёл урлаг (одон зурхай, ардын анагаах ухаан, байгалийн шинжлэл, экологи, шашин, гүн ухаан, улс төр, нийгэм, хууль цаазын сэтгэлгээ, ардын сурган хүмүүжүүлэх ухаан, ардын хийгээд үндэсний урлаг соёлын салбарууд зэрэг), эрчим хүч, экологийн мэдлэг (байгалын олон янзын юмс үзэгдлийн учир зүйг танин ухаарч тэдгээрийн байгальд өөрт нь хөнөөл, хохиролгүйгээр ахуй амьдралдаа ашиглах мэдлэг) (Чулуунбаатар.Г, 2008, pp. 136-137, 192) гэж тэдгээрийн бүрдэл элементүүдийг ангилж, ялгасан.

Үйл ажиллагааны төрлөөр нь академич Ч.Авдай, С.Төмөржав нар бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, мал аж ахуйн тоног хэрэгсэл, орон сууц, түүний дотоод тавилга хэрэгсэл, үйл урлал, газар тариалан, металл боловсруулах, зураг төсөл ба дархны ажил, модон эдлэл үйлдэх (Авдай.Ч, Төмөржав.С, 2003) гэж ангилсан бөгөөд ажлын ачаалал, хүнд хүчир байдлаас хамаарч эрэгтэй, эмэгтэй хүний, хүүхдийн хийх ажил гэж хуваарилдаг гэжээ. Доктор Ц.Нансалмаа мал аж ахуйн технологитой холбоотой, сүргийн нөхөн үйлдвэрлэлтэй холбоотой-9, малын ашиг шим авах-6, ашиглахтай холбоотой-4 зүйл (Нансалмаа.Ц, 1998, р. 53) болгон ангилсан.

Нарийн бүтэц, зохицуулалт бүхий үйлдвэрлэлийн арга, түүнээс үүдэлтэй олон талын мэдлэг, соёл хөгжсөн атал зарим судлаачид "... оюуны хүч чадал төдийлөн шаардахгүй, бүтээл эрчимжилт багатай, биеийн хөдөлмөр зонхилж байна." (Дорлигсүрэн.Д, Хотын ба хөдөөгийн хүн амын ажилгүйдэл, тэдгээрийн онцлог, 1998, р. 128) гэх байдлаар хандаж дүгнэсэн байх нь хэт хөнгөн, эсвэл тогтож нарийн судлаагүй, бүр өөрөөр мал аж ахуйн үйлдвэрлэл дагасан маш нарийн уялдаа бүхий гүнзгий боловсорсон ухааныг судлан шинжлэхэд барьц алдсан уу гэмээр дүгнэлт хийсэн байх нь бий. Барууны иргэншсэн соёлд суралцсан гэх хожуу үеийн залуус, төлөөлөгчид өөрийгөө үл судлаагүй, үл мэдэхийн хэрээр "малын бөгс харсан амьдралтай хүмүүс" гэх байдлаар түүх соёл руугаа нулимж, тохуурхсан байдлаар хандах болсон нь их эмгэнэл.

Зохиолч Л.Түдэв мал аж ахуйн үйлдвэрлэлийн олон талт шинжийг ажиглан "Ийм зардал бараг гаргахгүйгээр их баялаг бүтээдэг эдийн засагтай улс хаана ч байхгүй. Юун Маркс, юуны Кейнс! Тэд ийм онол эдийн засгийн ухаанд оруулж чадаагүй. Яагаад гэвэл мэдээгүй учраас! Доод зэргийн зарлагатай, дээд зэргийн ашигтай бас экологийн цэвэр эдийн засаг... "Economy be one self", "ecology pure", "economy model"... " (Түдэв.Л, 2009, р. 276) гээд бүхэлд нь "академик айл" гэж, өөрөөр "Нүүдлийн мал сүрэг нь эдийн засгийн хувьд хөрөнгө зардал нэн бага гарах хирнээ орлогыг их оруулдаг, хөрөнгө мөнгө, техникийн хүч чадлаар биш, байгаль цаг агаартай зохицох хэр хэмжээгээр арвижин өсөж хөгжиж байдаг, бараг цэвэр ашигтай аж ахуй." (Хавх.Н, Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан, 2000, р. 6), "хүн бүр үйлдвэрлэгч, өрх бүр үйлдвэр" (Чулуунбаатар.Г, 2008, р. 300) гэсэн тайлбар, тодорхойлтыг өгсөн. Үүнийг үгүйсгэх бололцоогүй бөгөөд судлаач Д.Дагвадоржийн "Академич Майский Хүнс тэжээлийн зүйлийнхээ 77.1%-ийг, орон байрныхаа 86.4%-ийг, гэрийн эд хогшлын 66.0%-ийг, ажлын багаж хэрэгслийнхээ 67.2%-ийг өөрсдөө үйлдвэрлэж хэрэгцээгээ хангаж чаддаг байжээ ... өнөөгийн малчин өрхийн аж ахуй жилийн нийт хэрэглээнийхээ 76%-ийг өөрөө, 24%-ийг худалдаа солилцоогоор хангажээ" (Дагвадорж.Д, 1998, р. 7) гэж тэмдэглэсэн баримтууд хангалттай нотолдог. Иймдээ ч доктор Д.Шомбодоны "... малчин бол мал аж ахуйгаа тогтвортой эрхэлж, насан туршийн мэргэжсэн ажилтай хүмүүс..." (Шомбодон.Д, 1993, р. 19) гэж тодорхойлсон нь бүрэн үндэслэлтэй болж байгаа юм.

Мал аж ахуйн хөдөлмөртэй холбоотой "Саалийн үнээ, шөлний төлөг" гэх хэлцийг хэрэглэх нь их. Өнөөдөр судлаачдын баримтлаж буй нийтлэг шалгуураар цөөн малтай өрхийг ядуу дорой гэж харж, үнэлж болох ч мөн чанартаа хүн хүчний бололцоо, бие махбодийн тэнхээ чадал, хэрэгцээндээ тохируулан үйлдвэрлэл эрхлэж байгаа нь энэ. Биеийн болон хүн хүчний хэрэгцээ, ач холбогдлыг "Нүүдлийн мал аж ахуй нь сүргээ харийн халдлага, байнгын шахам дээрэм тонуул болон араатны аюулаас хамгаалахын тулд олон хүний хүч буюу бүл чадалтай байхыг шаардсан салбар болно. Мал сүргээ бэлчээрлүүлэх, тарга тэвээрэг авахуулах, тоо толгойг өсгөх зэрэг бүтэц үүргийн цогц шинжтэй маллагааны технологи нь малчдыг анхнаасаа "бүл"-ийн зохион байгуулалтад барьж мал сүргээ адгуулахад бүрэн дасан зохицсон нийгмийн нэгж болгон төлөвшүүлсэн юм. Гаднын халдлагаас сэргийлэхийн тулд төрөл бүлүүд ойртон нягтрах, холбоо

тогтоох, багахан хулгай, дээрмийн хариуг дангаар барих чадвартай байх зэрэг хамтын хөдөлмөр зохион байгуулалтыг зайлшгүй шаардаж байв.” (Чулуун.С, 2017, pp. 51-52) гэж үйлдвэрлэл нь дан ганц мэдлэг ухаан, туршлагын үр дүн бус юм гэсэн санааг илэрхийлдэг.


Үйлдвэрлэл нь “амьд, амьлаг харилцааны” дунд өрнөж, үйлдвэрлэлийн явц дахь үйл ажиллагаа бүр нь бие даасан арга ажиллагаа, ухаан, тэсвэр хатуужил шаарддагийн хувьд мэргэжлийн шинжтэй болгож байгаа юм. Тухайлбал, хөдөлмөрийн үргэлжлэх цаг тогтвортой бус бөгөөд Б.Сэмбээжавын судалсныг “... 1990 онд мал аж ахуйн хөдөлмөр нь эргэх дөрвөн улирлын орчинд эхлэл, төгсгөлгүй үргэлжлэл, малчид хоол, нойроо хайрлахгүй, өдөр бүхэн 14-18 цаг ажиллаж байхад өдөрт 8 цаг ажилласан гэж тооцож, тэднийг эрүүл мэнд, хөдөлмөр, хөлс цалингаар нь хохироож ирснийг ... Малчин хүн унтаж амарлаа ч ажлын байран дээрээ мал сүргийнхээ дэргэд, шаардлага тохиолдсон цагт (бороо, цас, салхи, шуурга, чоно нохой, хулгай дээрэм гэх мэт) хэзээ ч бэлэн байхаар хөнгөн (хагас) нойрсдог болохоор тэднийг шөнө ажиллаагүй гэх үндэсгүй юм.” (Шомбодон.Д, 1993, pp. Зөвлөмж, 47) гэжээ. Барууны сэтгэгчдийн үзэл онолыг баримжаа болговол энэ нь цагийн менежментийн асуудал ч гэлээ хөдөлмөрт зарцуулж буй цагийн хэмжээгээр нийгмийн ялгаа тодорхойлогддог бол малчид түүний оройд байрлах юм.

Малын тоо хэмжээ, түүний өсөлт бууралт нь бэлчээр, малчин гэх хоёр хүчин зүйлийн тасралтгүй харилцан үйлчлэл, тухайлан малчин хүний энэ их мэдлэг ухааны үр дүн бөгөөд үүгээр суурь шинжтэй ялгаа тодорхойлогддог. Энэ тухайд "Малчдын давхраажлыг малтай холбохгүйгээр, мал сүргийн өсөлттэй уялдуулахгүйгээр ухаарах аргагүй. ... малчид дундчууд гэхээсээ хоёр туйл руугаа ялгаран давхраажиж байна..." (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, pp. 113-114) гэж тэмдэглэсэн (яг ийм гэхэд эргэлзээтэй О.Б) бөгөөд малчдыг судалсан эрдэмтэн судлаачдын гаргасан дүгнэлт, хэрэглэсэн аргачлал, тодорхой судалгааны баримт үр дүнд ихэвчлэн малын тоо толгойн хэмжээг баримжаа (Х.Гүндсамбуу, Ц.Пүрэв, О.Мөнхбат, Д.Дорлигсүрэн, Ц.Уртнасан, Ц.Отхон, Ц.Бат-Эрдэнэ, С.Идшинноров, Ш.Нацагдорж, Д.Юнгэр, Г.Нямсүрэн, Ц.Жагварал, Д.Дагвадорж г.м) болгодог. Гэхдээ "... байгалийн бүсүүд, оршин суугаа газрын байршил, ястан угсаатны гарвал, нас хүйсний бүрэлдэхүүнтэй ямар нэгэн холбоотойгоор нийгмийн ялгарал, зааграл бий

болсон... хөдөөнийхний давхраажил нь ... намхан, хавтгайдуу, тэгшдүү, зэрэгцмэлдүү, жирэлзэх төдий долгиолог ... мал сүрэг, өмч хөрөнгө, ажил төрөл, нутагшил байршил зэргээрээ ямар нэгэн хэмжээгээр давхраажиж буй нь эргэлзээгүй." (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, pp. 105, 539) г.м олон хүчин зүйлсийг тэмдэглэдэг.

Малчид малын тоо хэмжээгээр ялгарч буй нь илэрхий боловч үүнд гол нь зарим малчид их, зарим нь цөөн малтай байгаа нь чухам юунаас болж байгаа, амьдралд нь ямар байдлаар тусч, нөлөөлж байна вэ, нийгмийн хүчин зүйлсийн нөлөөлөл, хамаарлын асуудал анхаарал татах тал шинж нь болж байгаа юм. Үүний шалтгааныг тодруулах хэрэгцээ нь гүнзгийрүүлсэн судалгаа хийж, нөлөөлж болох олон талын нөхцөл, хүчин зүйлсийг шинжлэх, улмаар онолын шинжтэй гэмээр асуудал хөндөхөд хүргэж болох талтай. Эрдэмтэн, судлаачдын судалсан баримтад үндэслэвэл малчдын эрхэлж буй үйлдвэрлэлийг дараах байдлаар ойлгож, бүтэцчилж болохоор байна. Үүнд:

Бүдүүвч 1. Мал аж ахуйн үйлдвэрлэл



Мал аж ахуйн үйлдвэрлэл нь амьд, хөдөлгөөнт шинжтэй бөгөөд байгалиасаа бие даан хоол тэжээлээ олж идэх чадвартай, өөрөөсөө үрждэг учир хэд ч хувааж өвлүүлэх боломжтой зэргээрээ онцлогтой. Малчдын ялгаа нь үйлдвэрлэл эрхлэх нөхцөл, түүнд тохируулан үйлдвэрлэлээ удирдан зохицуулж буй онцлогоор тодорхойлогдох ба учир шалтгааныг нь ийн ойлгож болох юм.

Социологид нийгмийн хүчин зүйлээс гадна газар зүй (газар зүй, хүн ам зүй, сэтгэл зүй, технологи г.м детерменизмийн хэд хэдэн төрөл бий)-н хүчин зүйлтэй холбон тайлбарлах хандлага XIX зууны сүүл XX зууны эхээр (Г.Бокль 1821-1862, Лев Ильич

Мечников 1838-1888 г.м) нэлээд хэлэлцэгдэж байсан. Тэднийхээр нийгэм, хүний үйлдэл хийгээд байгалийн хооронд холбоо хамаарал бий тухайлбал, хүн амын өсөлт, хэмжээ, улс төрийн эдийн засаг ба нийгмийн тэгш бус байдлын хамааралт шинж, бүхэл соёлын хувь заяаг тодорхойлдог гэх санааг дэвшүүлдэг. Социологийн тодорхой судалгааны түвшинд гэхэд хүн амын болон боловсон хүчний шилжилт хөдөлгөөний шалтгааныг газар зүйн хүчин зүйлтэй холбон тайлбарлах нь бий.

Түүхч, академич Ш.Нацагдорж "... нүүдэлчдийн нийгмийн хөгжлийн асуудлыг түүх, нийгмийн шалтгааны зэрэгцээгээр газар зүйн орчин, байгалийн нөхцөлийн үүднээс, тэгэхдээ газар зүйн детерменизмд хальтран орчихгүйгээр тайлбарлаж чадвал бид нүүдлийн нийгмийн олон асуудалд хариу олж чадах юм." (Нацагдорж.Ш, Монголын феодализмын үндсэн замнал, 1978, р. 18) бүтээлдээ тэмдэглэснийг анхаарах зайлшгүй шаардлагатай юм. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдал нь байгалийн, бодлого эрх зүйн, эдийн засгийн орчин нөхцлөөс, тэр дундаа үйлдвэрлэлийн гол үндэс болох бэлчээр, бүс нутгийн онцлог (Жүгдэр.Ч, 2006, р. 21) зэрэг байгалийн хүчин зүйл тодорхойлогч шинжтэй бөгөөд өмнө тэмдэглэсэнчлэн нийгмийн харилцааны хэв маягийг төлөвшүүлдэг. Энэ нь дараах шалтгаантай:

Улирлын шинжтэй бэлчээр тохируулах, айл саахалтын хол ойрыг тооцон нутаглах байдлаар үүрэг хариуцлага нь илэрдэг бол өөр бусдын зүгээс бэлчээр, ус унд, хонд бууц, хадлан талбай хамгаалах зэрэгт хяналтын механизм үйлчилдэг. Үүнийг үйлдвэрлэлийн онцлогтой холбогдол бүхий баримтуудаар нотлон харуулж болно.

Монгол орны газар нутгийн хэмжээ өргөн бөгөөд бэлчээрийг ерөнхийд нь хангайн, хээр талын, говийн гэж ангилах бөгөөд Ж.Самбуу "... гурван бүслүүр болгон үздэг шалтгаан нь агаар, улирал, газрын хөрс, ургамал болон ус ундааны ахуй байдлаар тийнхүү ялгаварлагдах боловч тэрхүү орон нутгийн мал аж ахуйтан ард түмний мал адгуулах үндсэн ажиллагааны сайн арга туршлага нь ерөнхийдөө адил боловч цаг улирлын эргэлт хувирлаас нөхцөлдсөн мал маллах ажиллагааны дотор хангай, говь түүний завсар бүслүүрийн зарим нэгэн ажиллагааны арга туршлагыг тодруулан ялгаварыг гаргах нь ... чухал юм." (Самбуу.Ж, Ма аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардуудад өгөх сануулга сургаал, 1945, pp. 19-20) гэж тэмдэглэсэн. Хожуу бэлчээрийн хэв маягийг тодорхойлох судалгааны арга зүй, аргачлал гүнзгийрч, дэвшилттэй технологи хөгжиж, тэдгээрийг ашиглахын хэрээр илүү нарийвчлалтай ялгах болсон.

А.Д.Симуков (1934) нүүдлийн хэв шинжийг нь онцлон хангайн, хээрийн, баруун Монголын, хангайн өврийн говь хээрийн, дорнодын, говийн хэв шинж." гэж (Чагдаа.Х, Монгол малчны амьдрахуйн ухаан, 2002, pp. 25-26), академич Н.Жагварал Хэнтийн, хангайн, говийн, баруун, дорнод хэв шинж (Ганболд.И, 2013, р. 4) гэж ялгасан бол Д.Базаргүр бүр засаг захиргааны нэгжийн түвшинд ялган харуулсан. Тэрээр Алтайн уулархаг нутаг (Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь зэрэг аймгийн 20 гаруй сум), Хангай-Хэнтийн уулархаг нутаг (Сэлэнгэ, Орхон, Туул, Онон голууд тэдгээрийн салбарууд), Төв-Дорнодын талын бэлчээр (Өвөрхангай, Төв, Дундговь, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод), Дорнодын талархаг говийн бэлчээр (Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн сумууд) гэж нарийн ялгасан (Базаргүр.Д, 1998, pp. 91-116). Бэлчээрийн онцлог, бүсчлэл, талбайн хэмжээ, газрын гарц өөр өөр байх бөгөөд айлсаж, хотолсох нь ч үүгээр зохицуулагддаг аж. Өмнө тэмдэглэсэн, нийгмийн харилцаа нь үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой болох нь үүгээр илэрхийлэгдэж байгаа юм.

Лавшруулбал “Малчид айлсахдаа бэлчээрийн даац, өрхүүдийн малын тоог харьцуулан хот айлын малын тоог зохистой хэмжээнд байхаар урьдчилан тооцдог тул хэлбэлзэл багатай байдаг. Тэгэхдээ хот айлын хэмжээг хязгаарлагч байгалийн хүчин зүйл нь бэлчээрийн даац учир түүхий улирлын хэлбэлзэлийн аясаар хот айл урин дулаанд тэлж өвөл, хавар хэмжээ нь багасдаг.” (Шомбодон.Д, 1993, р. 28) гэж тэмдэглэжээ. Тэгэхлээр тодорхой судалгааны түвшинд бүс, бэлчээрийн онцлогийг хамгийн эхэнд харгалзан үзэх шаардлагатай болж байгаа юм. Нийгэм, соёлын үйлчилгээний хүртээмж, ХАА-н үйлдвэрлэлийн дэд бүтэц (Шомбодон.Д, 1993, р. 5)-ийн хүртээмж, хөгжлийн асуудал ч үүнтэй хамт яригдана.

Үйлдвэрлэлийн тогтвортой байдал, үр ашиг нь бэлчээрээс гадна бодлогын болон эдийн засгийн орчин нөхцлөөс хамаарах ба үйлчлэл, нөлөө нь тухайн цагийн байдлаас хамаарч өөр өөрөөр илэрч, үр дүн нь малчдад харилцан адилгүй хүрдэг. Социалист нийгмийн үед малчдын эзэмших малын тоог бүсийн онцлогоос хамааран ялгаатай тогтоож, хожуу ийм зохицуулалт хийхээ больсон (ШУА-ийн ФСЭХ, 2001, pp. 153-154) ч нэг талаас бүс нутгийн онцлогийг харгалзсан гэмээр, нөгөө талаас төрөөс малчид дотооддоо ялгарахад ийнхүү оролцож байсныг илтгэдэг. Мал аж ахуйд холбогдох ажлыг зориудаар задлаж, тэр бүрийг бие даасан хөдөлмөр хэмээн үзэж өгөх цалин

мөнгөний хэмжээг нь ялгаатай тогтоож байв. Тухайлбал, "... нэгд, ХААН-ийн цалин хөлс нийтдээ доогуур; хоёрт, нэг аймгийн доторх сум нэгдлүүдийн хөдөлмөрийн хөлс нэлээд ялгаатайн дээр хамгийн бага ... болон хамгийн их ... хөлс олгосон сум-нэгдлийн зөрөө бараг тав дахин байгаа. Хөдөө аж ахуйн түүхий эдийн бэлтгэлийн үнийг зориуд доогуур тогтоодгоос ХААН-үүд гавитай орлого олдоггүй, түүнийгээ дагаад нэгдэлчдийн амьдрал тарчигхан байлаа. Үүнээс болоод ХААН-ийн хөдөлмөрийн хөлс ажилчдынхаас, тариаланчдаас, тэр битгий хэл Сангийн аж ахуйн малчдынхаас ихээхэн доогуур, зааг ялгааг багасгахаар төлөвлөдөг ч бодит байдал дээр хүсч хүлээсэн үр дүнд хүрдэггүй байв. Харин нэгдэлч-малчдын амьжиргаанд амины хэд нь ихээхэн жийрэг болдог байв. Гэтэл түүнийг хангай, тал хээрийн бүсэд 50, говийн бүсэд 75 толгойгоор тогтоон, шаггүй хязгаарласаар ирсэн." (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, pp. 100-101). Мөн албан татвар төлөлт, төлөвлөгөө биелэлт зэрэг хатуу шалгууруудыг хэрэглэж байсны учир малын тоог худал мэдээллэх, дарах (Ишдорж.Ц, 2013, pp. 374-375) зэрэг бодлогын алдаа илэрч байсан нь судалгаа, шинжилгээний баримтад туссан байдаг.

Зах зээлийн нийгэмд шилжснээс хойш зохих хууль, журмаар зохицуулан малчдын амьжиргаа, мал аж ахуйн салбарыг дэмжихэд чиглэсэн ажлыг хэрэгжүүлж байгаа юм. “Малчдаас ноолуур худалдан авах” (МУЗГ, Малчдаас ноолуур худалдан авах, 2008), “Ноолуур хөтөлбөр” (МУЗГ, Ноолуур хөтөлбөр, 2000), “Ноолуур хөтөлбөр 2018-2021” (МУЗГ, Ноолуур хөтөлбөр 2018-2021, 2018), “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам” (МУЗГ, Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, 2019) г.м үйлдвэрлэлийн салбарыг, давхар малчдын амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрүүдэд хамрагдаж, мөн малчид зохих нөхцөл, шаардлагын дагуу нийгмийн хамгаалал (тэтгэвэр, тэтгэмж, тусламж г.м)-ын бодлогын өгөөжийг хүртдэг болов. Гол нь эдгээр нь бодит байдалд малчдын ялгаралд хэрхэн нөлөөлж байгаа, хувь өрх хийгээд байгаль орчинд үр дүнтэй нөлөө үзүүлж чадаж байна уу гэдгийг тодруулах хэрэгцээ бий. Өнөөдөр жишээ нь, бэлчээрийн талхлалт мал сүргийн өсөлт, цаг уурын өөрчлөлттэй холбоотой гэж тайлбарлах нь үндэстэй ч сүргийн бүтэц, харьцаа алдагдсан нь эдгээр хүчин зүйлтэй зэрэгцэхүйц хортой нөлөө үзүүлж байгаа юм.

Боломж гэдэг нь нэг талаас үйлдвэрлэл дэх хувь хүний үүрэг оролцоо, нөгөө талаас социаль хүчин зүйлсийн харилцан үйлчлэлээр тодорхойлогдох бөгөөд ялгаа нь эдгээрийн харилцан үйлчлэлийн үр дүн болж илэрдэг. Үүнтэй холбоотой:

Нэгдүгээрт, үйлдлийн илрэх хэлбэр, агуулга нь өгөгдсөн нөхцлөөр тайлбарлагдана. “Үйлдэл” гэх ойлголтын тухайд ч тэр, М.Веберийн рациональ үйлдлийн тал шинжийг⁷ илэрхийлэх (ШУА-ийн ФСЭХ, 2006, р. 203) боловч агуулгын хувьд өөр өнцөг, хандлагаар ойлгож хэрэглэнэ. Веберийн тодорхойлсон зорилгот ухамсартай үйлдэл нь бидний өөрийн өнцөг (малчид, монголчууд)-өөс харахад рациональ шинжтэй бус, харин ч “бусдыг өгсөх замын гишгүүр болгож буй” мэт нийцтэй бус хэв маяг, агуулгыг илэрхийлдэг. Түүний тодорхойлсон үйлдлийн үлдсэн хоёр хэв маягийг тэр хэвээр нь ойлгож хэрэглэж болно. Судлан буй сэдвийн хүрээнд зорилтот ухамсартай үйлдэл гэдгийг, тодорхой нөхцөл дэх хувь хүний “хариу үйлдэл”-ийн үр дүн бөгөөд хувь хүний өөрт буй боломж буюу хувь хүний болон социаль хүчин зүйлсээс хамаардаг. Хүн өөрт буй боломжуудыг, эсвэл хөндлөнгийн байж болох эрсдэл, сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн тооцоолол, түүнд суурилсан үйлдлээр илрэх бөгөөд энэ засвар социаль ялгарал, тэгш бус байдал, давхраажил хэлбэржин тогтдог.


Хоёрдугаарт, “нөөц” гэх ойлголтыг тодруулах шаардлагатай. Т.Парсонсын “нөхцөл байдлын, зан үйлийн, соёлын” гэсэн нөөцийн гурван хэв маягийг ялгаснаас агуулга, багтаамжийн хувьд өөр. Нөөц гэдгийг “өгөгдсөн нөхцөл” гэж ойлгоно. Учир нь хүний үйлдэлд зан үйл, соёлын шинжтэй нөлөөллүүд ордог ч эцсийн дүнд ямар ч тохиолдолд өгөгдөн буй нөхцлөөс хамаарч, өөрт буй боломжийг хэмжиж үйлддэг.

Гуравдугаарт, боломж гэх ойлголт нь нобелийн шагналт эдийн засагч Амартья Сений дэвшүүлсэн “боломж ба чадавх” гэсэн харилцан уялдаа бүхий ойлголттой ойролцоо боловч түүний дэвшүүлсэн “боломж” гэх ойлголт нь нийгэм-улс төрийн бодлого хийгээд ёс суртахуунтай (Beckley, Jan 2002, р. 109), чадавх гэдэг нь тэгш бус байдлыг даван туулахын тулд бодлогын дэмжлэг шаардлагатай гэх санааг агуулдаг. Өөрөөр хэлбэл, боломж хийгээд чадавх нь өөрөөс үл хамаарах шинжтэй гэсэн санаагаар гадаад орчин (тэгш эрхийг хангах бодлого, хууль эрх зүйн орчин г.м)-той нь холбон тайлбарладаг. Суурь боломж нь зорилгодоо хүрэх чухал хэрэгсэл (Sen grants that primary

⁷ Тодорхойлолт: хэрэв түүний үндэс нь гадаад ертөнцийн болон бусад хүнээс тодорхой үйл хөдлөлийг хийхийг хүлээх явдал болж тэгээд энэ хүлээлтийг өөрийнхөө ухамсартай тавьсан бодож боловсруулсан зорилгод хүрэх “нөхцөл” юмуу “хэрэглэлүүд” болгон ашиглаж байгаа бол зорилгот ухамсартай үйлдэл

goods are useful means for achieving one's chosen goals.), чадавхиа боломж болгон ашиглах (Beckley, Jan 2002, p. 112) гэсэн санааг мөн илэрхийлдэг. М.Веберийн боломж (chance) гэх ойлголтын хүрээнд эдийн засаг, анги ба эд хөрөнгө, улс төр, хууль, шашны гэсэн голлох нөлөө бүхий хэлбэрийг ялгаж өгсөн. Эдгээрээс эдийн засгийн боломж нь голлох нөлөөтэй бөгөөд нийгмийн боломжийг тодорхойлох шинжтэй юм. Үүнтэй холбоотой нийгмийн тэгш бус байдлыг зохицуулах бодлого эрх зүйн зохицуулалтын тухай асуудлыг давхар ярьдаг. Мөн хувь хүний үзэл хандлага зохих нөлөөтэй (Müller, 2020). Тэгэхлээр Амартья Сений “боломж” гэх ойлголтыг агуулгын хувьд ойролцоо утгаар хэрэглэж байгаа ч хэнд хамааруулж, эсвэл хэнээс хамаардаг вэ гэдэг нь агуулгын хувьтай ялгаатай болохыг илэрхийлнэ. Харин боломж, түүний үйлчлэх зарчим (суурь боломж)-ыг ойролцоо утгаар ойлгож болохоор байна. М.Веберийн боломжийн тухай ойлголт дахь хүчин зүйлс нь нийгмийн тэгш бус байдал бий болох, давхраажихад нөлөөлдөг гэх утгыг илэрхийлж байна. Эл судалгаан дахь “нөхцөл” буюу үйлдвэрлэл эрхлэх орчин нь нийгмийн ялгааг илэрхийлэх суурь нөхцөл болдог гэсэн утгаар хэрэглэгдэж байгаа юм. Веберийн тодорхойлсон хувь хүний зан байдал, хандлага нь “боломж” гэх ойлголттой ойролцоо утгыг илэрхийлэх боловч эл судалгаан дахь боломж нь хувь хүний өөрийн чадавх, социаль хүчин зүйлсийн цогцоор нөхцөлдөнө гэсэн утгаар хэрэглэгдэнэ.

Бүдүүвч 2. Боломжийг тодорхойлох нь



Үйлдвэрлэлийн явц дахь хувь хүний оролцооны тухайд МАА-н үйлдвэрлэл нь жилийн дөрвөн улиралд, байгалийн хүчин зүйлийн нөлөөн дор явагддаг учир малчин

хүн үйлдвэрлэлээ амжилттай удирдан явуулж, амьдралын тогтвортой байдлаа хангахын тулд нөхцөл байдлыг цаг ямагт үнэлж, улмаар өөрт өгөгдсөн боломж (хувь хүний болон анхдагч бүлгийн г.м)-ийг тооцох байдлаар үргэлжлүүлдэг тасралтгүй үйл ажиллагаа юм. Тэгэхлээр үйлдвэрлэлийн талаас нэн түрүүнд хүн хүчний болон бие мах бод, мэдлэг ухамсрын, мөн сэтгэл зүйн тодорхой чадамжтай байхыг шаардах бөгөөд эдгээр хүчин зүйлс зохистой хангагдсанаар үйлдвэрлэлд ирэх эрсдлийг бууруулах, тогтвортой байдлыг хангах (тоо хэмжээ, чанарыг хадгалах), үр өгөөжийг нь нэмэгдүүлэх байдлаар удирдан зохицуулах боломж бүрддэг. Тухайлбал, хүн хүчээр тааруу, бие эрхтний аль нэг хэсэг эмгэгтэй (хөдөлмөрийн онцлогт үл нийцэх байдлаар) бол мал маллахад бэрхшээлтэй. Мэдлэгийн тухайд хэрэв малчин хүнд эрсдлийг бууруулах, тогтвортой байдлыг хангах мэдлэг, чадамж үгүй бол ихээхэн гарз хохирол амсана. Мэдлэгтэй байгаад сэтгэл зүйн хувьд түүнийг хэрэглээ болгох чадамжгүй, эсвэл хайхрамжгүй байдлаар хандах нь мөн л адил үр дүнд хүргэнэ.

Малчин хүний мэдлэг ухааны чадамж нь гэрчилгээ бүхий албан ёсны боловсрол, мэргэжлээс илүүтэй туршлагаар хуримтлагдсан мэдлэгээр тодорхойлогдох бөгөөд тодорхой нөхцөлд үйлдвэрлэлд учрах эрсдлийг бууруулах (малдаа тарга тэвээрэг авахуулах-нүүдэллэх, хашаа хороо бэлтгэх сэлбэх, өвс тэжээл, хужир мараа бэлтгэх, отор нүүдэл хийх г.м), тогтвортой байдлыг хангах (зориудаар шалгаруулах буюу сул доройг нь муулах, жилийн өнгөөс хамаарч тоо хэмжээг цөөлөх, эсвэл илүү төл бойжуулах г.м) арга ажиллагаа, туршлагаар дамжин хэрэгждэг. Эцсийн дүнд үр ашигтай байлгах, өгөөжийг нэмэгдүүлэх эсэх нь хувь хүний сэтгэл зүй (тэсвэр сайтай мал үржүүлэх, таваарлаг чанарыг нэмэгдүүлэх, анхдагч болон хоёрдогч түүхий эдийн ашиглалт, боловсруулалт)-н төлвөөр тодорхойлогдох бөгөөд нийгмийн ялгаа нь ч үүгээр тайлбарлагдах үндэстэй. Өөрөөр хэлбэл, малчдын ялгаатай байдал нь “тодорхой нөхцөлд тохирсон боломжийн харилцан үйлчлэлийн үр дүн” юм.

Нийтлэг тохиолдолд өгөгдсөн гурван зүйлийн аль нэг шинж давамгайлан хөгжсөн тохиолдолд онцгой чадвар гэж үнэлэгддэг бол эсрэг тохиолдолд эдгээрийн аль нэг шинж нь нормал түвшинд хүрч хөгжөөгүй юм уу, тодорхой нэг шинж нь эмгэг бүхий тохиолдолд эерэгээр үнэлэгдэх боломж нь хязгаарлагддаг. Доктор Д.Шомбодоны “... бэлчээр усны боломж, мал сүргийн биологийн чадавхийг харьцуулан тооцож үйлдвэрлэлийн нөөцөд бодитой үнэлэлт өгч, хамгийн оновчтой хувилбарыг сонгон

хэрэгжүүлэх замаар сүргээ өсгөж биологийн төгс чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг...” гэж малчин хүний үйлдвэрлэл нь нөхцөл хийгээд боломж (Шомбодон.Д, 1993, р. 45)-оос хамаардаг болохыг ийн тэмдэглэн хэлсэн байдаг. А.В.Чаянов тариалан эрхлэгчид “... бүтээгдэхүүний үнэ өсөх үед ч фермер ... үйлдвэрлэлээ бууруулах тохиолдол байх боломжтой” (Бакей.А, Хөдөө аж ахуйн эдийн засаг, 2014, р. 11) гэж тэмдэглэснийг үндэслэвэл МАА-н үйлдвэрлэлд байгаль, цаг уурын эрсдэл тохиогоогүй л бол тухайн цагийн бодлого, шийдвэр, эдийн засгийн өсөлт бууралт зохих нөлөө үзүүлэх боловч үйлдвэрлэл нь тогтвортой өсөн нэмэгдэх хандлагатай байдаг.

Харилцааны шинж нь аж үйлдвэржсэн нийгмийнхээс тэс өөр үйлчлэлээр нөхцөлдөж, хэлбэрждэг. Үйлдвэрлэлийн нөхцөл ба боломж гэх хоёр зүйлийн харилцан үйлчлэлийн үр дүнд хэлбэрждэг бөгөөд нөхцөл нь малчдаас нийгмийн харилцаанд хариуцлагын болон хяналтын механизмыг, боломж нь харилцан тэтгэх, дэмнэх харилцааг төлөвшүүлдэг. Үйлдвэрлэлийн үйл явц нь тодорхой субъект (түүхийн тодорхой үед эзэн, хамжлагын тухай асуудал байсан)-ээс илүүтэй байгалиас шууд хамааралтай, байгалийн нөөцийг тэнцвэртэй ашиглах хэрэгцээ нь малчид “хариуцлага ба хяналт”-ын механизмаар холбогдох үндсийг бүрдүүлдэг бол үйлдвэрлэлийн үйл явц дахь ажиллах хүрэлцээ боломж нь “тэтгэх, дэмнэх” харилцааг төлөвшүүлдэг.

Үйлдвэрлэлийн явцад хэлбэржин тогтсон харилцааны энэхүү онцлог шинж нь өөрийнхөө тохиолдолд хамгийн үр ашигтай хэлбэр гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Судлаач Д.Мөнхтөр “Нүүдэлчдийн эдийн засгийн үйл ажиллагаа нь бүхэлдээ задгай бэлчээрт, байгальтай шууд нүүрэлдсэн тийм орчинд явагддаг учир байгалийн хүчин зүйлс (жишээ нь, ган зуд гэх мэт) тэдний амьдралд гагцхүү дасан зохицохоос өөр аргагүй тийм тодорхойлогч нөлөөллийг үзүүлдэг. ... байгаль цаг уурын хүнд хүчир саадыг устгаж үгүй хийх замаар харин тэрхүү саад тоггороос хамгийн зөв байдлаар зугтан, эсхүл хүлээн зөвшөөрөөд даван туулахыг оролдох явдал юм” гэж үйлдвэрлэлийн явц дахь хувь хүний оролцоо, онцлогийг тодотгож, энэ шинж онцлогт тулгуурлан нийгмийн харилцааны онцлог тал шинжийг нь “бюрократ тогтолцооны дүрмүүдтэй холбогдох байдал сул”, “үл хайхрах, аргалах-дасан зохицох, зайлсхийх, даван гарах, зугтан зайлах”, “албан бус холбоо: төрлийн харилцаа, үүрэг, өгөө аваа” гэх ойлголтуудыг гарган тавьсан (Мөнхтөр.Д, Нүүдлийн соёлоос улбаатай Монголын

нийгмийн бүтцийн зарим онцлогийн тухайд, 2020, pp. 38-40). Эдгээрээс, албан бус холбоо, өгөө аваа гэх томъёололд мал аж ахуйн үйлдвэрлэл, түүний тогтвортой байдлыг хангахад чиглэсэн “хамжих, дэмжих” гэсэн санаа ямар нэг байдлаар агуулагдаж байгаа юм.

Үйлдвэрлэлийн онцлогийг илэрхийлсэн энэхүү суурь дэвсгэр дээр буюу үйлдвэрлэлийн онцлог, түүнээс хамаарах ялгаа, харилцааны төлөвшил, онцлогийг дээрх байдлаар дүрслэж, суурь нөхцлийг энэ дагуу шинжилж, ойлгож болохоор байна. Харин нийгмийн ялгаа, ялгарлын тухайд өмнө тэмдэглэсэнчлэн боломж нь социаль шинжүүдийн цогц бөгөөд ийм шинжүүдийн үйлчлэлээр малчид бүтэцжин ялгардаг. Малчдыг судалсан баримт, сонгодог болон орчин үеийн онолын сэтгэгчдийн үзэл хандлагад үндэслэвэл дараах таван бүлэг үзүүлэлтийг тодорхойллоо. Үүнд:

Нэг. Хүн ам зүй (нас, хүйс), нийгэм (гэр бүлийн хэв маяг, ам бүлийн тоо), туршлага-боловсрол, эрүүл мэндийн байдал зэрэг нь тэгш бус байдал, ялгааг тодорхойлох үзүүлэлтэд тооцогддог. Жишээлбэл, “... ам бүлээр цөөхөн, тэр бүр хүүхэд шуухаддаа дарагдан түүртдэггүй нь харагдсан.” (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, р. 101) гэж тэмдэглэсэнчлэн тодорхой судалгааны түвшинд амьжиргааны түвшин доогуур айл өрхүүд малын тоо хэмжээгээр цөөн атал ам бүлийн тоогоор олон, эсвэл гэр бүлийн өрөөсгөл, эсвэл нийлмэл шинж байдаг тухай тэмдэглэн үлдээсэн нь бий. Туршлага, мэдлэгийг Лукач, Грамши, С.Малле, А.Горц нар шалгуур болгон судалгааны ажилдаа тусгасан байсан бөгөөд МАА-н үйлдвэрлэлд өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдлаар илэрнэ.

Малчдын туршлагаар олж авсан мэдлэг (Дашням.Л, 2020, р. 31), цаашлаад ертөнцийг таних аргыг барууны эрдэмтдийн тэмдэглэдэгчлэн “баталгаажсан баримт”-аар гэрчлэн илэрхийлэх боломжгүй бөгөөд үйлдвэрлэлийн харилцааны явцад өөрөө хэлбэржин, хэрэгжиж, үр дүнгээ өгч байдаг. Магадгүй үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой шинжлэх ухаанд суурилсан мэдлэгийн орчин үеийн хэлбэр нь гол бус шинжтэй байж болно. Тухайлбал, Ус цаг уурын хүрээлэнгээс хийсэн судалгаанд “Судалгаагаар мянгат малчин эсвэл боломжийн чинээлэг амьдралтай айлын өрхийн тэргүүн нь нэгдлийн үед улсын, аймаг, сумын тэргүүний малчин байсан хүмүүс голдуу байлаа. Мөн ам бүл олуулаа, малаас гадна аймаг сумын төвд худалдаа наймаа эрхэлдэг (дэлгүүр, шатахуун түгээгүүр гэх мэт) эсвэл Улаанбаатар хотод зах зээлийн харилцагч

түнштэй байдаг зэрэг давуу талтай байна." (Ус цаг уурын хүрээлэн, 2005, р. 108) гэж туршлагаар өгөгдсөн мэдлэг илүү ач холбогдолтой болохыг илэрхийлсэн байдаг.

Шинжлэх ухааны мэдлэг нь мал аж ахуйн талбартаа ажиллаж, мэргэжил (эмч бол хамгийн тод жишээ)-ийн шинжтэй ажил хариуцсан үед ач холбогдолтой болж ирдэг. Тэгэхлээр эндээс нэгд мэргэжлийн шилжилт буюу оролт гаралт, хоёрт туршлагаар өгөгдсөн мэдлэг хийгээд шинжлэх ухаанд суурилсан мэдлэгийн ялгаралд үзүүлэх нөлөөллийг тодруулах хэрэгцээ харагдана.

Хоёр. Өмчийн хувьд мөн онцлог шинжтэй бөгөөд хэрэглэж буй эд зүйлс, тэр бүү хэл хоол хүнс нь (ХНХЯ, ХНХСИ, 2018, pp. 84-85) бэлчээр даган амьдрахад зохицсон байдаг. Малчдын өмч, хөрөнгийг уламжлалт (гаанс, хөөрөг, эмээл, үнэт эдлэл, удам сайтай мал г.м), орчин үеийн (ахуйн болон хөдөлмөр хөнгөвчлөх цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, газар, компани аж ахуйн нэгж, байр сууц г.м), үл хөдлөх (үнэт эдлэл, өвөлжөө хаваржаа, сууц, хадгаламж г.м) ба хөдлөх хөрөнгө (мал, машин унаа, зөөврийн сууц г.м) гэж ангилж болох бөгөөд эдгээр нь М.Веберийн өмч, Э.Гидденсийн баялаг, орлого, Эрик Олан Райтын мөнгө, биет капитал ойлголттой дүйх юм. Нийгэм-соёлын антропологийн талаас хөрөнгө (capital), баялаг (wealth) гэх ойлголтыг ялган тэмдэглэж, мал маллах гэдэг нь давхар хөрөнгөө хамгаалах гэсэн утгыг илэрхийлдэг (Bumochir Dulam, Byambabaatar Ichinkhorloo, Ariell Ahearn, Nov 2020, p. 186) гэж тэмдэглэсэн байдаг. Нийгмийн талаас хөдлөх шинжтэй хөрөнгө нь өмчийн бусад зүйлсийг тодорхойлох шинжтэй (Bumochir Dulam, Byambabaatar Ichinkhorloo, Ariell Ahearn, Nov 2020, p. 195) байдгаараа сонгодог онолын төлөөлөгчдийн тодорхойлдогос ялгарна. Иймд малын тоо, сүргийн бүтцийг харгалзан өмчийн бусад хэлбэрээр хэрхэн ялгарч байгааг тодруулна. Тодруулбал,

Малын тоо толгой буюу бодитой хэмжигдэхүйц үр дүнгээр малчдын ялгааг илэрхийлэх нь социологийн ерөнхий онолын зарчим (ШУА-ийн ФСЭХ, 2008), арга зүйд нийцэх боловч аргачлалын хувьд нийт малын зах зээлийн үнэлгээг тооцох байдлаар өмчийг үнэлэх, олж буй орлого нь тогтвортой бус (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, р. 115) тул боломжтой бол дансны гүйлгээг шинжлэх байдлаар орлогын хэмжээ, зарцуулалт, зориулалтыг нь тодорхойлж, ойлгох боломж бас бий. Ийн тодорхойлоод Монгол улсын хүн амын орлогын дундажтай харьцуулан үнэлэх нь үр дүнтэй, найдвартай аргачлал гэж үзэх боломжтой. Тодорхой

судалгааны түвшинд жилийн орлогыг тодорхойлж, саруудад хуваах байдлаар тооцдог жишиг тогтсон (ХНХЯ, ХНХСИ, 2018, р. 24).

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар түүнээс хүртэх өгөөж нэмэгдэх ч сүргийн бүтэц, үүнд мөн байгалийн шууд хүчин зүйл ихээхэн нөлөөтэй. Малчдын амьдрал, амьжиргааны түвшин нь зах зээлд ямар төрлийн бүтээгдэхүүн зарж борлуулахаас ихээхэн хамаардаг онцлогтой. МАА дагнасан үйлдвэрлэлд, малын төрөл зүйл бүрээс тэдгээрээс гарах бүтээгдэхүүний төрөл, хэмжээ, зах зээл дэх эрэлт, бүтээгдэхүүний үнэт чанар (хар ямааны бэлдмэл, саам г.м-ээр өөр бусад зүйлсийг судлах ажил маш хангалтгүй) харилцан адилгүй. Малын үүлдэр, угсаа чухал нөлөөтэй бөгөөд үүрэгтэй. Гагцхүү малын гаралтай түүхий эдийн ашиглалт, боловсруулалтад анхаарч экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүн түгээх, цаашлаад гадаад зах зээлд нийлүүлж чадаж байна уу, малчдад өгөөж нь хүрч байна уу, өрхийн орлогод хэдий хэмжээний жин дарж байна вэ? гэдэг нь асуулт юм.

“Малчин өрхийн жилийн мөнгөн орлого өрхийн малын тоо, чанар, үүлдэр угсаанаас гадна тухайн жилийн байгаль цаг агаарын нөхцөл, өвс ургамлын гарцаас ихээхэн шалтгаална. Тухайлбал, сүүлийн хэдэн жил цаг агаар харьцангуй сайн байсан аймагт хонь, ямаа, үхэр сүргээс олох орлого бусад аймгаас харьцангуй илүү...” (Пүрэв.Ц, Хөдөөгийн өрхийн хэрэглээ, аж байдлын үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт, 2006, р. 162). М.Г.Торновский "Монголчуудын эд баялаг, сайн сайхан аж ахуй нь малаасаа, ялангуяа үхрээс хамаарна. ... Хэрвээ мал сүргийнх нь нийт тоо толгойг хангинах зоосонд шилжүүлэх юм бол (нас гүйцсэн бухыг 15 алтан рубль, хонийг 2-3 рублиэр тооцоод) үхэр, хонины нийт үнэ 45 сая алтан рубльд хүрч, нэг хүнд ердөө л 45 алтан рубль ногдоно." (Торновский.М.Г, 2009, р. 26) гэж тэмдэглэсэн байдаг. Тэгэхлээр сүргийн бүтэц нь малчдын ялгааг тодорхойлох нэг хэмжүүр болох юм. Ашигт чанар, өгөөжийг нь нэмэгдүүлэх нь зах зээлийн зарчимд нийцэх боловч сүргийн бүтцийг бодлогын түвшинд зохицуулахгүйгээр мал аж ахуйн үйлдвэрлэл өөрөө уналтад орж болзошгүй нөхцөлд орсон байх талтай байгаа юм.

Гурав. Өмч захиран зарцуулах эрх хэмжээгээр малчид өөр хоорондоо ялгарч, бүтэцжих болсон юм. Өдгөө уг шинжээр туслах, хөлсний, гэрээт, хамжлагын шинжтэй хэв маяг бодитой оршиж (ШУА-ийн ФХ, 2018, р. 76; ХНХЯ, ХНХСИ, 2018, pp. 51-53), “өмч захиран зарцуулах эрх хэмжээ”-тэй холбоотой илэрч, албажсан хөдөлмөрийн

харилцааны шинжтэй болох (Засгийн газар. Тогтоол №34., 2020) чиг рүү орж байгаа юм. Л.Гумпловичийн хөдөлмөрийн шинж чанар, Г.Шмолер (мэргэжил, хөдөлмөрийн үйл ажиллагаа, өмч, боловсрол, улс төрийн эрх, сэтгэл зүйн байдал, арьс өнгө г.м), Р.Дарендорф, В.Зомбарт, Р.Вормс (ажил мэргэжлийн статус) нарын ойлголтод хамааруулж болно. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос албан ёсны статистик мэдээлэл гаргах болсон бөгөөд “2017 оны байдлаар нийт малчдын 4.5 хувийг нь туслах малчид” (ҮСХ, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, 2017, р. 34) эзлэж байсан бол 2019 онд 285.482 малчин тоологдсоны 5.3 хувь нь буюу 15.2 мянга нь туслах малчин гэжээ. Туслах малчдын эзлэх хэмжээ сүүлийн хоёр жилийн хугацаанд 15 орчим хувиар өссөн зэрэг нь малчид илэрхий ялгарч, тэдгээрийн онцлог хэв маягийг тодруулан судлах хэрэгцээтэйг харуулж байна. Ийм хэв маяг дүр зургийг зөвхөн туслах малчин гэх ойлголтоор илэрхийлэх нь өрөөсгөл бөгөөд тохироо, зорилго зэргээр ялгаатай өөр хэв маягуудыг тодруулах хэрэгцээ, шаардлага бий. Тухайлбал, хөлсний малчид гэх хэв маяг бий. Ийм төрлийн малчид малын эзэд (суурин амьдралтай мал бүхий өрх)-ээс цалин авч малыг нь ганцаар юм уу, өрхөөрөө хариулдаг байх жишээний.

Дөрөв. Малчдын орлогын хэмжээ, бүтэц, орлого олох давтамж суурин амьдрал бүхий иргэдээс ихээхэн ялгаатай. Социологийн төлөөлөгчдөөс Э.Гидденс, К.Дэвис, У.Мур, Г.Шмоллер нарын орлогын хэмжээг шалгуур болгон шинжилсэн. Малчдын хувьд орлогын бүтцэд МАА-н орлого дийлэнх хэсгийг бүрдүүлэх (Бүрэнжаргал.Т, 2001, р. 62; Баасантогтох.О, Хот, хөдөөгийн тэгш бус байдал бүс нутгийн ялгаа, 2019, р. 193) боловч цалин ба МАА, тэтгэмж ба МАА, үйлдвэрлэл, үйлчилгээ ба МАА-аас, эсвэл эдгээрийн аль алинаас өрхийн орлого нь бүрддэг өрх олон. Засгийн газраас 1997 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 487 дугаар тогтоол болон Монгол улсын эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар «"... хувиараа хөдөлмөр эрхлэгч малчин" гэдэгт төр, олон нийт, хувийн хэвшлийн байгууллагад аливаа гэрээ, томилолт, сонгуулийн үндсэн дээр байнгын ажил эрхэлж, цалин хөлс авдаггүй, зөвхөн өөрийн өмчлөлийн малыг байнга маллаж олдог ашиг орлогоороо амьдардаг, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаггүй иргэдийг хамруулан ойлгоно. Харин бусдын өмчлөлийн малыг аливаа гэрээний үндсэн дээр маллаж, цалин хөлс авч амьдардаг иргэд хувиараа хөдөлмөр эрхлэгч малчин гэсэн ойлголтод хамаарахгүй.» (Бат-Эрдэнэ.Ц, 2004, р. 16) гэж албан ёсоор ангилсан.

Малчдын ихэнх нь МАА-аас орлого залгуулдаг бөгөөд орлого нь тогтмол бус буюу улирлын шинжтэй, цаг үеийн хэрэгцээгээр тодорхойлогддог онцлогтой ба малын тоо хэмжээ, сүргийн бүтэц зохих үүрэг гүйцэтгэдэг. Нөхцөл байдлаас хамааран мал нь төлбөрийн хэрэгсэл (ШУА-ийн ФСЭХ, 2001, р. 144) болох нь ч бий.

Орлогын эх үүсвэр малын түүхий эд, түүнийг зарж борлуулсны орлого хэр хэмжээнд байгаа, түүний байж болох үнэ цэнийг тодорхойлох нь энэ ажлын хүрээнд хийх шинжилгээний орхигдуулж болохгүй хэсэг юм. Үйлдвэрлэл эрхлэхэд нарийн нандин хийцтэй, өндөр үнэ бүхий технологи шаарддаггүй бөгөөд үйлдвэрлэл эрхлэх арга зарим талаар өөрчлөгдсөн ч хэрэглэх зүйл хэвэндээ шахуу байгаа нь илүү зардал гаргахгүйгээр шахам үйлдвэрлэлийн өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой (Эрдэнэцог.Н, 1998, р. 45).

Түүхий эд боловсруулах арга, аргачлал нь бүсүүдэд (Пүрэв.Ц, Хөдөөгийн өрхийн хэрэглээ, аж байдлын үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт, 2006, р. 161), тэр байтугай аймгуудад өөр өөр байх нь бий. Гол нь малын гаралтай түүхий эдийг байгалийн гаралтай зүйлс ашиглан боловсруулж, энгийн бөгөөд олон төрөл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Энэхүү туйлын ашиг шимт чанарыг нь “Шинжлэх ухаан яаж ч хөгжсөн бэлчээрийн малын мах, сүүг чанар, амин дэмийн хувьд орлох бүтээгдэхүүн гаргана гэдэгт эргэлзнэм” (Батхишиг.Б, 2018, р. 181) гэж үнэлэн дүгнэсэн ч хэрхэн үнэд хүргэж байгаа нь чамлалттай. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO, 2002, р. 5)-аас хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр ийм бодлого баримтлаж байгаа нь Монголын МАА-н үйлдвэрлэлд бүрэн нийцнэ.

Угтаа түүхий эд бүрийг эцсийн бүтээгдэхүүн байдлаар боловсруулах нь малчдын амьдрал амьжиргаанд шууд үр өгөөжөө өгөх үндэстэй. Бүтээгдхүүнийг зах зээлд нийлүүлэх өнөөгийн дүр зураг бол үйлдвэрлэл эрхлэх аргаас үл хамаарах шинжтэй шахуу их хөлийн газрын ойр нэгэнт бэлэн болсон (Дашпүрэв.О, 2017, рр. 34-35) түүхий эд, бүтээгдэхүүнийг зарж борлуулах төдийгөөр л хязгаарлагддаг.

ШУА-ийн Философийн хүрээлэнгээс гаргасан “Монголын хөдөөгийн амьдралын хэв маягийн өөрчлөлт (XXI зууны эхэнд)” сэдэвт хамтын бүтээл (ШУА-ийн ФХ, 2018)-д дурдан буй шалгуураар хөдөөгийн иргэдийн ялгарлыг шинжлэн гаргасан. Сүүлийн жилүүдэд харамсалтай зүйл ажиглагдах болсон нь зах зээлийн нийгэмд шилжснээс бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тодорхой хэсэг үнэлэгдэхээ байж, орхигдох шинжтэй

болсон. Тухайлбал, “хонь ямааг саах явдал ихэнх нутагт ховордож байгаа нь бог малын сүү цагаан идээний ашиглалт хэмжээг бууруулахад хүргэж байна.” (Пүрэв.Ц, Хөдөөгийн өрхийн хэрэглээ, аж байдлын үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт, 2006, р. 161) гэснийг анхаарах буюу бүтээгдэхүүн боловсруулалтын дүр зураг, түүнээс өрхийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг тооцон гаргах нь мөн судалгааны үзэл санаа, арга зүй, шалгуур үзүүлэлт болохын хувьд чухал боловч яг бодит үнэ цэн, үр өгөөж нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түвшнийг нэмэгдүүлэх, цаашлаад малчдын амьжиргаанд дэмжлэг үзүүлэх боломж хэрэгцээгээр тодорхойлогдоно.

Тав. Үйлдвэрлэлийн явц дахь хөдөлмөр, үйлдвэрлэл эрхлэх арга хэлбэрээр, мөн суурьшлын хувьд зах зээлд хэр ойр байрлаж байгаагаас хамаарч малчид өөр хоорондоо ялгарч байна. Илэрхийлэн тэмдэглэсэн ойлголтын хувьд зарим нэг ялгаа байх боловч судлаачид энэ шинж байдлыг харгалзан судалсан нь цөөнгүй. Тухайлбал, “... бэлчээр ашиглах аргын хувьд суурьшилтай (энэ тохиолдолд бэлчээр ашиглах тухай ярих нь алдаатай гаргалгаа болно О.Б), хагас суурьшилтай, нүүдлээр бэлчээр ашиглах ...” (Мягмаржав.Б, 2006, р. 42; Ганболд.И, 2013, pp. 1-2) ангилал үүсгэсэн нь бий. Х.Ньюби фермерүүдийг судалсан тохиолдлоос нүүдлийн болон хагас суурин хэлбэрүүд зэрэгцэн оршиж байгаагаараа онцлогтой.

Малчдын ялгарлыг тодорхойлоход үйлдвэрлэлийн хийгээд суурьшлын байдлыг харгалзан үзэх нь зайлшгүй бөгөөд социаль талаас доктор Ц.Пүрэв “... Хөвсгөл, Баянхонгор, Ховд аймагт сүү цагаан идээ хийх, зарах харин Улаанбаатарт мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг арай өндөр үнээр борлуулах боломжтой байх зэрэг бүс нутгаас хамаарах онцлогууд бас байлаа. Төв суурин газар, төв замын ойролцоох айлууд сүү цагаан идээгээ зарж борлуулах нь элбэг байхад төвлөрсөн газраас зайтай айлууд голдуу өрхийн болон хамаатан садныхаа хүнсэнд хэрэглэх нь их. ...1000 давсан малтай малчин өрхүүд гэсэн хагас суурин (малтай өрх болно О.Б), суурин, нүүдлийн амьдралын хэв маяг бүхий чинээлэг айл өрхүүд бий болов” (Пүрэв.Ц, Хөдөөгийн өрхийн хэрэглээ, аж байдлын үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт, 2006, pp. 161, 166) нэг талаас бүс нутгийн ялгаатай байдлыг, нөгөө талаас социаль ялгаралд хэрхэн нөлөөлж буйг тэмдэглэсэн хэрэг. Төв суурин, суурьшлын төвөөс зайтай айл, өрхүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зориулалт, түүний үр ашиг ч ялгаатай болох нь үүнээс харагдана.

Онолын талаас сонгодог болон орчин үеийн онолуудад дурдан буй шалгуур үзүүлэлтүүдийг ямар нэг байдлаар ашиглаж нийгмийн бүтэц, давхрааг судлахдаа ашиглаж байсан. Арга зүйн хувьд нэгд үйлдвэрлэлийн онцлог (нөхцөл, боломж)-ийг харгалзан, хоёрт дурдан буй таван бүлэг шалгуур үзүүлэлтээр малчдын ялгарч буй дүр зургийг бүтцийн хандлагаар дараах байдлаар тодрууллаа.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1. Судлагдсан байдлын тойм

Мал аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан соёл, түүнтэй холбогдох судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг IX, дундад зуунаас XVII зуун, XVII эхнээс, XX-XXI гэж хамаарах хугацааг нэлээд бүрхэг байдлаар ангилсан (Энхтүвшин.Б, 2014, pp. 131-132) ч нийгэм, хүмүүнлэгийн талаас уламжлалт харилцааны онцлог, нийгмийн бүтэц, дүр зургийг судлахад чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эхлэл үечлэлийн дөрөв дэх үе буюу социалист нийгэм байгуулах эхэн үеэс суурь нь тавигдсан гэж үзэх үндэстэй. Судалгааны ажил түүх-соёлын, нийгмийн бүтцийн гэсэн үндсэн чиглэлд үргэлжилж, дотоодын болон гадаадын эрдэмтэд судалжээ.

Малчдын нийгмийн асуудлаар хийсэн судалгааны ажлын хүрээ, заагийг социологийн шинжлэх ухааны хандлагаар судалж эхэлсэн^{8,9} үетэй холбогдуулан 1970-аад оны эх хүртэл буюу түүхэн болон статистик баримтад үндэслэсэн, 1970-1990-ээд он буюу нэг хэмжээст буюу марксист социологийн хандлагаар, 1990 оноос хойш буюу олон хэмжээст онол, арга зүйгээр судалж эхэлсэн үе гэж гурван түвшинд ангилж судлагдсан байдлыг тоймлолоо. Ийн үечилснээр малчдыг судалсан сэдэв, агуулга (гэрлэлт, гэр бүл, хөдөлмөр, харилцаа, соёл, боловсрол, ёс суртахуун, ертөнцийг үзэх үзэл г.м), онол үзэл баримтлал (нэг болон олон хэмжээст), ашигласан арга зүй, аргачлал (дүрслэл, тайлбарлалын буюу түүхчлэх, бүртгэл мэдээлэлд үндэслэсэн, социаль г.м), хэн судалсан (монгол болон монголч эрдэмтэд) дүр зураг, өөрчлөлтийг харж болно.

Цэвэр социаль аспектаар хэрхэн судалсан бэ гэж хүрээг нь хумих нь хувь судлаачид хялбар боловч шинжлэх ухааны бусад салбарт малчдыг гол судлагдахуун болгон үзсэн байх нь элбэг тул тэдгээрийг орхигдуулж болохгүй. Ялангуяа, 1970-аад оныг хүртэл ийм байдлаар судлаж ирсэн. Олон шинжлэх ухаан (мал аж ахуйн

⁸ Батын Самбуу ШУА-ийн ФСЭХ-ийн анхны ажилтан бөгөөд ШУА-ийн Ерөнхийлөгчийн 1968 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 211 тоот тушаалаар эрдэм шинжилгээний ажилтнаар томилогдож ШУА-ийн Ерөнхийлөгчийн 1969 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн №23 тушаал гарч Сэлэнгэ аймагт томилолтоор ажиллаж, хөдөөгийн иргэдийн дунд анхны социологийн судалгааг хийж байжээ (Лувсанцэрэн.Г, Жамбал.А, 2011, pp. 189, 192, 226, 227).

⁹ Социологийн сектор 1972 оны 7 дугаар сард секторын эрхлэгч Х.Нямбуу (дараа нь шинжлэх ухааны доктор, профессор, төрийн шагналт болсон) эрдэм шинжилгээний ажилтан Б.Самбуу, Ц.Төрбилэг нарын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхэлжээ (Уртнасан.Ц, Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ, 2017, р. 10).

үйлдвэрлэл, статистик, философи, эдийн засаг, түүх, антропологи, маркетинг, менежмент, бодлого судлал г.м)-ы аспектаар судалсан баримтуудыг ашиглаж, судалгааны талбарыг өргөн хүрээнд авч үзсэнээр сэдвээ онохгүй төөрөлдөх, гол зүйлийг гол бусаас ялгахгүй байх зэрэг алдаа гаргах магадлалтай ч “малчдын ялгарал”-д нөлөөлөгч суурь хүчин зүйлс буюу үйлдвэрлэлийн онцлог, харилцааны уламжлал, нийгмийн ялгарал, түүний уг шалтгааны талаар шинжлэх бусад салбар, чиглэлүүдэд тэмдэглэсэн баримт олон тул анхааран судлах зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл, бусад салбарт хийсэн судалгааны ажлууд зохих түвшинд сэдвийн судлагдсан байдалд хамаарах бөгөөд зорин буй үр дүн, таамаглалыг шалгахад чухал ач холбогдолтой. Баримтын хүрээг ийн өргөн тогтоосноор түүхийн тодорхой үеийн талаарх баримтыг хожуу өөр хандлага, баримтаар тайлбарлах, гажуудуулах явдал түгээмэл гардаг учир ийм тохиолдолд баримтыг тухайн цаг хугацаанд нь хамааруулан ойлгож хэрэглэх боломж олгох давуу талыг олгоно.

Нэг. Түүх, соёлын талаас нэг Монголын нийгмийг С.А.Плетнева (1926-2008), Г.Е.Марков (1923-2018) нар “төр байгуулаагүй”, хоёр С.И.Вайнштейн (1926-2008), Ю.И.Семенов (1929-) нар “өвөрмөц онцлог бүхий төр”, гурав Н.Я.Данилевский (1822-1885), А.Ж.Тойнби (1889-1975), В.В.Бартольд (1869-1930), Г.А.Давыдов (1931-2000) “ангийн болон нийгмийн ялгарал бодитой байсан” тухай хандлага, байр суурийг баримтлан судлаж байв (Железняков.А.С). Нийгмийн байгуулал, бүтцийн талаас Б.Я.Владимирцов (1884-1931) "Монголын нийгмийн байгуулал. Монголын нүүдлийн феодализм" бүтээлээ гаргасан нь энэ чиглэлээр хийсэн анхны томоохон судалгаанд тооцогддог. Мөн Л.Н.Гумилев (1912-1992), Н.Ц.Мнгуев нараас гадна И.Майский (1884-1975)-н судалгааны ажлыг найдвартай баримт, эх сурвалжид тооцдог. Монголын эрдэмтдээс Ш.Нацагдорж (1918-2001), Д.Гонгор (1924-1976), Н.Ишжамц, Ч.Далай (1929-2009) нар (Эрдэнэбат.Д, 2003, р. 3)-ын эрдэм шинжилгээний, судалгааны ажил зүй ёсоор орно.

Түүхэн болон статистик баримтад үндэслэн тодорхой шинжлэх ухааны арга зүй, аргачлалаар судалж эхэлсэн үе нь оросын аялагч, судлаач И.Майскийтай холбогдох бөгөөд эзэмшиж буй өмч буюу малын тоо толгой, өрхийн орлогын хэмжээ, бүтцийг үндэслэн нийгмийн бүлгүүдийн ялгааг тодорхойлсон (Майский.И, 2001, pp. 145-146, 181). Тухайн үед нийт монголчуудын хувьд мал бараг дангаар нийгмийн гол өмчид

тооцогдож байсан учир малын тоог шалгуур болгон нийгмийн бүлгүүдийн ялгааг гаргасан гэж үзэж болно. Үүнээс хойш ялангуяа, монголын түүх, мал аж ахуйн чиглэлээр судалж, туурвиж асан түүхч Ш.Нацагдорж (Нацагдорж.Ш, Монголын феодализмын үндсэн замнал, 1978, pp. 289-290), С.Идшинноров (Идшинноров.С, 2013, pp. 58-74), төр нийгмийн зүтгэлтэн С.Данаажав (Данаажав.С, 1981), Н.Жагварал (НСИСОУХ, 2017, р. 40) зэрэг эрдэмтэн, судлаачид, ШУА-ийн Түүхийн хүрээлэн (ШУА-ийн Түүхийн хүрээлэн, ШУА-ийн ФСЭХ, 1984, pp. 57-58)-ээс хэвлүүлсэн бүтээлүүдэд энэ хандлага, шалгуурыг түлхүү ашиглаж байв.

Зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш мөн Ц.Бат-Эрдэнэ (Бат-Эрдэнэ.Ц, 2004, р. 23), Б.Сэмбээжав (Сэмбээжав.Б, Өрхийн тэргүүнээс фермер, фермерээс биофермерт хүрэх замд-II, 2008, р. 38), Б.Сумъяа (Сумъяа.Б, 2005, pp. 53-54), П.Юнгэр (Юнгэр.Д, 2003, р. 57), А.Бакей (Бакей.А, Хөдөө аж ахуйн эдийн засаг, 2014, р. 220) зэрэг судлаач эрдэмтэд малын тоо хэмжээг баримжаалан шалгуур болгож малчдын бүтэц, ялгааг тодорхойлон судалжээ. Гадаадын эрдэмтдээс В.В.Грайворонский (Грайворонский.В.В, 1997), Г.С.Яскина (Яскина.Г.С, 1998) зэрэг эрдэмтэн судлаачид өрхийн орлого зарлага, малын тоо хэмжээг үндэслэн малчдын ялгааг мөн гаргасан. Үүний зэрэгцээ антропологи (Bumochir.D, 2020; Bumochir Dulam, Byambabaatar Ichinkhorloo, Ariell Ahearn, Nov 2020; Мөнх-Эрдэнэ.Г, 2021; Daniel J.Murphy, 2011; Joshua Wright, Cheryl Makarewicz; Azjargal Jargalsaikhan and et al., 2015), экологи (Tserennadmid Mijiddorj, Ariell Ahearn, Charudutt Mishra, Bazartseren Boldgiv , 2019; Sergey Bazha and et al., 2012; Taylor, 2015; Banzragch Nandintsetseg and et al., 2021)-н судалгааны ажлуудад малчид хийгээд уламжлалт соёл, түүний өөрчлөлтийн талаар судлан буй сэдэвтэй холбогдол бүхий чухал санаа, баримтуудыг гаргаж тавьсан.

Хоёр. Социологийн шинжлэх ухааны хандлагаар судалж эхэлснээс хойш малчдын социаль бүтэц, ялгаа, заагийг тодорхойлохдоо малын тоо толгойн хэмжээг шалгуур болгохоос гадна хүн ам зүй, нийгэм, эдийн засаг, соёлын г.м социаль хүчин зүйлүүдийн нөлөө, тэдгээрийн уялдаа холбоог илүү гүнзгийрүүлж, нарийвчлан судлах болсон. Малчид, уламжлалт нийгмийн харилцааны асуудлаар эхэн үед ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэмтэд дангаар, зарим тохиолдолд бусад хүрээлэн төвүүдтэй хамтран, зах зээлийн нийгэмд шилжсэний дараагаас олон улсын болон

дотоодын хөрөнгө оруулалт, санхүүжилтээр их дээд сургууль, бие даасан судалгааны төв, хамтлагууд олон судалгааны ажил гүйцэтгэсэн юм.

Нийгмийн ялгарлыг социаль хандлагаар судалж эхэлсэн үеийг үндсэндээ 1969 оноос эхлэн тооцож болох бөгөөд анхны судалгааг ШУА-ийн Ерөнхийлөгчийн 1969 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн №23 тушаалын дагуу одоогийн Философийн хүрээлэнгийн анхны ажилтан Б.Самбуу (Лувсанцэрэн.Г, Жамбал.А, 2011, pp. 189, 192, 226, 227) Сэлэнгэ аймагт томилолтоор ажиллаж, хөдөөгийн иргэдийн дунд хийсэн бол анхны томоохон судалгааг ШУА-ийн Философи, эрхийн тасгийн судлаачид Польшийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай хамтран 1971 оны 8 дугаар сарын 7-17 залуу малчдын дунд, 1973 оноос (ШУА-ийн Түүхийн хүрээлэн, 2012, p. 250) энэ судалгааг илүү өргөн хүрээнд хийсэн. Судалгааны ажилд малчин залуучуудын төлөөлөл болох 300 орчим залууг (Самбуу.Б, 1982, pp. 100-101) хамруулсан байдаг. Үүний дараа 1977 онд 400 малчдын дунд (Төрбилэг.Ц, 1980, p. 78), 1978-1979 онд 1100 орчим малчдыг (Дагвадаш.Ц, Малчдын хөдөлмөрт хандах харилцааны түвшинг тодорхойлох асуудал, 1982, p. 76), 1981 онд Эдийн засгийн хүрээлэнтэй хамтран мянгаад илгээлтийн эзэн залуу малчид болон мал аж ахуй дээр ажиллаж байгаад шилжин явсан зарим хүмүүс, мал аж ахуйн үйлдвэрлэлийн удирдах ажилтан, ахмад туршлагатай малчдыг хамарсан судалгаа (Дагвадаш.Ц Э. , 1987, p. 52) хийсэн. Хавсарга байдлаар 1983-1984 оны хооронд сэхээтний дүр төрхийг тодорхойлохоор 8 аймгийн 1200 гаруй орчим сэхээтнийг (ШУА-ийн ФСЭХ, 1987, p. 4) судалгаанд хамруулсны дотор малчид, хоршоологчдын төлөөлөл хамрагдсан байдаг. Өрнөд нутгийн аж төрөх ёсны судалгааг 1984-1985 онд¹⁰ хийж үр дүнг хэвлүүлсэн. МХЗЭ-ийн Төв хорооноос илгээлтийн эзэн 13 мянган залуу малчныг хамарсан социологийн судалгаа хийж тодорхой санал боловсруулсан (Мөнхжаргал.Я, 1984, p. 77) тухай мөн тэмдэглэсэн. Социализмын үед малчдыг шууд болон дам байдлаар судалсан эдгээр судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд үндэслэн цөөнгүй эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлж, тэдгээрийн үр дүнг бодлого хөтөлбөр боловсруулахад зохих ёсоор ашиглаж байсныг тэмдэглэх нь зүйтэй (ШУА-ийн ФСЭХ, Ховд дахь УБДС, 1989, p. 156).

¹⁰ Тайлбар: тус бүтээлийн 6 дахь талд “1984-1987 онд ... өрнөд мужид хамаарагддаг аймгуудад социологийн судалгаа хийж” гэж, 14 дэх талд “1984-1986 онд өрнөд мужид явуулсан социологийн судалгааны материалыг өргөн ашигласан” гэж судалгаа хийсэн хугацааг зөрүүтэй тэмдэглэсэн учир судалгааны анхдагч мэдээлэл цуглуулсан хугацааг энэхүү судалгааг албан ёсоор хийсэн гэж үзсэн болно. (ШУА-ийн ФСЭХ, Ховд дахь УБДС, 1989, p. 6)

Судалгааны ажлын үр дүнд ШУА-ийн ФСЭХ-ээс “БНМАУ-д социалист аж төрөх ёс төлөвшин хөгжиж буй асуудал” (ФСЭХ, 1982), “Өнөөгийн монголын ажилчин анги, хоршоолсон малчдын нийгмийн зарим асуудал” (Ред: Нямбуу.Х, Дагвадаш.Ц, 1985), Түүхийн хүрээлэнгээс “БНМАУ-ын социалист хөдөө аж ахуйн түүхийн зарим асуудал” (Түүхийн хүрээлэн, 1976), ФСЭХ, Түүхийн хүрээлэнгээс хамтран “Бүгд найрамдах Монгол ард улсын нийгмийн бүтэц (Түүх, социологийн судалгаа)” (ФСЭХ, Түүхийн хүрээлэн, 1984), ФСЭХ, Ховд дахь УБДС-иас хамтран “Монголын өрнөд нутгийн хүн амын аж төрөх ёсны хөгжил” (ШУА-ийн ФСЭХ, Ховд дахь УБДС, 1989) зэрэг томоохон эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн бөгөөд тэдгээрт малчдын нийгмийн бүтэц, ялгааг тодруулан судалжээ. Мөн Ц.Төрбилэг (Төрбилэг.Ц, 1980), Ц.Дагвадаш (Дагвадаш.Ц, Малчдын хөдөлмөрт хандах харилцааны түвшинг тодорхойлох асуудалд, 1982), Ү.Нямдорж (Нямдорж.Ү, 1985), С.Дашдаваа (Дашдаваа.С, 1989), Я.Мөнхжаргал (Мөнхжаргал.Я П. , 1989), Х.Гүндсамбуу (Гүндсамбуу.Х, Малчин залуучуудын нийгмийн дүр төрх, 1984) зэрэг судлаач, эрдэмтэд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлжээ.

Онолын хувьд социологийн шинжлэх ухааны суурь тавигдаж зах зээлийн нийгэмд шилжих үеийг хүртэл марксист хандлага (нэг хэмжээст)-ыг удирдлага болгон судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэж байв. Сэдэв, агуулгын хувьд нийтлэг байдлаар малчдын хэрэглээ, материаллаг хангамж, хэрэгцээ, орлого, зарлагын харьцаа, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг, оюуны болон материаллаг, соёлын хэрэгцээ, хувь хүний үзэл хандлага, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмж, сэтгэл ханамж, чөлөөт цаг, гэр бүлийн харилцаа, үйлчилгээний хүртээмж, үнэлэмж, хандлага зэрэг олон талын асуудлыг хөндөж байсан. Арга зүйн хувьд газар нутгийн бүсчлэл, байгаль цаг уурын онцлог, ястан үндэстний бүтцийг харгалзан үзэх (ШУА-ийн ФСЭХ, 1982, р. 22) нь малчдын нийгэм, эдийн соёл, үнэлэмж, баримжаалал, хандлага, цаашлаад уламжлалт харилцааг уг үндсээр нь илрүүлэн ойлгоход чухал санаануудыг тэмдэглэсэн нь ихээхэн ач холбогдолтой юм.

Социализмын үед үзэл сурталын нөлөө их байсан ч малчид дотооддоо ихээхэн ялгарч, тэгш бус байдал илэрч байсныг эрдэмтэн, судлаачид тэмдэглэн үлдээжээ. Доктор Х.Гүндсамбуу “Биеийн хөдөлмөр давуутай эрхэлдэг нэгдэлчид нь (нийт нэгдэлч малчдын 30 гаруй хувь буюу 40 шахам мянган хүн болно); чөлөөт хэм бүхий нарийн гар

хөдөлмөрт мэргэшсэн ажиллагчид, мөн хөдөлмөрт мэргэшиж яваа болон мэргэжлийн бэлтгэл үл шаардах гар хөдөлмөр эрхлэгчид (60 гаруй хувийг эзлэнэ); механикжсан ба машин механизм ашигласан хөдөлмөр эрхлэгчид гэсэн гурван дэд бүлэг үүсгэх ажээ (7 орчим хувь).”, “Оюуны хөдөлмөр давуутай эрхэлдэг нэгдэлчид нь: захиргаа-удирдлагын ажилтан (3.0 мянга гаруйхан), мэргэжилтэн (4.3 мянга), албан хаагчид гэсэн 3 бичил бүлгийг үүсгэж байна.” (Гүндсамбуу.Х, Өнөөгийн нэгдэлчдийн доторхи нийгэм мэргэжлийн бүлгүүдийг тодорхойлох асуудалд, 1982, pp. 93-96), амьжиргааны түвшний хувьд "... тэгшитгэлийн хуваарилалтын дунд давхраа, мөн харьцангуй ядуурлын илэрхийлэл болсон далд ядуучуудын давхраа өргөжин тэлж байлаа. ... хоршоолсон ардын дотор орлогын буюу эдийн засгийн давхраажил бүдэгхэн ч, мэргэжил-мэргэжлийн ялгарал мэдэгдэм тодорч, давхраа, бүлгүүд үүсгэсэн гэж хэлж болно." (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, p. 103), "... говь хангайн бүсийн ялгаагаар 50-75 толгойгоос илүү малтай байхыг зөвшөөрдөггүй байв. ... 1977-1978 онд бидний явуулсан социологийн судалгааны дүнгээс үзэхэд нэг өрхөд дунджаар 38 толгой мал оногдож байв. ... малчид бүрэлдэхүүний хувьд хоньчин, ямаачин, адуучин гэх мэт мэргэжлийн гэж болох бүлгээс тогтож байсан..." (Уртнасан.Ц, Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ, 2017, pp. 149-150) гэх байдлаар олон талаас нь судлаж үр дүнг нь гаргасан.

Гурав. Зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхмээс “Монголын нийгмийн давхраажилт, төлөв байдал, чиг хандлага” (МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, 1993-1998), “Монголын нийгмийн дотоод ялгарал” (МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, 1998-2001), Удирдлагын академи “Сумын судалгаа: онол, арга зүйн асуудал” (Удирдлагын академи, 2004), ШУА-ийн Философийн хүрээлэнгээс “Малчдын нийгмийн асуудал” (ШУА-ийн ФСЭХ, 2007), “Хөдөөгийн амьдралын хэв маяг” (ШУА-ийн ФСЭХ, 2016), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт “Малчдын аж байдлын судалгаа” (ХНХЯ, ХНХСИ, 2018) зэрэг суурь судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн.

Дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчид, донор орнуудын санхүүжилтээр “Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх талаарх судалгаа” (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, 2003), “Монголын мал аж ахуйн ирээдүй” (ННФ, Монголын мал аж ахуйн ирээдүй, 2004), “Малчдын хөрөнгийг

эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ” (МУЗГ, UNDP, 2004), “Монголын малчдын амьжиргааны судалгаа” (ШХА, МБМХ, 2010), “Монголын дундаж давхаргын судалгаа” (Эдийн засгийн судлагаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, 2016), “Залуу малчдын судалгаа” (Туяадэлгэр.Д, 2013), “Дунд орлоготой орны дундаж орлоготой хүн амын бүлгийн шинжилгээ: Монгол Улсын жишээ” (Дунд орлоготой орны дундаж орлоготой хүн амын бүлгийн шинжилгээ: Монгол Улсын жишээ, 2014), “Малчин өрхийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааны тайлан” (Швейцарын хөгжлийн агентлаг, ММСГ, 2017), “Туслах малчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал ба хүний эрхийн хэрэгжилт” (ХЭҮК, 2021) зэрэг захиалгат болон тодорхой судалгааны ажлуудыг гүйцэтгэжээ.

Нийгмийн шилжилтийн өмнөх болон дараах үед хийсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын онол, арга зүй зарчмын хувьд өөрчлөгдсөн. Социализмын үед малчдыг хоршоолсон ард ангийн гол бүрэлдэхүүнд багтаан судлаж байсан бол шилжилтийн дараа онол, арга зүйн хувьд давхраанд хувааж, бүтцийг нь илэрхийлэх хандлага давамгайлах (Отгоннасан.В, Монголын нийгэм ба олон нийтийн санал бодол, 2021, р. 182) болсон.

Монголын нийгмийн бүтцийг судалсан эрдэмтэд: доктор Ц.Уртнасан (1947-2017) нийгмийг бүхэлд нь дээд, дунд, доод анги гэж гурван түвшинд хуваан тэдгээрийн бүтэц харьцааг тодорхойлон судалсны зэрэгцээ малчдыг бие даасан бүлэг болохынх нь хувьд онцлон судалсан (Уртнасан.Ц, Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ, 2017, pp. 156-170). О.Мөнхбат давхраажлын онолд үндэслэн эд баялаг ба орлого, боловсрол, мэргэжил, албан тушаал ба эрх мэдэл гэсэн үзүүлэлтүүдээр Монголын нийгмийн бүтцийг шинжлэн малчдыг гурван бүлэг буюу социаль дунд (С статус), дундаас доогуур социаль давхраа (С ба Д статус), социаль доод (Д статус) давхраанд хуваан гурав дахь бүлэгт цөөн малтай малчдыг хамруулжээ (Мөнхбат.О, 2000, pp. 84, 123-124). Т.Бүрэнжаргал давхраажлын онолын буюу олон хэмжээст хандлагад үндэслэн нийгмийн бүтцийг судалсан бөгөөд малчдын тухайд “Өрхийн орлого хот, хөдөөд ялгаатай байсан бөгөөд 1999 оны статистикт тэмдэглэснээр хотын хүн амын 46.6 хувь нь цалингаар, хөдөөгийн хүн амын 49.9 хувь нь мал аж ахуйн бүтээгдэхүүнээс орлогоо бүрдүүлдэг. ... Өнөөдөр манай улсад хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийн 60 хувь, хөдөөгийн хүн амын 50 хувь нь ядуу байна. Хөдөөгийн ядуу иргэдийн 40 гаруй хувь нь

ажилгүй байна.” (Бүрэнжаргал.Т, 2001, pp. 62, 70) гэжээ. Эрдэмтдийн бүтээлээс нийтлэг хоёр зүйл ажиглагддаг бөгөөд нэгд монголын нийгмийг давхраанд хуваахдаа суурин болон нүүдлийн гэх ялгаатай хэв маягуудыг давхраанд хуваах нэгдмэл шалгуур боловсруулав уу, хоёрт малын тоо хэмжээ нь дангаар давхраажлын шалгуур үзүүлэлт болж чадах уу гэж. Доктор Ц.Уртнасан энэ асуудалд нэлээд баримт, нотолгоо бүхий тайлбар, ангилал (Уртнасан.Ц, Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ, 2017)-ыг санал болгосон. Нийгмийн бүтцээр дагнан судалсан эрдэмтдээс гадна Н.Хавх (Хавх.Н, Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан, 1995), Ц.Нансалмаа “Малчин өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн менежментийн асуудал” (Нансалмаа.Ц, 1998), Д.Өлзийсайхан (Өлзийсайхан.Д, 2009), Ц.Пүрэв (Пүрэв.Ц, Монголын нийгмийг социологиор шинжлэхүй: бодол, төсөөлөл, эргэцүүлэл, 2015), Ё.Ундрал нарын судлаач, эрдэмтэд илтгэл, өгүүллээс эхлээд нэг сэдэвт болон хамтын бүтээл, бүлэг зүйл хэвлүүлэн гаргажээ.

Малчдын нийгмийн ялгарлын талаар тухайлан, Ё.Ундрал социологийн онолын түвшинд М.Вебер, Р.Дарендорф, П.Бурдые нарын гүйцэтгэсэн үүргийг онцлон, энэ чиглэлээр монголын судлаачид (Х.Гүндсамбуу, Ц.Уртнасан, О.Мөнхбат)-ийн судалсан хандлагыг тодорхойлж доктор Х.Гүндсамбуугийн баялаг ба орлого, мэдлэг ба боловсрол гэсэн хосолмол үзүүлэлтээр хөдөө дэх нийгмийн бүлгүүд (ШУА-ийн ФХ, 2018, pp. 106-125)-ийг судалсан. Өөрөөр хэлбэл, нэг талаас давхраажлын, нөгөө талаас тэгш бус байдлыг илэрхийлэх шалгуур үзүүлэлтүүдэд ялгарч буй байдлыг судлан тодорхойлсон.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаас малчдын дүр зураг, ялгааг малын тоо толгой, хүн ам зүйн шинжтэй цөөн тооны үзүүлэлтээр хязгаарлах, онол арга зүйн талаас барууны үзэл онолыг туйлчлах хандлага давамгайлах болсноор өөрийгөө таних бүтээлч эрэл хайгуул орхигдох, малчдыг асуудал тээгч мэтээр үзэж, практик зорилт шийдвэрлэх, ингэхдээ үзэгдэл үйл явц, өөрчлөлтийг давтан буулгасан шинжтэй үр дүн олширсон. Онол, арга зүйн хувьд хайрцаглагдах шинжтэй дүр зураг ажиглагдах болсон учир хуулбарлах, даган дууриах энэ хандлагаас илүүтэй мөн чанар, шалтгааны асуудлыг эрэн хайх чиглэлд илүү анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна.

Судалгааны хэрэглэгдэхүүн, эх материал болохын хувьд эдгээр болон бусад баримт дахь үр дүн, дэвшүүлсэн санаа зэрэг нь эл бүтээлд нэгдүгээрт онол, арга зүйн

чигийг тодорхойлох эх сурвалж, хоёрдугаарт судалгааны ажлын үр дүнг харьцуулан шинжлэх, баталгаажуулах баримт, гуравдугаарт судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдлыг жишиж харьцуулж ойлгох хэрэглэгдэхүүн болно.

2.2. Судалгааны талбар, түүвэр

Мал аж ахуйн үйлдвэрлэл нь өрхийн хэмжээнд явагддаг учир хувь хүний статус, ялгаа нь өрхийн шинж байдлаар тодорхойлогдоно. Таамаглал шалгахад ХНХЯ, ХНХСИ-ээс хамтран хийсэн “Малчдын аж байдал” сэдэвт суурь судалгааны анхдагч дата мэдээллийг голлон ашиглалаа. Учир нь хувь судлаачийн зүгээс тус судалгааны аргачлал, ялангуяа хэрэглэгдэхүүнийг боловсруулахад арга зүйн талаас голлон зөвлөж ажилласан.

Мэдээлэл цуглуулах ажлыг 2018 онд гүйцэтгэсэн бөгөөд багийн судлаачид баруун бүсээс Говь-Алтай, Завхан, хангайн бүсээс Өвөрхангай, Хөвсгөл, төвийн бүсээс Сэлэнгэ, Дундговь, зүүн бүсээс Дорнод, Сүхбаатар аймгийн 24 суманд ажиллаж анхдагч мэдээлэл цуглуулсан.

Хүснэгт 1. Мэдээлэл цуглуулсан аймаг, сум ба түүврийн харьцаа

Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Түүврийн хэмжээ	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Түүврийн хэмжээ
Сүхбаатар	Баруун-Урт	25	Хэнтий	Өндөрхаан	25
	Баяндэлгэр	50		Өмнөдэлгэр	50
	Түвшинширээ	50		Баянхутаг	50
Сэлэнгэ	Сүхбаатар	25	Хөвсгөл	Мөрөн	25
	Цагааннуур	50		Алаг-Эрдэнэ	25
	Баруунбүрэн	50		Цагаан-Уул	50
Дундговь	Сайнцагаан	25	Говь-Алтай	Алтай	25
	Эрдэнэдалай	50		Жаргалан	50
	Дэрэн	50		Халиун	50
Өвөрхангай	Арвайхээр	25	Завхан	Улиастай	25
	Өлзийт	50		Тэлмэн	50
	Зүүнбаянулаан	50		Эрдэнэхайрхан	50
Улаанбаатар	Сонгинохайрхан	25	-	-	-
	Хан-Уул	25	-	-	-
Нийт	1050				

Судалгаанд хөдөөгийн 1000 малчин өрх (аймгийн төвийн ойролцоох 201, сумын төвийн ойролцоох 104, хөдөөгийн 695 малчин), Улаанбаатар хотод бүртгэлтэй 50 малчин (хувиараа фермер эрхлэгч) буюу нийт 1050 малчин өрхийн тэргүүлэгчээс анкетын аргаар мэдээлэл авч малчдын ялгааг тодрууллаа. Тухайн жил Монгол улсын

хэмжээнд 288.700 мянган малчин бүртгэгдсэн бөгөөд үүнээс түүврийн найдвартай байдлыг 95 хувь байхаар алдааны хязгаарыг тооцож үзэхэд ± 3.02 хувийн хооронд хэлбэлзэж байна. Түүвэрлэлтийн хувьд малчдын ялгарч буй дүр зургийг хэмжиж, илэрхийлэх бүрэн бололцоотой.

Эл судалгаанаас гадна шаардлагатай зарим үр дүнг ШУА-ийн Философийн хүрээлэнгээс 2007 онд хийсэн “Малчдын нийгмийн асуудал” (ШУА-ийн ФСЭХ, 2007), 2014-2016 онд хийсэн “Хөдөөгийн иргэдийн амьдралын хэв маяг: өөрчлөлт, хандлага” (ШУА-ийн ФСЭХ, 2016) сэдэвт суурь судалгааны дата мэдээлэл, статистикийн тоон мэдээлэл болон холбогдох бусад материалыг шинжлэн тодрууллаа.

2.3. Өгөгдөл цуглуулах арга

Судалгааны үндсэн мэдээллийг CAPI буюу мэдээлэл авахад зориулсан программ хангамж бүхий таблетыг асуулгын судалгааны мэдээлэл цуглуулахад ашигласны зэрэгцээ чанарын судалгааны арга (ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, баримт бичгийн шинжилгээ)-аар мэдээлэл цуглуулсан болно.

Тоон судалгааг *нэгдүгээрт*: судалгааны асуулга, түүврийн мэдээллийг утасгүй интернет ашиглаж бүх таблетад нэгэн зэрэг байршуулах, *хоёрдугаар*: судлаач өгөгдсөн асуулгын дагуу респондентоос сурвалжжлагын аргаар мэдээлэл цуглуулах (байршил, мэдээлэл авах үеийн болон мэдээлэл авахад зарцуулсан хугацаа), *гуравдугаарт*: хуримтлагдсан мэдээллийг утасгүй интернетийн сүлжээгээр дамжуулан төв систем рүү илгээх, *дөрөвдүгээрт*: системд ирсэн мэдээлэл өгөгдсөн командын дагуу нэгтгэж хуримтлагдсан мэдээлэлд шинжилгээ хийлээ.

Чанарын судалгааны арга: нэгд баримт бичгийн шинжилгээний аргыг ашиглаж малчдыг судалсан байдал, тэдгээрийн үр дүнг тоймлон зурагласны зэрэгцээ, МАА-н үйлдвэрлэлийн онцлог, түүнээс үүдэлтэй малчдын ялгааг тодорхойлон гаргах байдлаар шинжилгээ хийсэн. Хоёрт, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын аргаар малчдын дотоод дахь дэд бүлгүүдийн онцлог, хэв маягийг тодруулан судалсан бөгөөд мэдээлэлд агуулгын болон логикийн шинжилгээ хийж тоон судалгааны үр дүнг баталгаажуулах байдлаар ашигласан.

2.4. Өгөгдлийн шинжилгээ

Судлан буй сэдэвт хамаарах эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, ном зохиол, бодлого хөтөлбөр, дүр журам г.м анхдагч болон хоёрдогч баримт, малчидтай хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагад агуулгын болон логик шинжилгээ, тоон судалгааны үр дүнг дескриптив статистикийн аргаар боловсруулж, ашиглалаа. Гол үр дүн буюу малчдын бүтэц, ялгааг илэрхийлэх аргачлал индексийг тооцохдоо малын тоо, орлого, хадгаламж, өмчийн бусад хэлбэртэй эсэхээс хамаарч өндөр үзүүлэлтээс нам түвшин хүртэл 1-0 гэсэн утга оноосон бол зээлийн хэмжээнд үндэслэн эсрэг утга буюу 0-1 утгыг харгалзуулан үр дүнг боловсруулсан. Жишээ нь: хамгийн их малтай, эсвэл өндөр орлоготой бол 1 гэсэн утгыг оноож хамгийн бага орлого, цөөн малтай бол 0 хүртэл утгыг тоо хэмжээнээс хамааруулан оноосон бол зээлийн утгыг оноохдоо эсрэг байдлаар утга оноолоо. Эцсийн үр дүнг нийт утгын нийлбэрийн дундаж утгыг тооцож 0-0.9, 1-1.9, 2-2.9 г.м байдлаар арван бүлэгт хуваан үр дүнг тооцон нийгмийн үзүүлэлтүүдтэй харьцуулан үр дүнг гаргасан болно

Уламжлалт харилцааны дүр зураг, онцлогийг тодорхойлоход ерөнхийгөөс нэгжид, нэгжээс ерөнхийд шилжих, задлах болон нэгтгэх, үгүйсгэл, бататгал зэрэг шинжлэх ухааны ерөнхий арга, аргачлалыг ашиглаж дэвшүүлсэн таамаглал, үр дүнг шалгалаа.

2.5. Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол

Өмнө хийсэн социологийн судалгааны ажлуудад барууны нэг хэмжээст болон олон хэмжээст онолын шалгуурыг үндэс болгон судлаж ирсэн бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн онол, арга зүй, аргачлалд суралцах, улмаар нийгмийн дүр зургийг тодорхой хэмжээнд танин мэдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн ч цаашид судалгаа, шинжилгээний ажил ийм байдлаар үргэлжлэх нь мал аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан монголын гэх нийгмийн өөрийнх нь мөн чанарыг танин мэдэх бүтээлч эрэл хайгуулд харшилна. Иймд монголын, малчдын гэх тодотголтой аливаа судалгааны ажилд сонгодог болон орчин үеийн онолын чигийг баримжаалан судаллаа ч уламжлал, мөн чанараа аль болох уг углуургаар нь таних чиглэлийг орхигдуулалгүй авч явах нь чухал.

Зарим судлаачдын зүгээс тухайлан, 1990-ээд оноос өмнөх эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудад уламжлалаа хэрхэн таних тухай арга, аргачлалын шинжтэй

бүтээлч эрэл хайгуул эрчимтэй өрнүүлэн зохих үр дүнд хүрч, тэдгээрийг судалгаа шинжилгээний эргэлтэд оруулж байсан. Нийтлэг тохиолдолд, ололт бүхий үр дүнг гүнзгийрүүлэлгүй бага хэмжээний баримт, санал таамаглал байдлаар хязгаарлаж орхисон, хожуу хүлээн зөвшөөрөгдсөн гэх үзэл суртал, онолын хүлээсэнд орох болсноор өөрийгөө таних хайгуулд бодитой ахиц гараагүй, тасалдсан. Сүүлийн жилүүдэд энэ чиглэлд анхаарч эрдэм шинжилгээний тухайлан, философи хүмүүнлэгийн чиглэлээр хэд хэдэн бүтээл гаргажээ. Эл судалгааны ажилд дээрх чиглэл, зарчмыг баримтлан ажиллахыг эрхэмлэсэн бөгөөд онцлог, ач холбогдол нь:

Нэг. Социологийн шинжлэх ухаан монголд хөгжиж эхэлсэн үеэс эхлэн суурь болон хавсарга, тодорхой судалгааны ажлуудад аж төрөх ёс, амьдралын хэв маяг гэх ойлголтуудын хүрээнд малчдын ялгарал, нөлөөлж буй хүчин зүйлсийг хамааруулан судлаж ирсэн ч уг сэдвийг дангаар нь, суурь судалгааны түвшинд нарийвчлан судлаагүй.

Хоёр. Малчдын ялгаралд нөлөөлж буй хүчин зүйлсийг гүнзгийрүүлэн судлахыг зорин энэ чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээ, судалгааны баримтуудыг шинжилж мал аж ахуйн үйлдвэрлэл дэх малчдын оролцоог тодорхойлох оролдлого хийсэн.

Гурав. Малчдын нийгмийн ялгааг тодруулах шалгуур үзүүлэлтийг судлагдсан баримтуудаас тодруулан, энэ дагуу нарийвчилсан шинжилгээ хийж малчдын ялгаралд нөлөөлж буй голлох хүчин зүйлсийг тодорхойлохыг эрмэлзсэн.

Дөрөв. Малчдын дотоод бүтцийг дүрслэн илэрхийлэх арга зүй, аргачлал боловсруулан, үр дүнг зурагласан.

Тав. Нүүдлийн болон суурин амьдралтай иргэдийн бүтэц, ялгааг нэгдмэл арга зүй, шалгуураар илэрхийлэн судлах санаа дэвшүүлэн, түүнийг малчдын жишээн дээр туршиж, малчдын дотоод бүтцийг илэрхийлэн дүрсэлж, суурин амьдралтай иргэдтэй харьцуулан судлах боломжтой гэж үзсэн.

Зургаа. Малчдын харилцаанд “хариуцлагын болон хяналтын”, “дэмнэх болон тэтгэх” хэв шинжийн харилцаа илүүтэй үйлчилдэг бөгөөд өмнө судалсан баримт, эл судалгааны ажлын үр дүнгээр нотлон харуулахыг оролдсон.

Долоо. Хэрэглээний талаас малчдын амьдралын суурь нөхцлийг дээшлүүлэх арга зам, боломжуудыг тодорхойлсон бодлогын болон үйл ажиллагааны шинжтэй баримтуудыг шинжилж үр нөлөөг нэмэгдүүлэх боломж, чигийг тодруулсан.

Найм. Судалгааны ажил нь малчдыг судлах дараа дараагийн ажлуудад хэрэглэгдэхүүн болж ашиглагдахын хувьд өмнө хийсэн судалгаа эрдэм шинжилгээний баримт, материалуудыг зохих түвшинд нэгтгэснээрээ ач холбогдолтой.

2.6. Судалгааны ажлын хязгаарлагдмал тал

Нэг. Сүүлийн жилүүдэд туслах болон хөлсний малчдын тоо нэмэгдэх болсон ч “Малчдын аж байдал” судалгааны дата мэдээллээс тодруулах боломж хязгаарлагдмал болсон учир энэ хэсгийнхний дүр зураг, ялгааг өмнө дурдсан ШУА-ийн Философийн хүрээлэн болон бусад судалгааны байгууллагаас хийсэн судалгааны ажлын тайлан үр дүн, холбогдох мэдээлэл, кейс баримтуудыг шинжлэх байдлаар тодруулахыг хичээсэн. Дэд бүлгүүдийн онцлог, хэв маягийг тусгайлан судлах хэрэгцээ байгаа юм.

Хоёр. Мэдээлэл цуглуулахад ашигласан аргатай холбоотой тухайлбал, шалтгаан үр дагаврыг тодруулах нээлттэй болон хагас нээлттэй асуултаар зарим ач холбогдол бүхий мэдээлэл, санаа тодорхой гарч ирдэг ч судалгааны асуултын хэмжээ их, зөөврийн хэрэгсэлд их хэмжээний текстэн мэдээллийг богино хугацаанд оруулахад төвөгтэй зэрэг шалтгааны улмаас авсан мэдээлэлд шинжилгээ хийж асуудлын шалтгаан, нөхцлийг нарийвчлан илэрхийлэх боломжгүй болсон. Мөн судалгааны өгөгдөл нэгтгэхэд арга зүйн алдаа гаргасны улмаас сумдын мэдээлэл бүрэн ороогүй. Үүнээс улбаатай бэлчээрийн хэв маяг, онцлогоос хамааралтай малчид ялангуяа, өмч, орлого, амьжиргааны түвшнээр хэрхэн ялгарч буйг тодруулахад бэрхшээлтэй болсон.

Гурав. Малчдын ялгаралд бүс нутгийн, цаг уурын онцлог хэрхэн нөлөөлж буйг холбогдох мэдээ баримттай харьцуулан шинжилжилгээ хийх боломжтой ч ижил хугацаанд, ижил тооны хэмжилт хийж бүс нутгуудын цаг уурын өөрчлөлт, ялгааг гаргасан судалгааны баримт хязгаарлагдмал байсны учир энэ талын шинжилгээ орхигдсон. Судлаачийн зүгээс энэ талын баримтыг бүс ба малын зүй бус хорогдлын тухай статистик мэдээллээс холбогдох үр дүнг ашиглан оруулсан. Арга зүйн хувьд дурдан буй нөхцлүүдийг харгалзан судлах тал дээр учир дутагдалтай байлаа.

Дөрөв. Үйлдвэрлэлийн талаас цаашид нүүдлийн хэв маягийг хадгалах, эсвэл фермер дагнасан аж ахуй хөгжүүлэх тухай бодлогын түвшинд нэлээдгүй яригддаг ч аль нэгийг дангаар хөгжүүлэхийн өмнө ажиллах хүчний шингээлт, хүн амын суурьшлын нягтаршил, МАА-аас гаралтай түүхий эдийг борлуулах зах зээлийн багтаамж, гарц зэрэг асуудлыг тооцох шаардлагатай. Эдгээр нөхцлийг тооцохгүйгээр даган дууриах,

хуулбарлах байдлаар асуудалд хандах нь тухайлбал, фермерийн аж ахуй хөгжүүлэх гэх нь ажилгүйчүүд болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсдын тоог нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөөтэй байж болох тул үүнийг олон шинжлэх ухааны уулзвар дээр өргөн бүрэлдэхүүнтэйгээр судлан тогтоох.

Тав. Судлаачийн зүгээс бүтцийн хандлагад үндэслэн дэд бүлэг хийгээд бүлгүүдийн ялгарч буй байдлыг судлан гаргахыг зорьсон. Иймд феноменологи, бихевиорист, бэлэг тэмдгийн хандлагаар судлан, эсвэл онолуудыг зэрэгцүүлэн уламжлалт харилцааны онцлог, хэв маяг, ялгааг тодруулан судлах нь сонирхолтой, ач холбогдолтой хэдий ч малчид, малчдын дотоод дахь дэд бүлгүүдийг ялган, түүнийг баримжаалан судлах нь илүү үр дүнтэй байх талтай. Өөрөөр хэлбэл, бүлгийн онцлог, дотоод бүтцийг ялгаж өгснөөр цаашид дурдан буй онол, хандлагаар судалгаа хийхэд баримжаа болох юм.

БҮЛЭГ 3. МАЛЧДЫН ЯЛГАРЧ БУЙ ДҮР ЗУРАГ

3.1. Үйлдвэрлэлийн онцлогоос хамаарах ялгаа

Малчдын ялгаа, ялгаралд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахын тулд эрхэлж буй үйлдвэрлэлийн онцлогийг тодруулах шаардлагатай. Монголчуудын эрхэлдэг нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь юуны өмнө орчин үеийн үйлдвэрлэлээс эрс ялгаатай.


Нэгдүгээрт, байгалийн хүчин зүйлээс гадна бодлогын болон эдийн засгийн орчин зохих нөлөө үзүүлэх бөгөөд үүнийг дотор нь үйлдвэрлэл эрхлэх үйл явцад, нийгмийн ялгаатай байдлыг даван туулахад ямар нөлөөлөл үзүүлж байна гэх байдлаар зааглаж, шинжлэх шаардлагатай. Учир нь байгалийн хүчин зүйл нь үйлдвэрлэлийн хэмжээ, багтаамжид, бодлогын болон эдийн засгийн орчин нь үйлдвэрлэлд, мөн нийгмийн харилцаа, ялгаралд тусгалаа олж, хэрэгждэг.

Хоёрдугаарт, үйлдвэрлэлийн үйл явц хувь хүний оролцоо боломжоос хамаардаг. Нийгмийн ялгаа нөхцөл ба боломжийн харилцан үйлчлэлийн үр дүнгээр тодорхойлогддог.

Үйлдвэрлэлийн нөхцөл. Байгалийн хүчин зүйл буюу бэлчээрийн талбай, газар тариалан, бүс нутгууд дахь цаг уурын онцлогоос хамаардаг. Эдгээр хүчин зүйл нь малын тоо, сүргийн бүтэц, хэмжээ, цаашлаад малчдын амьдрал, амьжиргааны түвшин, соёл, амьдралын хэв маягт зохих нөлөө үзүүлдэг.

Монгол улсын статистикийн мэдээлэлд малтай өрхийн эмзэшиж буй малын тоо хэмжээг харуулдаг бөгөөд улсын хэмжээнд 242.024 малтай өрх бий.

Зураг 1. Малтай өрхийн тоо ба малын тоо (малчдын тоо)



Эх сурвалж: Малтай өрх 2020. ҮСХ-ны бүртгэл мэдээлэл

Тэдгээрийн 83.3 хувь нь 500 хүртэл толгой, 12.5 хувь нь 501-999, 3.5 хувь нь 1000-1499, 0.5 хувь нь 1500-2000, 0.2 хувь нь 2001-ээс дээш малтай. Мал аж ахуйн хөдөлмөр дагнан эрхэлж, өрхийн орлогоо бүрдүүлдэг 181.050 малчин өрхийн 298.789 малчин тоологдсон. Үүний 24.6 хувь нь баруун бүсд (73,659.00), 41.6 хувь нь хангайн бүсд (124,350.00), 20.3 хувь нь төвийн бүсд (60,689.00), 12.2 хувь нь зүүн бүсд (36,483.00), 1.3 хувь нь Улаанбаатар хотод (3781) бүртгэгдсэн аж (ҮСХ, Малчдын тоо (улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр), 2021; ҮСХ, Малчин өрхийн тоо (улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр), 2021).

Хүснэгт 2. Малчид, малчин өрхийн тоо: бүс нутгаар (малын тоогоор)

Бүс	Утга	2016	2017	2018	2019	2020
Баруун бүс	Малчид	82.239	79.192	72.395	70.477	73.659
	Малчин өрх	38.560	37.740	38.520	38.970	40.590
	Өрхийн ажиллах хүч	2.13	2.10	1.88	1.81	1.81
Хангайн бүс	Малчид	127.687	124.682	120.381	119.171	124.350
	Малчин өрх	60.370	59.910	61.670	63.010	65.390
	Өрхийн ажиллах хүч	2.12	2.08	1.95	1.89	1.90
Төвийн бүс	Малчид	61.722	60.290	58.293	57.935	60.689
	Малчин өрх	29.640	29.640	30.780	32.050	33.990
	Өрхийн ажиллах хүч	2.08	2.03	1.89	1.81	1.79
Зүүн бүс	Малчид	36.547	36.411	34.508	34.313	36.310
	Малчин өрх	16.430	16.560	17.050	17.810	18.940
	Өрхийн ажиллах хүч	2.22	2.20	2.02	1.93	1.92
Улаанбаатар хот	Малчид	3.178	3.015	3.123	3.586	3.781
	Малчин өрх	1.570	1.460	1.710	1.250	1.730
	Өрхийн ажиллах хүч	2.02	2.07	1.83	2.87	2.19

Эх сурвалж: ҮСХ-ны бүртгэл мэдээлэл

Малчид болон малчин өрхийн тоонд үндэслэн нэг өрхийн ажиллах хүчний дундаж улсын хэмжээнд 1.92 байгаа бол хамгийн их нь Улаанбаатар хотод 2.19, хамгийн бага нь төвийн бүсд 1.79 байна. Монгол улсын нийт хүн амын 19.4 хувийг, ажиллах хүчний 26.7 хувийг малчид дангаар бүрдүүлдэг (ХЭҮК, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 2021, р. 296). Нэг өрхөд ногдох малын тоо, мөн малчдын эзэмшиж буй дундаж малын тоо бүсүүдэд харилцан адилгүй бөгөөд бэлчээрлэх талбайн хэмжээ, ургамлын гарц, төрөлжилт, газар тариалангийн бүсчлэл, мөн зүй бус хорогдолтой холбоотой. Тухайлбал, малын тоо хэмжээг бэлчээрийн талбайн хэмжээ (ХХААХҮЯ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны веб сайт, 2019)-тэй харьцуулахад баруун (34.000.00 сая га), төвийн бүс (33.780.00 сая га), зүүн бүс (21.940.00 сая га)-д 1 га талбайд тус бүр 0.5 толгой мал

ногдож байгаа бол хангайн бүс (20,110.00 сая га), Улаанбаатар хот (430.00 мянган га)-д тус бүр 1.1 толгой, улсын хэмжээнд дунджаар нэг га талбайд 0.6 толгой мал ногдоно гэж тооцвол баруун, төвийн, зүүн бүсд дунджаас цөөн, хангайн болон Улаанбаатар хотын орчимд дунджаас 0.5 толгой илүү мал ногдоно.

Нэг га талбайд ногдох малын тоо хэмжээгээр баруун, төвийн, зүүн бүс харьцангуй цөөн мал оногдож байгаа ч төвийн бүс отор (3485.7 мян га)-ын болон хадлан (1012.33 мян га)-ийн талбайн хэмжээ харьцангуй их. Хангайн бүсд нэг га талбайд оногдох малын тоо толгой харьцангуй өндөр, мөн отор (589.8 мян га)-ын болон хадлан (233.5 мян га)-ийн талбайн хэмжээгээр төвийн болон зүүн бүсээс бага, баруун бүс (отрын талбай 441.6 мян га, хадлангийн талбай 55.1 мян га)-ээс өндөр (ХХААХҮЯ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны веб сайт, 2019; ҮСХ, Нийт тариалсан талбай (улс, бүс, аймаг, нийслэл, жилээр), 2021), Монгол улсын газар тариалангийн гол хэсэг хангайн бүсд хамаардаг байх жишээтэй. Зүүн бүс (отрын талбай 922.2 мян га, хадлангийн талбай 405.2 мян га)-ийн хувьд нэг га талбайд оногдох малын хэмжээ бага, нэг малчинд оногдох малын тоо хэмжээ өндөр, отрын болон хадлангийн талбай багатай. Газар тариалангийн зориулалт бүхий талбайн хэмжээг 2020 онд 591.157.7 га гэж бүртгэсний 65.0 хувь нь төв, 16.6 хувь нь хангай, 10.8 хувь нь зүүн, 7.1 хувь нь баруун бүсд байрладаг (ҮСХ, Нийт тариалсан талбай (улс, бүс, аймаг, нийслэл, жилээр), 2021). Бэлчээрийн даац болон малын тоо хэмжээ, отрийн болон хадлангийн талбайн хэжээ, газар тариалан зориулалт бүхий талбай гэсэн үзүүлэлтүүдийг үндэс болговол зүүн, баруун бүсийн малчид харьцангуй таатай нөхцөлд үйлдвэрлэл эрхэлдэг аж.

Цаг уурын нөхцлөөр баруун болон хангайн бүс харьцангуй хүйтэн, зудын эрсдэл өндөр бол зүүн болон төвийн бүс харьцангуй дулаан, ган тохиох нь элбэг. Статистикийн бүртгэл мэдээн дэх тухайн жилд тоологдсон нийт малаас зүй бусаар буюу зудад эрсэдсэн (мал олноор үрэгдэх гол шалтгаан болдог) малын хэмжээг тооцоход 2000 онд төв, хангай, баруун бүсд, 2005 онд баруун болон зүүн бүсд, 2010 он (Монгол банк, 2015, р. 572)-д баруун, хангайн, төвийн бүс, Улаанбаатар хотод, 2015 онд хангайн бүсд, 2020 онд баруун бүсд хамгийн олон мал хорогджээ (ҮСГ, Малын зүй бус хорогдол (төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр), 2021; ҮСХ, Малын тоо (төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багаар, хороогоор, жилээр), 2021). Тэмдэглэсэн хугацаанд нэг хүнд ноогдох малын тоогоор тэргүүлж буй зүүн бүсд малын

зүй бус хорогдол харьцангуй бага байсан бол баруун болон хангай бүсд зүй бус хорогдол хэд дахин илүү, давтамж өндөртэй тохиож байсан харагдана.

Хүснэгт 3. Тухайн жилд тоологдсон малаас зүй бус хорогдлын хэмжээг тооцсон үр дүн (тухайн бүсд тоологдсон нийт малын тооноос хувь тооцсон үр дүн)

	2000 он	2005 он	2010 он	2015 он	2020 он
Баруун	10.9	3.3	40.6	0.7	1.2
Хангайн	11.7	1.2	35.5	1.7	0.0
Төвийн	17.5	1.6	30.1	0.8	0.1
Зүүн	2.4	3.2	11.9	0.8	0.0
Улаанбаатар	2.8	1.1	28.1	0.7	0.2

Эх сурвалж: ҮСХ-ны бүртгэл мэдээлэл

Цаг уур хүндэрсэн үеийн тухай “Сүүлийн гурван жилд гэхэд л монголын малын тоо 11 саяар хорогдсон баримт бий. Зөвхөн Говь-Алтай аймагт л гэхэд сүүлийн жилүүдэд 11.000 өрх огт малгүй болжээ. Түүвэр судалгааны дүнгээс үзэхэд малчин өрхийн 58.5 хувь нь ачлагын тэмээгүйн дээр 18 хувь нь унах морьгүй, 18 хувь нь саах үнээгүй болжээ” (Номун-Эрдэнэ.Д, 2016; Taylor, 2015; Tserennadmid Mijiddorj, Ariell Ahearn, Charudutt Mishra, Bazartseren Boldgiv , 2019). Бүс тус бүрээс судалгаанд хамрагдсан өрхүүдийн малын тоо ойролцоо ч жилийн нийт мөнгөн орлогын дүн, үүний дотор мал аж ахуйгаас орсон орлогын хэмжээ ихээхэн зөрүүтэй байгаа нь бүс тус бүрийн малын төрлийн бүтэц, байгаль-цаг уурын онцлог, тухайн жилүүдийн өвөлжилт, хаваржилт болон ган, зудын байдал, зах зээлийн алслалтаас хамаарсан бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн ялгаа зэрэгтэй холбоотой.” (Бат-Эрдэнэ.Ц, 2004, р. 81) гэж байгалийн хүчин зүйлээс хамаарч амьжиргааны эх үүсвэрээсээ салсан, уг шалтгааны улмаас шилжилт хөдөлгөөн бий болдог (ШУА-ийн ФХ, 2018, pp. 96-105).

Монгол улсын нийт малын 23.6 хувь нь баруун бүсд (15.845,18), хангайн бүсд 33.9 хувь (22.752,40), төвийн бүсд 24.9 хувь (16.691,03), зүүн бүсд 16.9 хувь (11.311,20), Улаанбаатар хотод 0.7 хувь (468.7) нь (ҮСГ, Малын тоо (төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багаар, хороогоор, жилээр), 2021) бүртгэгджээ. Бүсүүд дэх малчид болон малын тоон үзүүлэлтэд үндэслэн нэг малчинд ноогдох малын тоо хэмжээг тооцоход зүүн (311.5), төв (275), баруун (215.1) бүсд өндөр, хангай (182.9)-н болон Улаанбаатар хот (123.9)-д харьцангуй бага аж. “Малчдын аж байдал” сэдэвт судалгааны үр дүнгээс нэг малчин өрхөд ногдох малын тоог хонин толгойд шилжүүлж тооцоход зүүн бүсд дунджаар 519.98 толгой, баруун бүсд 410.63 толгой, төвийн бүсд 381.07 толгой, хангайн бүсд 306.18 толгой, Улаанбаатар хотод 63.4 толгой ногдож байгаа нь

дээрх үр дүнг бататгаж байгаа юм. Өөрийн эзэмшлийн малын тоогоор зүүн бүс харьцангуй өндөр (413.12 толгой) үзүүлэлттэй бол баруун бүс 386.86, төвийн бүс 328.87 хангайн бүс 279.72, Улаанбаатарт хотод 56.78 толгой, тавиул малын тоогоор зүүн бүс хамгийн их буюу нэг малчин өрхөд дунджаар 106.9 толгой, төвийн бүсд 52.2, хангайн бүсд 26.5, баруун бүсд 23.8 толгой, Улаанбаатар хотод 6.62 толгой ногдож байна. Өөрийн болон тавиул малын харьцаа өөр өөр бөгөөд баруун бүсийн малчдын малын 84.8, хангайн бүсд 78.1, Улаанбаатар хотод 78.0, төвийн бүсд 74.3, зүүн бүсд 56.8 хувь нь өөрийн эзэмшлийнх бол үлдсэн хэсэг нь тавиул мал ажээ.

Сүргийн бүтэц, харьцаа бүсүүдэд харилцан адилгүй. Адууны 80.8 хувь нь хангайн, төвийн, зүүн бүс (хангайн бүс 33.5, төвийн бүс 23.4, зүүн бүс 23.9), үхрийн 41.6 хувь нь хангайн бүсд дангаар (баруун бүсд 18.2, төвийн бүсд 18.1, зүүн бүсд 20.3), тэмээний 54.8 хувь нь төвийн бүсд дангаар (баруун бүсд 23.0, хангайн бүсд 18.4 хувь), хонины 35.1 хувь нь хангайн бүсд (баруун бүсд 21.4, төвийн бүсд 24.1, зүүн бүсд 18.8 хувь), ямааны 86.1 хувь нь баруун, хангайн, төвийн бүс (27.8%: 31.7%: 26.6%)-д бүртгэлтэй байна (ҮСХ, Малын тоо (төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багаар, хороогоор, жилээр), 2021). “Малчдын аж байдал” судалгаанд оролцогчдын мэдээлэлд үндэслэн холбогдох үр дүнг шинжлэхэд: сүргийн бүтцэд ялангуяа урт хөлийн малын эзлэх хэмжээ бүс нутгийн байршлаас хамаарах шинжтэй ($r = 0.217^{**}$) бол урт болон богино хөлийн малын тоо хэмжээ бие биеэс хамааралтай ($r = 0.448^{**}$) өөрчлөгддөг зүй тогтол харагдаж байна. Үүнийг бүс тус бүрээр тодруулахад, үхэр (зүүн бүс 38.5, Улаанбаатар хот 29.3, төвийн бүс 22.2, хангайн бүс 19.3, баруун бүс 12.7), адуу (зүүн бүс 31.5, баруун бүс 17.7, хангайн бүс 17.3, төвийн бүс 17.2, Улаанбаатар хот 12.3), тэмээ (зүүн бүс 2.9, баруун бүс 1.2, төвийн бүс 0.95, хангайн бүс 0.8) зүүн болон баруун бүсд, хонь (зүүн бүс 290.8, төвийн бүс 194.3, баруун бүс 191.9, хангайн бүсд 157.5, Улаанбаатар хот 14.3) зүүн болон төвийн, баруун бүсд, ямаа (баруун бүс 187.1, зүүн бүс 156.3, төвийн бүс 146.4, хангайн бүс 111.2, Улаанбаатар хот 7.6) баруун, зүүн, төвийн бүсд харьцангуй олон байгаа нь бүтцийн хувьд статистикийн бүртгэл дэх мэдээлэлтэй давхцаж байгаа юм.

Хүснэгт 4. Нэг өрхийн сүргийн бүтцийг илэрхийлэх дундаж: бүсээр

	Нийт үхэр	Нийт адуу	Нийт тэмээ	Нийт хонь	Нийт ямаа
Баруун	12.68	17.68	1.24	191.94	187.08
Хангайн	19.33	17.33	0.84	157.51	111.16


Төвийн	22.24	17.19	0.95	194.31	146.38
Зүүн	38.51	31.48	2.86	290.83	156.31
Улаанбаатар	29.26	12.28	0.00	14.30	7.56
НИЙТ	23.48	20.51	1.40	199.36	143.41

Эх сурвалж: ҮСХ-ны бүртгэл мэдээлэл

Малчдын эзэмшиж буй малын тоо, бүтэц харьцаа өөр өөр байгаагийн зэрэгцээ үнэ цэнэ нь зах зээлийн үнэ, эзэмшиж буй нийт малын үнэлгээ, МАА-аас олох орлогын хэмжээ өөрчлөгдөнө. Үүнд зах зээл, суурьшлын бүсд хэр ойр байрлаж байгаагаас, нийт малын үнэлгээ нь малын тоо хэмжээ, сүргийн бүтэц, малын нас, хүйс, бойжилт, үүлдэр, гойд ашиг шимт шинж г.м олон хүчин нөлөөлдөг.

Бүсүүд дэх малын зах зээлийн үнэ (малчдын тэмдэглэсэн үнэ)-д үндэслэн малчдын эзэмшиж буй малын нийт үнэлгээг тооцож үзэхэд Улаанбаатар хот болон зүүн бүсийн малчдын үнэлгээ өндөр гарчээ. Малын үнэлгээнд нөлөөлж буй хоёр дахь хүчин зүйлийн тухайд, Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан 50 малчин өрхөд дунджаар 56.78 толгой мал ноогдож байсан бол өөрийн эзэмшлийн болон нийт малын үнэлгээгээр бусад бүсээс өндөр гарсан нь ашиг шим өндөр, үүлдэрлэг мал малладагтай холбоотой.

Зураг 2. Малчдын өөрийн эзэмшлийн малын зах зээлийн үнэлгээ: бүсийн ханшаар (төгрөгөөр)



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Судалгаа хийх үеийн зах зээл дэх малын үнийг баримжаа болгон тухайн бүс дэх малчдын эзэмшиж буй дундаж малын тоог мөнгөн дүнгээр илэрхийлэхэд Улаанбаатар хотод бүх төрлийн малын үнэ ханш өндөр, баруун бүсд хямд, малын төрөл зүйлээр

адууны үнэ төвийн бүсд өндөр (690.384 төг), баруун бүсд хямд (421.052 төг), тэмээний үнэ баруун бүсд өндөр (750.000 төг), зүүн бүсд хямд (250.000 төг), хонь ямааны үнэ төвийн бүсд өндөр (хонь 86.267 төг, ямаа 62.672 төг), зүүн бүсд хямд (44.876 төг) байжээ.

Хүснэгт 5. Зах зээл дэх малын дундаж үнэ ханиш: бүсээр (төгрөгөөр)

	Нэгжийн үнэ - Үхэр	Нэгжийн үнэ - Адуу	Нэгжийн үнэ - Тэмээ	Нэгжийн үнэ - Хонь	Нэгжийн үнэ - Ямаа
Баруун	511627.907	421052.63	750000.00	71485.58	45163.64
Хангайн	515984.848	477653.06	600000.00	71066.04	52347.83
Төвийн	662368.421	690384.62	600000.00	86267.61	62672.41
Зүүн	547034.722	417777.78	250000.00	58965.52	44876.54
УБ	1967857.143	640000.00	-	86267.61	62672.41
Дундаж	639599.631	486840.49	591666.67	70256.89	49953.22

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Бүс нутгийн онцлогоос хамааралтай малын тоо, бүтэц, зах зээлийн үнэ, үнэлгээ бүсүүдэд ийнхүү ялгаатай байгаа нь малчдад ялангуяа, өрхийн орлого бүрдүүлэлт, амьжиргаанд дараах байдлаар нөлөөлдөг. Мөн зах зээл, суурьшлын бүсэд хэр ойр байрлаж байгаа, дэд бүтэц хөгжсөн эсэх, зах зээл дэх түүхий эд бүтээгдэхүүний ханш, тодорхой нэр төрлийн түүхий эдийн эрэлт зохих нөлөө үзүүлнэ (Хавсралт-3. Сүргийн бүтэц, малын тоо, өрхийн орлогын хамаарал).

Мал аж ахуйгаас олж буй орлого нь нэгд түүхий эдээс, хоёрт амьдаар болон махалж зарсан бүтээгдэхүүнээс бүрдэх ба бүтэц, харьцааг харахад малчин өрх орлогынхоо 48.4 хувийг ямааны ноолуураас, 16.3 хувийг хонь, 15.3 хувийг үхэр зарж борлуулсан орлогоос бүрдүүлж байгаа нь малчдын орлого нэг зүйлээс хэт хамааралтай гэж болохуйц үр дүн харагдаж байгаа юм. Тиймээс бодлогын түвшинд малын гаралтай бусад түүхий эдийн боловсруулалт, эргэлтийг сайжруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 6. Малын мах, түүхий эд борлуулснаас орж буй орлогын харьцаа (хувиар)

	Ямаа	Хонь	Тэмээ	Адуу	Үхэр	Нийт
Түүхий эд	48.4	2.7	0.1	3.5	0.7	55.5
Мал, мах	6.8	16.3	0.1	6.0	15.3	44.5
Нийт	55.2	19.0	0.3	9.5	16.0	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Малчид орлогынхоо 87.3 хувийг ноос, ноолуураас бүрдүүлж байгаагаас ямааны ноолуур 92.6 хувийг дангаар, үхэрийн түүхий эд бүтээгдэхүүнээс орлогын 6.4 хувийг

бүрдүүлж байгаагаас сүүнээс 83.5 хувийг, хонины түүхий эд бүтээгдэхүүнээс орлогын 4.8 хувийг бүрдүүлж байгаагаас хонины ноосноос 83.3 хувийг бүрдүүлдэг. Түүхий эд бүтээгдэхүүнээс олох орлогын хэмжээ мөн аж ахуй эрхэлж буй арга хэлбэрээс хамаарч өөр өөр бөгөөд баруун бүсийнхэн ямааны ноолуураас, баруун, төвийн бүсд хонины ноосноос, Улаанбаатар хот, хангайн бүсд үнээний сүү (Хавсралт-8. Түүхий эд борлуулсны орлого: малын төрөл зүйл, бүсээр)-ээс олох орлого харьцангуй өндөр байдаг.

Хүснэгт 7. Малын түүхий эдээс олох орлогын дундаж (төгрөгөөр)

Түүхий эд	Ямаа	Хонь	Тэмээ	Үхэр	Адуу
Ноос, ноолуур	3.856.984,8	192.282,81	10.933,33	1.524,76	33.083,43
Арьс, шир	265.418,6	38.490,11	263,43	48.543,33	14.130,38
Сүү	26.969,05	-	485,71	253.552,67	15.460,95
Бусад	16.398,1	-	-	-	-
Нийт	4.165.770,5	230.772,92	11.682,48	303.620,76	62.674,76
Хувиар	87.3	4.8	0.2	6.4	1.3

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Мал, мах зарж олсон орлогын хэмжээ нь мөн малын бүтэц, суурьшлаас хамааралтай. Судалгаанд оролцогчдын мэдээлэлд үндэслэн үр дүнг шинжлэхэд орлогын 70 орчим хувийг үхэр болон хонь зарж олсон орлого бүрдүүлж байгаа бол 15.3 хувь нь ямаа, 13.4 хувь нь адуу, 0.6 хувь нь тэмээнээс олжээ. Бүс нутгаар үхэр (таваарлаг шинж, чиглэлийн үүлдэрлэг чанар), адуу (амьдаар буюу хурдан удмын) Улаанбаатар хотод, хонь зүүн бүсд, ямаа баруун бүсд орлогын гол эх үүсвэр болдог.

Хүснэгт 8. Мал, мах борлуулсны орлого: малын төрөл зүйл, бүсээр (төгрөгөөр)

	Үхэр	Адуу	Тэмээ	Хонь	Ямаа
Баруун	347.260,0	200.110,0	14.800,0	1.210.240,0	916.116,0
Хангай	651.631,3	573.318,7	15537,9	1.105.051,8	400.042,6
Төв	1.468.029,3	549.192,8	14056,2	1.541.112,5	565.018,5
Зүүн	2.036.629,0	650.438,8	4000,0	2.022.656,0	581.317,2
Улаанбаатар	5.163.640,0	916.000,0	-	-	-
Нийт	1.317.383,8	513.418,3	11.523,8	1.403.646,7	586.722,5
Хувь	34.4	13.4	0.6	36.6	15.3

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Бүс нутаг, бэлчээрийн онцлогоос үүдэлтэй малчид дээрх байдлаар ялгарч байгаагийн зэрэгцээ МАА эрхлэх нь бодлогын болон эдийн засгийн зохицуулалт чухал нөлөө (Бүдүүвч 1)-тэй болохыг судлаачийн зүгээс тэмдэглэсэн.

Монгол улсад МАА-н салбарын үйл ажиллагааг урт болон богино хугацааны бодлого, холбогдох хууль, журмаар зохицуулж байгаагийн зэрэгцээ малчид, МАА-н салбарт тулгамдаж буй асуудлуудыг дотоодын болон ОУ-ын байгууллагын санхүүжилтээр олон төсөл хөтөлбөрийн хүрээнд судлан таньж, нөлөөллийн ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. Монгол улсын хэмжээнд мөрдөж буй бодлогын чанартай баримт бичиг хийгээд хэрэгжсэн, хэрэгжиж буй бодлого төсөл, хөтөлбөрүүдийг хамаарах объектоор нь:

Нэгд, МАА-н үйлдвэрлэлийн харилцааг зохицуулах, үр ашгийг нь нэмэгдүүлэх, давхар малчдын амьжиргааг тэтгэхэд чиглэсэн Монгол мал үндэсний хөтөлбөр (УИХ, Монгол мал үндэсний хөтөлбөр, 2010), Ноос ноолуурын урамшуулал (МУЗГ, Малчдаас ноолуур худалдан авах, 2008; МУЗГ, Ноолуур хөтөлбөр 2018-2021, 2018; МУЗГ, Ноолуур хөтөлбөр, 2000; МУЗГ, Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, 2019), Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль (УИХ, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, 2011), Арьс ширний урамшуулал (МУЗГ, Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, 2013) хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрийн хамрах хүрээ зорилго нь, Монгол улсын хэмжээнд МАА-н салбарын тогтвортой байдлыг хангах, малчдын амьжиргааг дэмжихэд чиглэдэг бол донор болон хандивлагч байгууллагуудын зүгээс бага малтай өрх, залуу малчид, эмэгтэйчүүд г.м тодорхой хэсэгт чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх хандлагатай байдаг. Судлан буй сэдэвтэй холбоотой малчид, МАА-н салбарт чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд үйлдвэрлэлд, мөн малчид дотооддоо ялгарахад хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад хэрэгжүүлж буй төлсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үйл ажиллагаа санхүүгийн ил тод байдал хязгаарлагдмал, төсөл хөтөлбөрт хамрагдагчдын мэдээлэл, хүрсэн үр дүнг нэгтгэн боловсруулсан нь хязгаарлагдмал, цэгцрээгүй тоон мэдээлэлд үндэслэн үр дүнг дүгнэх зэрэг бэрхшээлүүд их. Үүнтэй холбоотой тэмдэглэхэд Монгол улсын хэмжээнд хэрэгжүүлж буй, эсвэл тодорхой салбар чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн тайлан үр дүн, дата мэдээлэл бүхий нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх тал дээр Засгийн газрын түвшинд анхаарал хандуулж


ажиллах шаардлагатай юм. Энэ мэт бэрхшээлүүд бий боловч судлаачийн зүгээс зарим тоон болон чанарын үр дүнд малчдад хэрхэн хүрч, үйлчилдгийг тодруулъя.

Монгол мал үндэсний хөтөлбөр нь 5 бүлэг 30 дэд зорилт дэвшүүлснээс 43.3 хувь нь үйлдвэрлэлийн чанар, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил байгаагаас эцсийн үр дүнг “... экспортын баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжинө” гэж томъёолсон үйлдвэрлэлийн дэд бүтэц сүлжээг сайжруулах, үйлдвэрлэх бүтээгдэхүүний чанар гарцыг нэмэгдүүлэх, гадаад худалдааг дэмжих гэх олон талын ажил, үйлчилгээг хамрахаар байна (ХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019, р. 12). Хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнг ийм байдлаар ерөнхийлөн ойлгож болох бөгөөд зардал, санхүүжилтийн хувьд улсын төсвөөс 500 тэрбум төгрөг зарцуулахаар тусгаснаас 2010-2018 оны 485.6 тэрбум, орон нутгийн төсвөөс 95.9 тэрбум буюу нийт 581.5 төгрөг зарцуулснаас улсын хэмжээнд захиргааны болон үйл ажиллагааны зардлын бүтэц харьцаа, түүний үр өгөөж яаж гарсан тухайд тайлагнаагүй. Орон нутгийн төсвийн 50.6 хувийг дэд бүтэц буюу зам, эрчим хүч, түүхий эд боловсруулах үйлдвэр гэх мэт хөрөнгө оруулалтад, 23.4 хувийг малын эрүүл мэнд, 10 хувийг ус, худаг, 4.7 хувийг малчдын амьжиргааг дээшлүүлэхэд, 3.6 хувийг хадлан бэлтгэл, үлдсэн 7.7 хувийг бусад үйл ажиллагаанд зарцуулжээ (ХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019, pp. 22-23).

Салбарын суурь нөхцлийг сайжруулснаар эдийн засгийн бодит үр өгөөж нэмэгдэх, аж ахуй эрхлэгчдийн өмч, орлогын суурь дээшлэх учиртай. Гол асуудал нь хөтөлбөр үнэлгээний тайлан, үр дүнтэй танилцах явцад өнгөрсөн 11 жилийн хугацаанд Монгол улсын хэмжээнд МАА-н үйлдвэрлэлийн үр ашиг хэрхэн нэмэгдсэн, дотоод дахь үйлдвэрлэл төрөлжиж өссөн үү, үндэсний орлого бүрдүүлэхэд яаж нөлөөлсөн, МАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн үү, хөтөлбөр хэрэгжүүлснээр нийгэм эдийн засгийн үр дүн хэзээнээс гарч эхэлсэн, эцсийн үр ашгийг нь хэн, хэрхэн хүртэж байгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд эдийн засагт нийт хэдэн хувийн өсөлт үзүүлсэн гэсэн асуултуудад тодорхой хариу өгөх зайлшгүй шаардлагатай юм. Ялангуяа нийгэм эдийн засгийн үр өгөөжийг үнэлж, тооцох аргачлал бүрхэг бөгөөд үнэлгээний тайланд боловсрол, эрүүл мэнд, амьжиргаанд гарсан өөрчлөлтийн тухай цухас дурдаад энэ талын үр дүн хязгаарлагдмал (ХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019, pp. 49-54, 83) болохыг тэмдэглэжээ.

Монгол мал үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед малын тоо толгой 32.7 сая байсан бол 2020 онд 67.0 сая болж өссөн. Өнгөц харвал үүнийг уг хөтөлбөрийн үр дүн гэж үзэж болох ч үүнээс өмнө 2008 онд ноолуурын урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь малчдад шууд нөлөөлсөн. Сүргийн бүтэц харьцаа тогтворжих шинжтэй байгаа ч малын төрөл зүйл бүрээр тэр дундаа, хонь ямааны тоо 2010 оноос огцом нэмэгдэж, улам бүр өсөх болсон нь ноолуур, ноосны хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсний шууд үр нөлөө гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Шилжилтийн эхэн үед нийт сүргийн 58.3 хувийг хонь, 19.8 хувийг ямаа, 11.0 хувийг үхэр, 8.7 хувийг адуу, 2.1 хувийг тэмээ бүрдүүлж байсан бол 2005 он гэхэд сүргийн бүтцэд ямааны эзлэх хэмжээ нэмэгдэж 43.6 хувьд хүрсэн бол хонь 42.4 хувийг, адуу 6.7 хувийг, үхэр 6.5 хувийг, тэмээ 1.1 хувийг, 2020 оны байдлаар хонь 44.8 хувийг хонь, 41.3 хувийг ямаа, 7.1 хувийг үхэр, 6.1 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзлэх болсон (ҮСГ, Малын тоо (төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багаар, хороогоор, жилээр), 2021).

Зураг 3. Мал сүргийн бүтэц (тоон үзүүлэлт)



Эх сурвалж: ҮСХ-ны бүртгэл мэдээлэл

Үндэсний хэмжээний ялангуяа, малчдын амьжиргаанд шууд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хамрагдалт өндөр, олон улсын хөрөнгө оруулагчдын зүгээс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хамрагдалт харьцангуй доогуур, зарцуулж буй хөрөнгийн хэмжээгээр ОУ-ын төслийн хөрөнгө оруулалт өндөр байх жишээтэй.

Хүснэгт 9. Төсөл, хөтөлбөрт хамрагдалт (хувиар)

Хэрэгжүүлэгч	Хөтөлбөрүүд	Хамрагдалт
--------------	-------------	------------

Үндэсний хөтөлбөр, арга хэмжээ	Ноос ноолуурын урамшуулал	85.6
	Арьс ширний урамшуулал	67.7
	Залуу малчдыг малжуулах хөтөлбөр	8.5
	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3.0
	Монгол мал үндэсний хөтөлбөр	1.4
Олон улсын санхүүжилттэй	ШХА-ыг “Ногоон алт” төсөл	11.2
	Дэлхийн зөн ОУБ-ын хөтөлбөр	7.3

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Бодлого нь “өсөлт”-ийг давхар (ямааны тоо толгойн өсөлт) урамшуулж буй бөгөөд малчид энэ төрлийн бүтээгдэхүүнээс нэгд түүхий эдээ холбогдох хоршоодоор дамжуулж, эсвэл зах зээлд шууд нийлүүлэх замаар, хоёрт Засгийн газрын хөтөлбөрийн урамшууллаас ашиг хүртдэг. Тухайлбал, 2011-2019 онд 196.5 тэрбум төгрөгийн ноосны урамшуулал (ХХААХҮЯ, 2020), ноолуурын урамшуулалд 2020 онд 196.099 малчин хамрагдаж, 170.779.6 тэрбум төгрөгийн урамшуулал (Өдрийн сонин, 2020)-д олгожээ. “Малчин өрхийн мөнгөн орлогын зонхилох хэсгийг ямааны ноолуур бүрдүүлж байна. Судлагдсан нэг өрх дунджаар 500 орчим мянган төгрөгийн орлогыг зөвхөн ямаанаас үүний 90 орчим хувийг зөвхөн ноолуураас олдог. Энэ нь малчин өрхийн жилийн мөнгөн орлогын 50 гаруй хувийг эзэлнэ. Зөвхөн ямааны ноолуураас 14 сая төгрөгийн орлогыг нэг жилд олсон өрх ч судалгаанд хамрагдсан...” (Пүрэв.Ц, Хөдөөгийн өрхийн хэрэглээ, аж байдлын үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт, 2006, р. 162) гэж тэмдэглэж байсан бол 2018 онд буюу судалгаа хийх үед 14 саяас дээш төгрөгийн орлого олсон 44 өрх байснаас хамгийн их нь 53.5 сая төгрөгийн орлого олжээ. Өөрөөр хэлбэл, зах зээлд шилжих үеэс малчид санхүүгийн хэрэгцээндээ хөтлөгдөн ямааны тоо толгойг нэмэгдүүлэх (орлогын голлох эх үүсвэр учир) чиглэлд ихээхэн анхаарч эхэлсэн, мөн төрөөс ноос ноолуурын урамшуулал зарласан, мөн зах зээл дэх бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэг нь ийнхүү сүргийн бүтэц харьцаа өөрчлөгдөхөд нөлөөлжээ. Хөдөө аж ахуйн бирж (mce.mn) байгуулсан ч бүтээгдэхүүний төрөл туйлын хангалтгүй ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос гэсэн гурван төрлийн бүтээгдэхүүнээр хязгаарлагддаг.

Бодлогын эерэг талыг харвал малчдын амьжиргааг дэмжих, МАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хоршоодоор дамжуулж МАА-н үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, дэд бүтэц, сүлжээ үүсгэх, НД, ЭМД, эрсдэлийн даатгалын зэрэг үйлчилгээнд бүрэн хамруулах зэрэг бодлого хэрэгжиж байгаа юм (МХААХҮХ, 2010). Бэлчээрийн аж ахуй голлон буй үйлдвэрлэлийн нөхцөлд энэ мэт үйлчилгээг хоршоодоор дамжуулж малчдад хүрэх нь оновчтой хувилбар байж болох талтай ч

“Малчдын аж байдал” судалгаанд оролцогчдын 37.6 хувь нь ямар хоршооны гишүүнчлэлтэй бөгөөд үүнээс 37.0 хувь нь л хоршооллож ажиллах нь ач холбогдолтой гэж үнэлсэн. Шийдэж, зохицуулах нэлээдгүй асуудал байгаа нь үүнээс харагдах ба малчдын зүгээс юуны түрүүнд түүхий эд хүлээн авах, нийлүүлэх ложистикийн үйлчилгээг нарийн төлөвлөх (16.2%), хөрөнгө, санхүүгийн хувьд бэхжүүлэх (13.5%), бүрэн гишүүнчлэлтэй болгох (12.8%), үйл ажиллагааг нь тогтворжуулах буюу түүхий эд бүтээгдэхүүний боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлтийн цогц стандарт нэвтрүүлэх (11.7%), хоршоод жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд санхүүгийн болон материал, мэдээллийн дэмжлэг үзүүлэх (11.7%), хоршоодын удирдлагуудыг чадавхжуулах (9.5%), нээлттэй гишүүнчлэлтэй болгох (5.9%) зэрэг арга хэмжээнүүдийг нэн түрүүнд хэрэгжүүлэх. Өөрөөр хэлбэл, суурь нөхцөл буюу үйлдвэрлэлийн бодит капиталд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай болох нь харагдаж байгаа юм. Хоршоодыг ийм байдлаар дэмжин ажилласнаар хөдөө дэх ажилгүйдэл, ажилгүйдлийн асуудал шийдэгдэх, хүний болон үйлдвэрлэлийн нөөцийг үр ашигтай ашиглах боломж нөхцөл бүрдэх бөгөөд сайн үр дүн бүхий жишээ баримт олон (МХААХҮХ, 2010). Монгол улс 2019 онд мах 545.027 тн, сүү 1.074.234 тн, ноос 33.692 тн, ноолуур 10.944 тн, арьс шир 19.555.770 ширхэг үйлдвэрлэсэн гэж мэдээллэсэн бөгөөд эдгээрийн хэдэн хувь нь эргэлтэд орж, хэдэн хувийг ашиглаагүй, зах зээлийн нийт үйлдвэрлэлийн хэдий хэмжээ нь болох, үр ашгийг малчдад хэрхэн хүргэх тухай асуудал эргэлзээтэй. "Хөгжил, хөгжлийн явц, эсхүл хөгжлийн үзүүлэлт гэдэг бол нийгэм, үндэстэн, улс орон хэрэгцээндээ тулгарсан юмаа өөрөө үйлдвэрлэж бүтээх, ашиглах, эдгээр ажил хэргээ зохион байгуулах ур чадварын үе шат, сайхь үе шатны шинж чанар юм" (Даш-Ёндон.Б, Нийгмийг танихуй: түүх-хөгжлийн философи, 2014, р. 237) гэснийг үндэслэвэл өөрсдийн гэлгүй, гадаад зах зээл (Бакей.А, Хөдөө аж ахуйн эдийн засаг, 2014, р. 4)-д нийлүүлэхүйц нөөц бий. Өнөөдөр жишээлбэл, хоршоодын үйл ажиллагааг жигдрүүлж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, биржийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, гадаад худалдааг нэмэгдүүлэх, борлуулсан бүтээгдэхүүний үр ашгийг хоршоодоор дамжуулж эргээд малчдад түгээх байдлаар бодит үр ашгийг нь нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр бөгөөд үүнийг бодлогоор дэмжин ажиллаж байгаа ч өмнө тэмдэглэсэн бэрхшээлүүд бас бий.

Бодлогын сөрөг нөлөө нь үр ашгаасаа дутахгүй. МАА-н салбар бүхэлдээ эрсдэлд орохуйц нөхцөлд хүрч болзошгүй бөгөөд малын тоо хэмжээ, сүргийн бүтэц алдагдсантай холбоотой сөрөг нөлөөлөл үүсч байгаа юм. Нийт мал сүргийн тоо хэмжээг зохицуулах талаар чанаржуулах байдлаар тоо хэмжээг нь бууруулах, бэлчээрийг нь өмчлүүлэх, татвар татаасаар зохицуулах зэрэг шийдлийн хэд хэдэн хувилбар яригддаг. Малын тоо хэмжээг бууруулна гэдэг нь малчдын амин зуулгатай холбогдох асуудал учир шууд хэрэгжүүлэх боломжгүй. Бэлчээр өмчлүүлэх тухайд ОУ-ын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч бэлчээрийн талбайн хэмжээ бага, гарц муудсан, малчдын хоорондын зөрчил нэмэгдэнэ гэх шалтгаануудын улмаас эсэргүүцдэг. Татвар хураамжаар зохицуулах асуудлыг малчид дэмжиж (63.2%) буй бөгөөд үүний үр дүнг бэлчээр сэргэнэ (76.8%), малын чанарт илүү анхаардаг болно (40.0%), ус худгийн хүрэлцээ нэмэгдэнэ (27.0%), малын эрүүл ахуй сайжирна (15.5%), ажлын ачаалал буурна (9.8%) гэж эерэг талыг нь онцолж байгаагийн зэрэгцээ бага малтай иргэд ядууралд өртөх эрсдэлтэй (7.2%) гэх хүн ч цөөнгүй. Зарим нэг нөөц боломж ашиглах буюу усжуулалтын байршлыг оновчтой болгох бэлчээрийн талбайн хэмжээг нэмэх, талхлалтаас сэргийлэх боломжтой (Цэрэндаш.С, Төмөржав.М, Гомбосүрэн.Ч, 2003, pp. 51-52).

Сүргийн бүтцэд ямааны тоо толгой давамгайлах нь бэлчээрт ихээхэн халгаатай бөгөөд "Зун эрт хялгана-хазаар-алаг өвст бэлчээрт ямаа 1 өдөр идээшлэхдээ 38 удаа хөрсийг малтаж 2.5 ам метр талбайд ургасан ургамлын 198 ургал найлзуурыг бүрэн гэмтээсэн нь хонь идээшлэсэн хэсгээс 3 дахин их талбайн ургамлын найлзуурыг гэмтээж байна." (Оюунцэцэг.Ч, 2006, р. 158), "... тэмээ нь 1 см квадрат талбайд 0.44 кг-тай тэнцэхүйц даралт учруулдаг бол ямаа нь тэмэнээс 2-3 дахин илүү даралт үзүүлж хөрсний механик бүтэц, бүрэлдэхүүнийг эвддэг, идээшлэхдээ өвс, ургамлыг үндсээр нь зулгааж идэхийн дээр ургамлын үржлийн ба ургал эрхтэнг сорчлон иддэг тул бэлчээрийн дахин сэргэлтэнд хэт сөрөг нөлөөтэй" (Мөнхтамир.Д, 2017, р. 105) гэж судалгааны тайлан материалуудад тэмдэглэжээ. Тэгэхлээр цөлжилт, бэлчээр талхлах үзэгдэл нь малын тоо хэмжээ, цаг уурын өөрчлөлтөөс гадна сүргийн бүтэц харьцаанаас хамаардаг болохыг илэрхийлж буй тул бодлого төлөвлөхдөө үүнийг харгалзах шаардлагатай болж байгаа юм. Гэхдээ сүргийн бүтэц дэх ямааны тоо толгой буурах тохиолдолд малчдын орлого дагаж буурах эрсдэлтэй учир орлогын тогтвортой байдлыг

хадгалж үлдэх арга замыг тодорхойлох шаардлага үүснэ. Шийдлийн хувьд фермержүүлэх тухай асуудал яригддаг ч МАА-г бүхэлд нь ийм хэлбэрт шилжүүлэх бололцоо бага, байгалийн эрсдэлд дасан зохицсон малыг таваарлаг үйлдвэрлэлээр солих нь ч эрсдэлтэй. “Монгол мал үндэсний хөтөлбөр”-т “Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулах, бэлчээрийн даац хэтэрсэн нутагт байлгах малын тооны дээд хязгаарыг тогтоож, түүнээс давуулахгүй байлгах эдийн засгийн хөшүүргийг бий болгох” гэсэн чухал заалт орсон боловч чухам хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус (Бакей.А, Хөдөө аж ахуйн эдийн засаг, 2014, pp. 221-222) болохыг онцолсон байдаг.

Малчин хүн бэлчээрийн гарц, хүрэлцээг харж, тооцон ойрын болон холын бэлчээр тохируулах, нүүдэл суудал хийх нь мөн чанартаа гарч болох эрсдлийг бууруулахад чиглэсэн хөдөлгөөн боловч мал сүргийн бүтэц өөрчлөгдсөнөөр энэ нь байгалийн эсрэг үйлдэл болон хувирч, малчдын амьдралын хэмнэл, хэв маягт зохих нөлөө үзүүлэх болсон юм. ХХААХҮЯ-ны харъяа Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны мэдээлснээр Завхан, Дорнод, Хэнтий, Говь-Алтай, Увс, Говьсүмбэр, Ховд, Төв аймгийн отрын бүс нутагт 527 өрхийн 467039 мал (ХХАХҮЯ, 2018), 2020-2021 тайланд 2771 өрхийн 2.601.623 (Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, 2021), хоёр жилийн өмнөхөөс 5 дахин их мал отроор өвөлжих болж. Отрын бүс нутгуудад өвөлжих малын тоо ийм боловч тухайн орон нутаг, засаг захиргааны нэгжийн доторх, эсвэл хил залгаа аймаг, орон нутаг руу чиглэсэн отор, нүүдэл хийж буй малчид, малын тоог гаргадаг бол үүнээс хэд дахин өндөр тоо гарна. Малчид отор нүүдлийн тоо, хамрах талбай нэмэгдсэн. Энэ нь нэгд цаг уурын өөрчлөлтийн үр дагавар болж, хоёрт бэлчээр хамгаалах чиглэлээр сүргийн бүтцийг тохируулдаг уламжлалт мэдлэг, хандлага ашгийн төлөөх үзэл хандлагаар солигдсонтой холбоотой.

Бэлчээрийн талхлалттай холбоотой сүүлийн жилүүдэд бэлчээр өмчлүүлэх, түрээслүүлэх тухай ихэд ярих болсон. Үүний нэг жишээ, Дэлхийн зөн ОУБ-аас логикийн хувьд хэт их зөрчилтэй (өөрийн бэлчээртэй болж худаг ус гаргаж харж хамгаалах, цөөлөх, нэг нутагт удаан суухгүйгээр бэлчээр сэлгэх, малтайгаа ярьж нутаг сэлгэж чаддаг байх, цаг хүндэрвэл нүүж очих нөөц нутагтай байх), малчдын эдийн засгийн ашиг сонирхлын эсрэг (Малынхаа тоо толгойг бэлчээрийн даац, багтаамжид ямагт тохируулж байх) зөвлөмж (Дэлхийн Зөн Монгол, 2003, р. 39) гаргасан. Эл

асуудлаар ярьж дэмжигчдийн тоо ч нэмэгдэх төлөвтэй болжээ. Цөөн баримт сөхвөл"... бэлчээрийг эхний удаад үнэгүйгээр хуваарилан эзэмшүүлэх нөхцөлд малын тоо болон ам бүлийн тоог харгалзан (40:60 гэсэн харьцаатай) хуваарилах нь нийгмийн шударга ёсонд илүү нийцнэ гэж үзэж байна." (Дорлигсүрэн.Д, Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудалд, 2006, р. 63), "Монгол орны бэлчээрийн хөрс ургамлан нөмрөгийн доройтлын сүүлийн үеийн явцаас үзэхэд цаашид бэлчээрийг уламжлалт аргаар ашиглах нэгэнт боломжгүй болсон... Бэлчээрийн газрыг малчдад урт хугацаагаар эзэмшүүлэх асуудлыг хууль эрх зүйн хувьд шийдмээр байна." (Аваадорж.А, 2006, р. 123), "Захиран зарцуулах эрхийг зөвхөн өмчтөн эдэлдэг бол эзэмших ба ашиглах эрхийг бусдад шилжүүлж болдог. Бэлчээрийг малчдад эзэмшүүлэх нь түүнд эзний ёсоор хандаж, даацыг нь хэтрүүлэхгүй байх хуваарьтай ашиглах, бэлчээр сайжруулах талаар санаачлагатай ажиллах сонирхлыг бий болгоно." (Батхишиг.Б, 2018, р. 175) г.м-ээр МАА-н гол үндэс болсон бэлчээрийг хувьчлах, хумих асуудал ярьж байгаа нь соёл уламжлал, үйлдвэрлэл, байгаль орчин, нийгмийн харилцааны гээд олон зүйлд харшилна.

УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн “Бэлчээрийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалд “... малчин өрхийн 40 гаруй хувь буюу 18 аймгийн 136 сумын нутаг дэвсгэрт малчдын өөрсдийн үүсгэл санаачлага дээр тулгуурлан бий болсон 1360 гаруй бэлчээр ашиглагчдын хэсэгт бэлчээрийг гэрээгээр хамгаалуулж, ашиглуулах ажлыг хэрэгжүүлж байна.” гэж тэмдэглэсэн байдаг. “Малчдын аж байдал” судалгаанд оролцогчдын 78.4 хувь нь эсэргүүцэж байгаа, 16.0 хувь нь дэмжиж, 5.6 хувь мэдэхгүй гэсэн нь энэ талын мэдээлэл иргэдэд бүрэн хүрээгүй, хүлээн зөвшөөрөөгүйг илэрхийлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүч түрсэн, тулгасан шинжтэй шийдвэр байж болзошгүй. Эсэргүүцэж буй хүмүүсийн зүгээс олонх нь (64.8%) малчдын хооронд зөрчил тэмцэл үүснэ гэж болгоомжилж байгаа бол 15.9 хувь нь өвс ус дагаж нүүдэллэх боломжгүй болно, 7.9 хувь нь бэлчээр талбайн хэмжээ бага, ургамлын гарц муу учир бэлчээрээр аж ахуйгаа эрхлэхээс өөр аргагүй, 3.4 хувь нь нүүдлийн гэх уламжлалт хэв маяг алдагдана, 2.6 хувь нь эрх мэдэлтэй, мөнгөтэй хүмүүс, мөн гадныхан газар оронд эзэн сууна, 1.9 хувь нь ган зуд болвол хэцүүднэ, 1.3 хувь нь хуулинд зааснаар үлдээх, 1.1 хувь нь бага малтай хүмүүс хохирно, 0.5 хувь нь шинэ залуу малчид хохирно, 0.3 хувь нь мал тарга тэвээрэг авахгүй, 0.3 хувь нь цөлжилт үүсэх эрсдэлтэй гэжээ. Тэгэхлээр хүч түрсэн

шийдвэр гаргахаас бусад тохиолдолд малчдын зүгээс эсэргүүцэлтэй тулна. Дэмжиж буй хүмүүсийн тухайд бэлчээр сэргэнэ гэж 36.7 хувь нь, өөрсдийн өмчлөлийн бэлчээртэй болно гэж 28.6 хувь нь, малын тоо цөөрнө гэж 20.4 хувь нь, тохитой амьдарна гэж 6.1 хувь нь, фермерүүдэд зөв гэж 6.1 хувь нь, газраа тордож арчлах боломжтой гэж 2.0 хувь нь хариулжээ.

Бэлчээр өмчлүүлэх асуудлыг дэмжиж буй хэсэг байгаа боловч зарим нэг туршлага, үр дүнг заавал тодруулах шаардлагатай бөгөөд судлаачид энэ мэт зүйлийг анхаарвал зохилтой. Өвөр Монголд энэ аргачлалыг хэрэглэж буй боловч нөхцөл байдал хүндэрсэн тухай цөөнгүй баримт, жишээ дэлгэж болно. Б.Алтангариг “Уламжлалт нүүдэл малжил нь дөрвөн улирлаар тасралтгүй нүүдэллэдэг тул бэлчээр сэлгэж, өвс ургамлын ургалтанд ашигтай мөртлөө улирлаар тасралтгүй нүүдэллэдэг тул бэлчээр сэлгэж, өвс ургамлын ургалтанд ашигтай мөртлөө улирлын чанартай уур амьсгалын хувиралтанд зохицож малын хүч таргыг баталдаг юм. Зүүн үзэмчин хошуу бэлчээр нутаг хуваах үед зүүн хэсгийн Мандахбулаг зэрэг сумын малчид хүйтэн, халуун хоёр улирлыг харгалзан бэлчээр нутаг хувааж олсныг гаргавал өмнө хэсэг баруун хэсгийн сум балгасын малчид үндсэндээ улирлыг харгалзан бэлчээр нутаг хувааж олгосонгүй. Жилийн тунадасны хэмжээ 300 мм ч хүрэхгүй бөгөөд услалтыг ашиглан таримал тарихад зохихгүй дан хуурай тал нутагт бэлчээр нутгийг тогтмол болгосон нь амархан туурайн зуд¹¹ үүсэхэд хүргэжээ. Бидний магадласнаар туурайн гамшиг үүссэн шалтгаан нь бэлчээр нутгийг хэсэглэн хуваасан ба торлосонд оршино.” (Алтангариг.Б, 2016, pp. 58-59) гэж сөрөг нөлөөллийг нь тодорхой тэмдэглэсэн.


Доктор Н.Хавх "Монголын түүхэнд газраа гурван удаа хувьчилж байж, гэхдээ гол төлөв харийнханд эзлэгдсэн тэр түүхэн үедээ". Үүнд: 1) Уйгурын хаант улсын үед бэлчээр феодалуудын хувийн өмч болж, тэд малын бэлчээрийн төлөө өөр хоорондоо байлдан дайтсаар 90 гаруйхан жилийн дараа дотоодын тэмцэл байлдаанаас болж задран бутран мөхсөн, 2) Кидан гүрний үед хоёр дахь удаа газар, бэлчээр хувьчилсан бөгөөд монгол угсаатны тусгаар тогтнол хүнд байдалд орж, 3) 1906 онд "Бээжинд тариачин хятадыг монголд нүүлгэх оруулах товчоо" байгуулан, монгол газрыг тариалангийн

¹¹ Тайлбар: Туурайн зуд гэж “Малчдын ойлголтоор, мал сүрэг нь торлосон, тогтоосон хэмжээтэй бэлчээр дээр дөрвөн улирлын турш бэлчээвэл өвс бэлчээр ба хөрсийг гишгэлэн талхидаж, бэлчээр сэлбэхгүйн дээр ган хуурай уур амьсгал давхацвал хөрсний шим аажмаар алдагдаж, өвс бэлчээр шимгүйтэн гандаж хувхайрдаг байна.” (Алтангариг.Б, 2016, p. 51).

талбай, хятад хувь хүмүүсийн хувийн өмч болгож эхэлсэн бөгөөд 1915-1921 онд хувьчлал хүчээ авсан. 1915 оны гурван улсын гэрээгээр Монгол Хятадын автономит эрхтэй нэгэн муж болсон нь газрыг хувийн өмч болгох ажилд чөлөөт зам нээж өгсөн (Хавх.Н, Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан, 2000, pp. 126-127) гэж тэмдэглэн үлдээсэн нь “Бэлчээрийн” гэх хуулийн асуудал яригдаж буй энэ цагт мартаж үл болох асуудал юм.

Өмнө бүс нутгийн онцлогоос хамааралтай малын тоо толгой өөрчлөгдөж, тэр нь малчдын амьжиргаанд нөлөөлдөг тухай нэлээд дэлгэрэнгүй тэмдэглэсэн. Бодлогын хувьд бэлчээрийн бүс, түүнд нийцүүлэн дэд бүтэц хөгжүүлэх ажлыг эргэн харвал зохилтой. “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа”-ын эцсийн дэлгэрэнгүй тайлан ХАА-н үйлдвэрлэлийг 18 байршилд хөгжүүлэхээр төлөвлөсний нэгийг зүүн бүсд, үлдсэн 17 нь төвийн болон говийн бүсд байрлах ба үүний нэгийг Дундговь аймагт, хоёрыг Өмнөговь аймагт, үлдсэн 14-ийг Төв, Сэлэнгэ, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Завхан аймгуудад байгуулахаар төлөвлөжээ. Төлөвлөлтийн зургаас баруун болон зүүн бүсийн малчдаас ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байрлах цэгээс алслагдмал зайд буюу орон зайн хуваарилалт тэнцвэртэй бус (ЖАЙКА, Алмек корпораци, ЭКСИ, Идея ХХК, 2016, pp. 5-ийн 11).

Зураг 4. ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байгуулах байрлал



Бэлчээрийн МАА голлосон аж ахуйд зохицуулан бэлчээр хийгээд аж үйлдвэр хөгжүүлэх төлөвлөгөөг дараах байдлаар зохицуулах нь үр ашигтай байж болох талтай. Үүнд "... бэлчээрийн мал аж ахуйг эдийн засгийн бүсчлэлд хэрхэн хамруулах тухай асуудлыг сайтар бодолцох хэрэгтэй. Эдийн засгийн бүс хангай, хээр тал, говийн аль

алиныг нь багтаасан, өөрөөр хэлбэл хойноос урагш чиглэсэн байх тусмаа сайн. Манай уамжлалт засаг захиргаа, эдийн засгийн хуваарь ч тийм байсан. Энэ нь байгаль, цаг уурын хүндрэл тохиолдсон нөхцөлд мал сүргийг өнтэй, өвс бэлчээр сайтай нутаг руу оторлуулах боломжийг олгоно. Учир нь эдийн засгийн бүсийн дотор ингэж чөлөөтэй нүүдлэх боломжтой байх ёстой." (Батхишиг.Б, 2018, р. 219) гэсэн малчдын аж ахуйн шаардлага, уламжлал, эрсдлийг бууруулахад үр дүнтэй.МАА-н үйлдвэрлэл дэх байгалийн хийгээд бодлогын хүчин зүйлийн нөлөө, малчид өмчийн хувьд ялгарахад хэрхэн нөлөөлж байгаа, цаашид бодлогын хувьд ямар зүйлүүдэд анхаарах вэ гэсэн асуудлыг нь дээрх байдлаар гаргалаа.

Хоёрт, малчдын амьжиргаа, нийгмийн хамгааллыг дээшлүүлэх чиглэлээр “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” (УИХ, Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, 2009), “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” (УИХ, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай, 2017), “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” (Сангийн яам, 2018), “Монгол малчин үндэсний хөтөлбөр” (МУЗГ, Монгол малчин үндэсний хөтөлбөр, 2020)-өөс гадна МУ-ын хэмжээнд хэрэгжиж буй нэгдсэн бодлого хөтөлбөрүүд дэх салбарт хамаарах зорилго, зорилтууд туссан.

Нийгмийн шинж байдлаар ялгаатай бүлгүүдийн асуудлыг бодлогод хэрхэн тусгаж, тэр нь ямар байдлаар үйлчилж байна вэ гэдэг нь зайлшгүй хөндөх асуудал юм. Малчдын нийгмийн асуудлаар “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын баримтыг 2009 онд баталж 2020 оныг хүртэл хэрэгжүүлсэн бөгөөд нийт 46 дэд зорилт дэвшүүлснээс 15 нь, “Монгол малчин үндэсний хөтөлбөр” (МУЗГ, Монгол малчин үндэсний хөтөлбөр, 2020)-ийг 44 зорилттой баталснаас 12 (хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 2, мэдлэг, мэдээлэл түгээх 4, амьжиргаа дэмжих 2, нийгмийн үйлчилгээний 1, тодорхой бүлэгт чиглэсэн 3) нь малчдын нийгмийн асуудлыг шийдэхэд чиглэсэн бол хоёр хөтөлбөр дэх үлдсэн зорилтууд нь МАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрсдлийг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хэрхэн хангах тухай юм. Эдгээрээс эхний хөтөлбөрт малчдын доторх ялгаатай бүлэгт чиглэсэн гурав, дараагийн хөтөлбөрт гурван зорилт тусгажээ. Эхний хөтөлбөрт туслах малчны хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх тухай тусгаж 2017, 2017 онд тус бүр нэг ажил хийсэн

(ХХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019, р. 27) гэж тэмдэглэсэн ч ямар баримт бичиг гаргасан талаар тусгаагүй бөгөөд үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээнд гурван ажил хийснээс нэгийг нь 70 хувьтай, хоёрыг нь 100 хувь гүйцэтгэсэн гэжээ.

Хүснэгт 10. Хөтөлбөрүүд дэх нийгмийн бүлгүүдэд чиглэсэн зорилт

	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого	Монгол малчин үндэсний хөтөлбөр
Нийт малчдад чиглэсэн	3.2.18. мал аж ахуйн хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилж хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх	4.5.11. ... хөдөлмөрөө хөнгөвчлөх боломж нөхцөлийг сайжруулж, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх
	3.3.10. малчдад зориулсан зайны сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	4.3.3. малчдын хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг тогтоох арга зүйг боловсруулж, нэвтрүүлэх
	3.3.4. малчид, малчин өрх, мал аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийн талаархи мэдээллийн цогц сан бий болгон ажиллуулж малчдыг мэдээллээр хангах	4.1.5. малчдад хэрэгцээт мэдээллийг шуурхай хүргэх, энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж орон зайн хамаарлыг бууруулах
	3.3.11. малчдад зориулсан сонин, сэтгүүл тогтмол гаргахыг дэмжих	4.2.8. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, ангилал, чанар, үнийг сум, дүүрэг, аймаг, нийслэл тус бүрээр нийтэд мэдээлэх
	3.3.8. малчин өрхийн эдийн засаг, бизнес, ур чадварын түвшинд нийцсэн сургалтын ялгавартай хөтөлбөр бий болгож хөгжүүлэх	4.1.7. “ухаалаг” аж ахуй эрхлэх мэдлэгийг түгээж, малчдыг чадавхжуулах
	3.3.6. малчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол, бүрэн хамруулж, зардлыг төрөөс хариуцах	4.1.3. орон нутгийн онцлогтой, мал аж ахуйд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэж, түгээн дэлгэрүүлэхэд малчдын оролцоог нэмэгдүүлэх
	3.1.6. нийгмийн даатгалд заавал хамруулах тогтолцоонд шилжүүлэх	4.5.10. соёл урлагийн болон бусад ахуйн үйлчилгээг сайжруулах, малчдыг өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах ажлыг идэвхжүүлэх
	3.3.13. малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах оновчтой арга механизмыг бий болгох	4.5.9. малчдыг тогтмол орлого, хуримтлалтай болгох зорилгоор мал, мах бэлтгэн нийлүүлэх арга хэмжээг идэвхжүүлж ... талуудын хамтын ажиллагааг нягтруулах
	3.1.7. хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг арилгах	4.2.6. чанараас хамаарсан үнэ, үнэлгээний ач холбогдлыг малчдад таниулах
	3.3.7. ... мал, амьтнаас хүнд дамжин халдварлах өвчнөөс малчид ... урьдчилан сэргийлэх ... хөтөлбөр хэрэгжүүлэх	4.3.2. туслах малчны хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх
Ялгаа бүхий бүлэгт	3.1.2. хувь хүний орлогын албан татвараас малчин өрхийг чөлөөлж...	4.5.2. “Залуу малчин” төсөл, дэд хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, малчдын орлого, ашгийг нэмэгдүүлэх
	3.2.9. шилжин суурьшсан малчин байсан иргэдийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан нийгмийн үйлчилгээнд хамруулах	4.5.2. малчдын хүүхэд бага ангид шинээр элсэн суралцахтай холбогдон ... хүндрэлийг багасгахад чиглэгдсэн шинэ арга барилыг нэвтрүүлэх
	3.1.5. ... туслах малчны хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх	

Туслах малчдад чиглэсэн гэх ажлуудаас “Дархан-Уул аймагт Дэлхийн зөн ОУБ-тай хамтран хэрэгжүүлдэг “Хүүхдийн төлөөх орон нутаг” төслийн хүрээнд “Гэр бэлэглэе” аяны шалгаруулалтаар Хонгор, Дархан сумдын 2 туслах малчинд гэр олгосон”, “Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, байнгын ажилтай, тогтмол орлоготой болгох, малчин ажил олгогч болон туслах малчдын хөдөлмөрийн харилцааг сайжруулах зорилгоор хот суурин газраас хөдөө, орон нутагт шилжин суурьшиж, олон малтай малчны малыг гэрээгээр маллах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Гэрээт малчин - өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл”-ийг 2018 оны 8 дугаар сараас хэрэгжүүллээ. Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрт 2018 оны эцсийн байдлаар нийт 225 ажил олгогч малчин, 223 гэрээт малчин өрхийн 406 иргэн ажлын байраар хангагдаж 51.0 сая төгрөг зарцуулсан байна. Энэхүү төслийг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэн Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн арга хэмжээ болгон боловсруулж, ХЭҮЗ-ийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор шинэчлэн батлан хэрэгжүүлж байна.” (ХХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019, pp. 46, 48) гэжээ. Орлого багатай малчдад ур чадвар олгох, ажлын байраар хангах тухай зорилтын үр дүнг туслах малчны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилттой дээрх байдлаар хамт хэрэгжүүлсний зэрэгцээ тусад нь “Орлого багатай малчдыг бусад төрлийн аж ахуй эрхлэх, бие даан бизнес эрхлэх ур чадварыг дээшлүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдний хэрэгцээ, чадавх, санаачилгыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх”-ээр төлөвлөсөн ч хэрэгжээгүй (ХХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019, p. 82).

Хөтөлбөрийн зорилтод тодорхой тусгаагүй боловч “НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй “Монгол улсад ажлын байр нэмэгдүүлэх нь (Бүрэлдэхүүн хэсэг 2): Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” төслийн санхүүжилтээр сүүний цехийн тоног төхөөрөмжийг Дорнод, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн 6 сумын эмэгтэйчүүдийн сүү үйлдвэрлэгчдийн бүлгүүдэд хоногт 500 л сүү боловсруулах хүчин чадалтай нийт 63 гаруй сая төгрөгийн гэр цехийн тоног төхөөрөмжийг 2018 оны 6 дугаар сард хүлээлгэн өгсөн.”; “... нийт 20 -иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй болж тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан”

(ХХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019, pp. 32, 50) гэж тайланд тэмдэглэжээ. Мөн хөтөлбөрийн эхний шатны тайланд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөдөө, орон нутагт гүйцэтэгдэг бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх чиглэлээр 2012 онд 4558 өрхийн малчдыг ажиллуулж нийт 595.0 сая, 2013 онд 4408 өрхийн малчдыг ажиллууж 587.1 сая төгрөгийн цалин урамшуулал, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр “Улсын төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдийн гэрээнд орон нутгийн малчдаас тодорхой тооны малчинг авч ажиллуулах заалт оруулан 2012 онд 240 малчинг ажиллуулж 96 сая, 2013 онд 320 малчинг ажиллуулж 128 сая төгрөгийн цалин, урамшуулал олгосон бол Засгийн газрын “Орон нутгийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай” 2013 оны 210 дугаар тогтоолын хүрээнд сумдын өвсний нөөц бүрдүүлэх ажлын малчид, малчдын хоршоогоор гүйцэтгүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулсаны үр дүнд нийт 50 гаруй сумын нөөцөд 2,6 мянган тн өвсийг 312,0 сая төгрөгөөр малчид, малчдын хоршооноос худалдан авсан.” гэж тайланд тусгажээ (Тайлангийн эх онлайнаас устсан бөгөөд хүснэгтэлсэн тайлангийн эх файл хэлбэрээр бий). Гүйцэтгэлийн тайлангаас орлого багатай, цөөн малтай өрх хамрагдаж чадсан уу гэдэг нь эргэлзээтэй.

Бодлогын зорилт, хэрэгжүүлсэн ажилтай холбоотой тэмдэглэхэд, хэрэв уг хөтөлбөр нь малчдын нийгмийн асуудлыг шийдэхэд чиглэсэн бол туслах, орлого багатай, залуу, эмэгтэй гэх хэв маягуудаас гадна нас, хүйс, боловсрол, гэр бүл, ам бүлийн тоо, аж ахуй эрхэлж буй арга, суурьшлын гээд ялгаатай хэв маягууд дахь ялгааг арилгах, бууруулах гэхээс илүүтэй (үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой зарим ялгааг арилгах боломжгүй) тэдгээрт буй асуудал бэрхшээлийг шийдэх, гарч болох эрсдлүүдийг бууруулах, эсвэл суурь нөхцлийг нь сайжруулах г.м байдлаар төлөвлөх ёстой байжээ. Гэтэл хөтөлбөрүүд дэх зорилт, агуулга, тэдгээрийн хүрээнд хийсэн ажил зэргийг харахад малчдад чиглэсэн бодлого, хөтөлбөр гэж үзэх боломжгүй.

Бодлогын хэрэгжилтийн үнэлгээний тайлан (ХХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019)-д малчдад чиглэсэн ажил хийсэн тухай тэмдэглэсэн боловч тэдгээрийн ихэнх нь МАА-н үйлдвэрлэлтэй холбоотой хэрэгжүүлсэн ажлууд байгаа юм. “Монгол малчин үндэсний хөтөлбөр”-т нийт малчдад хамаарах, мөн туслах болон залуу малчин гэж ялгаа бүхий хоёр бүлэгт чиглэсэн зорилт дэвшүүлсэн нь өмнө хэрэгжсэн хөтөлбөрөөс ялгарах зүйлгүй. Асуудлаа оноогүй хөтөлбөр, нийгмийн судалгааны үр дүнд үндэслэгдээгүй эл

хөтөлбөр нь цаашид энд тэндээс мөнгө хөрөнгө босгох хэрэгсэл төдийгөөр ашиглагдах (дэд зорилт бүр дээр хөрөнгө татах зорилготой) бүрэн үндэс бүхий, дээр дурдсан малчдын ялгаатай бүлгүүд дэх асуудал, бэрхшээлийг шийдэх боломжгүй хөтөлбөр болсныг нь харуулж байна. Тухайлбал, эрсдлийн даатгалын үйлчилгээний үр ашиг шууд хүрч байх ёстой. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 20 хувь нь малаа бүрэн даатгуулсан бол 6.0 хувь нь зарим хэсгийг нь даатгуулсан аж. Статистикт даатгуулсан малчдын тоо 4.6 дахин (нийт малчин өрхийн 17.9%), малын тоо 7.2 дахин өссөн аж (ҮСХ, Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчин өрх, даатгуулсан малын тоо (бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр, жил бүрийн эцэст), 2020).

Зураг 5. Даатгалд хамрагдсан малчид, малын тоо



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.


Эдгээр баримтыг, тухайлбал даатгалд хамрагдсан малчид, малын тоо хэмжээг өссөн тухай тэмдэглэсэн боловч хэдэн малчин яаж даатгалын нөхөн төлбөр авсан тухай баримт тэмдэглэгдээгүй. Даатгалд хамруулах үйлчилгээг зах зээлийн нийгэмд шилжихээс өмнө эхлүүлж үр дүн нь хэнд, хэрхэн хүрсэн нь тодорхойгүй байгаа юм. Эдийн засагч Ө.Ганзориг “Монголчууд 1963 онд малыг заавал даатгах тухай хууль баталж 1970-аад оны үед Ллойдс дээр зудаас болж малаа алдах эрсдлээ даатгуулсан байдаг. Тэр байтугай 1983 оны зудын дараа Ллойдоос чамгүй хэмжээний нөхөн төлбөр авсан мэдээ ч байна.” (Ганзориг.Ө, 2021, р. 91) гэжээ.

Өнөө цагт “Даатгалын сурталчилгааг Малчдадаа зориулан цаг тооны бичиг 20.0 мянган ширхгийг, “Даатгал” сонинг 40.0 мянган ширхэг, Төрийн болон Хаан банкны сурталчилгааны зурагт хуудас нийт 1000 ширхэг, 2000 ширхэг гарын авлагыг тараасан.”

(ХХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019, р. 34) г.м байдлаар үр дүнг тайлбарласан нь бодлогын хүрээнд хэрэгжиж буй зорилт, түүний үр өгөөжид найдах боломжгүй гэмээр дүр зураг харагдаж байгаа юм. Судалгаанд оролцогчдын 8.6 хувь нь сүргийнхээ 6 хүртэл хувийг, 9.0 хувь нь 6-30 хувийг, 8.6 хувь нь 30-аас дээш хувийг алдсан (275 малчин) ч үүнийг 1.1 хувь нь буюу 3 малчин даатгалаас эрсдлийн нөхөн төлбөр гаргуулсан (бүрэн бус) бол 98.9 хувь нь даатгалын нөхөн төлбөр гаргуулж чадаагүй аж. Даатгалын нөхөн төлбөр олгох нөхцөл, шалгуур нь хувь малчинд бус даатгагчид ашигтай байдлаар зохицуулагджээ. “Малын индексжүүлсэн даатгалын тухай” хууль (УИХ, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, 2017)-ийн зорилтод “... даатгагч болон даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад...” чиглэсэн гээд энэ хуулийн 3.3-т малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд даатгуулж болно гэж тэмдэглэсэн боловч тухайн нэг суманд харъяалагдах даатгалд хамрагдсан нэг, эсвэл нижгээд малчин ямар нэг эрсдэлт хүчин зүйлийн улмаас малаа алдсан тохиолдол үүссэн байлаа ч тэр нь Засгийн газраас тогтоосны дагуу сумын нийт малын зургаан хувьд хүрээгүй тохиолдолд хуулийн 12.1-д заасан нөхөн төлбөр (Олгох үндэслэл нь: 6.3 “... сумын малын хорогдлын хувийг малын төрөл тус бүрээр гаргаж, ...”, 12.1 “... даатгалын гэрээ)-ийг авах бололцоогүй (12.3) болж байгаа юм. Одоогийн түвшинд энэ чиглэлийн үйлчилгээ нь малчдыг сангийн “хөрөнгө бүрдүүлэх эх үүсвэр” байдлаар ашигладаг гэх ойлголтыг төрүүлж буй бөгөөд ийм байх боломж, нөхцлийг хуульчлан баталсан.

Ялгаатай бүлэгт чиглэсэн зорилтоос гадна “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” нь хөтөлбөрийг хоёр үе шаттай буюу эхний шат (2009-2015 он)-нд малчдын орлогын түвшин 50 хувиар өсч, эрүүл мэндийн даатгалд 70-аас доошгүй, нийгмийн даатгалд 50-аас доошгүй хувийг хамруулсан байхаар, хоёр дахь шат (2016- 2020 он)-нд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь, орлогын түвшин 80 хувиар өсч амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна гэж тусгасан. Хэрэгжилтийн үр дүнг харвал, 2017 оны статистикийн мэдээнд малчдын 23.9 хувь нь НДШ төлдөг гэсэн бол ЭМД-д 65.3 (2020 оны байдлаар 73.7%) хувь нь хамрагджээ. “Малчдын аж байдал” судалгаанд оролцсон малчдын 31.5 хувь нь НДШ, 67.4 хувь нь ЭМД сүүлийн 12 сарын байдлаар төлсөн гэжээ. Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш гурван жилийн хугацаанд эхний үе шатны зорилт хангагдаагүй, бага зэргийн өсөлт үзүүлжээ.

Зураг 6. Даатгалд хамрагдалт (хувиар)



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Даатгалд хамрагдагчид, 45-54 хүртэл насныхны 42.4 хувь, 35-44 насныхны 27.4 хувь, 25-34 насныхны 22.9 хувь, 24 хүртэл насныхны 13.6 хувь нь, 55-аас дээш насныхны 23.1 хувь нь, хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн 28.1 хувь нь, эмэгтэйчүүдийн 36.0 хувь нь, боловсролын түвшнээр дээд боловсролтой малчдын 41.0 хувь нь, ТМС-ийн боловсролтой малчдын 29.2 хувь нь, бүрэн дунд боловсролтой малчдын 38.6 хувь нь, суурь боловсролтой малчдын 24.4 хувь нь, бага боловсролтой малчдын 19.0 хувь нь, боловсрол эзэмшээгүй малчдын 25.8 хувь нь, гэрлэлтийн хэв маягаар тусгаарласан малчдын 83.3 хувь нь, цуцалсан малчдын 40.0 хувь нь, бэлэвсэн хүмүүсийн 36.5 хувь нь, гэрлээгүй хүмүүсийн 31.3 хувь нь, гэрлэсэн хүмүүсийн 27.4 хувь нь НДШ төлдөг. ЭМД-ийн тухайд насны бүлэг дээшлэх тусам төлөлт нэмэгдэж (24 хүртэл насныхны 68.2%, 25-34 насныхны 70.3%, 35-44 насныхны 72.2%, 45-54 насныхны 79.2%, 55-аас дээш 48.7%) байгаа бол хүйсийн хувьд ойролцоо (эрэгтэй 67.6%, эмэгтэй 65.8%), боловсролын түвшин дээшлэхэд даатгалд хамрагдагчдын эзлэх хэмжээ нэмэгдэх (боловсрол эзэмшээгүй 59.6%, бага 63.5%, суурь 65.4%, бүрэн дунд 74.7%, ТМС 56.9%, дээд 76.9%) хандлагатай байна.

Ажиллаж буй хэлбэрээр хөлсний малчдын даатгалын үйлчилгээнд хамрагдалт өндөр, туслах малчдынх бага, аж ахуй эрхлэх аргын хувьд уламжлалт аж ахуй эрхлэгчдийн хамрагдалт өндөр, хосолсон аж ахуй эрхлэгчдийнх бага, суурьшлын хэлбэрээр хөдөөгийн малчдын хамрагдалт өндөр, нийслэлийн малчдынх бага хувьтай байна.

Хүснэгт 11. Даатгалын үйлчилгээний хамрагдалт (хувиар)

Хэв маяг		ЭМД-ийн хамрагдалт	НД-ийн хамрагдалт
Ажиллаж буй хэлбэр	Үндсэн	67.0	29.3
	Туслах	40.0	25.0
	Хөлсний	75.0	37.5
Аж ахуй эрхлэх арга	Уламжлалт	68.2	29.2
	Фермер	64.3	28.6
	Уламжлалт болон фермер	48.6	22.9
Суурьшлын бүс	Нийслэлийн малчид	50.0	22.0
	Аймаг, сумын төвийн ойролцоох малчид	67.2	31.5
	Хөдөөгийн малчид	68.8	28.3

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Нийгмийн үйлчилгээний хамрагдалтаас гадна малчдын тухай шийдвэр гаргах түвшин дэх шууд оролцоо туйлын хангалтгүй. Хурал зөвлөгөөн зохион байгуулахад үг хэлэхээс хэтэрдэггүй. "... Монголын хууль тогтоох дээд байгууллага - Ардын их хурлын депутат нарын тодорхой хувьд нь малчин ардаас оруулан сонгуулдаг журамтай байлаа. Энэ бүхэн нь малчдыг төрийн хэрэгт оролцуулах нэг хэлбэр болж байв. Тэр ч байтугай ардчилал шинэчлэлийн жилүүдэд алдарт малчин Ц.Намхайнямбуу, Г.Лхагважав зэрэг малчдыг Улсын Их хурлын гишүүнээр сонгож, хууль тогтоох ажилд оролцуулж байв. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын адуучин Дашдооров МАХН-ын онц их хурал (1990) дээр монгол малын генефондыг хамгаалах зэрэг олон чухал санал гаргаж байсан ба 1993 онд болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Монголын ардчилсан намаас түүний нэрийг дэвшүүлэн хэлэлцүүлж байсан нь санамсаргүй хэрэг гэж үү. Энэ бүхэн бол монгол амьдралаа ямар нэгэн "изм"-гүй, үнэн мөнөөр нь мэддэг малчны хар ухааныг төрийн бодлогод ашигладаг, зөвхөн Монголд л байдаг үзэгдэл." (Сумьяа.Б, 2005, pp. 53-54) оролцож байсан туршлага байсан ч өнөө цагт залуу малчны, мянгат малчны, туслах малчны, эмэгтэй малчны гэх хурал зөвлөгөөн зохион байгуулах болсон нь шууд оролцоо бус. Хатуугаар хэлэхэд эрх баригч намууд улс төрийн байр суурь ахиулах, ухуулгын хэрэгсэл байдлаар ашиглах талын зүйл ажиглагддаг бөгөөд хурал зөвлөгөөний талаарх мэдээлэл хаалттай, тэдгээрийн үр дүнд ямар бодлого, хөтөлбөрт хэрхэн тусгасан тухай мэдээлэл ч бүрхэг байдаг.

Хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх нь үйлдвэрлэлийн хувьд, нөөцийн үр ашгийг өсгөх, малчдын орлогыг нэмэгдүүлэх гээд олон талын ач холбогдолтой. Гэвч "... 4477 хоршоо байгаа нь нийт бүртгэлтэй ААН, байгууллагын 2.6 хувийг бүрдүүлж

байна. ... нийт хоршоодын 61 хувь нь буюу 2732 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа, 19 хувь нь үйл ажиллагаа эрхлээгүй, 23.6 хувь нь үйл ажиллагаа нь түр зогссон, үлдсэн хувь нь үйл ажиллагаа нь бүрэн зогссон” (ХХАХҮЯ, 2018) гэж тэмдэглэсэн байдаг. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд мөн хоршоодын үйл ажиллагааг бэхжүүлэх, гишүүнчлэлийн тоог нэмэгдүүлэх, үүгээр дамжуулж НДШ, ЭМДШ, татвар авах, малын гаралтай түүхий эд бэлтгэх, тээвэрлэх г.м үр дүнтэй байдлаар хөгжүүлэх боломжтой ч “Малчдын аж байдал” судалгаанд оролцогчдын 37.6 хувь нь хоршоонд гишүүнчлэлтэй бол эдгээрээс НДШ төлдөг нь 26.8 хувь, ЭМДШ төлдөг 11.4 хувь, эрсдэлийн даатгал төлдөг гэж 10.1 хувь нь хариулжээ. Харин хоршооны гишүүнчлэлгүй малчдын 17.5 хувь нь НДШ, 40.7 хувь нь ЭМДШ, 9.9 хувь нь эрсдэлийн даатгал төлдөг гэсэн нь бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Гурав, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хөрөнгө оруулагчдын зүгээс тухайлбал, ШХА, Дэлхийн зөн, НҮБ, Мерси кор, ЖАЙКА, Азийн хөгжлийн банк зэрэг хөрөнгө оруулагчид болон хүмүүнлэгийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр гэж ангилж болно. Олон улсын төсөл хөтөлбөрийн үр дүн нийт малчдын зохих хэсэгт ийнхүү ямар нэг байдлаар хүрдэг ч улс орны хэмжээнд үр ашиг нь яаж тусдаг нь сонирхолтой? Тодруулбал, өрхийн малын тоо толгойг өсгөх, малтай болгох, бэлчээр хамгаалах, ядуурлыг бууруулах, амьжиргаа дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудын дэмжлэг, хөрөнгө оруулалтаар 2006 оныг хүртэл 77.5 сая долларын төсөл хөтөлбөр (МУЗГ, UNDP, 2006, р. 10) хэрэгжүүлсэн. Сүүлийн хориод жилийн хугацаанд олон улсын байгууллагын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт нь улам бүр нэмэгдсэн байх магадлал өндөр. Гол нь тэдгээр нь нийт малчдад бус тодорхой бүлэг, төлөөллийг хамруулан их хэмжээний хөрөнгө зарцуулдаг жишиг тогтсон. Дурдан буй зардлыг 2006 оны ханш (Монгол банк, 2006, р. 146)-аар хөрвүүлэхэд 91.551,0 тэрбум төгрөг зарцуулсан нь 2009 он (2006 оны мэдээлэл статистикийн электрон санд бүртгэгдээгүй)-д ХАА-н салбарт зарцуулсан төсвийн хөрөнгө оруулалт (21.034,5)-ын үнийн дүнгээс 4.35 дахин давсан үзүүлэлттэй байгаа юм. Судалгааны дата мэдээллээс эдгээрийн үр дүнг нэг жишээгээр гаргахад, ОУ-ын болон орон нутгийн төсөл хөтөлбөрт хамрагдаж малтай болсон өрх 4.4 хувь (хөрөнгө оруулалт олон чиглэлд хийгдэж байгаа)-тай байгаа бол туслах малчдаа малжуулсан санаачлагын үр дүнд судлагдсан 2.6 хувь нь малтай болжээ. Зарим шүүмжлэлтэй

зүйлүүд байгаагийн зэрэгцээ жишээлбэл, Швейцарын хөгжлийн агентлагаас сүүлийн 17 жилийн хугацаанд бэлчээр хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ 18 аймгийн 166 суманд 1500 гаруй малчдын хэсэг байгуулж 20.6 сая га бэлчээр нөхөн сэргээсэн туршлага мэдлэг хуримтлуулж, ашиглаж байгаа нь олзуурхуштай.

ОУ-ын хөрөнгө оруулалтаар өндөр дүн бүхий зардал гаргадаг ч маш жижиг бүлгийг хамарсан (бодлогын хэмжээнд үр ашгийг нь нэмэгдүүлэхэд бага анхаардаг) байдлаар маш өндөр зардал бүхий төсөл хэрэгжүүлдэг бөгөөд зарим төсөл хөтөлбөрийн бодит үр дүн нь хязгаарлагдмал байгаа нь энэ мэт үр дүнгээс харагдаж буй тул төсөл хөтөлбөрийн бодит үр өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс хөрөнгө оруулалтыг салбарын дэд бүтэц, аж үйлдвэр хөгжүүлэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмж нийлүүлэх, ашиглах сургалтын чиглэлд зарцуулах нь өгөөжтэй. Мөн нэг ажлыг нөгөөгөөр орлуулж тооцдог бодлогын алдааг засаж залруулах шаардлагатай юм. Тухайлбал, малжуулах чиглэлд өөрсдийн боломж бололцоог ашиглах, нөөц бүрэн бүрдсэн нь судалгааны үр дүнгээр баталгаажиж буй тул олон малтай айл өрхүүдийг ажил олгогч, малжуулах төсөл хэрэгжүүлэгч байдлаар дэмжиж туслах зардлыг бууруулах, нөөцийг үр ашигтай зүйлд зарцуулах боломж байна. Олон тооны, эсвэл хөлсөөр малчин ажиллуулдаг айл өрх шууд ажлын байр бий болгож байгаагийн зэрэгцээ МАА-н гаралтай түүхий эд борлуулж, боловсруулдаг хувь хүн, үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулах боломжоор хангаж байгаа нь дам ажлын байруудыг бий болгодог. Гэхдээ МАА-н салбараас хамааралтай ажлын байрны бүртгэл мэдээлэл цэгцтэй бус (MWCA, 2017, р. 9; ХХААХҮЯ, 2019, р. 24) бөгөөд сүү сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур, яс болон бусад дайвар бүтээгдэхүүн худалдах боловсруулах г.м байдлаар ангилж бий болсон ажлын байрны бүртгэл, мэдээлэл хөтлөх хэрэгцээ байгаа юм. Тухайлбал, ҮСХ-оос “Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдал” судалгаагаар 2020 онд (I-VI) хөдөө аж ахуйн үйлдвэрлэл ДНБ-ий 12.4 хувийг бүрдүүлж байсан бол 2021 оны мөн үед 4.6 хувь болж буурсан (ҮСХ, Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдал, 2021) нь онцгой нөхцөл байдлын үед малчид болон МАА-н салбараас хамааралтай худалдаа, үйлдвэрлэл эрхэлж буй субъектүүдийн үр өгөөжийг тогтвортой хадгалах нөөц бодлого, эсвэл шуурхай зохицуулах боломж бүрдэнэ.

Үйлдвэрлэлийн явц дахь хувь хүний оролцоо, үр дүн. Өмч хийгээд амьжиргааны эх үүсвэр болох малын тоо хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлэхэд үйл явц бүрт

малчин хүний оролцоо, чадамж голлох нөлөө үзүүлдэг. Эцэст нь малчид өөр хооронд ийнхүү ялгарахад малын тоо, сүргийн бүтцээр, үүнээс улбаатай орлого хэрэглээний зүйлсээр ялгарч буй тул өмчийн анхдагч эх үүсвэр болох малын тоо хэмжээ ямар хүчин зүйлээс хамаардаг болохыг тодруулъя. Бүдүүвч-2-д үйлдвэрлэлийн үр ашиг нь хувь хүний боломж буюу бие махбодийн хэвийн байдал, мэдлэг ухамсар, сэтгэл зүйн хандлагаар тодорхойлогдоно гэсний дагуу шинжилгээ хийхэд үр дүн тодорхой хэмжээгээр батлагдаж байна.

Биеийн болон хүн хүчний боломжийн тухайд тус судалгаанд оролцсон малчдын 7 хувь нь өөрийгөө хөгжлийн бэрхшээлтэй (харааны 13, хэл ярианы 3, сонсголын 10, хөдөлгөөний 23, мэдрэлийн 8, хавсарсан 5, бусад 11) гэж тодорхойлсон бөгөөд 74.0 хувь нь олдмол, 36.0 төрөлхийн гэж. Тэдгээрийн насны бүтцийг харвал 70 гаруй хувийг 45-аас дээш насныхан (41.1 хувь нь 55-аас дээш насны, 31.5 хувь нь 45-54 насны) бүрдүүлж байгаа бол 19.2 хувийг 35-44, 8.2 хувийг 25-34 насныхан, хүйсийн эрэгтэй (83.6)-чүүд зонхилж байна. Хөгжлийн бэрхшээлтэй малчдын 91.2 хувь нь 40 хүртэл тооны малтай, 8.8 хувь нь 41 (41, 60, 219, 283, 345)-ээс дээш тооны мал малладаг аж.

Мэдлэг хийгээд сэтгэл зүйн боломжийн тухайд бэлчээрийн хэв маягаар адил, засаг захиргааны нэг бүсд амьдарч буй, адилхан малч удамтай, туршлага ижил малчид ямар шалтгааны улмаас адил биш тооны мал маллаж, адил биш амьдралын түвшин, хэрэглээний хангамжтай байна гэдэг нь сонирхолтой асуулт юм.

Малчин хүний мэдлэгийг илэрхийлэх үзүүлэлт нь эрсдлийг бууруулах арга ажиллагаа (нүүдлийн тоо, нэмэгдэл тэжээл, эрдэс бодис авах, сүрэг хуваах, мал зарах, мал муулах, хашаа саравч барих, отор нүүдэл хийх)-ны үр дүн бөгөөд энэ нь малын тоо, чанарын өсөлтөөр илрэн гардаг. Үүнийг илэрхийлэх үзүүлэлтүүдийн хооронд хамаарал тооцоход бараг бүх үзүүлэлтийн хооронд эерэг утга зааж байгаа нь малын тоо өсөхийн хэрээр тухайн арга хэмжээг авдаг, эсрэгээр эрсдлээс хамгаалах, тогтвортой байдлыг хангах арга хэмжээний үр дүн нь малын өсөлтөөр хангагддаг гэсэн үг юм.

Хүснэгт 12. Эрсдэл бууруулах арга: малын тоо, арга ажиллагааны хамааралт шинж (Пирсоны корреляцийн коэффициент¹²)

	1	2	3	4	5	6	7
1. Өөрийн нийт малын тоо	1.0						
2. Нүүдлийн тоо	.452**	1.0					
3. Нэмэгдэл тэжээл, эрдэс бодис авах	.032	.053*	1.0				
4. Сүргээ хуваасан	.166**	.123**	.023	1.0			
5. Мал зарсан	.143**	.090**	.066*	.142**	1.0		
6. Мал махалсан	.150**	.101**	.084**	.089**	.530**	1.0	
7. Хашаа саравч барьж, сэлбэсэн	.047	-.058*	.281**	.107**	.085**	.167**	1.0
8. Оторг явуулсан	.222**	.260**	.421**	.061*	.101**	.129**	.128**

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Нүүж суух, буурь сэлгэх нь эрсдлийг бууруулах, тогтвортой байдлыг хангах уламжлалт мэдлэгт, мөн амьдралын зайлшгүй хэмнэл гэж тооцогдох ч малын тоо хэмжээ гэсэн үзүүлэлттэй хамаарал тооцоход эерэг дундаж ($r = 0.452^{**}$) хамаарал илэрчээ. Ц.Балхаажав энэ тухайд "Хэн ямар малчин бэ гэдгээс арга нь ч, дэг журам нь ч хамаардаг тул урьдчилан дурсах нэг зүйл байна. Энд малчныг үндсэнд нь гурав хувааж болно. Удамтай, заяаны, ясны, төрөхийн, угийн, багын, харахаас адтай, сайн малчин гэгдэж үнэлэгддэг жинхэнэ малчин. Тийм хүмүүс нэг их олонгүй. Гэтэл өөдгүй, арчгүй, залхуу, муу малчин гэж бий. Тиймэрхүү нь ч бас төдий л их биш. Энэ хоёрын дунд хувиа борлуулаад л байдаг ердийн малчид л дийлэнх олонхи нь байх." (Балхаажав,Ц, 1992, р. 23) гэж тэмдэглэсэн нь бодитой аж. Хонин толгойд шилжүүлсэн малын дундаж хийгээд нүүдлийн тоо гэх үзүүлэлтүүдийн хооронд дундаж үзүүлэлт тооцоход 534 хүртэл тооны малтай өрх 3.2, 535-аас дээш тооны малтай өрх 4.8 удаа нүүж сууж бэлчээр сэлгэдэг аж.

Мал зарах, муулах ($r = 0.530^{**}$), нэмэгдэл тэжээл, эрдэс бодис авах ($r = 0.421^{**}$) зэрэг үзүүлэлтүүдийн хооронд эерэг дундаж хамаарал илэрч байгаа нь нэг талаас мал маллахад нэг арга ажиллагааг дангаар хэрэглэдэггүйг, нөгөө талаас энэ бүх арга ажиллагаа нь эцсийн дүнд эрсдлийг бууруулж, тогтвортой байдлыг хангахад чиглэдгийг шууд илэрхийлж байгаа юм. “Малч ухаан” гэх хэлц ийм учиртай аж.

Малаас хүртэх ашиг шимийг нэмэгдүүлэхэд байгалийн таатай нөхцөл шууд нөлөөлөх боловч малчид олон жилийн туршлага, шинжлэх ухааны ололтын үр дүнд

¹² Хамаарах болон үл хамаарах хувьсагчдын хоорондын шугаман хамаарлын хүч болон чиглэлийг тодорхойлдог бөгөөд хамаарлын коэффициентийн утга нь -1.00 ба +1.00 утгын хооронд байрлана (Х.Абу-Бадер, 2013, р. 158).

эрдсэл даах чадвартай, таваарлаг шинж бүхий мал өсгөж, үржүүлэх чиглэлээр олон арга сэдэн, хэрэглэж байгаа юм.

Хүснэгт 13. Үр ашгийг нэмэгдүүлэх арга зам (Пирсоны корреляцийн коэффициент)

	1	2	3	4
1. Нийт орлого	1.0			
2. Малын эрүүл ахуйг сайжруулах	.118**	1.0		
3. Шилмэл үүлдрийн малтай болох	.161**	.235**	1.0	
4. Эрчимжсэн МАА хөгжүүлэх	.180**	.135**	.213**	1.0
5. Дэд бүтэц сайжруулах	.115**	.086**	.224**	.200**


Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Судлагдсан малчдын тухайд үр ашгийг нь нэмэгдүүлэх буюу шууд утгаар тэсвэрлэг, таваарлаг чанартай малын тоог нэмэгдүүлэхийн тулд малын эрүүл ахуйг сайжруулах, шилжмэл үүлдрийн малтай болох, МАА-г эрчимжүүлэх зэрэг аж ахуй эрхлэлттэй холбоотой арга ажиллагаануудыг хэрэглэдэг. Холбогдох шинжилгээний үр дүнгээс хүчтэй бус боловч эерэг үр дүн илэрч байгаа юм. Үйлдвэрлэлийн арга хэлбэр (Хавсралт-5. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх арга зам ба үйлдвэрлэл эрхэлж буй арга хооронд хамаарал тооцсон үр дүн)-ээс хамаарч тухайлбал, уламжлалт үйлдвэрлэлд малын эрүүл ахуй, шилмэл үүлдэртэй болох, таваарлаг чанарын аль алиныг нь харгалзан орлого нэмэгдүүлэх санаачлага, ажиллагаа зэрэгцэн өрнөх зүй тогтолтой байгаа бол фермерийн аж ахуйд бүтээгдэхүүний гарц (Маралмаа.А, 2015)-ыг нэмэгдүүлэх байдлаар орлого нэмэгдүүлэх ($r = 0.404^*$), үйлдвэрлэлийн аргыг хослуулан хэрэглэж буй аж ахуй шууд орлого гэхээс илүүтэй малын таваарлаг чанарыг сайжруулах, эрчимжүүлэх зэрэг ажиллагаа нь дэд бүтцээс хамааралтай ($r = 0.474^{**}$) буюу дам үр дүнг эрэлхийлсэн шинжтэй болох нь хамаарал тооцсон үр дүнгүүдээс харагдаж байгаа юм.

3.2. Малчдын ялгааг илэрхийлэх хүчин зүйлсийн шинжилгээ

Өнөөдрийн малчид төлөвших шилжилтийн үеийн эдийн засгийн, нийгмийн, бодлогын шинжтэй олон хүчин зүйл нөлөөлсөн. Юуны түрүүнд одоогийн малчдын гэх бие даасан бүлэг бүрэлдэн төлөвшихөд өмч хувьчлах үйл явц хүчтэй нөлөөлсөн. 1991 оноос эхэлж 1993 он гэхэд нийт малын 70.2 хувийг (ШУА-ийн ФСЭХ, 2013, р. 410) хувьд шилжүүлснээр малчид тоо хэмжээний хувьд өргөжсөн юм.

Зураг 7. Өмч хувьчлал ба малчдын өсөлт (мянгачилсан үр дүн)



Эх сурвалж: ҮСХ-ны бүртгэл мэдээлэл

Хувьчлалын үр дүнд, 1989 оны сүүл гэхэд монгол улсын хэмжээнд 135.4 мянган малчин бүртгэлтэй байсан бол 1993 онд энэ тоо 347.9 мянгад хүрч 2.6 дахин, 2000 он гэхэд малчдын тоо 421.4 мянга (ҮСГ, Монгол улс зах зээлд статистикийн эмхтгэл, 2004, р. 163; ҮСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл-2007, 2008; ҮСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл-2010, 2011)-д хүрч 3.1 дахин өссөн. Шилжилтийн үеийн мал аж ахуйн салбарт гарсан энэхүү өөрчлөлт, өргөжилтийг академич Ш.Бира, ОХУ-ын монголч эрдэмтэн В.В.Грайворонский, Германы Ф.Мюллер зэрэг эрдэмтэд “дахин нүүдэлчлэх” буюу “реномадизмын” үзэгдэл (Энхтүвшин.Б С. , 2015, р. 31) хэмээн нэрлэсэн. Өдгөө харьцангуй тогтворжсон эл үзэгдлийн шалтгааныг судлаач Д.Мөнхтөр:

1. Өмнө нь оршин тогтнож асан социалист хүрээллийн улс орнууд дахь улс төрийн донсолгоонуудын нөлөөллөөр Монголд төрийн социализм нуран

унаж, улс орон бүхэлдээ улс төр – эдийн засгийн шинэ бүтэц рүү шилжиж эхэлсэн.

2. Дээрх ерөнхий шалтгааны улмаас улсын өмч байсан мал аж ахуйд бүрэн хувьчлал хийсэн.
3. Удирдлагын социалист тогтолцоо өөрчлөгдсөнтэй (угтаа түр зуурын хаос байдалд орсны улмаас) холбоотойгоор, ялангуяа хөдөөгийн жижиг сум суурингуудад ажлын байр ба амьдралын тогтсон социаль хэв ёс, тэнцвэр алдагдсаны улмаас мянга мянган хүн ажилгүй болж, амьдрахын тулд өөр шинэ сонголт хийхээс аргагүй байдалд орсон.
4. Улмаар нийгмийн албан ёсны институц болон байгууллагуудын дийлэнх нь гэнэтийн бөгөөд эрс хатуу эргэлтэд өртсөн тэр цаг үе дэх хөдөөгийн хүн амын зарим хэсгийн хувьд мал аж ахуй эрхлэх нь амьжиргаагаа залгуулах илүү аятай, гарын дор хэрэгсэл мэт харагдаж байсан нь ч мөн нэгэн шалтгаан болон заагдаж болох юм (Мөнхтөр.Д, Пост модерн соёлын нөхцөл дэх нүүдэлчид: шинэ эрсдэл үү, эсхүл боломж уу?, 2012, р. 156).

Ф.Ф.Мюллер “Монголын номадизм эргэж ирсэн нь” (Мюллер.Ф.Ф, 2002) “... Нүүдэлчдийн уламжлалт системд өөрсдийн нь эрхлэн хэрэгжүүлж байсан ажил үүргийг малын эмч, зоотехникчид, тээвэр, усны аж ахуйнхан, худалдаачид, засаг захиргаа, улс төрийн албаныхан, эрдэмтэн багш, соёл урлагийн хүмүүс хүлээж авсан юм. Тэд энэ ажлыг ямар ч малчны хийж байснаас илүү мэргэжлийн түвшинд гүйцэтгэж байв. Мал аж ахуйд туслах үүрэгтэй эдгээр мэргэжилтнүүд суурин байдлаар сум, аймгийн төв, нийслэл хотод сууж амьдрах болсон юм...” (НСИСОУХ, 2017, р. 47) гэж тэмдэглэсэн.

Шилжилтийн эхэн үед нийт хүн амын дунд малчдын эзлэх хэмжээ 6.9 хувь байсан бол 2000 онд 17.6 хувь болж өссөн бөгөөд үүнээс хойш буурсаар 2015 он гэхэд 9.7 хувьд хүрсэн (ҮСХ, Монгол улсын хүн амын тоо (хүйс, хот/хөдөөгөөр), 2021). Хөдөөгийн хүн амын дунд малчдын эзлэх хувь 1990 онд 15.5, 1995 онд 36.5, 2000 онд 41.6 болж өссөн бол үүнээс хойш буурсаар 2005 онд 35.7, 2010 онд 32.1, 2015 онд 31.0 хувийг эзлэж байна. Хөдөлмөрийн зах зээлийн багтаамж, харьцааны хувьд орон нутаг дахь ажиллагсдын эзлэх хэмжээ Улаанбаатар хотын ажиллагсдаас 1995 онд 3.1 дахин, 1996 онд 3.2 дахин, 1997 онд 3 дахин өндөр, харин хөдөөгийн ажиллагсдын дотор малчдын эзлэх хувийн жин 1990 оны эхнээс 2009 оныг хүртэлх хугацаанд, ялангуяа

1994-2001 оны хооронд бусад салбарт ажиллагсдаас 2-2.5 дахин их байсан бол үүнээс хойш буурсан (ҮСГ, Монгол улс зах зээлд статистикийн эмхтгэл, 2004; ҮСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл-2007, 2008; ҮСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл-2010, 2011; ҮСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл-2015, 2016) байна.

“Малчдын аж байдал” судалгааны үр дүнгээс нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийн үеийг баримжаалвал малчдын гэх бүлэг нь шилжилтийн өмнөх 14.9 хувь (31-ээс дээш жил, дундаж нас 59.4), шилжилтийн буюу өмч хувьчлалын 34.6 хувь (21-30 жил, дундаж нас 49.1), шилжилтийн дараах үе 50.5 хувь (20 хүртэл жил, дундаж нас 39)-ийн малчдаас бүрдэж байгаа юм.

Хүснэгт 14. Малчдын туршилага (Пирсоны корреляцын коэффициент)

	Мал малласан жил		
	20 хүртэл	21-30 жил	31-ээс дээш
Өвлөж авсан	33.8	23.4	9.9
Өмч хувьчлалаар	1.8	5.5	5.8
Худалдаж авсан	5.5	3.8	1.7
Малжуулах төсөлд хамрагдаж	2.9	1.1	0.5
Малаа маллуулж буй айл тасдаж өгсөн	2.4	0.4	-
Бусад	0.9	0.6	-

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Өнөөдөр малчдын дийлэнх хэсгийг удам дагасан малчид гэж үзэж болох ч тэдний нэлээдгүй хэсэг нь хуучин нэгдлийн үеийн үйлдвэр, ахуйн үйлчилгээний газар, САА, нэгдлийн ажилчдаас эхлээд сэхээтнүүд, 1990 оны дунд үеэс худалдаа наймаа эрхэлж байсан ажилтан албан хаагчид, тэдний үргэлжлэл, үр хойч юм. Тухайн үед мал дээр гарсан хүмүүсийн гарал үүслийг “Хөдөөгийн амьдралын хэв маяг: өөрчлөлт, хандлага” суурь судалгааны дата мэдээллээс тодруулахад дийлэнх хэсэг нь ажилчин ангид (64.2 хувь нь ажилчин ангийн төлөөлөл буюу үйлчилгээний болон үйлдвэрлэлийн чиглэлийн ажилчид, 11.9 хувь нь ХАА-н салбарт ажиллагсад), 9.6 хувь нь сэхээтний давхраанд хамаарч байжээ. Бусад (4.8%) гэсэн бүлэгт хамаарах хүмүүс харьцангуй хожуу мал маллаж эхэлсэн.

Хүснэгт 15. Малчдын гарал, үе залгамжлал (хувиар)


Ажилчин	64.2
Мэргэжлийн ажил (оёдол, тогооч, барилга, бичээч, жолооч, гуталчин, үсчин г.м)	35.7
Уул уурхайн салбарт (өрмийн мастер, туслах, хувиараа ашигт малтмал олборлогч)	9.5
Үйлдвэрийн ажилчин (цонх, мод боловсруулах, сүлжмэл, тоосгоны г.м)	7.1
Мэргэжил шаардахгүй ажил (хамгаалагч, зөөгч, галч, үйлчлэгч, манаач, түгээгч)	7.1
Нярав, ня/бо	4.8
ХАА-н салбарын ажилтан	11.9
Малчин, саальчин	7.1
Газар тариалан (үрийн будаа цэвэрлэх, хүнсний ногоо, тариа тарих)	4.8
Хувиараа аж ахуй Эрхлэж байсан	0.1
Сэхээтэн	9.6
Цэргийн байгууллагын ажилтан (харуулын дарга, хурандаа)	4.8
Банкны ажилтан (теллер, архивын ажилтан)	2.4
Мэргэшсан ажилтан (эмч, сувилагч, малын эмч, цаг уурч, эм зүйч, багш г.м)	2.4
Удирдах албан тушаал (сум, хороо, багийн дарга, орлогч)	0.0
Бусад	4.8
Худалдаа, наймаа	4.8
Ажил хийж байгаагүй	9.5

Эх сурвалж: “Хөдөөгийн амьдралын хэв маяг: өөрчлөлт, хандлага” суурь судалгаа. ШУА-ийн ФХ. 2015.

Судалгаанд оролцогчид (Малчдын аж байдал)-ын мэдээллээс харахад олонх нь (66.7%) удам дагасан малчид (эцэг эхийн таслаж өгсөн малыг үргэлжлүүлэн маллаж байгаа 57.4%, өвлөгдөж ирсэн гэж 9.3%) байна. Харин үлдсэн хэсэг нь өмч хувьчлалаар (13.6%), мал худалдан авч (11.3%), малжуулах төсөлд хамрагдаж (4.4%), туслах малчнаа малжуулсан (2.6%), өөр бусад (1.4%: ах дүү, хүүхдүүдийн дэмжлэгээр 3, бэлгэнд авсан 1, ажлын газраас өгсөн 1 г.м) хэлбэрээр малтай болжээ.

Малчдын гэх нийгмийн бүлэг бүрэлдэн тогтсон нь дээрх шалтгаантай бөгөөд өнөөдөр малчид хүн ам зүйн бүтэц харьцааны хувьд, мөн нийгмийн олон шинжээр өөр болжээ. Хүн ам зүйн талаас гэхэд, Монгол улсын нийт хүн амын дунд залуучууд буюу 34 насныхны эзлэх хэмжээ өндөр. Малчдын дунд энэ харьцаа 2005 оныг хүртэл хадгалагдаж (50 гаруй хувийг 34) байсан, 2010 оны тооллогоор залуу болон дунд насны малчдын харьцаа тэнцэж үүнээс хойш дунд насныхны эзлэх хэмжээ нэмэгдэж 50-иас дээш хувийг (ХНХЯ, ХНХСИ, 2018, р. 9) бүрдүүлэх болсон юм.

Зураг 8. Малчдын насны бүтэц, өөрчлөлт (хувиар)



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Хүйсийн харьцаа 2017 онд 128 (56.1 хувь нь эрэгтэй, 43.9 хувь нь эмэгтэй) буюу 100 малчин эмэгтэйд 128 малчин эрэгтэй ногдож байсан бол энэ үзүүлэлт 15-24 насны малчдын дунд 210 (67.7 хувь нь эрэгтэй, 32.3 хувь нь эмэгтэй), 65 ба түүнээс дээш насны малчдад 96 (51.1 хувь нь эмэгтэй, 48.9 хувь нь эрэгтэй) байна. Малчдын насны бүтэц, хүйсийн харьцаа ийнхүү өөрчлөгдөж байгаагаас үүдэлтэй нэг дүгээрт МАА-н салбар ажиллах хүчний хомсдолд орж, үүнээс улбаатай хумигдаж болзошгүйг хоёр дугаарт хүйсийн тэнцвэр алдагдсанаас үүдэлтэй залуучуудад суурьших үйл явцад татагдах, урт хугацаанд малчдын залгамж чанар алдагдах сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

“Малчдын аж байдал” сэдэвт судалгаанд тухайн үеийн статистикийн бүртгэл дэх малчдын насны бүтцийг харгалзан мэдээлэл цуглуулсан бөгөөд судалгаанд оролцогчдын дунд 24 хүртэл насны малчид 2.1 хувийг, 25-34 насныхан 18.3 хувийг, 35-44 насныхан 28.5 хувийг, 45-54 насныхан 25.1 хувийг, 55-аас дээш насныхан 26.0 хувийг бүрдүүлж байна. Судалгааны үндсэн мэдээллийг өрхийн тэргүүн (эрэгтэй 89.4%, эмэгтэй 10.6%: малчдын хувьд өрхийн статус нь хувь хүний статусыг тодорхойлно)-ээс авсан учир хүйсийн харьцаа статистик бүтцээс зөрнө.

Гэр бүлийн хэв маягийг тодруулахад нэгд хүн ам зүйн нөлөө, хоёрт нийгмийн хүчин зүйлээс хамаарал бүхий ялгаа ажиглагдана. Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 2.2 хувийг 24 хүртэл насныхан, 20.1 хувийг 25-34, 30.4 хувийг 35-44, 24.9 хувийг 45-54, 22.4 хувийг 55-аас дээш насныхан бүрдүүлж байгаа бол эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 56.8 хувийг 55-аас дээш насныхан дангаар, 27.0 хувийг 45-54, 12.6 хувийг 35-44, 2.7

хувийг 25-34, 0.9 хувийг 24 хүртэл насныхан эзлэж байна. Насны бүтцээр харьуулахад гэрлэсэн хүмүүсийн эзлэх хэмжээ бүх насныханд өндөр байгаа ч насны бүтцээс хамааралтай зарим ялгаа илэрч харагдана. Нас залуужих тусам гэрлээгүй хүмүүсийн, насны бүлэг дээшлэхэд бэлэвсэн хүмүүсийн эзлэх хэмжээ нэмэгдэж, тусгаарласан болон гэр бүл цуцалсан хүмүүс 35-54 насныхны дунд харьцангуй өндөр хувьтай байна.

Хүснэгт 16. Гэр бүлийн хэв маяг ба насны бүлэг (хувь)

	Дундаж	Насны бүлэг				
		24 хүртэл	25-34	35-44	45-54	55-аас дээш
Гэрлээгүй	4.6	31.8	7.8	5.4	3.4	0.4
Гэрлэсэн	84.0	68.2	90.6	90.6	83.3	74.0
Тусгаарласан	0.6	-	-	1.0	1.1	-
Цуцласан	1.0	-	1.0	1.0	0.4	1.5
Бэлэвсэн	9.9	-	0.5	2.0	11.7	24.2
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Ам бүлийн хувьд нэг өрх дунджаар 4 ам бүлтэй бол хамгийн ихдээ 8 хүртэл тооны гишүүд (2 хүртэл 16.8%, 3-4 гишүүнтэй 22.4%, 5-6 гишүүнтэй 60.4%, 7-8 гишүүнтэй 0.5%)-тэй. Гэр бүлийн хэв маяг хийгээд ам бүлийн тоог харьцуулсан үзүүлэлтээс харахад 5-6 ам бүлтэй өрхийн эзлэх хэмжээ хамгийн их аж. Нас, хүйс, боловсролын түвшнээр харьцуулахад мөн ийм харьцаа бүхий үр дүн гарна.

Хүснэгт 17. Гэр бүлийн хэв маяг ба ам бүлийн тоо (хувь)

	Ам бүлийн тоо				Нийт
	2 хүртэл	3-4	5-6	7-оос дээш	
Гэрлээгүй	12.5	18.8	68.8	-	100.0
Гэрлэсэн	16.8	22.1	60.5	0.6	100.0
Тусгаарласан	0.0	33.3	66.7	-	100.0
Цуцласан	40.0	20.0	40.0	-	100.0
Бэлэвсэн	17.3	26.0	56.7	-	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Нийгмийн шинж байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдээс боловсрол, туршлагын асуудлыг ялангуяа, нийгмийн ялгааг тодорхойлогч үзүүлэлт гэж тооцдог ч малчдад аль нь чухал ач холбогдолтой вэ гэсэн асуулт сонирхол татдаг. Ялангуяа, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаатай холбоотой, түүний үр дүнд үндэслэн (Хүснэгт 20. Нас ба малын тоо, орлогын ялгаа (дундаж үзүүлэлт, төгрөгөөр): Хүснэгт 20. Нас ба малын тоо, орлогын ялгаа: Хүснэгт 21. Боловсролын түвшин) энэ асуудлыг хөндөн тавих нь элбэг.

Судалгааны үр дүнгээс харахад малчдын 90.0 хувь нь (Бүрэнд дунд 31.6%, Бүрэн бус дунд 30.9%, Бага 19.0%, Боловсрол эзэмшээгүй 8.5%) бүрэн дундаас доош боловсролтой бол 10.0 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн гэжээ. Боловсролын үзүүлэлтийг насны бүлэгтэй харьцуулсан үр дүнгээс үеийн шинжтэй ялгаа харагдана. Тухайлбал, 24 хүртэл насныхан ББД-аас дээш 25-44, 55-аас дээш насныхны дунд боловсрол эзэмшээгүй хүмүүсийн эзлэх хэмжээ өндөр бол 45-54 хүртэл насныхны дийлэнх нь ББД, БД боловсрол эзэмшсэн аж.

Хүснэгт 18. Боловсролын түвшин (хувь)

	Боловсролын түвшин						НИЙТ
	Б-гүй	Бага	ББД	БД	ТМС	ДЭЭД	
24 хүртэл	-	-	22.7	36.4	18.2	22.7	100.0
25-34	13.5	18.8	21.9	35.9	2.1	7.8	100.0
35-44	9.0	21.4	36.8	30.1	0.7	2.0	100.0
45-54	4.9	8.0	36.7	37.5	10.6	2.3	100.0
55-аас дээш	8.4	28.9	25.6	24.2	9.9	2.9	100.0
Нийт	8.5%	19.0%	30.0%	31.6%	6.2	3.8%	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Нэгд залуучуудын мэргэжлийн боловсрол эзэмшихийг чухалчилж эцэг эх нь дэмжих болсон. “Хөдөөгийн амьдралын хэв маяг: өөрчлөлт, хандлага” сэдэвт судалгаанд оролцсон малчдын 14.0 хувь нь, гэхдээ хүйсийн хувьд ихэнхдээ эрэгтэй хүүхдээ малчин болгоно гэж байсан бол 43.6 хувь нь сургуульд сургаж мэргэжилтэй болгоно гэж, 42.4 хувь нь өөрсдийнх нь сонголт мэднэ гэж хариулсан байдаг. Малчин болгохгүй гэсэн шалтгааны дунд мэргэжил, боловсролтой болгоно гэсэн хариултын эзлэх хэмжээ дангаараа 68.1 хувийг эзлэж байгаа бол хэцүү хүнд ажил гэж 9.5 хувь нь, баталгаа муутай гэж 5.6 хувь нь хариулж, үлдсэн 16.8 хувь нь өөр бусад шалтгааныг тэмдэглэжээ (ШУА-ийн ФХ, 2018, р. 69). Тэгэхлээр өнөөдөр малчдын нас, хүйсийн бүтэц алдагдах болсон (Зураг 8. Малчдын насны бүтэц, өөрчлөлт) нь малчдын хандлага, залуусын мэдлэг боловсрол эзэмших сонирхол хийгээд түүний үр дүнтэй ийнхүү холбогдож байна. Хоёрт 25-44 насныхан нийгмийн шилжилтийн үеийн сурагчид бөгөөд тухайн үед сургууль завсардалт нэмэгдсэн үетэй давхцана. Сургуульд хамрагдалтын хувь 1989 онд 91.1 хувьтай байсан бол энэ үзүүлэлт 1993 оныг хүртэл буурч 69.7 хувь (ҮСГ, Монгол улс зах зээлд статистикийн эмхтгэл, 2004, р. 263)-д хүрч энэ үеэс эргэж нэмэгдсэн байдаг. Мал малласан туршлага (20.6 хувь нь 10, 29.9 хувь нь 11-20 жил, 34.6 хувь нь 21-30 жил, 10.5 хувь нь 31-40, 4.4 хувь нь 41-ээс дээш жил мал малласан)-ыг

илэрхийлэх үзүүлэлтийг боловсролын түвшинтэй харьцуулахад өмнөх үр дүн давтадана.

Боловсролын үзүүлэлтийг гэр бүлийн хэв маягтай харьцуулахад техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн малчдын дунд гэр бүл тусгаарлах, цуцалсан тохиолдол бүртгэгдээгүй бол суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүсийн дунд тусгаарлах болон гэр бүл цуцлах, бага боловсролтой малчид гэр бүл цуцлах, боловсрол эзэмшээгүй малчид тусгаарласан тохиолдол цөөнгүй тэмдэглэгдсэн. Гэр бүл тусгаарлах гэсэн ойлголт нь хоёр янзаар ойлгогдох ба нэгд гэрлэлт цуцлуулахгүйгээр салах, хоёрт тодорхой хэрэгцээ, шаардлагаас үүдэлтэй тус тусдаа амьдрах гэсэн утгыг агуулахын зэрэгцээ үргэлжлэх байдлаар нь урт хугацааны болон улирлын шинжтэй г.м ангилах нь бий. Малчдын тухайд дийлэнх тохиолдолд жишээлбэл, хүүхдээ сургуульд сургах зорилгоор улирлын шинжтэй тусдаа амьдрах тохиолдол элбэг бөгөөд зарим тохиолдолд гэр бүл цуцлах шалтгаан болдог.

Хүснэгт 19. Гэр бүлийн хэв маяг боловсролын түвшин (хувь)

	БОЛОВСРОЛ						
	Б-гүй	Бага	ББД	БД	ТМС	Баклавр	Магистраас
Гэрлээгүй	5.6	3.0	3.1	5.4	3.1	17.9	-
Гэрлэсэн	86.5	80.5	86.4	83.1	86.2	79.5	100.0
Тусгаарласан	-	1.5	0.6	0.3	-	-	-
Цуцласан	2.2	-	1.2	1.2	-	-	-
Бэлэвсэн	5.6	15.0	8.6	9.9	10.8	2.6	-
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.


Орлогын хувьд өмнө тэмдэглэсэнчлэн малчдын зонхилох хэсэг нь мал аж ахуй (48.4%) болон тэтгэвэр тэтгэмж (38.1%), бусад эх үүсвэрээс (цалин 8.5%, бизнес 2.4%, бусад 2.6%)-ээс орлого бүрдүүлдэг бөгөөд аж ахуй эрхэлж буй арга, суурьшлын бүсд хэр ойр байрлаж байгаа, цалин бүхий ажил хөдөлмөр эрхэлдэг эсэхээс хамаарч орлогын бүтэц харилцан адилгүй.

Орлогын хэмжээг¹³ тооцож үзвэл нэг өрх дунджаар 959.034 (бага 5000, их 13.260.000) төгрөгийн орлого олдог (данс хөтлөх байдлаар нарийвчлан тодорхойлох шаардлагатай О.Б). Нийт орлогын дундаж утга (959.034) их болон бага утгаас хамааран савлах магадлал өндөр, эсвэл жагсаасан утгуудаас голын утгыг сонгох байдлаар дундаж

¹³ Тайлбар: улирлын шинжтэй буюу МАА болон бусад эх үүсвэрээс орж буй орлогын нийлбэрийг 12 сард хувааж өрх сарын дундаж орлогыг тооцож гаргасан.

(441.968)-ийг тогтоох нь хэт механик шийдэл болдог талтай (Х.Абу-Бадер, 2013, pp. 84-92). Геометрийн буюу өсөлтийн дундаж утга (664.211) дээрх хоёр утгад ойр, үнэний магадлал өндөр мэт харагдах ч мөн л оновчтой бус.

Зураг 9. Өрхийн сарын дундаж орлого (хувь)



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.


Малчдын орлогын хэмжээг судалгаа хийх үеийн амьжиргааны доод түвшний үнэлгээний дунджийг¹⁴ баримжаалан бүлэглэж, үр дүн гаргахад бага орлоготой өрхийн эзлэх хэмжээ өндөр, үүнээс 68.2 хувь нь 727.041 төгрөгийн орлого олдог. Тухайн үеийн хөдөөгийн өрхийн сарын дундаж орлогын хэмжээ (973.400)-г баримжаа болгон (ҮСХ, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018 оны II улирлын танилцуулга, 2018, р. 2) малчдын орлогыг тооцоход 78.2 хувь нь дунджаас доош, 21.8 хувь нь дунджаас дээш орлоготой байгаа юм.

Өрхийн орлогын эх үүсвэрээр судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 62.4 хувь нь хоёр эх үүсвэр (цалин, тэтгэвэр 1.1%, цалин, МАА 3.7%, тэтгэвэр, МАА 55.2%, тэтгэвэр, бусад 0.1%, МАА, бизнес 1.2%, МАА, бусад 1.0%)-ээс дунджаар 869.943 төгрөг, 21.2 хувь нь нэг эх үүсвэр (МАА 17.6%, тэтгэвэр 3.0%, бизнес 1.2%, цалин 0.6%)-ээс буюу 966.849 төгрөг, 14.9 хувь нь гурван эх үүсвэр (цалин, тэтгэвэр, МАА 9.1%, тэтгэвэр, МАА, бусад 3.0%, тэтгэвэр, МАА, бизнес 1.8%, цалин, МАА, бизнес 0.6, цалин, МАА, бусад 0.3%, цалин, тэтгэвэр, бизнес 0.1%)-ээс 1.250.571, 1.3 хувь нь дөрвөн эх үүсвэр (тэтгэвэр, МАА, бизнес, бусад 0.2%, цалин, тэтгэвэр, МАА, бусад 0.3%, цалин, тэтгэвэр, МАА, бизнес 0.8%)-ээс буюу 1.685.690, 0.2 хувь нь таван эх

¹⁴ Амьжиргааны баталгаажих доод түвшин: Баруун бүс 178.000, Хангайн бүс 182.600, Төвийн бүс 175.600, Зүүн бүс 174.000, Улаанбаатар 198.600 (ҮСХ, ҮСХ-ны даргын тушаал: Хүн амын амьжиргааны 2018 оны доод түвшнийг тогтоох тухай", 2018).

үүсвэрээс буюу 2.250.000 төгрөгийн орлого олдог. Орлогын эх үүсвэр бүрийн дунджийг тооцвол бизнес (фермер, хосолмол аж ахуй)-ийн АА голлосон бусад эх үүсвэрээс 1.288.249 төг, уламжлалт МАА голлосон бусад 667.664, цалин голлосон бусад эх үүсвэрээс 543.660 төг, тэтгэвэр тэтгэмж голлосон бусад эх үүсвэрээс 212.438 төг, бусад эх үүсвэрээс орлого бүрдүүлдэг өрх 139.170 төгрөгийн орлого олдог.

Зураг 10. Орлогын эх үүсвэрийн тоо, орлогын хэмжээ (төгрөгөөр)



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Малчдын тогтмол орлогын эх үүсвэрт тэтгэвэр голлох нөлөөтэй бөгөөд төрөөс тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх боломж олгож 1995 оноос мал малласан 15-60 хүртэл насны иргэдийн сард нөхөн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг 2020 онд мөрдүүлэхээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувьтай тэнцүү байхаар 2021 оны нэг дүгээр сарын нэгний өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчлэхээр зохицуулсан (KAS, 2020, р. 38).

Өрхийн орлогын хэмжээг насны бүлгээр харьцуулахад өрхийн орлогын хэмжээ, насны бүтцийн хооронд дараах зүй тогтол илэрч байна. Тодруулбал, 35-44 насныхан дунджаар 990.958 төгрөг (403 толгой малтай)-ийн орлоготой үүнээс дээш, доош чиглэлд малын тоо толгой, өрхийн орлого буурсан дүр зурагтай байна.

Хүснэгт 20. Нас ба малын тоо, орлогын ялгаа (дундаж үзүүлэлт, төгрөгөөр)

	Өөрийн нийт малын тоо	Нийт орлого
24 хүртэл	282	567.121
25-34	297	862.601
35-44	403	990.958
45-54	378	944.459
55-аас дээш	262	1.037.216
Нийт	338	959.034

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Хүйсээр эрэгтэй тэргүүлэгчтэй өрх дунжаар 988.700 төгрөг (357 толгой мал)-ийн, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 708.345 төгрөг (170 толгой мал)-ийн орлого олдог аж.

Гэр бүлийн хэв маяг ба малын тоо, орлогын хэмжээг харвал өрхийн тэргүүн нь гэрлээгүй айл өрх дунджаар 556.597 төгрөг (264 толгой мал маллаж), дан болон нийлмэл өрх дунджаар 1.276.044 төгрөг (365 толгой мал маллаж), өрөөсгөл (тусгаарласан, салсан, бэлэвсэрсэн) гэр бүл дунджаар 685.761 төгрөг (163 толгой мал маллаж)-ийн орлого олдог.

Боловсрол болон орлогын хэмжээг харьцуулахад боловсрол эзэмшээгүй малчид хамгийн бага (830.955 төг) орлоготой бол техник мэргэжил (ТМС)-ийн боловсрол эзэмшсэн малчид (1.569.546 төг)-ийн орлоготой бөгөөд хэмжээ нь боловсролын түвшнээс хамаарах зүй тогтолтой байна. Тодруулбал, бүрэн дундаас доош боловсролтой малчдын орлого ТМС, түүнээс дээш боловсрол эзэмшсэн малчдаас доогуур байгаа юм. Энд мөн аж ахуй эрхлэх аргаас хамааралтай ялгаа дам байдлаар ажиглагдана.

Хүснэгт 21. Боловсролын түвшин: өөрийн эзэмшлийн малын тоо, орлого (дундаж үзүүлэлт, төгрөгөөр)

	Өөрийн малын тоо	Нийт орлого
Боловсролгүй	308	830955
Бага	326	869070
Суурь	373	933985
Бүрэн дунд	313	890597
Техникийн болон мэргэжлийн	390	1569546
Бакалавр	309	1460214
Магистр, түүнээс дээш	177	1000000
Нийт	338	959034

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Малчдын эрхэлж буй аж ахуйтай холбоотой хөдөлмөрийн үйл ажиллагаагаар нэгд МАА-н хөдөлмөр дагнан эрхэлдэг, хоёрт МАА-ын хөдөлмөрийн зэрэгцээ цалин бүхий хөдөлмөр (8.5%) эрхэлдэг малчдын бүлэг бий. МАА-тай холбогдох хөдөлмөрийн үйл ажиллагааны хувьд 14 хэлбэрийг ялгаж, үр дүнг тодруулахад эдгээр хэлбэр тус бүр жигд оролцоо, ажиллагааг шаарддаг. Нас, гэр бүлийн хэв маяг, хүйс, эзэмшсэн боловсролын түвшнээр харьцуулахад нас хийгээд гэр бүлийн хэв маягаар ялгаа төдийлөн харагдахгүй байгаа бол хүйс, боловсролын түвшнээр зарим ялгаа илэрчээ. Тодруулбал, эмэгтэйчүүд цагаан идээ сүү сааль бэлтгэх, боловсруулах, борлуулах ажлыг, эрэгтэйчүүд мал хариулга, арчилгаа (Насанбалжир.С, 1978, р. 17) тордолгоотой

холбоотой ихэнх ажлыг гүйцэтгэдэг. Хөдөлмөрийн хүнд хүчир байдлаас нарийн хуваарь тогтсон мэт харагдаж болох ч энэ нь хатуу тогтсон зүйл бус юм. Боломж бололцооноосоо хамаардаг гэж болно.

“Хөдөөгийн амьдралын хэв маягийн өөрчлөлт” бүтээлд судалгаанд оролцогчдын 72.5 хувь нь гэрийн ажлыг эрэгтэй, эмэгтэй хүнийх гэж зааглах шаардлагагүй гэж хариулсан байдаг. Гэхдээ өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад ийм байр суурь баримтлаж буй хүмүүсийн эзлэх хэмжээ буурах төлөвтэй байгаа юм (ШУА-ийн ФСЭХ, 2016, р. 204).

Хүснэгт 22. Малчдын хөдөлмөрийн үйл ажиллагааны хэлбэр ба ялгаа (хувиар)

	Хүйс		Боловсрол					
	Эр	Эм	Бгүй	Бага	Суурь	БД	ТМС	Дээд
Мал хариулах	8.9	8.5	9.6	9.2	9.2	8.4	8.6	8.0
Мал услах	8.9	8.2	9.6	9.1	9.2	8.3	8.6	8.3
Сааль бэлтгэх	4.2	8.4	4.5	3.4	4.1	5.4	5.1	4.2
Нутаг сэлгэх нүүх/мал туух	8.4	6.9	8.4	8.7	8.4	8.1	7.8	7.7
Нүүдэл шилжих хөдөлгөөн/отор	7.8	6.3	7.7	8.1	7.7	7.7	7.1	6.4
Хашаа, хороо барих, сэлгэх	8.7	7.2	9.1	8.7	8.7	8.4	8.5	9.0
Өвлийн бэлтгэл/хадлан тариа бэлтгэх	7.4	7.1	6.8	7.0	7.2	7.7	7.6	8.3
Нэмэлт тэжээл/эрдэс бордоо бэлтгэх	6.9	6.2	5.8	7.1	6.6	7.0	7.6	7.4
Малын ноос, ноолуур хяргах/самнах	8.3	7.9	9.3	8.6	8.4	7.9	8.1	7.4
Сүү, цагаан идээ боловсруулах	3.9	8.5	3.3	3.9	3.9	4.9	5.0	4.8
Сүү, цагаан идээ зарж борлуулах	4.7	6.0	4.4	4.3	4.8	5.0	5.3	6.4
Арьс, шир, түүхий эд боловсруулах	5.5	4.6	5.5	5.7	5.4	5.7	4.3	4.5
Арьс, ширэн эдлэл борлуулах	7.6	6.4	7.3	7.4	7.7	7.4	7.0	8.3
Мал зарж борлуулах	8.7	7.9	8.6	8.8	8.9	8.2	9.1	9.3

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.


Боловсролын түвшний ялгаа нь: 1). Боловсролын түвшин буурахад мал хариулга, нутаг сэлгэх, нүүдэл хийх, ноос ноолуур бэлтгэх, арьс шир боловсруулах зэрэг ажлыг илүү, 2). Боловсролын түвшин дээшлэхийн хэрээр өвс тэжээл бэлтгэх, сүү цагаан идээ боловсруулах, борлуулах, мал мах зарж борлуулах зэргээр малын үр ашгийг тогтвортой байлгах, орлого нэмэгдүүлэхэд чиглэсэн арилжааны шинжтэй үйл ажиллагаанд, 3). Сааль бэлтгэх, хашаа хороо барьж сэлгэх, арьс шир боловсруулах ажлыг боловсролын түвшнээс хамаарахгүйгээр хийж гүйцэтгэдэг. Түүхий эд боловсруулалтын хувьд “Малын ашиг шимийг сайжруулах, тоо толгойг өсгөх, эрүүл байлгахад чиглэсэн арга

ухаан сэргэх хандлагатай байгаа бол уламжлалт мэдлэг, ухааны хэрэглээ улам буурч, орхигдох шинжтэй болжээ. Харин малын гаралтай түүхий эдээс айрагнаас бусад сүү, сүүн бүтээгдэхүүн (сүү 2.4, ааруул 2.4, өрөм 2.4, бяслаг 2.3, эззгий 2.4, аарц 2.4, тараг 2.3, шар тос 2.4)-ийг өрхийн хэрэгцээнд зориулж, малын гаралтай бусад түүхий эд (айраг 3,мах 2.8, ноос 2.8, ноолуур 2.9, арьс шир 2.9, дэл сүүл 2.8)-ийг ... өрхийн хэрэгцээнээс илүү гарсан сүү цагаан идээг зарж борлуулдаг.” (ШУА-ийн ФХ, 2018, pp. 77-78) төдийгөөр хязгаарлагддаг. Хэрэглээ, хөдөлмөр эрхлэлт, амьдралын хэв маягийн хувьд 1990 оны өмнөхтэй харьцуулахааргүй өөрчлөгдсөн (Төмөрхүлэг.А, 2018, pp. 61-63).

Нийгмийн шинжээс гадна малчид өмч, өмчийн хэлбэр, үнэ, хэрэглээний зүйлээр мэдэгдэхүйц ялгарах болсон. Үүнийг тодруулбал, судлагдсан малчдын 90 орчим хувь (зун 88.3%, өвөл 86.0%) нь гэр сууцанд амьдарч байгаагаас хөдөөгийн малчдын 90 гаруй хувь нь (зун 94.1%, өвөл 92.80%), аймгийн төв болон сумын төв орчмын малчдын 80 орчим хувь нь (зун 78.6%, өвөл 77.0%) улирлын онцлогоос хамааралгүй шахам гэр сууцанд амьдарч байгаа бол нийслэлийн хотын малчид улирлын онцлог (зун 64.0%, өвөл 44.0%)-оос хамааран гэр, байшин сууцны хэрэглээ өөр, үүгээр зогсохгүй бүс нутаг, улирлын онцлогоос хамааран сууцны хэрэглээ өөрчлөгдөх болсон. Тухайлбал, говь, хээрийн бүсд дулааны улирлалд дугуй бүхий бүхээгт сууц хэрэглэх нь нэмэгдэж байгаа бол хангайн бүсд өвлийн улиралд дулаан байшинд суух малчдын тоо нэмэгдэх болсон.

Малчдын хувьд мал нь өмч болон хэрэглээний гол эх үүсвэр болдог бөгөөд малын тоог хонин толгойд шилжүүлсэн үр дүнгээс харахад 1000 хүртэл толгой малтай өрх дийлэнх хэсгийг бүрдүүлдэг. Үр дүнг нарийвчлан харвал, малын төрөл тус бүрийн тоог нийлүүлж тооцоход 50 гаруй хувь нь 250 хүртэл толгой, 24.7 хувь нь 251-500 толгой (100 хүртэл малтай 14.6%, 101-200 толгой малтай 15.9%, 201-300 толгой малтай 14.6%, 301-400 толгой малтай 12.4% буюу нийт 57.4%), 16.4 хувь нь 501-1000 хүртэл толгой малтай (Хавсралт-6. Мал төрөл болон хонин толгойд шилжүүлж харьцуулсан үр дүн) байна.

Зураг 11. Судлагдсан малчдын өөрийн эзэмшлийн малын тоо толгой (хувиар)




Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Өөрийн малгүй буюу бусдын малыг хөлсөөр хардаг 8 өрх байгаа бол цөөн буюу 10 хүртэл толгой малтай өрх 9 (бага нь 6 толгой малтай), 11-50 хүртэл тооны малтай өрх 56, 51-100 толгой малтай өрх 79 байгаа бол малын төрөл тус бүрийг нэгтгэн тоолоход 2000-аас дээш малтай дөрвөн өрх байгаагаас хамгийн их нь 2670 толгой малтай юм. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 3000-аас дээш малтай дөрвөн өрх байгаагаас хамгийн их малтай нь 4130 хүртэл толгойд хүрнэ.

Малчдын өөрийн өмчийн малын тоог зах зээлийн үнэд шилжүүлбэл хамгийн бага (6 толгой) малтай өрхийн нийт малын зах зээлийн үнэлгээ 491.725,38, хамгийн их буюу 4130 толгой малтай өрхийн малын зах зээлийн үнэлгээ 295.235.445,4 төгрөгтэй тэнцэх ба эдгээрийн хооронд 600 дахины зөрүүтэй.


Зураг 12. Өмчилж буй малын зах зээлийн үнэлгээний дундаж



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Малын төрөл тус бүрийн нийт тоо хэмжээ хийгээд өрхийн орлогын хэмжээг харьцуулан харахад малын тоо өсөхийн хэрээр өрхийн орлогын хэмжээ өссөн дүр зурагтай байна.

Зураг 13. Малын тоо толгой ба өрхийн сарын дундаж орлого (төгрөгөөр)



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Сүргийн бүтцээс хамаарч мөн орлогын хэмжээгээр ялгарах ба таван төрөл (зүүн бүсд 10.0%, баруун бүсэд 8.8%, төвийн бүсд 6.0%, хангайн бүсэд 3.2%)-өөр өсгөж буй өрхийн орлогын дундаж 17.713.198 төгрөгтэй тэнцэж байхад дөрвөн төрөл (зүүн бүсэд 69.6%, хангайн бүсэд 59.8%, төвийн бүсэд 55.8%, баруун бүсэд 52.8%)-өөр өсгөж буй өрхийн орлого 9.532.789, гурван төрөл (баруун бүсэд 25.2%, хангайн бүсэд 17.1%, төвийн бүсэд 16.9%, зүүн бүсэд 10.8%)-өөр өсгөж буй өрхийн орлого 6.716.918, хоёр төрөл (Улаанбаатар 24.0%, төвийн бүсэд 14.9%, хангайн бүсэд 12.7%, баруун бүсэд 11.2%, зүүн бүсэд 52.%) -өөр өсгөж буй өрхийн орлого 5.798.286, нэг төрөл (Улаанбаатар 60.0%)-ийн мал өсгөж буй өрхийн орлого 4.641.392 төгрөг (Хавсралт-2. Эзэмшиж буй малын төрөл зүйлийн харьцаа, олж буй орлогын хэмжээ). Сүргийн бүтэц, түүний ач холбогдлыг түүхч Ц.Насанбалжир “Ойт хээрийн бүсэнд адуу үхрийг дангаар үржүүлэхэд мах, арьс ноосоор, тал хээрийн бүсд хонь, ямааг үржүүлэх ахул уналга, ачлага, сүүгээр, говь дан тэмээ үржүүлэхэд мах, ноос, сүү арьс шир, уналгаар тус тус дутагдахад зайлшгүй хүрч байв.” (Насанбалжир.Ц, 1978) гэж хэрэглээний талыг онцлон тэмдэглэсэн ч малчид өөр хоорондоо ялгарахад нөлөөлдөг нарийн учиртай болох нь үүгээр батлагдаж байна.

Нас, хүйс, боловсрол, гэр бүлийн хэв маяг, орлого зэрэг үзүүлэлтүүдийн хооронд хамаарал тооцоход:

1). хүйс болон гэр бүлийн хэв маяг ($r = 0.798^{**}$)-ийн хооронд хүчтэй эерэг, нас гэр бүлийн хэв маяг ($r = 0.311^{**}$), нас хүйс ($r = 0.272^{**}$) сулавтар эерэг хамаарал,

2). боловсрол өрхийн орлогын хэмжээ ($r = 0.104^{**}$), малын тоо орлого ($r = 0.283^{**}$) гэсэн үзүүлэлтүүдийн хооронд дундаж эерэг хамаарал илэрч байна.

3). малын тоо болон гэр бүлийн хэв маяг ($r = - 0.186^{**}$), нас ($r = - 0.119^{**}$), хүйс ($r = - 0.167^{**}$) гэсэн үзүүлэлтүүдийн хооронд сөрөг сул хамаарал илэрчээ.

Эндээс нийгмийн ялгааг илэрхийлэх үзүүлэлтүүд (нас, хүйс, боловсрол, гэр бүлийн хэв маяг)-үүдээс хамаарах ялгаа хүчтэй, боловсролын түвшнээс хамаарч орлого, орлогын хэмжээ малын тоо хэмжээнээс хамаарч өөрчлөгддөг. Сөрөг хамаарал бүхий үзүүлэлтүүдийн тухайд нийтлэг хэв маяг алдагдах үед өрхийн орлого, малын тоо хэмжээ буурдаг гэж ойлгож болно. Жишээлбэл, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх, мөн өрөөсгөл хэв маяг бүхий гэр бүлийн эдийн засгийн чадамж сул байгаа нь харьцуулалт, шинжилгээний үр дүнгээс тодорхой харагдана.

Малчдын өмч ба хэрэглээний зүйл нь мөн малын тоо хэмжээнээс хамаардаг бөгөөд малын тоо толгой нэмэгдэх тусам өрхийн өмч, хэрэглээ хангамж нэмэгддэг. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр нэг өрхөд дунджаар 534 толгой мал ногдоно. Энэ үзүүлэлтийг шалгуур болгон өмчийн ялгааг тодруулахад дунджаас дээш малтай өрх техник хэрэгсэл, мал ахуйн эрсдлээс хамгаалах зүйлсийн хангамж, хэрэглээний түвшнээр өндрөөс гадна амьдралын хэрэгцээний зүйлс, тав тухыг хангах зүйлсээр ч цөөн малтай өрхөөс илүү хангагдсан болох нь доорх хүснэгтээс харагдана. Малын тоо хэмжээ хийгээд өмч, хэрэглэлийн хангамжийг илэрхийлэх үзүүлэлтүүдийн хооронд сул, сөрөг хамаарал илэрч байгаа ч энэ нь нэг талаас өрхийн хэрэглээ, хангамжийн малын тооноос хамаарч буйг, нөгөө талаас мал ахуйн арчилгаа, эрсдлийг бууруулах хангамж нь малын тоо хэмжээ өсөхөд, цаашлаад хэрэглээний зүйлсээр хангагдах боломжийг нь нэмэгдүүлдэг гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Хүснэгт 23. Дундаж малын тоо ба өмч, хэрэгслийн хангамж, зөрүү (хувь, Пирсоны корреляцийн хамаарал)

	534-өөс бага	534-өөс их	Зөрүү	Хамаарал
Ачааны машин	23.6	61.2	37.5	- 0.354**
Өвөлжөө	58.5	85.7	27.2	- 0.280**
Мотоцикл	54.8	81.5	26.7	- 0.274**
Хаваржаа	33.2	56.5	23.2	- 0.268**
Суудлын машин	20.0	36.6	16.7	- 0.228**
Цахилгаан үүсгүүр	50.1	65.0	14.9	- 0.189**

Сууцны байшин	23.6	38.3	14.7	- 0.215**
Хөргөгч	32.7	43.0	10.3	- 0.128**
Газар	38.3	45.5	7.1	- 0.120**
Орон сууц	4.4	7.2	2.8	- 0.122**
Интернет	5.8	7.7	1.9	- 0.053*

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Гэр бүлийн хэв маяг ба өмчийн хооронд сул боловч хамаарах зүй тогтолтой бөгөөд дан болон нийлмэл өрх, өрхийн тэргүүлэгч нь гэрлээгүй хүмүүс өрөөсгөл гэр бүлээс эд хэрэглэлээр тэр дундаа техникийн хангамж, хэрэглээгээр илүү байна. Гэхдээ сууцны байшин, өмчилсөн газартай гэх өрөөсгөл гэр бүлийн эзлэх хэмжээ дан болон нийлмэл гэр бүлтэй ойролцоо хэмжээнд байгаа юм.

Хүснэгт 24. Гэр бүлийн хэв маяг ба өмч (хувь, Пирсоны корреляцийн хамаарал)

	Гэрлээгүй	Гэрлэсэн	Өрөөсгөл	Хамаарал (p =)
Мотоцикл	60.4	69.4	26.7	0.217**
Ачааны машин	25.0	39.9	16.7	0.092**
Цахилгаан үүсгүүр	50.0	57.5	41.7	0.067*
Суудлын машин	16.7	27.9	14.2	0.053*
Хаваржаа	37.5	42.9	31.7	0.048
Өвөлжөө	60.4	69.6	57.5	0.046
Интернет	4.2	7.3	1.7	0.046
Орон сууц	4.2	5.8	2.5	0.031
Хөргөгч	29.2	37.8	28.3	0.031
Трактор	2.1	7.7	4.2	0.010
Сууцны байшин	24.0	28.9	29.1	- 0.006
Газар	29.2	41.7	39.2	- 0.018

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Малын тоо хэмжээнээс хамаарч аж ахуй эрхлэхэд зарцуулж буй цаг харилцан адилгүй. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр, 500 хүртэл тооны малтай өрх өдөрт дунджаар 12.2, 501-1000 толгой малтай өрх 12.9, 1001-1500 толгой малтай өрх 13.4 цагийг, 1501-2000 толгой малтай өрх 14.3 цагийг, 2001-ээс дээш малтай өрх 13.7 цагийг зарцуулдаг гэж. Малын тоо толгой нэмэгдэх тутам цагийн зарцуулалт нэмэгдэх нь зүй ёсны боловч 2001-ээс дээш мал бүхий малчны цагийн зарцуулалт багассан нь хөдөлмөрийн ачааллыг тархаасантай холбоотой юм. Тодруулбал, малын тоо хэмжээ өсөхийн хэрээр бусдаар туслуулж хамжих дэмнэх, хөлсөлж, ажиллах хүнтэй гэрээ байгуулах, түрээсийн гэрээ байгуулж г.м арга хэлбэрээр малын тоо хэмжээг тогтоон барих, үр ашгийг нэмэгдүүлэх аргыг хэрэглэх нь түгээмэл болсон.

Тодорхой хэв маягаар тодруулбал, малтай болсон аргаар (удам дагасан 66.7%, шинэ малчид 33.3%), өмч захирах эрх болон ажиллаж буй хэлбэрээр (өөрийн эзэмшлийн мал 952, туслах 23, цалин хөлсөөр ажиллагч 8), үйлдвэрлэл эрхлэх аргаар (фермер 28, хагас фермер 35, бэлчээрийн 987), суурьшлын байршлаар (нийслэл 50, аймаг, сумын төвийн ойролцоо амьдардаг 305, хөдөөгийн 695) дөрвөн хэв маяг болгож, ялгааг нь тодрууллаа.

Өмч зарцуулах эрх ба ажиллаж буй хэлбэрээр: өөрийн эзэмшлийн малыг маллаж буй бүлгийн гишүүд бүх насны төлөөлөл (24 хүртэл 2.1%, 25-34 насныхан 19.0%, 35-44 насныхан 29.9%, 45-54 насныхан 26.2%, 55-аас дээш насныхан 22.8%)-өөс, харин туслах болон хөлсний малчид 25-аас дээш насныхнаас бүрдэж байна. Хөлсний малчид ихэвчлэн гэр бүлийн хамтаар бусдын малыг малладаг бөгөөд малын түүхий эд болон нэмэлт цалин хөлс авч ажилладаг. Эл судалгааны ажлын тодорхойлолт, шалгуур үзүүлэлтээр хөлсөөр мал маллаж буй хүмүүсийг малчин гэх бол малын эздийг хувийн аж ахуй эрхлэгч (цалин урамшуулын харилцаагаар зохицуулагдаж байгаа учир) гэж цалин урамшууллын харилцааг шалгуур болгон “мал бүхий өрх”-өөс мөн ялгах боломжтой.

Хүйсийн хувьд өөрийн малыг маллаж буй хүмүүсийн 91.4 хувь, туслах малчдын 95.0 хувь, хөлсний малчдын 75.0 хувь нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй. Боловсролын түвшнээр өмнө тэмдэглэсэнчлэн бүрэн дунд боловсролтой хүмүүсийн эзлэх хэмжээ гурван бүлэгт жигд өндөр байгаа ч хүмүүс бий боловч туслах болон хөлсний малчид бүрэн дундаас боловсролтой бол өөрийн малыг маллаж буй малчдын дунд техник мэргэжлийн (6.3%) болон дээд (3.9%) боловсролтой малчид байна.

Хүснэгт 25. Ажиллаж буй хэлбэр ба нас, хүйс, боловсролын ялгаа (хувиар)

		Ажиллаж буй хэлбэр		
		Үндсэн	Туслах	Хөлсний
Насны бүлэг	24 хүртэл	2.1	-	-
	25-34	19.0	30.0	12.5
	35-44	29.9	25.0	37.5
	45-54	26.2	25.0	37.5
	55-аас дээш	22.8	20.0	12.5
Хүйс	Эрэгтэй	91.4	95.0	75.0
	Эмэгтэй	8.6	5.0	25.0
Боловсрол	Б-гүй	7.9	35.0	-
	Бага	17.1	15.0	25.0
	ББД	32.1	25.0	12.5

	БД	32.7	25.0	62.5
	ТМС	6.3	-	-
	Бакалавр	3.8	-	-
	Магистр, түүнээс дээш	0.1	-	-
Нийт		100.0	100.0	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Гэр бүлийн хэв маягийн хувьд хөлсний малчдын хувьд тусгаарлах болон гэр бүл цуцалсан тохиолдол байхгүй бол туслах малчдын дунд гэр бүл цуцалсан тохиолдол, өөрийн эзэмшлийн малыг маллаж буй малчдын дунд гэрлэсэн хүмүүсийн эзлэх хэмжээ өндөр байгаа ч гэр бүлийн өөр хэв маягууд бий. Ам бүлийн хувьд 5-6 тооны гишүүнтэй өрх аль алинд өндөр хувьтай байна.

Гэр бүлийн хэв маягийн хувьд өөрийн малыг маллаж буй малчдын 86.7 хувь нь гэрлэж, 4.4 хувь нь гэр бүл зохиогоогүй, 0.6 хувь нь тусгаарласан, 0.8 цуцласан, 7.5 хувь нь бэлэвсэрсэн бол туслах малчдын 80.0 хувь нь гэрлэж, 10.0 хувь нь өрх тусгаарласан, тус бүр 5.0 хувь нь гэрлээгүй, бэлэвсэрсэн, хөлсний малчдын 50.0 хувь нь гэр бүлтэй бол 37.5 хувь нь бэлэвсэрч, 12.5 нь гэрлээгүй гэжээ. Ам бүлийн хувьд бэлчээрийн аж ахуй эрхэлдэг малчдын олонх нь 5-6 ам бүлтэй бол фермерийн аж хуй эрхлэгчдийн 46.4 хувь нь хоёр, 39.3 хувь нь 5-6, 14.3 хувь нь 3-4 ам бүлтэй гэсэн нь хосолмол аж ахуй эрхлэгчдийн эсрэг дүр зургийг илэрхийлж байна.

Хүснэгт 26. Ажиллаж буй хэлбэр ба гэр бүлийн хэв маяг (хувиар)

		Ажиллаж буй хэлбэр		
		Үндсэн	Туслах	Хөлсний
Гэр бүлийн хэв маяг	Гэрлээгүй	4.4	5.0	12.5
	Гэрлэсэн	86.7	80.0	50.0
	Тусгаарласан	0.6	-	-
	Цуцласан	0.8	10.0	-
	Бэлэвсэн	7.5	5.0	37.5
Ам бүл	2 хүртэл	17.1	5.0	50.0
	3-4	21.3	45.0	-
	5-6	61.0	50.0	50.0
	7-8	0.5	-	-
Ажлын цаг	Mean	12.9	11.5	9.5
Нийт		100.0	100.0	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Уламжлалт, түгээмэл тархсан ийм нэг арга гэвэл мал аж ахуйн үйлдвэрлэлийг дангаар болон айл саахалтаар хамтран гүйцэтгэх явдал юм. Доктор Д.Шомбодон “... хүн хүч дутагдалтай буюу цөөн малтай өрхүүд үйлдвэрлэлийн болон нийгмийн шаардлагаар

айлсан мал ахуйгаа хамтран эрхэлдэг байна." (Шомбодон.Д, 1993, р. 26) гэж тэмдэглэсэн. Хэрэв ийм байдлаар харвал нийгмийн үйлдвэрлэлийн талаас хамжих, дэмжих үр ашиг бүхий (Ишдорж.Ц, 2013, pp. 376-377) харилцаа болох нь тодорхой харагддаг.

Судлагдсан туслах малчдын 80 хувь нь хөдөө, 15 хувь нь аймаг, сумын ойролцоо, 5 хувь нь нийслэлд хөдөлмөр эрхэлж байна. Малчдын харилцааны энэ онцлогийг түүхийн талаас судлахдаа нэг хэсэг үзэл суртлын нөлөөн дор “феодал ёс” тогтсон гэж батлан, харлуулах шахалтад орж (Бат-Очир.Л, 1986, pp. 6-7), хожуу үед судлаачдын нэлээдгүй хэсэг нь үгүйсгэх (Гомбосүрэн.Ц, Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү, 1995, pp. 10-11; Болд.Ба, 1992, р. 8) болсон. Ба.Болд "... феодализмийн моделийг батлахын эрхээр нэн ач холбогдолтой үзэх, харин гол чухлыг нь гүйцэд үнэлэлгүй орхигдуулах эндэгдэлд аль нэг хэмжээгээр орсон байна гэлтэй” (Чулуунбаатар.Г, 2008, р. 242) хатуухан шүүмжилсэн байдаг. Зарим нэг судлаач хүн баримт, нотолгоо султайдаа юу, эсвэл даган дуурайсан шинжтэй зориудаар мушгин гуйвуулсан (Чагдаа.Х, Монголын малчдын үе залгамжлалын нийгмийн асуудал: өнгөрсөн, одоо цаашид (диссертаци), 1997, pp. 31-32) гэмээр хандлага гаргасан байх нь бий. Мушгин гуйвуулах тухайд, доктор Х.Чагдаа “Ядуу малчид хэдийгээр өөртөө малгүй буюу цөөн малтай боловч их малтай баян айлын малыг таслан суурь болгон хотолж өөрийн мал шиг хайрлаж олон жилээр нүдлэн хамгаалж өсгөн үржүүлдэг байлаа. ... зөвхөн эзний сэтгэл, өглөгөөр тохирч малынхаа мах, сүү, ноос, арьс ширээс зохих хэмжээгээр өөртөө ашигладаг байжээ.” гэж нэг талаас эзний зүгээс дэмнэх, нөгөө талаас малгүй хүн хамжих гэсэн харилцааг орхигдуулсан зориудын дүгнэлт гэх ойлголтыг төрүүлдэг. Түүхч Ш.Нацагдоржийн ийм янзаар гэхдээ шахалтаар шахуу “хороо хийлгэх” (шим хэрэглэх, хүч эдлэх) дэмнэх гэсэн ойлголт, утга санаагаар тэмдэглэжээ. Мөн “сүрэг тавих¹⁵” гэж ойлголт ч бий (Нацагдорж.Ш, Сум, хамжлага, шавь ард (түүхэн найруулал), 1972, р. 74).

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн судлаачид 2007 онд “Малчдын улсын зөвлөгөөн”-д оролцсон 371 малчнаас судалгаа авахад тэдний 51.5 хувь нь туслах малчин

¹⁵ “... малаа хариулгуулах нь «сүрэг тавих», «хороо хийлгэх» хэмээх хоёр хэлбэртэй байсан. «Сүрэг тавих» гэдэг нь айлуудаар хуваарилан өгч маллуулахыг, «Хороо хийлгэх» хэмээх нь малаа гэр өргөөнийхөө дэргэд байлгаж маллуулахыг хэлнэ. "Бага малтай буюу огт гар хоосон ардууд, баячуудаас «шим хэрэглэх» (саалийн), «хүч эдлэх» (ачлага уналгын) малыг янз бүрийн хугацаа, болзолтойгоор авдаг байжээ.

ажиллуулдаг гээд 51.1 хувь нь айл өрхтэй хэлцэл хийж хөлслөн ажиллуулдаг гэж, 27.7 хувь нь садан төрлийн айлд мал өгч ашиг шимийн тодорхой хувийг авдаг гэж, 14.1 хувь нь амьдрал дорой айл өрхийг ажиллуулж ашгийн ихэнх хувийг өөрсдөө авдаг, 3.8 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг, 1.1 хувь нь мал цөөн айлыг малжуулах нөхцөлтэйгээр ажиллуулдаг (ШУА-ийн ФСЭХ, 2007) гэж тэмдэглэсэн байдаг. “Малчдын аж байдал” сэдэвт судалгаанд оролцогчдын 12.4 хувь нь буюу судалгаанд оролцсон малчдын 130 нь хүн хөлслөн ажиллуулдаг гээд үүний 90.8 хувь нь аман тохироогоор (малын тооноос хамаардаггүй), 4.6 хувь нь албан ёсны гэрээ байгуулж (хамааралгүй хүн ажиллуулах үед хэрэглэх хандлагатай), 4.6 хувь нь бусад хэлбэрээр тохирч ажиллуулдаг гэжээ. Туслаж буй малчдын 43.8 хувь нь хамаатан садных нь хүмүүс бол 36.9 хувь нь яс, цусны хамааралгүй хүмүүс, 19.2 хувь нь найз нөхөд, танилуудаасаа ажиллуулдаг.

Туслах малчин ажиллуулж буй өрхийн орлого (1.559.177), зарлага (1.745.480), малын тоо (хонин толгойд шилжүүлсэн 925.8) зэргээр дундаж үзүүлэлт (орлого 959.034 төг, зарлага 1.237.288 төг, хонин толгойд шилжүүлсэн малын тоо 534)-ээс өндөр бөгөөд малын тоо хэмжээг хонин толгойд шилжүүлсэн дүнгээс харахад тэдний 43.8 хувь нь 500 хүртэл, 14.6 хувь нь 501-1000, 19.2 хувь нь 1001-1500, 8.5 хувь нь 1501-2000, 13.8 хувь нь 2001-ээс дээш тооны малтай гэжээ. Бусадтай харьцуулахад цөөн буюу 500 хүртэл тооны малтай өрхийн зургаа нь 100 тооны үхэр, нэг нь мөн тооны дан ямаатай ба үлдсэн хэсэг нь (87.7%) уламжлалт хэлбэрээр хоёр болон түүнээс дээш тооны мал малладаг туслахаар хүн авна гэдэг нь эргэлзээтэй юм. Үүнийг тодруулахад тэдний 57.9 хувь нь хамаатан садныхаа айлыг, 28.1 хувь нь хамааралгүй хүн, 14.0 хувь нь найз нөхөд, таньдаг хүнээ авч ажиллуулдаг гэжээ. Хамааралгүй хүмүүс болон найз нөхөд, танил талаа ажиллуулж буй малчдын 58.3 хувь нь 3 хүртэл ам бүлтэй. Тэгэхлээр эндээс хоёр зүйлийг тайлбарлан хэлэх бололцоо үүсэх бөгөөд нэгд цөөн малтай ч хамаатан саднаа дэргэдээ байлгаж буй нь тухайн малчин ажилгүй, залхуудаа бус өөрт буй боломжид тулгуурлан харилцан туслаж, дэмнэх, хоёрт хөндлөнгийн хүн болон найз нөхөд, танил талаа ажиллуулж буй нь хүн хүчний хүрэлцээ, бололцоотой холбоотой үүсдэг харилцаа гэж үзэж болно.

Малчин хүний хувьд хүчний дэмжлэг авах, мал маллахад хүч нэмж буй хүмүүс хоорондын тохирооны нөхцлийг харгалзан үзвэл энэ нь “өөрт буй боломж”-д суурилсан харилцан ашигтай байх нөхцлийг хангаж буй бөгөөд хамжлага (Гомбосүрэн.Ц,

Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү, 1995, pp. 10-11)-ын шинжтэй боловч “харилцан дэмнэх хөдөлмөр” (Насанбалжир.С, 1978, р. 9) гэх нь илүү оновчтой юм. Амьжиргаа тэтгэх, хүч нэмэх, малгүй, эсвэл бага малтай өрх нөөц эх үүсвэртэй болох юм уу, нөөцийн чадамжийг өсгөж, нэмэгдүүлэх г.м олон талын үр ашигтай сэдэл, хэрэгцээгээр бодитой өрнөж, хэрэгждэг. Малчдын ялгарал хийгээд түүнээс үүдэлтэй үүргийн тал шинж нь үүгээр тайлбарлагдана.

Өөрийн эзэмшлийн малгүй хөлсөөр мал маллаж буй хүмүүс бий. Судалгаанд оролцсон хүмүүсийн 8 нь бусдын малыг хөлсөөр маллаж байгаа юм. Насны хувьд 25-34 насны нэг, 35-54 насны зургаа, 55-аас дээш насны нэг хүн байгаагаас зургаа нь эрэгтэй, хоёр нь эмэгтэй (өрх толгойлсон эх), боловсролын хувьд хоёр нь бага, нэг нь суурь, тав нь бүрэн дунд боловсролтой. Өрхийн сарын дундаж орлогоор хамгийн бага нь 240.000 төгрөгийн орлоготой бол хамгийн их нь 900.000 төгрөг олдог. Тэтгэвэр, цалин орлогын гол эх үүсвэр нь болдог.

Дээрх хэлбэрүүдээс гадна “Түрээсийн гэрээ” (судлаач ойлголтын томъёоллыг дутуу хийсэн байх магадлалтай О.Б)-ээр ажиллуулах бас нэг хэлбэр байгаа нь “сүрэг тавих” гэх ойлголттой дүйнэ. Нэгэн судалгааны ажилд энэ тухайд, малчин П.О (нэрийг нууцлав) нь 1560 толгой хувийн малтай. Түүний мал аж ахуй дээр Ц.Б, О.Б, Ц.А нарын малчид гэрээгээр ажиллана. ... малчин ... өрхийн нийт ам бүл 16, үүнээс хүүхэд 7, хөдөлмөрийн чадвартай 9 хүнтэй. Хүүхдүүдээс сургуулийн өмнөх насны 3, сурагч 4 байна. Нийт ам бүлээс бүрэн дунд боловсролтой 4, бага боловсролтой 8 хүнтэй. П.О-ын малыг түрээсийн гэрээгээр малладаг хоньчин 6, тодорхой ажил эрхлээгүй 3 хүнтэй. Малчин П.О мал аж ахуйгаа төрөлжүүлэн төллөх ба бог малын 2, эр сувай бог малын 1 сууриар тус тус зохион байгуулж, үхрийг бог малын 2 суурьт хувааж хариуцуулан адууг өөрөө хариуцан маллаж байна. Төллөх хонь, ямааг 250-иар өсвөр малыг 500-аар суурь болгон зохион байгуулж, нэг малчин өрхийн 2 малчинд түрээсийн гэрээгээр хариуцуулан маллуулдаг. Бод мал, таваарын малаа өөрсдөө малладаг. ... Хөлсний малчин өрхүүд өөрийн аж ахуйн орлогоос хэрэгцээгээ хангаж хүрэлцэхгүй боловч П.О малыг түрээсийн гэрээгээр маллаж биет ба мөнгөн хэлбэрээр сард дунджаар 40 орчим мянган төгрөгийн цалин хөлстэй амьдарч байна. Энэ нь 2007 онд өсч 120 орчим мянган төгрөг болсон байна. Малчдын цалин хөлсний түвшин нь орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн ханшаар зохицуулагддаг (Амаржаргал.З, 2009, pp. 14, 21, 37).

Үйлдвэрлэл эрхэлж буй арга, ажиллагаагаар: малын тоо хэмжээгээр харьцангуй цөөн, чиглэлийн аж ахуй эрхэлдэг хүмүүс суурин төв дагаж аж ахуй эрхэлдэг. Доктор Х.Гүндсамбуу "... Америкийг хуулбарласан фермерийн аж ахуйн, нөгөөдөхийг нь хот айлаа түшсэн, саахалт айлаа бараадсан уламжлалт хандлага..." (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, р. 119) гэж тэмдэглэж байсан нь өнөөдөр малчдын ялгааг тодорхойлох гол үзүүлэлтүүдийн нэг болжээ. Судалгаанд оролцсон малчдын 94 хувь нь уламжлалт хэлбэрээр буюу бэлчээр (нийслэлийн малчдын 30.0%, аймаг сумын малчдын 92.8%, хөдөөгийн малчдын 99.3%)-ээр, 2.7 хувь нь фермерийн (нийслэлийн малчдын 42.0%, аймаг сумын малчдын 2.0%), 3.3 хувь нь хосолмол хэлбэр (нийслэлийн малчдын 28.0%, аймаг сумын малчдын 5.2%, хөдөөгийн малчдын 0.7%)-ээр аж ахуйгаа эрхэлдэг. Уламжлалт болон фермер, фермер дагнасан хэлбэрийн аж ахуй суурьшлын төвүүд даган бий болж байгаа нь энэ үр дүнгээс тодорхой харагдаж байгаа юм.

Нийгмийн талаас фермерийн болон хосолмол аж ахуйд 25-аас дээш насны хүмүүс, хүйсийн хувьд эрэгтэй (фермерт ажиллагсдын 92.9, хосолмол аж ахуйд ажиллагсдын 91.4%)-чүүд, боловсролын түвшнээр бага болон эрдмийн зэрэг хамгаалснаас бусад, бүрэн дундаас дээш боловсролтой хүмүүсийн эзлэх хэмжээ уламжлалт хэлбэрийн аж ахуй эрхлэгчдээс харьцангуй өндөр байна. Гэр бүлийн хэв маягийн хувьд гэрлэсэн болон бэлэвсэн хүмүүс, эрүүл мэндийн хувьд бэлчээрийн болон хосолсон аж ахуй эрхлэгчдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй малчид ажиллаж байна.

Хүснэгт 27. Үйлдвэрлэл эрхлэх аргаас хамаарах ялгаа (хувиар)

		Үйлдвэрлэлийн арга		
		Бэлчээрийн	Фермер	Хосолсон
Насны бүлэг	24 хүртэл	2.2	-	-
	25-34	18.6	14.3	11.4
	35-44	29.0	14.3	25.7
	45-54	24.8	32.1	28.6
	55-аас дээш	25.3	39.3	34.3
Хүйс	Эрэгтэй	89.3	92.9	91.4
	Эмэгтэй	10.7	7.1	8.6
Боловсрол	Б-гүй	9.0	-	-
	Бага	20.0	7.1	2.9
	ББД	31.1	32.1	22.9
	БД	31.0	46.4	37.1
	ТМС	5.7	10.7	17.1
	Бакалавр	3.1	3.6	20.0
	Магистр, түүнээс дээш	0.1	-	-

Гэр бүлийн хэв маяг	Гэрлээгүй	4.8	-	2.9
	Гэрлэсэн	83.6	92.9	88.6
	Тусгаарласан	.6	-	-
	Цуцласан	1.0	-	-
	Бэлэвсэн	10.0	7.1	8.6
Ам бүл	2 хүртэл	15.4	46.4	31.4
	3-4	22.5	14.3	25.7
	5-6	61.6	39.3	42.9
	7-8	0.5	-	-
Ажлын цаг	Mean	12.7	11.9	10.4
Нийт		100.0	100.0	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Хөдөлмөрийн цаг зарцуулалт, ажлын ачаалал малын тоо хэмжээнээс хамаарч, мөн мал маллагааны арга хэлбэрээс хамаарч харилцан адилгүй. Уламжлалт хэлбэрээр аж ахуй эрхлэгчид өдөрт дунджаар 12.7, нэг чиглэлийн мал дагнасан аж ахуй эрхлэгч 11.9, чиглэлийн мал хосолсон аж ахуй эрхлэгчид 10.4, чиглэлийн мал, амьтан хосолсон аж ахуй эрхлэгчид 8.8 цагийг зарцуулдаг.

Эрхэлж буй аж ахуйн хэлбэр, өрхийн орлогын харьцаагаар хосолсон аж ахуй эрхэлдэг малчид 2.136.666 төгрөг, чиглэлийн мал дагнан эрхэлдэг малчид 1.444.861 төгрөг, чиглэлийн мал болон амьтан үржүүлдэг малчид 1.383.000 төгрөг, уламжлалт аж ахуй эрхэлдэг малчид 924.798 төгрөгийн орлого олддог. Ялангуяа үйлдвэрлэл эрхлэх арга хийгээд боловсролын түвшнээс хамардаг.

Боловсролын түвшнийг малын тоо, орлого, үйлдвэрлэл эрхлэх аргыг харьцуулахад уламжлалт аргаар мал маллахад боловсролын түвшнээс хамаарсан ялгаа бага байгаа бол орлогын хэмжээгээр илүү ялгарч байна. Фермерийн болон хосолмол аж ахуй эрхлэгчдийн хувьд энэ ялгаа мэдэгдэхүйц тухайлбал, ермөрийн аж ахуй эрхлэгчдийн бакалаврын түвшний боловсролтой нэг малчны эзэмшиж буй дундаж малын тоо түүнээс доош боловсрол эзэмшсэн фермер эрхлэгчээс доод тал нь 2.6 дахин олон мал маллаж байгаа бол бүрэн дундаас дээш боловсрол бүхий хосолсон аргаар аж ахуй эрхлэгч малчдын эзэмшиж буй малын тоо бага, суурь боловсролтой малчдаас 3 дахин олон малтай аж.

Хүснэгт 28. Үйлдвэрлэлийн арга ба боловсролын түвшин (дундаж үзүүлэлт болон төгрөгөөр)

	Уламжлалт		Фермер		Хосолсон АА	
	Малын тоо	Орлого	Малын тоо	Орлого	Малын тоо	Орлого
Боловсролгүй	308.0	830955	-	-	-	-
Бага	303.6	865655	5	820000	69.0	1640000
Суурь	389.6	923949	63.5	917630	68.1	1337500
Бүрэн дунд	328.7	833732	45.7	1452231	216.2	1667462
ТМС	412.8	1572009	26.7	1812667	357.8	1425000
Бакалавр	335.0	1318500	164.0	2450000	216.7	2134762

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Үйлдвэрлэл эрхлэх арга хийгээд боловсролын түвшний хооронд хүчтэй бус боловч эерэг хамаарал илэрч байгаа ($r = 0.188^{**}$) нь үүнийг баталгаажуулна.

Зарлагын хэмжээ, зориулалт мөн аж ахуй эрхлэх аргаас хамаарч өөр өөр ба уламжлалт болон хосолсон аж ахуй эрхэлж буй малчид (1.832.251), фермер эрхлэгч (1.876.474)-ийн зарлагын хэмжээ ойролцоо, уламжлалт мал аж ахуй эрхлэгч малчид (1.198.058)-аас дор хаяж 36 хувиар өндөр зарлага гаргадаг. Орлогын хэмжээгээр мөн адил бөгөөд хосолсон арга ажиллагаа бүхий аж ахуй (1.643.152)-н орлого уламжлалт аж ахуй эрхлэгч (924.798)-дийнхээс 56.3 хувиар, фермерийн аж ахуй эрхлэгч (1.309.488)-дийнхээс 21.3 хувиар өндөр байгаа юм. Орлого, зарлагын харьцаагаар үр ашиг нь тодорхойлогдоно гэж үзвэл хосолмол аргаар аж ахуй эрхлэгчдийн зарлага орлогоос 10.3 хувиар, уламжлалт аргаар аж ахуй эрхлэгчдийнх 20.8 хувиар, фермер эрхлэгчдийнх 30.2 хувиар өндөр аж.

Үйлдвэрлэлийн аргаас хамааралтай малын бүтэц харилцан адилгүй бөгөөд фермерийн болон хосолмол хэлбэрийн аж ахуйд чиглэлийн мал дагнан эрхэлдэг бол уламжлалт хэлбэрийн аж ахуй эрхэлдэг малчид дор хаяж гурван төрлийн мал малладаг. Уламжлалт хэлбэрээр аж ахуй эрхэлж буй малчдын тухайд сүргийн 49.3 хувийг хонь, 36.1 хувийг ямаа, 5.5 хувийг үхэр, 5.2 хувийг адуу, 0.2 тэмээ бүрдүүлдэг бол фермерийн аж ахуй эрхлэгчдийн 92.9 хувь нь, хосолсон аж ахуй эрхлэгчдийн 77.1 хувь нь чиглэлийн мал, фермерийн аж ахуй эрхлэгчдийн 7.1 хувь нь, уламжлалт болон фермерийн аж ахуй эрхлэгчдийн 22.9 хувь нь чиглэлийн мал болон амьтан үржүүлдэг. Чиглэлийн мал дагнасан фермер болон хосолмол аж ахуй эрхлэгчдийн 81.0 хувь нь сүүний чиглэлийн үнээ, 17.0 хувь нь мах, сүүний чиглэлийн үхэр, 9.4 хувь нь махны чиглэлийн үхэр, 1.9 хувь нь сүүний чиглэлийн ямаа үржүүлдэг бол хос аж ахуй эрхэлдэг

малчдын 50 хувь нь сүүний чиглэлийн үхэр махны чиглэлийн үхэр хослуулан, 50.0 хувь нь сүүний чиглэлийн үнээ, мах болон ноосны чиглэлийн хонь зэргийг гахай, тахиа, зөгийтэй зэрэгцүүлэн үржүүлдэг.

Суурьшлын хэв маягаар: нийслэлд 25 дээш насны, хүйсийн хувьд эрэгтэй өрхийн тэргүүлэгчид давамгай (88.0%) боловч хөдөөтэй харьцуулахад эмэгтэй өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хэмжээ өндөр (12.0%), боловсрол эзэмшээгүй болон эрдмийн зэрэгтэйгээс бусад түвшний боловсролтой, гэр бүлийн хувьд харьцангуй тогтвортой, 6 хүртэл тооны ам бүлтэй, хосолсон (28.0%) болон төрөлжсөн фермер (42.0%)-ийн аж ахуй эрхэлдэг малчдын эзлэх хэмжээ өндөр аж.

Аймаг сумын ойролцоох болон хөдөөгийн малчдын дунд бүх насны төлөөлөл, хүйсийн хувьд хөдөөд эрэгтэй тэргүүлэгчтэй өрх давуу (90.5%) бол аймаг сумын төвийн ойролцоох малчдын хувьд нийслэлийн малчидтай ойролцоо (эрэгтэй 87.2%, эмэгтэй 12.8%) байна. Үйлдвэрлэл эрхэлж буй арга, ажиллагаагаар аймаг, сумын төвийн ойролцоо амьдардаг малчдын 92.5 хувь нь бэлчээрээр, 5.2 хувь нь хосолсон аргаар аж ахуй эрхэлдэг бол хөдөөгийн малчдын 99.3 хувь нь бэлчээрээр аж ахуй эрхэлдэг.

Хүснэгт 29. Суурьшил ба нас, хүйс (хувиар)

		Ажиллаж буй хэлбэр		
		Нийслэл	Аймаг, сум	Хөдөө
Насны бүлэг	24 хүртэл	-	2.0	2.3
	25-34	10.0	15.1	20.3
	35-44	24.0	27.2	29.4
	45-54	20.0	23.9	26.0
	55-аас дээш	46.0	31.8	22.0
Хүйс	Эрэгтэй	88.0	87.2	90.5
	Эмэгтэй	12.0	12.8	9.5
Боловсрол	Б-гүй	-	6.9	9.8
	Бага	10.0	16.4	20.9
	ББД	26.0	27.2	32.8
	БД	46.0	36.1	28.6
	ТМС	10.0	7.2	5.5
	Бакалавр	8.0	5.9	2.4
	Магистр, түүнээс дээш	-	0.3	-
Нийт		100.0	100.0	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Боловсролын түвшний хувьд аймаг, сумын ойролцоо бүрэн дундаас дээш, хөдөөд бүх бүрэн дундаас доош түвшний, нийслэлд бага болон эрдмийн зэрэг хамгаалснаас бусад боловсролтой малчид энэ төрлийн аж ахуй эрхэлдэг аж.

Хүснэгт 30. Суурьшил ба боловсрол, гэр бүлийн хэв маяг (хувиар)

		Ажиллаж буй хэлбэр		
		Нийслэл	Аймаг, сум	Хөдөө
Гэр бүлийн хэв маяг	Гэрлээгүй	4.0	6.6	3.7
	Гэрлэсэн	86.0	80.3	85.5
	Тусгаарласан	-	1.3	0.3
	Цуцласан	-	1.6	0.7
	Бэлэвсэн	10.0	10.2	9.8
Ам бүл	2 хүртэл	50.0	19.3	13.2
	3-4	16.0	28.2	20.3
	5-6	34.0	51.8	66.0
	7-8	-	0.7	0.4
Ажлын цаг	Mean	11.7	12.1	12.9
Нийт		100.0	100.0	100.0

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Гэр бүлийн хэв маягийн хувьд гэрлэсэн хүмүүсийн эзлэх хэмжээ өндөр байгаагийн зэрэгцээ тусгаарласан болон гэр бүл цуцалсан, өрх толгойлсон эцэг эх бүхий гэр бүл цөөнгүй. Ам бүлийн тоог нийслэлийн малчидтай харьцуулахад аймаг, сумын төвийн ойролцоо амьдардаг малчдын 51.8 хувь нь, хөдөөгийн малчдын 66.0 хувь нь 5-6 гишүүнтэй. Ажлын цаг зарцуулалт нийслэлийн малчид бага (11.7 цаг), хөдөөгийн малчид их (12.9 цаг) цаг зарцуулдаг.

Орлогын хэмжээгээр нийслэлийн малчид өндөр бөгөөд (хөдөө 874.558, аймаг сумын ойролцоо 1.112.913, нийслэл 1.197.666) мал аж ахуйгаас олох орлого, цалин хөлс, аймаг сумын малчдын орлогын бүтцэд өрхийн бизнес, цалин хөлс, хөдөөд мал аж ахуйн болон, өрхийн бизнесийн орлого (Хавсралт-4. Өрхийн орлогын хэмжээ: суурьшлаар. Б) голлох хэсгийг бүрдүүлдэг.

Хүснэгт 31. Орлогын бүтэц харьцаа: суурьшлаар (хувиар)

	Нийслэл	Аймаг, сум	Хөдөө	Орлогын дундаж
Цалин	13.6	9.8	6.2	616.445
Тэтгэмж	36.4	31.7	35.5	219.810
МАА-н орлого	40.9	40.7	45.2	673.825
Өрхийн бизнес	1.8	4.0	1.3	874.660
Бусад	0.9	3.0	2.2	182.231
Нийт	100.0	100.0	100.0	-

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа

Орлогын эх үүсвэрийн бүтцэд нийслэл, аймаг сум, хөдөөд МАА болон тэтгэвэр тэтгэмж малчдын орлогын гол эх үүсвэр болдог. МАА-аас олох орлогыг задлаж тооцох тухай доктор Х.Гүндсамбуу "... зах зээлд мал сүрэг, түүний ашиг шимийг борлуулсан

байдлаар, цаашилбал амьжиргааных нь төвшин, амьдралынх нь хэв шинж, маягаар тодорхойлох учиртай." гэж тэмдэглэн хэлсэн (Гүндсамбуу.Х, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, 2002, р. 116)-ийг энэ судалгаанд шинжилгээ хийхдээ ашигласан. Цалин орлогын гол эх үүсвэрийн нэгд тооцогдох боловч энэ нь суурьшлаас хамааралтай ялгаатай байна. “Хөдөөгийн амьдралын хэв маягийн өөрлөлт” судалгаанд суурьшилд хэр ойр байрлаж байгаагаас хамаарч малчдын орлого ялгаатай, гэхдээ орлогын эх үүсвэр дээрх бүтэцтэй (ШУА-ийн ФХ, 2018, р. 111).

Хөдөөгийн малчид мал мах зарж жилд дунджаар 9.204.352 төгрөгийн орлого олдог бол аймаг сумын ойролцоо амьдардаг малчид 7.946.743 төгрөг, нийслэлийн малчид 7.439.908 төгрөг олдог. Малын гаралтай түүхий эдийн орлогын бүтэц суурьшлаас хамаарч мөн өөр өөр бөгөөд хөдөөд ноос, ноолуураас орлогын ихэнхийг олж буй бол Улаанбаатарын малчид орлогын ихэнхийг мал зарж олсон орлого (Хавсралт-4. Өрхийн орлогын хэмжээ: суурьшлаар А)-оос бүрдүүлж байгаа юм.

Өрхийн зарлагын хэмжээ нь мөн харилцан адилгүй бөгөөд нийслэлийн малчид сард дунджаар 1.721.660, аймаг сумын төвийн ойролцоо амьдардаг малчид 1.449.398, хөдөөгийн малчид 1.122.635 төгрөгийн зардал гаргадаг. Зарлагын бүтцийг тодруулахад малын арчилгаа тордолгоонд 20.6 хувийг, зээлийн төлбөрт 15.7 хувийг, хүнсэнд 13.3 хувийг, гэр ахуйн зүйлс, хувцас хэрэглэлд 10.9, шатахуунд 9.6 хувийг г.м зарцуулдаг бөгөөд зарлагын бүтэц, харьцаа суурьшлын хэв маягаас хамааралтай өөр өөр аж.

Хүснэгт 32. Малчдын зарлагын бүтэц: суурьшлаар (хувиар болон зарлагын дунджаар)

	Нийслэл	Аймаг, сум	Хөдөө	Нийт
Хүнсний зардал	13.2	12.4	14.3	181.130
Цахилгаан, ус дулааны төлбөр	1.6	1.6	0.5	12.261
Гэр ахуйн бараа, хувцас гутал	7.8	12.5	12.3	160.516
Сургалтын төлбөр	3.0	3.7	4.2	52.649
Малын тэжээл	28.5	18.5	14.8	222.999
Түлш (түлээ нүүрс г.м)	1.9	2.4	1.1	20.498
Шатахуун	9.0	9.0	10.9	135.031
Харилцаа холбоо	3.5	4.0	2.7	41.525
Боловсролын зардал	6.0	6.1	5.4	75.358
Эрүүл мэндийн үйлчилгээний зардал	5.2	5.7	5.1	70.060
Зээлийн төлбөр	14.8	16.2	16.2	213.736
Туслах ажилтны цалин	4.9	2.8	1.4	27.339
Бусад	0.5	5.2	1.3	32.974
Нийт	100.0	100.0	100.0	-

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Нийслэл орчмын малчид малын арчилгаа (28.5%)-нд зардлынхаа гуравны нэгийг зориулдаг бол аймаг сумын ойролцоох болон хөдөөгийн малчид гэр ахуйн хэрэглэл, хувцас хэрэгсэлд зориулж буй зарлага нийслэлийн ойролцоох малчдынхаас, аймаг сумын ойролцоох малчдын түлшний зардал хөдөөгийн малчдаас, нийслэлийн малчид туслах малчинд зарцуулах зардал аймаг сум, хөдөөгийн малчдынхаас бараг нэгээс хоёр дахин өндөр байх жишээтэй.

Орлого, зарлагын хэмжээ хийгээд суурьшлын хэв маяг, үйлдвэрлэл эрхлэх арга ажиллагаа гэсэн үзүүлэлтүүдийн хооронд хамаарал тооцооход нэг талын хүчтэй хамаарал ажиглагдахгүй байгаа ч мал маллагааны арга хэлбэрээс хамаарч орлого, зарлага өсөн нэмэгдэх, эсрэгээрээ суурьшлын төвөөс алслагдах тусам орлого зарлагын хэмжээ буурах зүй тогтол илэрч байна.

Хүснэгт 33. Хамаарал: суурьшил, мал маллагааны арга хэлбэр ба орлого, зарлага (Пирсоны корреляцийн коэффициент)

	1	2	3	4
1. Мал маллагааны арга хэлбэр	1			
2. Суурьшил	-.421**	1		
3. Орлого	.117**	-.097**	1	
4. Зарлага	.183**	-.137**	.565**	1

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Цахилгаан хэрэглээний эх үүсвэр гэхэд, судалгаанд оролцогчдын 1.9 хувь нь (20 өрх) цахилгаангүй бол үлдсэн хэсэг нь байнгын эрчим хүчтэй болсон. Тухайлбал, хөдөөгийн малчид сэргээгдэх эрчим хүч (69.5%), бага оврын цахилгаан үүсгүүр (25.5%)-ээс, аймаг, сумын төвийн ойролцоо амьдарч буй малчид сэргээгдэх эрчим хүч (44.7%), төвлөрсөн систем (44.3%), бага оврын цахилгаан үүсгүүр (9.6%)-ээс, нийслэлийн малчид төвлөрсөн систем (60.0%), сэргээгдэх эрчим хүч (20.0%)-ээс эхтэй цахилгаан хэрэглэдэг.

Аж ахуйн онцлогтой холбоотой бэлчээр сэлгэх хэрэгцээ, давтамж нь аж ахуй эрхлэх арга хэлбэр, суурьшлын онцлогоос хамааралтай ялгаатай байна. Хөдөөгийн малчдын 70.1 хувь нь, сумын төв орчмын малчдын 65.4 хувь нь, аймгийн төв орчмын малчдын 50.7 хувь нь, Улаанбаатар хотын малчдын 12 хувь нь бэлчээр сэлгэн нүүдэг бол үүний эсрэгээр Улаанбаатар хотын малчдын 60.0 хувь нь, аймгийн төв орчмын малчдын 41.8 хувь, сумын төв орчмын малчдын 26.0 хувь нь бэлчээр сэлгэх боломжгүй гэж.

Нүүдэллэх зай, нүүдэл хийх дараагийн хугацаа зэрэг нь газар зүйн байршил, бүс нутгийн онцлогоос хамаарч харилцан адилгүй (Azjargal Jargalsaikhan and et al., 2015, p. 156). Энэ судалгааны ажилд аж ахуй эрхэлж буй арга хэлбэрээр нь шинжилж үзэхэд: фермерийн аж ахуй эрхлэгчдийн 75.0 хувь нь бэлчээр сэлгэдэггүй гэсэн бол 25.0 хувь нь нэгээс дөрвөн удаа, уламжлалт болон фермерийн аж ахуй эрхлэгчдийн 45.7 хувь нь бэлчээр сэлгэдэггүй бол 25.7 хувь нь 1-2 удаа, 22.9 хувь нь 3-4 удаа, 5.7 хувь нь 5-8 удаа бэлчээр сэлгэдэг гэжээ. Уламжлалт аж ахуй эрхлэгчдийн 22.3 хувь нь 1-2 удаа, 40.8 хувь нь 3-4 удаа, 20.2 хувь нь 5-8 удаа, 7.5 хувь нь 9-өөс дээш удаа нүүдэл хийж бэлчээр сэлгэдэг гэсэн бол 9.2 хувь нь нүүдэл хийдэггүй гэжээ. Нүүдлийн тоо, бэлчээр сэлгэх тухай асуудал нь нэг талаас аж ахуй эрхэлж буй арга хэлбэртэй холбоотой болох нь тоон үр дүнгээс харагдаж байгаа бол нөгөө талаас нүүдэл суудал хийхгүй хэрнээ уламжлалт хэлбэрээр мал аж ахуй эрхэлдэг гэх малчид байгааг харгалзвал тэд “бууц сэлгэх” ойрын нүүдлийг бэлчээр сэлгэсэнд тооцохгүй байх, эсвэл бэлчээр сэлгэж мал хариулах тухай үзэл хандлага өөрчлөгдөж буйтай холбоотой.

Малчдын бүтэц, ялгаа. Хүчин зүйлсийг шинжилсэн үр дүнгээс харахад малчид дотооддоо ихээхэн ялгарч байна. Монгол улсад нийгмийн бүтцийг тодорхойлох чиглэлээр “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” (ҮСХ, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, 2019), “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”-аар (ХАХНХЯ, УБСЕГ, 2016) судлаж байгаа юм.

“Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд өрхийн орлого-орлогын бүтэц, зарлага-зарлагын бүтэц, хадгалалмж, зээлийн үзүүлэлтүүдийг ашиглаж үр дүнг тооцдог. Үүнд ийнхүү хэмжиж болохуйц тоон үзүүлэлтүүдийг ашиглаж хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэгтэй нь харьцуулан шинжилж үр дүнг гаргадаг ч өмч хийгээд нийгмийн бусад үзүүлэлтүүдийг харгалздаггүйгээс гадна нь нийгмийн бүтэц, түүний өөрчлөлтийг илэрхийлэхээс илүүтэй тайланд үзүүлэлтүүдийн үр дүнг шинжилсэн үр дүнг харуулдаг.

“Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”-аар нийгмийн бүтэц, ялгааг “1. Өрхийн ам бүлийн гишүүдийн тоо болон ам бүлийн бүтэц: Ам бүлийн гишүүдийн тоо, нас, 2. Хөгжлийн бэрхшээл: Хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүн байгаа эсэх, 3. Өрхийн тэргүүлэгчийн шинж чанар: Нас, хүйс, боловсролын түвшин, 4. Боловсрол: Өрхийн гишүүн бүрийн эзэмшсэн боловсролын түвшин, өрхөд байгаа боловсролтой хүний тоо гэх мэт, 5. Ажил эрхлэлт:

Сүүлийн долоо хоногт ажил эрхэлсэн өрхийн гишүүдийн тоо, ажил эрхэлсэн салбараар 6. Сууцны нөхцөл: Амьдарч байгаа сууцны төрөл, 7. Сууц өмчлөл: сууцны тоо, сууцны өмчлөл, орон сууцны зээлд хамрагдах хүсэлтэй эсэх гэх мэт, 8. Үйлчилгээ: Ус, ариун цэврийн байгууламжийн болон халаалтын эх үүсвэр, 9. Удаан эдэлгээт бараа: Гэр ахуйн хэрэгцээний болон тээврийн хэрэгсэл: хөргөгч, зурагт, суудлын машин гэх мэт, удаан эдэлгээт эд хогшлын тоо болон чанар, 10. Мал аж ахуй эрхлэлт: Малын тоо, малын төрөл. Малын тоо толгойг бодод шилжүүлэн тооцсон, 11. Газар: Газар өмчилдөг болон эзэмшдэг эсэх 12.Өрхийн байршил: Бүс нутаг, 13. Хадгаламж: Өрх нь хадгаламж эзэмшдэг эсэх” (ХАХНХЯ, УБСЕГ, 2016, р. 11) бүлэг үзүүлэлтээр, арга зүйн хувьд “Жишсэн дундаж нэг хүнийг тооцох гэдэг нь тэнцвэржүүлэх хэмжээсийг ашиглан өрхийн ам бүлийн гишүүдийн тоог засварлан тооцож байгаа хэрэг бөгөөд тэнцвэржүүлэх хэмжээс нь өрхийн ам бүлийн гишүүдийн харилцан адилгүй хэрэгцээний түвшинг харьцангуй зөв тооцох боломжийг бий болгосон. Тэнцвэржүүлэх хэмжээс ... нь өрхийн насанд хүрсэн эхний хүн 1 (хэрэв хөгжлийн бэрхшээлтэй бол 1.4), насанд хүрсэн дараагийн хүн 0.7 (хэрэв хөгжлийн бэрхшээлтэй бол 1), хүүхдүүд 0.5 (хэрэв хөгжлийн бэрхшээлтэй бол 0.7) гэх мэт харилцан адилгүй жинг өрхийн ам бүлийн нийт гишүүдийн тоог тооцоход оноож байна гэсэн үг болно.” (ХАХНХЯ, УБСЕГ, 2016, р. 10) гээд холбогдох тайлан (ХХҮЕГ, АХБ, 2017)-д үзүүлэлт бүрээр бүлэглэн тодорхойлсон байдаг.

“Монгол улсын өрх, хүн амын аж байдлын дүр төрх” судалгаанд амьжиргааны түвшин тогтоох аргачлалаар малтай өрхийг 5 бүлэгт ангилан, малын тоо хэмжээг гаргасан бөгөөд дундаж буюу III түвшний өрх 103 толгой малтай дийлэнх хэсэг (50.8%)-ийг бүрдүүлж байгаа бол I түвшин 18 толгой (2.4%), II түвшин 50 толгой (12.9%), IV түвшин 123 толгой (25.8%), V түвшин 76 толгой (8.0%) малтай (ХХҮЕГ, АХБ, 2017, р. 66) гэж тэмдэглэсэн. Арга зүйн хувьд бүтцийг ийн илэрхийлсэн ч (ХАХНХЯ, УБСЕГ, 2016, рр. 15-16) нэгд боловсролын түвшнийг, эсвэл хийж байгаа ажлаа нь сайн муу гэж зэрэглэх юмуу, тэдгээрийг шууд коэффициентээр илэрхийлж үр дүнг хэмжих үзүүлэлт болгох нь өрөөсгөл юм. Амьжиргааны түвшинд нь хэрхэн нөлөөлж байна вэ гэх байдлаар хэмжиж болохуйц үзүүлэлтүүдээр бүтцийг нь илэрхийлээд боловсролын түвшний ялгаатай бүлгүүд ямар байдлаар бүтэцжиж, эсвэл бүтцийн аль хэсэгт төвлөрч байна гэх байдлаар хэмжих нь арга зүйн хувьд зөв байх талтай. Хоёрт удаан эдэлтгээт


бараа (хэрэгсэл)-тэй гээд будаа агшаагч, тоос сорогч, хөргөгч хөлдөөгч, телевиз зэргийг амьжиргааны түвшин тогтоох хэрэгсэл болгосон нь үр дүн муутай бөгөөд суурьшлын онцлогоос хамаарах хэрэглээний шинжтэй болсон зүйлс юм. Жишээлбэл, малчдын хувьд зарим хэрэгсэл туйлын хэрэгцээтэй зүйлд тооцогдохгүйгээс гадна, амьдралын хэв маягт нь тэр бүр нийцэхгүй бөгөөд хэрэв эдгээр зүйлс байхгүй тохиолдолд амьжиргааны түвшнээр доогуур бүлэгт орох уу гэх асуултад хариулах хэрэгтэй болно. Тэгэхлээр, нийгмийн бүтцийг илэрхийлж судлахдаа ялгаатай хэв маягуудад тохирохуйц нийтлэг шалгуур хэрэглэх нь зүйтэй гэдэг санааг үүнээс урган гарч байгаа юм.

Социологийн талаас нийгмийн шинжтэй үзүүлэлт (гэр бүлийн хэв маяг, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, суурьшил, үйлдвэрлэлийн арга, өмч захирах эрх г.м)-үүд нь бүтцийг илэрхийлэх шууд хэмжүүр бус, харин бүтцийг шинжлэх үзүүлэлт болно. Жишээлбэл, боловсрол нь нийгмийн бүтцийг тодорхойлоход голлох үүрэгтэй, үүнээс хамаарч бүтэц өөрчлөгддөг бол дээд боловсролтой хүмүүсийг бүтэц нь доошоо харсан гурвалжин хэлбэртэй байна гэсэн үг юм.

“Малчдын нийгмийн ялгарал” судалгаанд ашигласан “ам бүлийн тоо, эрүүл мэндийн байдал, өрхийн тэргүүлэгчийн нийгэм хүн ам зүйн байдал, боловсрол, сууц, өмч (хөдлөх болон үл хөдлөх), газар зүйн байршил, хадгаламж” зэрэг үзүүлэлт нь “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал” дахь шалгуур үзүүлэлттэй таарч байгаа бол “гэр бүлийн хэв маяг, хөдөлмөр эрхлэлт, туршлага, өмч захирах эрх, үйлвэрлэл эрхэлж буй арга, суурьшлын хэв маяг” гэсэн үзүүлэлтүүдийг ашиглаж үр дүнг шинжилсэн. Ингэхдээ орлого, зарлага, зээл, өмч зэрэг үзүүлэлтэд үндэслэн бүтцийг илэрхийлж, нийгмийн ялгааг илэрхийлэх үзүүлэлтүүдээр шинжлэх (Хавсралт-7. Малчдын ялгарал, дүр зураг. А, Б)-д дараах үр дүн гарчээ.

Судалгааны баримт үр дүнд үндэслэвэл “малчдын зарим хэсгийн амьжиргааны түвшин харьцангуй өссөн хэдий ч эл бүлгийн (малчид) ядуу доод суурь өргөжсөн ...” (Мөнхбат.О, 2000, р. 105; Дагвадорж.Д, 1998, р. 36) гэж судлан тэмдэглэж байсан бол энэ удаагийн судалгааны үр дүнгээс доод сууриас дунд суурь руу шилжсэн дүр зураг илэрч байна. Үүссэн бүлгүүдийн онцлог, ялгааг тодруулбал:

Зураг 14. Малчдын нийгмийн бүтэц, ялгаа (малын тоо, өмч, орлого, зарлагаар)



Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Нэг. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр дунджаар 2674 толгой малтай (малын төрөл тус бүрийн нийлбэрээр 931.5 толгой), мал аж ахуйгаас жилд дунджаар 59.418.750 төгрөг олдог, орон сууц, байшин, газар, өвөлжөө, хаваржаа, суудлын болон ачааны машин, трактор, мотоцикл, гэр ахуйн хэрэглэлээр бүрэн хангагдсан, орлого нь зарлагаасаа 125.3 хувиар өндөр өрх 0.2 хувийг эзэлж байна.

Хоёр. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр дунджаар 1485 толгой малтай (малын төрөл тус бүрийн нийлбэрээр 673.9 толгой), мал аж ахуйгаас жилд дунджаар 28.749.571 төгрөг олдог, сууцны байшин, газар, өвөлжөө, суудлын болон ачааны машинаар бүрэн хангагдсан, зарлага нь орлогоосоо 12.1 хувиар өндөр өрх 0.4 хувийг эзэлж байна.

Гурав. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр дунджаар 1315 толгой малтай 20.675.842 төгрөг олдог, орлого нь зарлагаасаа 6.7 хувиар өндөр өрх 6.9 хувийг эзлэж байна.

Дөрөв. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр дунджаар 683 толгой малтай (малын төрөл тус бүрийн нийлбэрээр 435 толгой), мал аж ахуйгаас жилд дунджаар 12.203.837 төгрөг олдог, зарлага нь орлогоосоо 12.1 хувиар өндөр өрх 32.1 хувь (17.0%+15.1%)-ийг эзлэж байна.

Тав. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр дунджаар 409 толгой малтай (малын төрөл тус бүрийн нийлбэрээр 266 толгой), мал аж ахуйгаас жилд дунджаар 6.042.901 төгрөг олдог, зарлага нь орлогоосоо 31.7 хувиар өндөр өрх 35.7 хувийг эзлэж байна.

Зургаа. Хонин толгойд шилжүүлсэн дүнгээр дунджаар 253 толгой малтай (малын төрөл тус бүрийн нийлбэрээр 166 толгой), мал аж ахуйгаас жилд дунджаар 3.818.260 төгрөг олдог, зарлага нь орлогоосоо 45.1 хувиар өндөр өрх 23.5 хувийг эзлэж байна.

Нийгмийн хэв шинжийн хувьд 0.3-0.59 хүртэл насны дунджаас доош насныхан давамгайлах хандлагатай бол энэ үзүүлэлтээс дээш, доош чиглэлд ахмад малчид давамгайлж байна. Хүйсийн хувьд эрэгтэй тэргүүлэгчтэй өрх, боловсролын хувьд түвшин дээшлэх тусам, гэр бүлийн хэв маягаар дан гэр бүлийн бүл, ам бүлийн тоогоор дунджаас бага тооны гишүүдтэй өрх индексийн оройд байрлаж байгаа юм.

Хүснэгт 34. Нийгмийн хэв шинж ба индекс (дундаж үзүүлэлтээр)

Индекс	Нас	Хүйс	Боловсрол	Гэр бүлийн хэв маяг	Ам бүл
0.09 хүртэл	47.92	1.30	2.96	2.8776	4.35
0.1-0.19	46.07	1.13	3.06	2.3684	4.32
0.2-0.29	46.66	1.11	3.15	2.2658	4.26
0.3-0.39	46.18	1.06	3.36	2.1104	4.42
0.4-0.49	45.83	1.05	3.24	2.1149	4.05
0.5-0.59	45.24	1.02	3.46	2.0370	4.04
0.6-0.69	49.85	1.10	3.55	2.3000	3.0
0.7-0.79	38.75	1.00	4.00	2.0000	4.0
0.8-0.89	49.00	1.00	5.00	2.0000	4.0
Дундаж	46.44	1.11	3.20	2.2776	4.23

Эх сурвалж: “Малчдын аж байдал” судалгаа. 2018 он.

Малчдын нийгмийн ялгарч буй байдал нь өрхийн тэргүүлэгчийн хүйс, боловсролын түвшнээс, нарийн тодорхойлбол ялгаа нь гэр бүлийн хэв маяг, бүтцээс хамаардаг.

ДҮГНЭЛТ

Оюун санаа, сэтгэлгээний түвшинд эрдэмтэн судлаачид онолын олон урсгал чиглэл, хэв маягийг баримжаа болгон малчид, мал аж ахуйн асуудлаар зөв буруугийн тухай мэтгэлцэж буй боловч шийдтэй үр дүнд хүрсэн нь ховор. Соёлын ялгаатай байдлыг үл хайхран үзэгдлийг гөрдөн тайлбарлах юмуу, нүүдэлчдийн нийгмийн онцлог, харилцааг хэт дөвийлгөн туйлшруулах, тодорхой бүтэцлэгдсэн дүр зураг үгүйгээс болж уран яруу, гоёж чимсэн тодорхойлолтоор уралдах, үзэгдэл үйл явцын хувирал, түүний уг шалтгааныг тайлбарлан таниулахаас илүүтэй бүртгэн тэмдэглэх, практик асуудал шийдэх, асуудлыг танин мэдэх байдлаар судлах болсон нь малчдын талаар хийсэн судалгааны баримтуудаар батлагдаж байна. Үзэл санааны олон хувилбар яригдаж буй нөхцөлд зөв сэтгэлгээ, хандлага тогтдог ч энэ хэрээр өөрийгөө таньж мэдээгүй нь илэрч, бидний тохиолдолд уламжлалт харилцааны хэв шинж далдлагдах, нийгэм олон нийтийн дунд уламжлалаа үндэслэлгүйгээр үгүйсгэх хандлага ч хүчтэй илэрч байгаа юм.

Өмнө судалсан баримтуудад үндэслэн, эмпирик баримтуудыг нэгтгэн шинжлэх байдлаар асуудалд хандах чигийг баримтлан зорилго, зорилтын дагуу ажиллаж үр дүнгээ гаргалаа. Малчдын нийгмийн асуудлаар 1990 оноос өмнө, мөн үүнээс хойно хийсэн судалгааны ажил, холбогдох баримт материалуудыг шинжлэх явцад мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог шинж, нийгмийн харилцааны хэв маягийг ямар нэг байдлаар шинжилж, тус тусдаа үр дүнд хүрсэн баримт цөөнгүй. Ийм баримтуудыг шинжилж нэгтгэсний үр дүнд нэг дүгээрт аж ахуй үйлдвэрлэлийн онцлогийг тодруулж, энэхүү онцлог буюу нөхцөл ба боломжоос хамаарах ялгаа, мөн нийгмийн ялгааг тодорхойлох үзүүлэлтүүдэд үндэслэн шинжилгээ хийж таамаглал шалгалаа. Үүнд:

Таамаглал-1. Малчдын ялгаа нь нөхцөл, боломжийн харилцан үйлчлэлийн үр дүн. Нөхцөл нь өөр хоорондоо ялгарах суурь хүчин зүйл болох бол үйлдвэрлэлийн талаас боломж нь шийдвэрлэгч үүрэгтэй.

Малчдын асуудлаар ялангуяа, тэгш бус байдал, давхраажлын тухай ярьж буй тохиолдолд мал аж ахуйтай холбогдож, хутгалдах зүйл түгээмэл ажиглагддаг бөгөөд харилцааны онцлог нь, мөн өмч хийгээд орлогын голлох эх үүсвэр нь МАА-аас хамааралтай учир ийн үзэхээс өөр гарцаагүй. Таамаглал хийгээд судлан буй сэдвийн онцлогтой холбоотой шинжилгээг нэгдүгээрт үйлдвэрлэл эрхлэх онцлогтой холбоотой,

хоёрдугаарт үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой ялгаа бий болоход бодлогын болон эдийн засгийн нөхцөл хэрхэн нөлөөлдөг болохыг ялган шинжилж үр дүнг гаргасан.

Нэг. Үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой юуны түрүүнд бүс, байгалийн хүчин зүйлтэй холбоотой өмчилж буй малын тоо хэмжээ, бүтэц бүсүүдэд ялгаатай бөгөөд энэ нь малчид өмч хөрөнгө, орлогын хэмжээгээр ялгарахад нөлөөлдөг. Бодлогын түвшинд, 2008 оноос ноос ноолуурын урамшуулал олгож эхэлснээс хойш малын тоо хэмжээ улам бүр өсч, сүргийн бүтцэд ямаа, мөн хонин сүргийн эзлэх хэмжээ нэмэгдэхэд нөлөөлсөн байх жишээтэй.

Үйлдвэрлэл эрхлэхтэй холбоотой боломж нь малчин хүн бие махбод, мэдлэг ухаан, сэтгэл зүйн төлөв нь өмчийн хувьд ялгарахад тодорхойлогч нөлөөтэй. Учир нь бэлчээрийн болон газар зүйн аль ч бүсд шилдэг сайн малчид төрөн гардаг нь өөрийн болон өрхийн “боломж”-ийг хэрхэн ашиглаж байгаатай холбоотой юм. Тухайлбал, малын тарга тэвээрэг авахуулах, тэжээл хужир бордоо бэлтгэх, отор нүүдэл хийх, эрсдэлд бэлтгэх г.м арга ажиллагаа нь малын тоо толгойг өсгөхөд голлох нөлөө үзүүлдэг бөгөөд олон мал бүхий өрх ийм төрлийн ажиллагаанд илүүтэй анхаарч ажилладаг.

Хоёр. Нийгмийн шинжээр ялгарахад ялангуяа бодлогын зохицуулалтаар суурь нөхцөлийг дээшлүүлэх, эсвэл ялгаатай байдлыг арилгахад зохих нөлөө үзүүлэх учиртай. Малчдын тухайд энэ тал шинж туйлын хангалтгүй. Бодлого гэр бүлийн, боловсролын, соёлын, эрүүл мэндийн, нийгмийн хамгааллын чиг шугамаар нийгмийн бүлгүүдэд зохих байдлаар хүрдэг гэж болох ч тодорхой бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөрүүдэд ч чиглэл бүрээр тодорхой тодорхой шийдэл туссан байх учиртай.

Монгол улсын хэмжээнд малчдад чиглэсэн “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин үндэсний хөтөлбөр” бодлогын баримтууд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ч хөтөлбөрийн томъёолол нь агуулга, зорилгоосоо гажиж, үр дүн нь хэнд, хэрхэн хүргэж байгаа нь ойлгомжтой бус. Агуулгыг нь шинжилбэл, үндсэндээ МАА-н үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бөгөөд малчдын асуудлыг хавсарга байдлаар тусгасан. Хөтөлбөрийн үнэлгээний тайлангийн ихэнх хэсэгт аж ахуйн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлан, танилцуулга үүний баталгаа болно (ХХААХҮЯ, БОХААЭЗХ, 2019).

Судлан буй сэдэвтэй холбоотой “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” малчдын доторх ялгаатай бүлэгт чиглэсэн гурав, “Монгол малчин үндэсний хөтөлбөр” хөтөлбөрт хоёр зорилт дэвшүүлж энэ дагуу 9676 малчныг, тодорхой аймаг сумдын малчин эмэгтэйчүүд болон малчдыг зорилтот үйл ажиллагаанд хамруулсан гэж тайландаа тусгасан. Бодлого боловсруулагчид “малчид” гэж ерөнхий баримжаагаар ойлгодог ч тэдэнд тулгарч байгаа нийтлэг бэрхшээл нь юу болох, шалтгаан нь юунаас үүдэлтэй, цаашид ямар асуудалд анхаарч, яаж шийдэх тухай ойлгож судлалгүйгээр асуудалд ханддагийн тод жишээ энэ юм. Дэд бүлгүүдийн тухайд жишээлбэл, орлого багатай, цөөн малтай өрх, залуу малчин (МАА-н чиглэлээр суралцаж буй оюутанг малчин гэж тооцсон) гэж хэнийг хэлж байгаа нь тодорхой бус. Тэгэхлээр хэрэглээний талаас бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд малчдын, нийгмийн шинжээр ялгаатай бүлгүүдийн асуудлыг нарийвчлан судалсны үндсэн дээр холбогдох зорилтуудыг дахин төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгцээтэй.

Таамаглал-2. Боломж гэдэг нь мөн социаль шинжүүд (гэр бүлийн хэв маяг, үйлдвэрлэл явуулж буй арга, туршлага, боловсрол, гэр бүлийн хэв маяг, бүтэц, өмч, өмчийн хэлбэр, орлого)-ийг илэрхийлнэ бөгөөд малчдын дотоод дахь ялгарч, бүтэцжихэд нийгмийн шинжүүд голлох үүрэг гүйцэтгэнэ.

Малчдын нийгмийн ялгааг нэгд хүн ам зүй (нас, хүйс) болон нийгмийн г.м (гэр бүлийн хэв маяг, ам бүлийн тоо), туршлага-боловсрол, эрүүл мэндийн байдал, хоёрт өмч (хөдлөх ба үл хөдлөх), гуравт өмч захиран зарцуулах эрх буюу ажиллаж буй хэлбэр, дөрөвт орлого, тавд аж ахуй эрхлэх арга хийгээд суурьшлын хэв шинж гэсэн зургаан бүлэг үзүүлэлтээр шинжилж үр дүнг гаргасан.

Хүн ам зүйн шинжтэй буюу насны хувьд дунд насныхны эзлэх хэмжээ нэмэгдэж, хүйсийн хувьд эрэгтэйчүүд давамгайлах болжээ. Нийгмийн шинж байдлын хувьд гэр бүлийн хэв маягаар залуучуудын гэрлэлт оройтох, дунд насныханд салалт, тусгаарлалт нэмэгдэх, ахмад насныхан ялангуяа бэлэвсэн эмэгтэйчүүд их, боловсролын түвшнээр бүрэн дундаас доош түвшний боловсролтой, бэлчээрийн аж ахуй эрхэлдэг малчдын дунд салалт өндөр, орлогын хэмжээгээр залуучууд болон ахмад малчид бага, боловсролын түвшин буурахад орлогын түвшин буурах, малын тоо буурахад орлого буурах, хөдөлмөр эрхлэлтийн хувьд хүйсээс хамаарч, мөн аж ахуй эрхлэх арга хэлбэрээс хамаарч байгаа юм.

Хөдөлмөрийн хуваарилалтын хувьд эрэгтэйчүүд мал арчилгаа, тордолгоотой холбоотой ажлыг илүү гүйцэтгэж байхад, эмэгтэйчүүд түүхий эдийг боловсруулах борлуулах шинжтэй ажлыг, аж ахуй эрхлэх арга хэлбэрийн хувьд уламжлалт аж ахуй эрхлэгчид болон хосолмол аж ахуй эрхлэгчид мал хариулга, тордолгоотой ажлыг илүү гүйцэтгэж байхад, фермер эрхлэгчид өвс тэжээл бэлтгэх, хороо засах сэлбэх г.м аж ахуйн шинжтэй ажилд илүү анхаардаг. Ажлын цаг зарцуулалтын хувьд бэлчээрийн аж ахуй эрхлэгчид, өөрийн малыг маллаж буй малчид илүү олон цагаар ажиллаж байхад фермерийн аж ахуй эрхлэгчид, харьцангуй бага цагаар ажилладаг.

Судлаачийн зүгээс орлого, өмч, өмчийн хэлбэр, зарлага зэрэг үзүүлэлтүүдийг индексжүүлж 10 бүлэгт хуваан үр дүнг гаргахад 9 хэв маяг үүсч буй бөгөөд суурийн гурван бүлэг дийлэнх хэсэг (60.2%)-ийг бүрдүүлж байгаа бол дунд гурван бүлэг 37.4 хувийг, дээд гурван бүлэг 2.4 хувийг бүрдүүлж байна. Бүтцийн хувьд цаашид доод сууриас дунд хэсэг рүү чиглэсэн шилжих үйл явагдана.

Бүтцийн ялгаатай байдал нь гэр бүлийн хэв маяг, ам бүлийн тоо, боловсролын түвшин, аж ахуй эрхлэх арга, ажиллаж буй хэлбэр, суурьшлын хэв шинжээс хамаарч өөрчлөгддөг ба гэр бүлийн хувьд тогтвортой өрх, цөөн ам бүлтэй, мал ахуйгаа өөрөө болон бусдаар туслуулан эрхэлдэг, боловсрол өндөртэй, мал болон үл хөдлөх өмч бүхий малчид бүтцийн оройд, өрөөсгөл гэр бүл, олон тооны ам бүлтэй өрх, цөөн мал бүхий өрх, бэлчээрийн аж ахуй эрхэлдэг малчид оройн хэсгээс доош тархан байршиж байна.

Санал, зөвлөмж

1. Социологид нийгмийн ялгаа, тэгш бус байдлыг нийтлэг тохиолдолд үйлдвэрлэлийн үйл явц дахь хөдөлмөрийн харилцаатай холбон тайлбарладаг. Шинжлэх ухааны суурь тавигдсан үеэс үйлдвэрийн эзэн, ажилчид гэх тодорхой субъектүүдийн хоорондох эрх мэдлийн хуваарилалт, өмчийн хэмжээ, өмч захиран зарцуулах эрхийн тухай хүчтэй ярьж хожуу байгууллага, институцийн түвшинд судлан тодорхойлох болсон. Үндсэндээ үйлдвэрлэлийн явц дахь “субъект-субъект”-ийн хооронд үүсч буй харилцаанд илүүтэй анхаардаг. Мал аж ахуй эрхлэхэд харилцан үйлчлэлцэх субъектээс илүүтэй байгалийн хүчин зүйл (нөхцөл)-ийн нөлөөн дор үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь үргэлжилдэг бөгөөд энэ онцлогоос үүдэлтэй малчдын нийгмийн ялгаа нь нэгж субъект (эсвэл бичил бүлэг)-ийн боломжоор, мөн боломжоо хэрхэн ашиглаж байгаагаар тодорхойлогддог. Үүгээрээ институтижсэн үйлдвэрлэлийн харилцаанаас ялгаатай тул нийгмийн талаас судлахад энэ онцлогийг харгалзан үзэх.
2. Уламжлалт харилцаа төлөвшиж, хадгалагдахад үйлдвэрлэлийн нөхцөл буюу байгалийн хүчин зүйлийн нөлөө голлох үүрэг гүйцэтгэдэг болох нь судалсан баримт, шинжилгээний үр дүнгээр бага боловч баталгаажиж байна. Үйлдвэрлэлийн “нөхцөл”-өөс үүдэлтэй хариуцлагын болон хяналтын, нөгөө талаас боломжоос хамааралтай харилцан тэтгэх, дэмнэх харилцаа зайлшгүй төлөвшин тогтдог. Боломжийн тухайд мөн эмэгтэй өрхийн тэргүүн бүхий өрх, эсвэл залуучууд болон ахимаг настай малчдын хувьд үүсэн буй хэв маягийн доод түвшинд байрлаж байхад, малын тоо, малаас бусад өмч, эд хэрэглэл, орлогын хэмжээ нь хувь малчны хөдөлмөрийн идэвх, мал өсгөх, эрсдлийг бууруулах, хамгаалах зэрэг арга ажиллагаа нь үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашиг нь боломж (өгөгдсөн нөхцлийг даван туулахад)-оос хамаардаг болохыг илэрхийлж байгаа юм. Үүнтэй адилаар боломжид үйлдвэрлэлийн нөхцөл хэрхэн нөлөөлдөг (байгалийн хүчин зүйлийн шууд нөлөө байж болно О.Б), эдгээрийн дунд нийгмийн харилцаа хэрхэн хэлбэржин тогтдог вэ гэсэн асуултуудад хариулах шаардлагатай юм. Ингэснээр улалмжлалт харилцаа төлөвшиж буй дүр зургийг гүнзгийрүүлэн ойлгох боломжтой болно.
3. Суурин хийгээд нүүдлийн гэх ялгаатай хэв маягуудыг нэгтгэн ялгаа, заагийг тодорхойлж, зураглахдаа дээр тэмдэглэсэн (боломж) үзүүлэлтүүдийг хоёр түвшин (нэг суурь үзүүлэлтүүд, хоёр бүтцийг илэрхийлэх үзүүлэлт)-д ялгаж үзнэ. Эл

судалгаанд ашигласан шалгуур үзүүлэлтүүдээс суурь үзүүлэлтэд нас, хүйс, гэр бүлийн хэв маяг, ам бүлийн тоо, боловсрол, туршлага, эрүүл мэндийн байдал, өмч захиран зарцуулах эрх, үйлдвэрлэл эрхлэх арга, суурьшлын хэв маяг зэргийг, бүтцийг илэрхийлэх үзүүлэлтэд өмч, өмчийн хэлбэр, орлого, орлогын бүтэц, нэмээд зарлага болон зээлийн хэмжээг шалгуурт оруулж болно. Учир нь бүтцийг илэрхийлэх үзүүлэлтүүдийг хэмжих нэгж, утга нь суурин, хагас суурин, нүүдлийн амьдралтай иргэдийн аль алинд ижил утгаар хэрэглэгдэх учир ийм аргачлаар Монгол улсын нийгмийн бүтэц, нийгмийн бүлгүүдийн бүтэц ялгааг илэрхийлэх боломжтой юм. Шинжилгээнд бүтцийг илэрхийлэх үзүүлэлтүүдийг индексжүүлж (0-1) үр дүнг гаргах бөгөөд суурь үзүүлэлтүүдтэй харьцуулах байдлаар нийгмийн бүлгүүдийн ялгаа, онцлогийг тодруулна. Арга зүйн талаас шинэлэг бус байж болох ч бодитой хэмжиж, зураглаж болохуйц аргачлал юм.

4. Малчид дотооддоо нийгмийн шинжээр ялгарч байгаагаас гадна үүрэг хийгээд өмч захиран зарцуулах эрхээр туслах, хөлсний, гэрээт зэрэг гэх байдлаар ялгарах болсон учир эл хэлбэрүүдийг тухайлан судлах шаардлагатай бөгөөд практикт эдгээрийн харилцааг зохицуулах, бодлого төлөвлөх талын асуудал ч дулимаг байгаа юм. Арга зүйн талаас эзэн ба туслах, эзэн ба хөлсний, эзэн ба гэрээт малчдыг нэг түвшин (Баасантогтох.О, Шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн материалыг социологийн судалгаанд ашиглах нь (арга зүй, үр дүн), 2021.03.26)-д судлах арга зүйг нэвтрүүлэн ялгаа хийгээд асуудлыг нарийвчлан тодруулах боломжтой. Харилцаа бүхий хоёр бүлгийн төлөөллийг нэг түвшинд судлах энэ аргачлалаар судлаж шинжлэх нь бүлгүүдийг тус тусад нь судалдаг аргачлалаас үр дүнтэй болох нь тодорхой судалгааны үр дүнгээр баталгаажуулсан.
5. Хөгжиж буй орны хувьд нийгмийн болоод бүлгийн, үйлдвэрлэлийн талаас салбарын асуудлыг шийдэхэд төрийн зохистой оролцоо, органик зохицуулалт, бодит дэмжлэг туйлын чухал. Эерэг, дэвшилттэй зүйлүүд бий боловч суурь нөхцлийг сайжруулахад чиглэсэн төлөвлөлт хангалтгүй, зарим талаар малчдын төдийгүй уламжлалт соёл, хэв маягийг ганхуулах хэмжээний асуудал төлөвлөж, тэдгээрийг нь олон улсын хүмүүнлэгийн болон хандивлагч байгууллагуудын зүгээс дэмжиж байгаа нь илт. Бодлогын түвшинд мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх суурь

нөхцлийг сайжруулахад хүмүүнлэгийн болон хандивлагч байгууллагуудыг татан оролцуулахад илүү анхаарах.

6. Монгол хүн бүр соёл, уламжлал, малчид гэж ярьдаг боловч бодит байдалд бодлого тодорхойлогчид нь малчдаа бүрэн судлалгүйгээр, бодлого хөтөлбөр (тунхаг, уриа лоозон байдлаар) боловсруулж байгаа нь судалгааны үр дүнгээр баталгаажиж байна. Тухайлбал, 2009-2015 оныг хүртэл хэрэгжүүлсэн хөтөлбөрт хамрагдаж үр ашгийг нь 9526 малчин (хөтөлбөрийн үнэлгээний тайлангаас тооцов) бодитой хүртсэн хүрсэн нь нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн бодлогын хувьд туйлын хангалтгүй. Төрөөс боловсруулж, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг нь баталж гаргасан дүрэм, журмаар хэмжихээс илүүтэй чанарын шинжтэй ахиц гарсан эсэхээр хэмжигдэх учиртай.
7. Гэр бүлийн хэв маяг, бүтцээс хамаарч өрхийн амьжиргааны түвшин, материаллаг хангамжаар ялгаатай байгаа учир өрх толгойлсон малчин эхчүүд, ам бүлийн тоо олонтой айл өрхүүдийг малжуулах төсөл болон нийгмийн үйлчилгээнд хамруулах.
8. Хөдөлмөр эрхлэлт нь аж ахуй эрхлэх хэлбэр, боловсролын түвшнээс хамаарч буй бөгөөд энэ нь өрхийн орлогын хэмжээ, бүтцэд нөлөөлж буй тул суурин хэлбэрээр аж ахуй эрхэлж буй малчдын голлон анхаарч буй МАА-д чиглэсэн ажил хөдөлмөрийг нүүдлийн аж ахуй эрхэлж буй малчдын хөдөлмөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх.
9. Аж ахуй эрхлэх арга хэлбэр, малын үүлдэрлэг чанар, малаас олох орлогын хэмжээ зэрэг малчдын боловсролын түвшнээс хамаарч буй тул боловсролын түвшин бага малчдад чиглэсэн үйлдвэр угсаа, чанар, мал-малын түүхий эдийг хэрхэн боловсруулж орлогоо нэмэгдүүлэх практикт дадал олгох.
10. Олон улсын байгууллагаас зарцуулсан төсөв, мөнгөний мэдээлэл хязгаарлагдмал ч 2006 оныг хүртэл тус салбарт 2009 оны төсвийн хөрөнгөөс 4.35 дахин өндөр байгаа нь тухайн салбарыг мөнгө босгох хэрэгсэл байдлаар ашигладаг уу гэх хардалтыг төрүүлнэ. Ийм олон улсын болон хандивлагч байгууллагуудаас малчид, МАА-н салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалтыг бүртгэх шаардлагатай юм.
11. МАА-н салбараас хамааралтай үүсч буй ажлын байруудыг цэгцтэй, нарийвчлан бүртгэх тал дээр учир дутагдалтай бөгөөд салбарын бодит үр нөлөөг үнэлэхийн тулд дагалдах аж ахуй, ажлын байр буюу тухайлбал, сүү сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур худалдан борлуулах, боловсруулах чиглэлээр

бий болж буй ажлын байруудыг бүртгэх замаар салбарын бодит үр нөлөө, өөрчлөлтийг тооцох.

12. Зарчмын хувьд нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн бодлогын томъёолол нь түүнд тусгасан агуулгатай бүрэн нийцэж байх ёстой атал одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй “Монгол малчин үндэсний хөтөлбөр” дэх 44 зорилтоос 12 нь малчдын нийгмийн асуудлыг шийдэхэд чиглэж байгаагийн 2 нь малчдын доторх тодорхой бүлэг (туслах, залуу малчин, хүүхэд)-т чиглэсэн. Бодлого хэрэгжүүлэх явцад дайвар байдлаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, амьжиргааг дэмжих олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлсэн байдаг. Зүй нь бүлгийн суурь нөхцлийг ойлгож ерөнхий асуудлыг, үүний дараа бүлгийн доторх дэд бүлгүүдэд тулгарч буй асуудлыг, эсвэл салбар салбараар (боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, ахуйн үйлчилгээ, үйлдвэрлэлийн г.м) дамжуулж шийдвэрлэхээр төлөвлөж, энэ дагуу ажлын үр дүнг тооцох нийгмийн бодлогын хувьд зөв чиглэл болно.
13. Судалсан баримт хийгээд социологийн шинжлэх ухааны талаас харвал мал гэдэг нь өмчийн нэг л хэлбэр бөгөөд зөвхөн малын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар нийгмийн талын бусад асуудал үндсэндээ орхигдсон. Гэтэл нийгэм, хүн ам зүйн талаас тухайлбал, сүүлийн жилүүдэд залуучуудын хүйсийн тэнцвэрт байдал алдагдаж байгаа нь цаашид МАА-н салбар хүний нөөцөөс үүдэлтэй хумигдах бодит эрсдэл учир болзошгүй.
14. Гэр бүлийн харилцаа, хэв маягаар 50-иас дээш насны өрх толгойлсон эхчүүд бусад насны бүлгээс өндөр байхад эрэгтэйчүүдийн нас баралтын шалтгааныг судлах бууруулах, гэр бүл салалт, тусгаарлалт дунд насныханд, мөн бүрэн дундаас доош боловсролтой хүмүүсийн дунд харьцангуй өндөр боловч мөн л гэр бүлийн асуудлаар ажил үйлчилгээ огт төлөвлөөгүй.
15. Хөгжлийн бэрхшээлтэй тэргүүлэгч бүхий өрх, бага боловсрол бүхий өрхийн тэргүүлэгчтэй өрх мал ахуйгаа арчлах, эрсдлээс хамгаалах зэрэг ажил хангалтгүй, энэ хэрээр амьжиргааны түвшнээр доогуур байна. Боловсролын түвшин дээшлэхэд орлогын хэмжээ нэмэгдэж байгааг харгалзвал бага, дунд боловсролтой малчдад өрхийн санхүүгийн боловсрол олгоход чиглэсэн бодлого төлөвлөж, хэрэгжүүлэх.
16. Туслах малчны эрх зүйн харилцааг зохицуулахаар тусгасан ч өмнө тэмдэглэсэн өөр бусад хэлбэр үүнд хамаарах уу гэдэг нь эргэлзээтэй.

17. Сүүлийн жилүүдэд бэлчээр талхлалттай холбоотой “Бэлчээр ашиглалтын тухай” хууль санаачлах тухай нэлээд ярьж, УИХ-ын зарим гишүүдээр дамжуулж зарим олон улсын хөрөнгө оруулагчид лобби хийж, ихээхэн хөрөнгө зарцуулах болсон юм. Малчдын амьжиргаа, орлогын гол эх үүсвэр нэг төрлийн малаас хамаарах хандлагатай байгаа учир бодлого төлөвлөлт, зохицуулалтад болгоомжтой, нухацтай хандах шаардлагатай юм. Бэлчээр өмчлүүлэх, эзэмшүүлэх талын асуудлыг малчид соёл уламжлалд халгаатай, зөрчил тэмцэл нэмэгдэнэ гэх олон үндэслэлээр хүлээн зөвшөөрдөггүй. Зохицуулалтын хувьд харьцангуй уян хатан уламжлалт хэв маягийг алдагдуулахгүйгээр шийдэл хайх, энэ зарчимд нийцэх хэд хэдэн гарцыг тодорхойлж болохоор байна. Үүнд:

- 1) Ямаанаас авах татварын хэмжээг нэмэгдүүлж ямааны тоо толгойг нийт сүргийн 20 хувьд барих юм уу, чиглэлийн ямааны фермерийн үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлэх,
- 2) Малын нэг төрлөөс хамаарч буй орлогын бүтцийг төрөлжүүлэх буюу малын түүхий эдийн боловсруулалт, ашиглалт, борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн түүхий эдийг худалдан борлуулах, боловсруулах үйлдвэрлэл, түүхий эд татан авах (хоршоод хамгийн үр ашигтай бөгөөд биржид холбох), дэд бүтэц (зам болон үйлдвэрийн байгууламж)-ийн сүлжээ байгуулах. Асуудалд бодитоор хандах зайлшгүй шаардлагатай бөгөөд социализмын үеийн бүтэц, зохион байгуулалт, сүлжээг хоршоодод тулгуурлан байгуулах нь үр ашигтай байж болох бөгөөд төрөөс гадаад худалдааг дэмжих, технологи нэвтрүүлэх чиглэлд бодитой дэмжлэг үзүүлэх шаардлагатай юм.
- 3) Татвараар зохицуулж болно. Дундаж малтай өрхийн тоог тэнцвэржүүлэх шийдэл байж болох бөгөөд малын тоо хэмжээнээс хамаарч татвар тогтоох шийдлийг ажлын байр, үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулах. Их малтай өрхөөс их татвар авах юмуу, ажил олгогч малчдад татварын хөнгөлөлт эдлүүлэх. Бага малтай өрхөөс бага татвар авч таваарлаг мал үржүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлэх.

18. Хөгжиж буй орны хувьд бүх зүйлийг зах зээлийн харилцаанд зохицуулан орхих нь өөрөө бодлогын маш том алдаа болох тул ялангуяа үйлдвэрлэлийн суурь салбар, тэнд ажиллагсдын асуудлыг чиглүүлээд орхих бус суурь нөхцлийг нь тодруулан

судлаж, түүнээс үүдэн бодлогын асуудлыг тоймлож шийдвэрлэх нь үр дүнтэй. МАА-н салбарыг хүн амын суурьшил, нягтралаас хамаарч суурин, хагас суурин, нүүдлийн маллагаа бүхий аж ахуйг төлөвлөж, үүнд нийцүүлэн түүхий эд, бүтээгдэхүүнийг татан төвлөрүүлэх ложистикийг оновчтой зохицуулах, эргээд бий болгосон бүтцээр дамжуулан нийгмийн үйлчилгээг хүргэх боломжтой. Тээвэр ложистикийн дэд бүтэц, хөдөө аж ахуйн биржийн, хоршоодын уялдаа холбоог нарийн тооцоотой уялдуулж өгөх шаардлагатай.

19. Одоогийн түвшинд бодлогод зарим нэг санаа туссан байх боловч эрээвэр хураавар, зарим төлөвлөлт нь тухайн бүлэгтээ чиглэсэн гэхээс илүү бусад салбарыг дэмжих шинжтэй байгаа юм. Тухайлбал, эрсдлийн даатгалын үйлчилгээ нь малчдад чухал хэрэгцээтэй боловч нөхцөл нь малчдын хэрэгцээнд нийцдэггүй бөгөөд даатгалын компаниудын хувьд малчид нь хөрөнгө босгох зөвхөн нэг эх үүсвэр төдийгөөр ашиглагдаж байгаа юм.
20. ЭМД болон НД-ын шимтгэл төлөгчдийн хамрагдалтыг сайжруулах тухай ярьж, хоршоодод тушаасан бүтээгдэхүүнээс шимтгэл хураамж авахаар зохицуулсан боловч нэгд өвдөхөөс бусад тохиолдолд малчдад үйлчилгээ нь тогтмол хүрдэггүй, хоёрт хоршоод түүхий эд хүлээн авлаа ч арилжаалах түүхий эдийн нэр төрөл цөөн, үнэ бага, гуравт түүхий эдийн нэр төрөл олширсон ч бүтээгдэхүүн хадгалах, тээвэрлэх талын нөөц сул, дөрөвт хоршоодын олонх нь мал аж ахуйгаас өөр бусад салбарт төвлөрдөг, дөрөвт хуримтлуулсан түүхий эдийг боловсруулах, борлуулах зах зээлийн боломж хумигдмал зэрэг асуудлаас үүдэлтэй нөхцөл нь тэр бүр бүрддэггүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Монгол хэлээр

KAS. (2020). *Монгол улсын ахмад настны нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалт*. Улаанбаатар: KAS.

WBG, YXH. (2018). *Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн зураглал*. Улаанбаатар.

Аваадорж.А, Б. (2006). Бэлчээрийн газрын хөрсний физик шинж чанарын өөрчлөлт ба экологийн доройтол. (*Дорлигсүрэн.Д, 2006, р. 62*) (pp. 111-124). Улаанбаатар: Адмон.

Авдай.Ч, Төмөржав.С. (2003). *Монголын нүүдэлчдийн уламжлалт технологи*. Улаанбаатар: Бэмби сан.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа. (2021, 1 19). <http://otor.gov.mn/>. Retrieved 04 20, 2021, from Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны веб сайт: <http://otor.gov.mn/backend/files/Yc7I4VwYG76UkRF.pdf>

Алтангариг.Б. (2016). Өвөр Монголын нутаг бэлчээр муундсан шалтгааныг задлах нь. *Nomadic Studies* 16(23), 2016 , 45-61.

Амаржаргал.З. (2009). *Орчин үеийн нүүдэлч малчдын мал аж ахуй эрхлэх арга (МА)*. Улаанбаатар.

Аюурзана.Г. (2010). *Орчин цагийн аугаа их сэтгэгчид*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.

Баасантогтох.О. (2019). Хот, хөдөөгийн тэгш бус байдал бүс нутгийн ялгаа. *Нийгмийн тэгш бус байдлыг бууруулах нь: мэдлэгээс төрийн бодлогод* (pp. 186-195). Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Баасантогтох.О. (2021.03.26). Шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн материалыг социологийн судалгаанд ашиглах нь (арга зүй, үр дүн). *Тэнхмийн хэлэлцүүлэг*. Улаанбаатар.

Базаргүр.Д. (1998). *Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй*. Улаанбаатар.

Бакей.А. (2006). Бэлчээрийн харилцааны эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх асуудалд. *Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудлууд* (pp. 10-19). Улаанбаатар: Адмон.

- Бакей.А. (2014). *Хөдөө аж ахуйн эдийн засаг*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- Балхаажав.Ц. (1992). *Удамт монгол малчин*. Улаанбаатар: Д.Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэр.
- Батбаатар.М. (2016). *Монголчуудын амьдралын чанарт хийсэн социологийн дүн шинжилгээ (диссертаци)*. Улаанбаатар.
- Бат-Очир.Л. (1986). *Ард анги: өөрчлөлт, хоршоожилт*. Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэх үйлдвэр.
- Батсугар.Ц. (2015). *Олон улсын валютын сангийн бодлого ба Монголын нийгмийн ялгарал (МА)*. Улаанбаатар.
- Батхишиг.Б. (2018). *Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал*. Улаанбаатар: Бэмби сан хэвлэлийн газар.
- Батцэнгэл.Х. (1992). *Аж ахуйн соёл иргэвшил: монгол хэв шинж. - Бодрол, бясалгал*. Улаанбаатар.
- Батчимэг.Б. (2021, 2 11). *montsame.mn*. Retrieved 06 06, 2021, from Монцамэ агентлаг: <https://montsame.mn/en/read/253177>
- Бат-Эрдэнэ.Ц. (2004). *Малчин өрхийн эдийн засаг*. Улаанбаатар: Согоо нуур ХХК.
- Баянжаргал.Ч. (2011). *Нүүдлийн сонгодог мал аж ахуй гэж...* Улаанбаатар: Асо принт ХХК.
- Баярчимэг.Г. (2008). *Малчин өрхийн эдийн засгийн чадавхи*. Улаанбаатар.
- БНМАУ-ын Статистикийн төв газар. (1971). *БНМАУ 50 жилд*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- БНМАУ-ын Статистикийн төв газар. (1981). *БНМАУ-ын улс ардын аж ахуй 60 жилд (1921-1981)*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- БНМАУ-ын Статистикийн төв газар. (1986). *БНМАУ-ын улс ардын аж ахуй 65 жилд*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Болд.Ба. (1992). *Монголын феодализмын шалгуурын тухай асуудлаар маргах нь- бодрол, бясалгал (№8)*. Улаанбаатар.
- Болд.Р. (2007). *Мөргөлдөөний онол*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Болд-Эрдэнэ.Д. (2015). *Улс төрийн философи*. Улаанбаатар: Тод бичиг ХХК.
- Ганболд.И. (2013). *Монгол малчдын бэлчээр ашиглах уламжлал ба орчин үе (диссертаци)*. Улаанбаатар.

- Ганзориг.Ө. (2021). *Санхүүгийн философи*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- Ган-Өлзий.Ч. (2016). *Шинжлэх ухааны философийн зарим асуудал*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Ганхуяг.Д. (2017). *Судлаачдад өгөх зөвлөмж - Нийгэм түүхийн онолууд*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Гидденс.А. (2006). *Социологи*. Улаанбаатар: Адмон.
- Гомбосүрэн.Ц. (1995). *Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү*. Улаанбаатар: ШУ-ны хэвлэлийн "Эрдэм" компани.
- Гомбосүрэн.Ц. (1999). *Нийгмийн философийн интеграль (нэгдэгч) хувилбарыг боловсруулах эхлэл*. Улаанбаатар: Эрдэм компани.
- Гүндсамбуу.Х. (1984). *Малчин залуучуудын нийгмийн дүр төрх*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Гүндсамбуу.Х. (2002). *Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага*. Улаанбаатар.
- Гүндсамбуу.Х. (1982). Өнөөгийн нэгдэлчдийн доторхи нийгэм мэргэжлийн бүлгүүдийг тодорхойлох асуудалд. *Философи, эрхийн судлал. №4* , 91-98.
- Давааням.П. (1996). *Суваргын онол (Төрийн тэргүүн буюу хаан философи)*. Улаанбаатар.
- Дагвадаш.Ц. (1982). Малчдын хөдөлмөрт хандах харилцааны түвшинг тодорхойлох асуудал. *Философи, эрхийн судлал. 4* , 76-90.
- Дагвадаш.Ц. (1982). Малчдын хөдөлмөрт хандах харилцааны түвшинг тодорхойлох асуудалд. *Философи, эрхийн судлал. №4* .
- Дагвадаш.Ц, Э. (1987). Илгээлтийн эзэн малчин залуучуудын тогтвор суурьшлын талаар явуулсан судалгааны дүнгээс. *Философи, эрхийн судлал. №7* , 51-56.
- Дагвадорж.Д. (1998). *Монголын маркетингийн менежмент*. Улаанбаатар: Арцог хэвлэлийн газар.
- Дайрийжав.Д. (2016). *Талын малчин Макихара Сойчи*. Улаанбаатар: Соёмбо принтинг хэвлэлийн үйлдвэр.
- Данаажав.С. (1981). *Монголын ард түмний аж төрөх ёсонд гарсан өөрчлөлт*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

- Дашдаваа.С. (1989). *Өнөөгийн ажилчдын нийгмийн идэвхийн байдал, хандлага*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Даш-Ёндон.Б. (2018). Монгол хүний чин хүслэнгийн асуудалд (монгол хүнд юу хэрэгтэй вэ). *Хүний ертөнц ба тогтвортой хөгжил* (pp. 55-59). Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Даш-Ёндон.Б. (2014). *Нийгмийг танихуй: түүх-хөгжлийн философи*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс хэвлэлийн компани.
- Даш-Ёндон.Б. (2011). *Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. I боть*. Улаанбаатар: Интерпресс ХХК.
- Дашням.Л. (2020). *Язгуураа танихуйд өчүүхэн дусал*. Улаанбаатар: Адмон принт.
- Дашпүрэв.О. (2017). *Монгол нийгэм (философийн анализ)*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс хэвлэлийн үйлдвэр.
- Должинсүрэн.Ж. (2017, 5 29). *nda.gov.mn*. Retrieved 1 5, 2021, from Үндэсний хөгжлийн газар: <http://nda.gov.mn/backend/f/Jmm3nMfC5I.pdf>
- Дорлигсүрэн.Д. (2006). Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудалд. *Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудлууд* (pp. 20-63). Улаанбаатар: Адмон.
- Дорлигсүрэн.Д. (1998). Хотын ба хөдөөгийн хүн амын ажилгүйдэл, тэдгээрийн онцлог. *Шилжилтийн эдийн засаг дахь ажилгүйдэл: Монголын бодит байдал* (pp. 117-130). Улаанбаатар: Интерпресс ХХК.
- Дунд орлоготой орны дундаж орлоготой хүн амын бүлгийн шинжилгээ: Монгол Улсын жишээ*. (2014). Улаанбаатар.
- Дэлхийн банк. (2006). *Монгол улс ядуурлын байдлын үнэлгээ*. Улаанбаатар.
- Дэлхийн зөн. (2019). *Жилийн тайлан*. Улаанбаатар: <https://worldvision.mn/jiliin-tailan-2020/>.
- Дэлхийн Зөн Монгол. (2003). *Малчин өрхийн үйлдвэрлэлийн технологи (малчдыг зайнаас сургах сургалтын гарын авлага)*. Улаанбаатар: Эдо паблишинг ХХК.
- ЖАЙКА, Алмек корпораци, ЭКСи, Идеа ХХК. (2016). *Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа*. Улаанбаатар: https://openjicareport.jica.go.jp/pdf/12283339_01.pdf.

Железняков.А.С. (n.d.). Монгол улс холимог соёл иргэншлийн түүхийн бүтээлүүд: дэлхийн түүхийн бүдүүвчид гарсан өөрчлөлт. *Философи, эрхийн судлал*.

Железняков.С. (n.d.). Дэлхийн соёл иргэншлийн сонгодог болон орчин үеийн бүдүүвчүүд дэх Монгол орон. *Философийн, эрхийн судлал*.

Жүгдэр.Ч. (2006). *Монголын ийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил*. Улаанбаатар.

Засгийн газар. Тогтоол №34. (2020, 1 29). Монгол малчин үндэсний хөтөлбөр. Улаанбаатар, Монгол.

Идшинноров.С. (2013). *Бүтээлийн чуулган-II*. Улаанбаатар: Соёмбо принт хэвлэлийн үйлдвэр.

Ичинхорлоо.Ч. (2019). Нүүдэлчдийн ахуй соёл ба тогтвортой хөгжил. *Тогтвортой хөгжил ба оюуны соёлын өв* (pp. 108-120). Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Ишдорж.Ц. (2013). XIX-XX зууны зааг үеийн монголын аж ахуйн судалгаа (С.Идшинноровын судалгааны жишгээр). *Бүтээлийн чуулган-I* (pp. 371-378). Улаанбаатар: Соёмбо принт хэвлэлийн үйлдвэр.

Кагарлицкий, Б. (2018). *Марксизмыг шинжлэхүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Лиотар, Ж.-П. (2017). *Постмодерн нөхцөл: мэдлэгийн тухай тайлан*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Логи.Н, А. (2005). *Малчдын хоршоо-Монголын бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийн үндсэн нөхцөл*. Улаанбаатар: Өнгөт хэвлэл ХХК.

Лувсанцэрэн.Г, Жамбал.А. (2011). *Гүн ухаантан Чимидийн Жүгдэр*. Улаанбаатар.

Майский.И. (2001). *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*. Улаанбаатар.

Маралмаа.А. (2015). *Хотын малчин*. Улаанбаатар.

Маркс.К. (1999). *Капитал I*. Улаанбаатар: Согоо нуур ХХК.

Маркс.К. (2001). *Капитал III*. Улаанбаатар: Согоо нуур ХХК.

МННХ. (2003). *Ноос, ноолуур, тэмээний ноосны үйлдвэрлэл, боловсруулалтын судалгаа*. Улаанбаатар.

Монгол банк. (2006). *Жилийн тайлан 2006*. Улаанбаатар: <https://www.mongolbank.mn/documents/annualreport/2006.pdf>.

- Монгол банк. (2015). *ХАА-н салбарын өрсөлдөх чадвар ба орон нутгийн хүн амын амьжиргааны түвшин*. Улаанбаатар.
- Мөнхбат.О. (2000). *Нийгмийн социаль бүтцийн социологи*. Улаанбаатар.
- Мөнхжаргал.Я. (1984). Илгээлтийн эзэн малчин залуучуудын идээшлийн зарим асуудал. *Философи, эрхийн судлал*. №6 , 75-79.
- Мөнхжаргал.Я, П. (1989). *Хөдөө аж ахуйн нэгдлийн хамт олны нийгмийн хөгжлийн төлөвлөх зарим асуудал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Мөнхнасан.Б. (2004). *Монгол дахь социаль ялгарлын зарим асуудал: социологийн шинжилгээ (магисрын ажил)*. Улаанбаатар.
- Мөнхтамир.Д, Б. (2017). Ардын сурган хүмүүжүүлэх ухаан тогтвортой хэллэгээр илрэх нь. *Эрдэм сэтгүүл*. Vol 57. №01(221) , 99-109.
- Мөнхтөр.Д. (2020). Нүүдлийн соёлоос улбаатай Монголын нийгмийн бүтцийн зарим онцлогийн тухайд. *Социологи - 13*. №13(517) , 34-42.
- Мөнхтөр.Д. (2012). Пост модерн соёлын нөхцөл дэх нүүдэлчид: шинэ эрсдэл үү, эсхүл боломж уу? *Социологи - 8*. №8(377) , 153-163.
- Мөнхтуяа.н. (2018, 7 4). *Хүн, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам*. Retrieved from ХХААХҮЯ-ны веб сайт: <https://mofa.gov.mn/exp/article/entry/1203>
- Мөнх-Эрдэнэ.Г. (2021). 1990-ээд оноос хойших Монгол Улс дахь нийгмийн антропологийн судалгаа. *Философи, шашин судлал*. №23(551) , Тото пресс.
- МУЗГ. (2008, 6 18). Малчдаас ноолуур худалдан авах. Улаанбаатар, Монгол.
- МУЗГ. (2020, 1 29). Монгол малчин үндэсний хөтөлбөр. Улаанбаатар, Монгол.
- МУЗГ. (2000). Ноолуур хөтөлбөр. Улаанбаатар, Монгол.
- МУЗГ. (2018, 2 6). Ноолуур хөтөлбөр 2018-2021. Улаанбаатар, Монгол.
- МУЗГ. (2013, 11 30). Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам. Улаанбаатар, Монгол.
- МУЗГ. (2019, 9 4). Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам. Улаанбаатар, Монгол.
- МУЗГ, UNDP. (2006). *Малчдын бүлгийн үнэлгээ*. Улаанбаатар.

МУЗГ, UNDP. (2004). *Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ (НҮБ-ын ХХ/ШОУХА "Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" МОН/01/Ю01 төсөл)*. Улаанбаатар.

МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим. (1993-1998). *Монголын нийгмийн давхраажилт, төлөв байдал, чиг хандлага*. Улаанбаатар.

МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим. (1998-2001). *Монголын нийгмийн дотоод ялгарал*. Улаанбаатар.

МУИХ. (2020, 5 13). Алсын хараа-2050. Улаанбаатар, Монгол улс.

МУИХ. (2016, 2 5). Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (хүчингүй болсон). Улаанбаатар, Монгол улс.

МУИХ. (1996). Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал: 1996-2015. Улаанбаатар, Монгол улс.

МУИХ. (2008, 1 31). Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого: 2008-2021 (хүчингүй болсон). Улаанбаатар, Монгол улс.

МУИХ. (2014, 6 13). Ногоон хөгжлийн бодлого: 2014-2030. Улаанбаатар, Монгол улс.

МУ-ын Засгийн газар. (1998). Монгол улсын ХХI зууны тогтвортой хөгжлийн стратеги хөтөлбөр: 1998-2021. Улаанбаатар, Монгол.

МХААХҮХ. (2010). *Үндэсний холбооны VI их хурлын баримт бичгийн эмхтгэл*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.

Мюллер.Ф.Ф. (2002). Монголын номадизм эргэж ирсэн нь. *Төрийн захиргаа*. №2 , 3-4.

Мягмаржав.Б. (2006). *Дэлхийн нүүдлийн мал аж ахуй-II*. Улаанбаатар: Арвайн өнгө хэвлэлийн газар.

Нансалмаа.Ц. (1998). *Малчин өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн менежментийн асуудал: говийн бүсийн жишээн дээр (диссертаци)*. Улаанбаатар.

Нарантуяа.Т. (2006). *Монголын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн амьжиргааны чадавхын судалгаа (диссертаци)*. Улаанбаатар.

Наранцэцэг.Б. (2016). *Малчин өрхийн орлого ба түүнд нөлөөлөх хүчин зүйлс: Ховд аймгийн Булган сумын жишээн дээр*. Улаанбаатар.

Насанбалжир.С. (1978). *Монголын аж ахуй хөтлөлтийн уламжлал, шинэчлэл (XIX зууны эцэс ХХ зууны эхэн)*. Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэх үйлдвэр.

- Нацагдорж.Ш. (1978). *Монголын феодализмын үндсэн замнал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Нацагдорж.Ш. (1972). *Сум, хамжлага, шавь ард (түүхэн найруулал)* . Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэх үйлдвэр.
- НДЕГ. (2021, 9 5). Retrieved from НДЕГ-ийн веб сайт: <http://www.ndaatgal.mn/>
- ННФ. (2004). *Мал аж ахуйд төр, засгийн үүрэг*. Улаанбаатар.
- ННФ. (2004). *Монголын мал аж ахуйн ирээдүй*. Улаанбаатар: ВСІ компани.
- Номун-Эрдэнэ.Д. (2016). Малчдын нийгмийн байр суурьт үзүүлж буй байгаль цаг уурын нөлөө. *Социологи - 10. №10(444)* , 166-173.
- НСИСОУХ. (2017). *Нүүдлийн иргэншил бүс нутгийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл болох нь*. Улаанбаатар.
- НҮБ. (2020). *Монгол улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын ажлын үр дүнгийн тайлан 2017-2019*. Улаанбаатар: <https://mongolia.un.org/sites/default/files>.
- НҮБ Хөгжлийн хөтөлбөр. (2003). *Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ*. Улаанбаатар.
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. (2003). *Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос сэргийлэх талаарх судалгаа*. Улаанбаатар.
- Нямдорж.Ү. (1985). *Социализмын үед нүүдэлчин малчдын суурьших социологийн зарим асуудал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Нямсүрэн.Г. (2016). *Малчин өрхийн амьжиргааг сайжруулах боломж, арга зам (диссертаци)*. Улаанбаатар.
- Осака их сургуулийн Glocal төв, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн. (2014). *Хөгжил, малчин ахуй, ирээдүй: инженерүүдэд зориулсан этнографи*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Отгоннасан.В. (2003). Монгол дахь өмч хувьчлал ба олон нийтийн санаа бодол. *Социологи - 3. №204(17)* , 29-41.
- Отгоннасан.В. (2021). *Монголын нийгэм ба олон нийтийн санал бодол*. Улаанбаатар.
- Отхон.Ц. (2000). Билгүүн эрдэмтэн. *Нямын Жагварал: амьдрал үйл, үзэл баримтлал* (pp. 32-92). Улаанбаатар: Согоо нуур ХХК.
- ОУСХ. (2010). *Эрдмийн далай*. Улаанбаатар: Хас принт ХХК.

ОХУ-ын ШУА-ийн Социологийн институт, Шихихутуг ХЗДС-ийн Шихихутуг судалгааны төв. (2012). *Нийгмийн социал бүтэц ба социал давхаргажилт*. Улаанбаатар: Соёмбо принтинг хэвлэлийн үйлдвэр.

Оюунцэцэг.Ч, З. (2006). Бэлчээрт ямааны үзүүлэх нөлөө. *Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудлууд* (pp. 150-159). Улаанбаатар: Адмон.

Өдрийн сонин. (2020, 5 28). Retrieved from <https://dnn.mn>

Өлзийсайхан.Д. (2009). *Хөдөө аж ахуйн мэргэжлийн сэхээтэн: үүсэл, төлөвшил*. Улаанбаатар: Бит пресс.

Пүрвээ.Г. (2001). *Монгол орны хөгжил дэвшлийн зарим асуудал*. Улаанбаатар: Женко дээд сургууль.

Пүрэв.Ц. (2015). *Монголын нийгмийг социологиор шинжлэхүй: бодол, төсөөлөл, эргэцүүлэл*. Улаанбаатар: Амжа принтинг ХХК.

Пүрэв.Ц. (2006). Хөдөөгийн өрхийн хэрэглээ, аж байдлын үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт. *Философи, эрхийн судлал - XX*, 155-176.

Рафисович.М.С. (2014). *"Философские истоки французского либерального консерватизма (Ф.Гизо, А.Токвиль)" диссертаци*. Москва.

Ред: Нэргүй.Д, Батсуурь.Н, Биньез.Б. (2009). *Монгол малчны судар оршивой*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.

Ред: Нямбуу.Х, Дагвадаш.Ц. (1985). *Өнөөгийн монголын ажилчин анги, хоршоолсон малчдын нийгмийн зарим асуудал*. Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэх үйлдвэр.

Ред: Түмэндэлгэр.Ч, Цэрэннадмид.А. (1985). *Социалист аж төрөх ёсны онол практикийн асуудал*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.

Ринчинбазар.Р. (2004). *Монголын бүс нутгийн хөгжлийн төлөвлөл, удирдлагын асуудлууд*. Улаанбаатар: ВСИ ХХК.

Сайнхишиг.Г. (2006). Нийгмийн тэгш биш байдлыг бууруулах нь нийгмийн бодлогын зорилт. *Философи, эрх зүйн судлал - XXI*, 228-236.

Самбуу.Б. (1982). Хөдөөгийн хөдөлмөрчдийн нөхвөр хүчний асуудал. *Философи, эрхийн судлал. №4*, 99-108.

Самбуу.Ж. (1945). *Ма аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардуудад өгөх сануулга сургаал*. Улаанбаатар.

- Самбуу.Ж. (1956). *Малчдад өх зөвлөлгөө*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Сангийн яам. (2018). *Шалгалтын тэмдэглэл*. Улаанбаатар:
<https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/3>
- Смелзер.Н. (2001). *Социологи*. Улаанбаатар.
- Смит, А. (2015). *Үндэстнүүдийн баялаг*. Улаанбаатар: Монсудар.
- Сумъяа.Б. (2012). *Түүвэр зохиол-III*. Улаанбаатар: Согоо нуур ХХК.
- Сумъяа.Б. (2005). *Монголын нүүдэлчдийн соёл*. Улаанбаатар: Согоонуур ХХК.
- Сүрэн.А. (2021, 03 15). *news.mn*. Retrieved 05 28, 2021, from NEWS агентлаг:
<https://news.mn/r/2410664/>
- Сэмбээжав.Б. (2008). *Өрхийн тэргүүнээс фермер, фермерээс биофермерт хүрэх замд-II*. Улаанбаатар: ВСІ хэвлэлийн компани.
- Сэмбээжав.Б. (2009). *Ураг төрлийн аж ахуйн менежмент*. Улаанбаатар: ВСІ хэвлэлийн компани.
- Торновский.М.Г. (2009). *Монголчуудтайгаа бол би Лиссабон ч хүрнэ*. Улаанбаатар: Жиком Пресс ХХК.
- Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооны статистикийн газар. (1989). *БНМАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжил 1988 онд*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Төмөржав.М, Хүрэлбаатар.Н. (2017). *Монгол малчны эрдэм ухааны дээж оршвой*. Улаанбаатар: Тэпэ хэвлэх үйлдвэр.
- Төмөрхүлэг.А. (2018). *Бага орны дотоод зовлон*. Улаанбаатар: Адмон принт.
- Төрбилэг.Ц. (1980). Өнөөгийн хоршооллосон малчдын аж байдлын зарим асуудал. *Философи, эрхийн судлал*. №3 , 77-83.
- Тунгалаг.В. (2018). *Малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх арга зам: ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн малчин өрхийн жишээн дээр (магистрын ажил)*. Улаанбаатар.
- Туяадэлгэр.Д. (2013). *Залуу малчдын судалгаа*. Улаанбаатар.
- Түдэв.Л. (2009). *Малчин Ө-ийнд ноён Ө зочлов*. Улаанбаатар: Урлах эрдэм хэвлэлийн компани.
- Түмэннаст.Г. (2017). *Монголын нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоонд хийсэн социологийн шинжилгээ (диссертаци)*. Улаанбаатар.
- Түмэннаст.Г. (2014). Шилжилтийн босгон дахь Монголын социалист, халамжит төрийн уналт. *Социологи - 9*. №9(398) , 79-86.

Түүхийн хүрээлэн. (1976). *БНМАУ-ын социалист хөдөө аж ахуйн түүхийн зарим асуудал*. Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэлийн газар.

Тэрбишдагва.Д. (2006). "Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудлууд" онол-үйлдвэрлэлийн бага хурлын нээлтийн үг. *Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудлууд* (pp. 5-9). Улаанбаатар : Адмон.

Удирдлагын академи. (2018). *Нийгмийн дунд давхрааны төлөв байдал: аймаг, сумын суурин өрхийн судалгаа*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.

Удирдлагын академи. (2004). *Сумын судалгаа: онол, арга зүйн асуудал*. Улаанбаатар: Удирдлагын академийн Хэвлэх тасаг.

УИХ. (2020, 5 13). Алсын хараа-2050. Улаанбаатар, Монголулс.

УИХ. (2004, 5 14). Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2017, 12 8). Мал, амьтны эрүүл мэндийн тухай. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2017, 2 2). Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2017, 12 14). Малын генетик нөөцийн тухай. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2014, 6 13). Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль. Улаанбаатар, Монгол.

УУИХ. (2020, 11 13). Малын тоо толгойн албан татварын тухай. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2010). Монгол мал үндэсний хөтөлбөр. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2020, 1 29). Монгол малчин үндэсний хөтөлбөр. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2014, 6 13). Ногоон хөгжлийн бодлого: 2014-2030. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2009, 6 4). Төрөөс малчдын талаар баримтлах бодлого. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2011, 6 17). Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай. Улаанбаатар, Монгол.

УИХ. (2011, 6 2). Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль. Улаанбаатар, Монгол.

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар. (2016). *Хөдөө аж ахуйн салбар-2015*. Улаанбаатар.

Ундармаа.С. (2021, 04 18). *news.mn*. Retrieved 05 28, 2021, from NEWS агентлаг: <https://news.mn/r/2423066/>

- Урианхай.Д. (2000). *"Бодь сэтгэл, эв хамт ёс"-Ганцаарчилсан хөдөлгөөний улс төрийн үзэл онолын "Очир"-Үнэнээс цогцолсон Зэндмэнэ*. Улаанбаатар: Оюуны өмчийн газрын хэвлэх цех.
- Уртнасан.Ц. (1989). *БНМАУ-ын ажилчин ангийн нийгмийн бүтцийн социологийн асуудал*. Улаанбаатар.
- Уртнасан.Ц. (2017). *Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Уртнасан.Ц. (1990). Эдийн засгийн хөгжилд нийгмийн хүчин зүйлийн роль. *Философи, эрхийн судлал - XI*, 64-70.
- Ус цаг уурын хүрээлэн. (2005). *Уур амьсгалын өөрчлөлтөнд мал аж ахуй өртөх байдал*. Улаанбаатар: Адмон принт ХХК.
- ҮСГ. (2021, 3 1). Малын зүй бус хорогдол (төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр). Улаанбаатар, Монгол.
- ҮСГ. (2021, 5 3). Малын тоо (төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багаар, хороогоор, жилээр). Улаанбаатар, Монгол.
- ҮСГ. (2004). *Монгол улс зах зээлд статистикийн эмхэтгэл*. Улаанбаатар.
- ҮСГ. (2008). *Монгол улсын статистикийн эмхэтгэл-2007*. Улаанбаатар.
- ҮСГ. (2011). *Монгол улсын статистикийн эмхэтгэл-2010*. Улаанбаатар.
- ҮСГ. (2016). *Монгол улсын статистикийн эмхэтгэл-2015*. Улаанбаатар.
- ҮСХ. (2021, 01 27). Дотоодын нийт бүтээгдэхүүн 2018. Улаанбаатар, Монгол.
- ҮСХ. (2021). *Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдал*. Улаанбаатар: 1212.mn.
- ҮСХ. (2021, 5 4). Малчдын тоо (улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр). Улаанбаатар, Монгол.
- ҮСХ. (2021, 8 23). Малчин өрхийн тоо (улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр). Улаанбаатар, Монгол.
- ҮСХ. (2021, 4 19). Малын зах зээлийн дундаж үнэ (сум, дүүргээр, сараар). Улаанбаатар, Монгол.
- ҮСХ. (2020, 9 29). Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчин өрх, даатгуулсан малын тоо (бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр, жил бүрийн эцэст). Улаанбаатар, Монгол.

ҮСХ. (2021, 5 3). Малын тоо (төрлөөр, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багаар, хороогоор, жилээр). Улаанбаатар, Монгол.

ҮСХ. (2019). *Монгол улсын статистикийн эмхэтгэл-2018*. Улаанбаатар.

ҮСХ. (2021, 01 27). Монгол улсын хүн амын тоо (хүйс, хот/хөдөөгөөр). Улаанбаатар, Монгол.

ҮСХ. (2021, 8 23). Нийт тариалсан талбай (улс, бүс, аймаг, нийслэл, жилээр). Улаанбаатар, Монгол.

ҮСХ. (2019). *Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа*. Улаанбаатар: <http://web.nso.mn/>.

ҮСХ. (2018). *Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018 оны II улирлын танилцуулга*. Улаанбаатар: https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=HSES_tan_2018_2q.pdf&ln=Mn.

ҮСХ. (2018, 2 1). ҮСХ-ны даргын тушаал: Хүн амын амьжиргааны 2018 оны доод түвшнийг тогтоох тухай". Улаанбаатар, Монгол.

ҮСХ. (2017). *Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга*. Улаанбаатар.

ФСЭХ. (1982). *БНМАУ-д социалист аж төрөх ёс төлөвшин хөгжиж буй асуудал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

ФСЭХ, Түүхийн хүрээлэн. (1984). *Бүгд найрамдах Монгол ард улсын нийгмийн бүтэц (Түүх, социологийн судалгаа)*. Улаанбаатар.

Х.Абу-Бадер, С. (2013). *Нийгмийн ажлын практикт статистик арга хэрэглэх нь*. Улаанбаатар: Амжа принтинг ХХК.

ХААХҮЯ, БОХААЭЗХ. (2019). “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн II үе шатны хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайлан. Улаанбаатар: <https://mofa.gov.mn/>.

Хавх.Н. (1995). *Монголчуудын соёл иргэнийн гүн ухаан*. Улаанбаатар: Бит сервис.

Хавх.Н. (2000). *Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан*. Улаанбаатар.

ХАХНХЯ, УБСЕГ. (2016). *Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институтийн веб сайт*. Retrieved from http://rilsp.gov.mn/upload/2018/argazui/Orlogiig_Orluulan_Tootsoh_Argaar_Urhiin_Amjirgaanii_Tuvshing_Todorhoiloh_Argachlal.pdf

ХНХЯ. (2020). *Монгол улсын ажлын байрны нөхцлийн түүвэр судалгаа-2020*. Улаанбаатар.

ХНХЯ, ХНХСИ. (2018). *Малчдын аж байдлын судалгаа*. Улаанбаатар.

- Хөдөө аж ахуйн бирж. (2021, 5 17). 2021 оны 19 дахь долоо хоногийн арилжааны мэдээ. Улаанбаатар, Монгол.
- ХХААХҮЯ. (2019). *Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын таницуулга*. Улаанбаатар.
- ХХААХҮЯ. (2020). Retrieved from <https://uramshuulal.gov.mn/wool.aspx>
- ХХААХҮЯ. (2019). *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны веб сайт*. Retrieved 5 10, 2021, from Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам: <https://mofa.gov.mn/exp/blog/7/6>
- ХХААХҮЯ, БОХААЭЗХ. (2019). *“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайлан*. Улаанбаатар: mofa.gov.mn.
- ХХАХҮЯ. (2018, 11 17). <https://mofa.gov.mn>. Retrieved 04 20, 2021, from Хүн, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам: <https://mofa.gov.mn/exp/article/entry/1450>
- ХХҮЕГ, АХБ. (2017). *Монгол улсын өрх, хүн амын аж байдлын дүр төрх*. Улаанбаатар: http://hudulmur-halamj.gov.mn/uploads/files/niigmiin_hamgaalal_20200402.pdf.
- ХЭҮК. (2021). *Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Цэрэндаш.С, Алтанзул.Ц. (2006). *Бэлчээрийн менежментийн гарын авлага (II дэвтэр)*. Улаанбаатар: Edo publishing Co.ltd.
- Цэрэндаш.С, Төмөржав.М, Гомбосүрэн.Ч. (2003). *Газар, бэлчээр, мал*. Улаанбаатар: Жиком пресс компани.
- Чагдаа.Х. (2002). *Монгол малчны амьдрахуйн ухаан*. Улаанбаатар: Ти энд Ю принтинг ХХК.
- Чагдаа.Х. (1997). *Монголын малчдын үе залгамжлалын нийгмийн асуудал: өнгөрсөн, одоо цаашид (диссертаци)*. Улаанбаатар.
- Чулуун.С. (2017). Эртний нүүдэлчдийн нийгмийн байгууллын зарим асуудалд: було/бүл. *Угсаатан судлал. №XXV*. , 44-65.
- Чулуунбаатар.Г. (2008). *XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэнийн өөрчлөлт*. Улаанбаатар: Сансудай.
- Швейцарын хөгжлийн агентлаг, ММСГ. (2017). *Малчин өрхийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааны тайлан №2*. Улаанбаатар.
- Шомбодон.Д, Л. Н. (1993). *Малчдын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудал*. Улаанбаатар.

ШУА-ийн Түүхийн хүрээлэн. (2012). *Академич Базарын Ширэндэвийн бүтээлийн чуулган. Боть 10*. Улаанбаатар: Адмон принтинг ХХК.

ШУА-ийн Түүхийн хүрээлэн. (1976). *БНМАУ-ын социалист хөдөө аж ахуйн түүхийн зарим асуудал*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэлийн газар.

ШУА-ийн Түүхийн хүрээлэн, ШУА-ийн ФСЭХ. (1984). *Бүгд найрамдах Монгол ард улсын нийгмийн бүтэц*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр.

ШУА-ийн ФСЭХ. (1982). *БНМАУ-д социалист аж төрөх ёс төлөвшин хөгжиж буй асуудал*. Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэх үйлдвэр.

ШУА-ийн ФСЭХ. (2007). *Малчдын нийгмийн асуудал*. Улаанбаатар: Эх ноорог.

ШУА-ийн ФСЭХ. (2010). *Монгол дахь социологийн хөгжил*. Улаанбаатар: ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр.

ШУА-ийн ФСЭХ. (2013). *Монголын нийгмийн өөрчлөлт*. Улаанбаатар: Бэмби сан.

ШУА-ийн ФСЭХ. (2016). *Монголын хөдөөгийн амьдралын хэв маягийн өөрчлөлт (XXI зууны эхэнд)*. Улаанбаатар.

ШУА-ийн ФСЭХ. (2001). *Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт*. Улаанбаатар, Монгол: Урлах эрдэм хэвлэлийн газар.

ШУА-ийн ФСЭХ. (1987). *Өнөөгийн сэхээтний нийгмийн төрх*. Улаанбаатар.

ШУА-ийн ФСЭХ. (2006). *Социологийг үндэслэгч суутнууд*. Улаанбаатар: Адмон принт ХХК.

ШУА-ийн ФСЭХ. (2008). *Социологийн судалгааны арга зүй, аргачлал*. Улаанбаатар.

ШУА-ийн ФСЭХ. (1990). *Хөдөөгийн хүн амын аж төрөх ёс*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

ШУА-ийн ФСЭХ, Ховд дахь УБДС. (1989). *Монголын өрнөд нутгийн хүн амын аж төрөх ёсны хөгжил*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

ШУА-ийн ФХ. (2018). *Монголын хөдөөгийн амьдралын хэв маягийн өөрчлөлт (XXI зууны эхэнд)*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. (2008). *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь III (М-С)*. Улаанбаатар: Бемби сан хэвлэх үйлдвэр.

ШХА. (2014, 4). Retrieved from Ногоон алт бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл: http://www.greengold.mn/gallery/pdf/static_news/Factsheet_MN.pdf

ШХА, МБМХ. (2010). *Монголын малчдын амьжиргааны судалгаа*. Улаанбаатар.

ШХА, ХЭАСТ. (2009). *Казах үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт*. Улаанбаатар.

Эдийн засгийн судлагаа, эрдэм шинжилгээний хүрээлэн. (2016). *Монголын дундаж давхаргын судалгаа*. Улаанбаатар.

Энгельс.Ф. (1973). *Английн ажилчин ангийн байдал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Энхмандах.Б, Э.Энхчимэг. (2017). *Дундчуудыг түшин хөгжих хөгжлийн хандлага ба Монгол орон*. Улаанбаатар: ХЗҮХ-ийн Хэвлэх үйлдвэр.

Энхтунгалаг.Б. (2010). *Малчин өрхийн аж ахуйн бизнес орчин, түүнийг сайжруулах зарим арга зам (МА)*. Улаанбаатар.

Энхтүвшин.Б. (2014). *Монголын боловсрол, иргэний судлал*. Адмон принт ХХК: Улаанбаатар.

Энхтүвшин.Б, С. (2015). *Нүүдлийн ба суурин соёл*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Эрдэнэбат.Д. (2003). *Их Монгол улсын нийгмийн бүтцийн зарим асуудал (магистрын ажил)*. Улаанбаатар.

Эрдэнэбаяр.Г. (2000). *Нийгмийн хөгжлийн талаархи философийн зарим асуудал, тэдгээрийн арга зүйн ач холбогдол (диссертаци)*. Улаанбаатар.

Эрдэнэцог.Н. (1998). *Монголын нүүдлийн мал аж ахуй*. Улаанбаатар: Урлах эрдэм.

Юнгэр.Д. (2003). *Малчин өрхийн менежмент (МА)*. Улаанбаатар.

Яскина.Г.С. (1998). *Аграрный сектор экономики Монголии на подступах к рынку*. Москва: ИВРАН.

MWCA. (2017). *Ноолуурын салбарын техник, эдийн засгийн үндэслэл*. Улаанбаатар.

Англи хэлээр

Azjargal Jargalsaikhan, Batbuyan Batjav, Batkhishig Baival, Tungalag Ulambayar, Tamir Lhagvasuren, SolongooTsogtbaatar. (2015). Contemporary Mobility of Herders in Central Mongolia. *roceedings of the Trans-disciplinary Research Conference: Building Resilience of Mongolian Rangelands* , (pp. 154-162). Ulaanbaatar.

Anadolu University. (2019). *Social Structure of Turkey II*. Eskişehir.

Banzragch Nandintsetseg, Bazartseren Boldgiv, Jinfeng Chang, Philippe Ciais, Enkhbaatar Davaanyam, et al.. (2021). *Risk and vulnerability of Mongolian grasslands under climate change*. hal-03183966.

- Beckley, H. (Jan 2002). How Amartya Sen Revises Equal Opportunity. *Journal of Religious Ethics* , 107-135.
- Braverman, H. (1998). *Labor and Monopoly Capital: The Degradation of Work in the Twentieth Century*. New York: NYU press.
- Bumochir Dulam, Byambabaatar Ichinkhorloo, Ariell Ahearn. (Nov 2020). Herd Agency: Rethinking Herd–Herder Relations in Mongolia and Qinghai, China. *Inner Asia* 22(2) , 183-198.
- Bumochir.D. (2020). *The State, Popular Mobilisation and Gold Mining in Mongolia: Shaping 'Neoliberal' Policies*. London: UCL press.
- Chris Livesey & Tony Lawson. (2006). *A2 Sociology for AQA*. Spain.
- Daniel J.Murphy. (2011). *GOING ON OTOR: DISASTER, MOBILITY, AND THE POLITICAL ECOLOGY OF VULNERABILITY IN UGUUMUR, MONGOLIA*. Lexington.
- Edited by Austin Harrington, Barbara I. Marshall, Hans-Peter Muller. (2006). *Encyclopedia of Social Theory*. New York: Routledge.
- Foster, K. W. (2018, 5 9). *www.britannica.com*. Retrieved from Britannica Froup Inc: <https://www.britannica.com/topic/Gemeinschaft-and-Gesellschaft>
- Giddens, A. (1971). *Capitalism and modern social theory: An analysis of the writings of Marx, Durkheim and Max Weber*. New York: Cambridge University Press.
- H.Turner, J. (2006). *Handbook of Sociological Theory*. New York: Springer Science^Business Media, LLC.
- Joshua Wright, Cheryl Makarewicz. (n.d.). Perceptions of pasture: the role of skill and networks in maintaining stable pastoral nomadic systems inInner Asia. 263-283.
- Kathy S. Stolly. (2005). *The Basics if Sociology*. London: Greenwood Press.
- Kingsly Davis, Wilbert E.Moore. (1945). Some principles of stratification. *American Sociological Review*, Vol. 10, No. 2 , 242-249.
- Mingardi, A. (2011). *Herber Spenser*. New York: The Continuum International Publishing Group.
- Müller, H.-P. (2020). Lebenschance(n). *Max Weber-Handbuch* , 110-113.
- Offer, J. (2010). *Herbert Spenser and Social Theory*. New York: Martin's Press LLC,.
- Parsons, T. (2005). *The Social System*. Oxfordshire: Taylor & Francis Group.

- Poulantzas, N. (1975). *Classes in Contemporary Capitalism*. London: Lowe & Brydone Printers Limited.
- Ritser, G. (2009). *The Blackwell Encyclopedia of Sociology*. Australia: Blackwell Publishing.
- Royce, E. (2015). *Classical Social Theory and Modern Society: Marx, Durkheim, Weber*. London: The Rowman & Littlefield Publishing Group, Inc.
- S.Turner, B. (2003). *Max Weber and Karl Marx*. New York: Harper & Row Publishers Inc.
- Sergey Bazha, S.N.Bazha, Petr. D.Gunin, Elena Vladimirovna Danzhalova, Yu.I.Drobyshev, A.V.Prishcepa. (2012). *Eurasian Steppes. Ecological Problems and Livelihoods in a Changing*. New York.
- Taylor, M. (2015). *The Political Ecology of Climate Change Adaptation*. Routledge.
- Tönnies, F. (2001). *Community and Civil Society*. Edinburgh: Cambridge university press.
- Tserennadmid Mijiddorj, Ariell Ahearn, Charudutt Mishra, Bazartseren Boldgiv . (2019). *Human Ecology*. Springer .
- Umanailo, M. Chairul Basrun; Umanailo, Annisa Retrofilia; Umanailo, Askar Daffa Sophia. (2020). *Stratification and Differentiation in the Social Life*. Leibniz: https://www.ssoar.info/ssoar/bitstream/handle/document/73973/ssoar-2020-umanailo_et_al-Stratification_and_Differentiation_in_the.pdf?sequence=1&isAllowed=y&lnkname=ssoar-2020-umanailo_et_al-Stratification_and_Differentiation_in_the.pdf.
- Wes W.Sharrook, John A.Hughes, Peter J.Martin. (2003). *Understanding Modern Sociology*. London: Sage publications.
- WHO. (2002). *Food Safety Programme-2002*. Geneva: WHO.
- Wolin, R. (2015, 11 19). Events of May 1968 French history. New York, USA.

Орос хэлээр

- Бурдые, П. (2007). *Социология: социальная пространства*. Санкт Петербург: Алетейя.
- Бүрэнжаргал.Т. (2001). *Социальная структура Монголии в период перехода к рыночной экономике*. Москва.
- Вебер.М. (2016). *Хозяйство и общество: социология*. Москва: Издательский дом.
- Гантөмөр.Б. (1997). *Особенность развития общественного строя (Автореферат)*. Улаанбаатар.

- Грайворонский.В.В. (1997). *Современное аратство Монголии (Социальные проблемы переходного периода 1980-1995)*. Москва: Восточная литература РАН.
- Грамши.А. (2020, 2). Тюремные тетради. России.
- ИСПИ РАН, ИС РАН. (1998). *Социологический энциклопедический словарь*. Москва: Издательская группа ИНФРА М - НОРМА.
- Лукач.Г. (2003). *История и классовое сознание: Исследования по марксистской диалектике*. Москва.
- Парсонс.Т. (2000). *О структуре социального действия*. Москва: Академический проект.
- Радаев.В.В, Шкаратан.О.И. (1996). *Социальная стратификация*. Москва: Аспект пресс.
- Райт.Э.О. (2000). Марксистские концепции классовой структуры. *Politics & Society. Vol. 9. №. 3 (1980)* , 36-85.
- Сергеева.З.Х, Г. (2011). *Социальная стратификация*. Казань: КГТУ.
- Тихонова.Н.Е. (2007, 12 25). Модель социальной стратификации российского общества: эвристические возможности различных теоретических подходов. *Россия реформирующаяся* , 112-146.
- Тихонова.Н.Е. (2007). *Социальная стратификация в современной России; опыт эмпирического анализа*. Москва: http://www.civisbook.ru/files/File/socialnaya_stratifikacia.pdf.
- Тихонова.Н.Е. (2014). *Социальная структура России: теории и реальность*. Москва: Новый Хронограф.
- Токарев.В.В. (2012). *Курс лекций по дисциплине «Социология»*. Новосибирск.
- Уорнер.Л. (1999). Социальный класс и социальная структура. *Рубеж. №10-11* , 42-57.

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН НОТОЛГОО

Энэхүү судалгааны ажил нь миний өөрийн бүтээл бөгөөд Монгол улсын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу бусдын оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй болохоо нотолж байна.

.....

/Овог, нэр/

.....

/Гарын үсэг/

Хавсралт-1. Сүргийн бүтэц, харьцаа: эзэмшлийн хэлбэр, бүсээр

			Үхэр	Адуу	Тэмээ	Хонь	Ямаа
Өөрийн болон тавиул мал малладаг өрхийн сүргийн бүтэц: бүсээр	Өөрийн эзэмшлийн малын бүтэц харьцаа	Баруун	2,442	2,513	,261	29,179	38,189
		Хангайн	6,619	3,337	,057	36,011	27,313
		Төвийн	8,883	4,388	,109	27,338	23,805
		Зүүн	9,312	5,327	,061	26,576	19,417
		Улаанбаатар	49,120	9,130		12,590	5,850
		Дундаж	9,181	4,461	,097	28,471	24,123
	Тавиул малын бүтэц харьцаа	Баруун	1,124	1,811	,034	11,703	12,750
		Хангайн	3,611	2,020	,035	13,146	7,850
		Төвийн	8,250	2,234	,491	14,544	9,970
		Зүүн	8,448	2,335	1,274	17,362	9,902
		Улаанбаатар	21,760	,150		,810	,610
		Дундаж	6,913	2,096	,626	14,473	9,568
Өөрийн эзэмшлийн мал малладаг өрхийн сүргийн бүтэц: бүсээр		Баруун	5,275	5,175	,318	43,377	45,857
		Хангайн	14,442	5,702	,133	41,409	38,321
		Төвийн	12,021	6,817	,202	40,794	40,168
		Зүүн	13,551	6,203	,238	47,515	32,500
		Улаанбаатар	75,605	13,949		5,564	4,887
		Дундаж	14,300	6,334	,213	41,110	38,048
Бусдын мал малладаг өрхийн сүргийн бүтэц: бүсээр		Хангайн					100,000
		Зүүн	12,300	15,200		32,500	39,900
		Улаанбаатар	98,000	2,000		0,000	0,000
		Дундаж	36,767	5,733		10,833	46,633
НИЙТ ДУНДАЖ		Баруун	4,841	4,767	,309	41,202	44,682
		Хангайн	12,745	5,189	,117	40,238	35,933
		Төвийн	11,208	6,187	,178	37,307	35,928
		Зүүн	11,729	5,827	,162	38,517	26,878
		Улаанбаатар	70,200	12,965		6,998	5,084
		Дундаж	12,959	5,843	,182	37,798	34,400

**Хавсралт-2. Эзэмшиж буй малын төрөл зүйлийн харьцаа, олж буй орлогын
хэмжээ**

	ҮХЭР	АДУУ	ТЭМЭЭ	ХОНЬ	ЯМАА	Олсон орлого		
						Түүхий эд	Мал, мах	Нийт
Үхэр	100	-	-	-	-	706889,6	4198164	4905054
Ямаа	-	-	-	-	100	1344000	-	1344000
Адуу	-	100	-	-	-	73750	1800000	1873750
Үхэр, адуу	60.6	39.4	-	-	-	1157944,1	11263174	12421118
Үхэр, тэмээ	84.5	-	15.5	-	-	7240000	-	7240000
Үхэр, хонь	30.1	-	-	69.9	-	1023833,3	-	1023833
Үхэр, ямаа	48.0	-	-	-	52.0	3370500	5700000	9070500
Хонь, ямаа	-	-	-	38.5	61.5	2879087,7	330392,4	3209480
Адуу, хонь, ямаа	-	5.5	-	38.7	55.7	7041746,5	1339714	8381461
Тэмээ, хонь, ямаа	-	-	5.3	51.5	43.2	6098333,3	868666,7	6967000
Үхэр, адуу, хонь	33.2	12.2	-	54.6	-	932333,3	12063333	12995667
Үхэр, адуу, ямаа	38.1	8.4	-	-	53.5	4056742,9	754285,7	4811029
Үхэр, хонь, ямаа	10.1	-	-	44.2	45.7	3416344,4	1987970	5404314
Адуу, тэмээ, хонь, ямаа	-	3.1	3.8	29.2	63.9	10834500	6260250	17094750
Үхэр, адуу, хонь, ямаа	7.1	6.9	-	48.5	37.4	5179175,6	4256645	9435820
Үхэр, тэмээ, хонь, ямаа	2	-	6.5	38.5	53.0	7842250	-	7842250
Үхэр, адуу, тэмээ, хонь, ямаа	4.4	6.2	2.0	49.2	38.2	9830894,3	7882304	17713199
Нийт	14.2	6.4	0.2	41.5	37.7	4774521,4	3980505	8755026

Хавсралт-3. Сүргийн бүтэц, малын тоо, өрхийн орлогын хамаарал (Пирсоны коэффициент)

		Өөрийн нийт малын тоо	Нийт орлого	Сүргийн бүтэц дэх малын төрөл зүйлийн тоо
Өөрийн нийт малын тоо	Pearson Correlation	1	.594**	.447**
	Sig. (2-tailed)		.000	.000
	Sum of Squares and Cross-products	129568228.085	2618189839988.558	174303.803
	Covariance	123515.947	2495891172.534	166.162
	N	1050	1050	1050
Нийт орлого	Pearson Correlation	.594**	1	.218**
	Sig. (2-tailed)	.000		.000
	Sum of Squares and Cross-products	2618189839988.5 58	150127266519383296 .000	2888790577.08 9
	Covariance	2495891172.534	143114648731537.94 0	2753851.837
	N	1050	1050	1050
Сүргийн бүтэц дэх малын төрөл зүйлийн тоо	Pearson Correlation	.447**	.218**	1
	Sig. (2-tailed)	.000	.000	
	Sum of Squares and Cross-products	174303.803	2888790577.089	1174.706
	Covariance	166.162	2753851.837	1.120
	N	1050	1050	1050

**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Хавсралт-4. Өрхийн орлогын хэмжээ: суурьшлаар

А. Мал аж ахуйгаас олж буй орлогын хэмжээ (Өөрийн эзэмшлийн малаас олж буй орлогын хэмжээ)

	Ноос, ноолуур	Арьс, шир	Сүү	Бусад	Мал зарсан	Мал муулсан	Нийт орлого
Хөдөөгийн малчид	4702672,9	372579,9	278387,8	7118,0	2585545,3	1258048,7	9204352,6
Нийслэл малчид	209592,0	102720,0	945956,0	-	5740000,0	441640,0	7439908,0
Аймаг, сумын ойролцоох малчид	3119350,6	364514,6	200698,6	42624,4	2097221,1	1511434,9	7335844,1
Нийт	4094809,1	366845,8	296468,4	16398,1	2636913,3	1343591,2	8755026,0

Б. Орлогын эх үүсвэрийн төрөлжилт (Жилийн нийт орлогыг 12 сард хувааж үр дүнг гаргасан)

	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	Мал аж ахуйн орлого	Өрхийн бизнес	Бусад
Нийслэлийн малчид	560400,0	334975,0	825074,1	325000,0	300000,0
Аймаг, сумын ойролцоох малчид	857073,5	268813,9	610356,0	980357,1	189634,6
Хөдөөгийн малчид	447728,3	188981,7	666025,5	781650,0	167265,6
Нийт	616445,7	219810,7	673825,7	874660,0	182231,5

**Хавсралт-5. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх арга зам ба үйлдвэрлэл
эрхэлж буй арга хооронд хамаарал тооцсон үр дүн**

Уламжлалт аж ахуй

	1	2	3	4
1. Нийт орлого	1			
2. Малын эрүүл ахуйг сайжруулах	,008	1		
3. Шилмэл үүлдрийн малтай болох	-,004	.245 ^{**}	1	
4. Эрчимжсэн МАА хөгжүүлэх	-,080 ^{**}	.152 ^{**}	.253 ^{**}	1
5. Дэд бүтэц сайжруулах	,044	.092 ^{**}	.225 ^{**}	.181 ^{**}

Фермерийн аж ахуй

	1	2	3	4
1. Нийт орлого	1			
2. Малын эрүүл ахуйг сайжруулах	,223	1		
3. Шилмэл үүлдрийн малтай болох	-,216	-,032	1	
4. Эрчимжсэн МАА хөгжүүлэх	.404 [*]	,189	,037	1
5. Дэд бүтэц сайжруулах	-,152	-,167	,194	-,141

Хосолсон аж ахуй

	1	2	3	4
1. Нийт орлого	1			
2. Малын эрүүл ахуйг сайжруулах	-,221	1		
3. Шилмэл үүлдрийн малтай болох	-,213	,167	1	
4. Эрчимжсэн МАА хөгжүүлэх	,135	,103	,032	1
5. Дэд бүтэц сайжруулах	,085	,204	.357 [*]	.474 ^{**}

Хавсралт-6. Мал төрөл болон хонин толгойд шилжүүлж харьцуулсан үр дүн

		Малын төрөл тус бүрийн нийт тоо					НИЙТ
		500 хүртэл	501-1000	1001-1500	1501-2000	2001-ээс дээш	
Хонин толгойд шилжүүлсэн	500 хүртэл	597	0	0	0	0	597
	501-1000	169	83	0	0	0	252
	1001-1500	28	66	16	0	0	110
	1501-2000	14	16	17	1	0	48
	2001-ээс дээш	6	7	19	7	4	43
НИЙТ		814	172	52	8	4	1050

Хавсралт-7. Малчдын ялгарал, дүр зураг

А. Үзүүлэлтийг зургаан тэнцүү хэсэг хуваасан үр дүн

Бүлэглэлт	Орон сууц	Байшин	Газар	Өвөлжөө	Хаваржаа	Суудлын машин	Ачааны машин	Трактор	Мотоцикл	Интернет	Хөргөгч	Цахилгаан үүсгүүр	МАА-н нийт орлого	Малын тоо (хонин толгой)	Харьцаа
0.1666	-	.03	.11	.33	.09	.10	.08	.01	.32	.01	.14	.29	3818260.36	253.21	23.7
0.1667-0.3332	.03	.15	.35	.69	.43	.15	.28	.02	.64	.03	.25	.49	6042901.28	409.29	36.4
0.3333-0.4998	.09	.45	.58	.84	.54	.39	.57	.10	.82	.09	.54	.76	12203837.31	682.99	32.2
0.4999-0.6665	.10	.68	.88	.99	.78	.65	.79	.31	.92	.24	.86	.82	20675842.36	1315.31	6.9
0.6665-0.8332	.71	1.00	1.00	1.00	.71	1.00	1.00	.86	.71	.57	.86	.71	28749571.43	1485.71	0.7
0.8333	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	59418750.00	2673.50	0.2
Нийт дундаж	.05	.26	.41	.68	.41	.26	.37	.07	.64	.06	.36	.55	8755025.98	534.00	100

Б. Үзүүлэлтийг арван тэнцүү хэсэгт хуваасан үр дүн

Бүлэглэлт	Орон сууц	Байшин	Газар	Өвөлжөө	Хаваржаа	Суудлын машин	Ачааны машин	Трактор	Мотоцикл	Интернет	Хөргөгч	Цахилгаан үүсгүүр	МАА-н нийт орлого	Малын тоо (хонин толгой)	Харьцаа
0,09 хүртэл	-	.01	.04	.16	-	.06	.03	-	.22	.01	.04	.17	2880882.96	194.33	9.6
0.1-0.19	-	.05	.16	.44	.14	.13	.11	.01	.39	.01	.20	.36	4541975.66	301.49	14.9
0.2-0.29	.03	.15	.35	.69	.43	.16	.27	.02	.64	.03	.24	.49	5642287.10	368.48	35.7
0.3-0.39	.06	.29	.45	.81	.49	.34	.47	.06	.73	.09	.44	.74	11830842.21	621.54	15.1
0.4-0.49	.11	.57	.70	.86	.56	.41	.64	.15	.87	.09	.60	.76	11327099.49	719.07	17.0
0.5-0.59	.09	.61	.85	.98	.74	.61	.83	.24	.93	.17	.83	.80	20149021.30	1314.04	5.3
0.6-0.69	.15	.90	.95	1.00	.80	.80	.70	.55	.90	.50	.95	.85	20515225.00	1245.88	2.0
0.7-0.79	.75	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	.75	.50	.50	1.00	.75	40886875.00	1934.75	.4
0.8-0.89	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00	59418750.00	2673.50	.2
Нийт дундаж	.05	.26	.41	.67	.40	.26	.36	.07	.64	.06	.36	.55	8412261.27	517.27	100

Хавсралт-8. Түүхий эд борлуулсны орлого: малын төрөл зүйл, бүсээр

Бүс	Түүхий эд	Ямаа	Хонь	Тэмээ	Үхэр	Адуу
БАРУУН	Ноос, ноолуур	5.789.316,0	263.566,00	17.160,00	-	41.388,00
	Арьс, шир	366.928,0	35.004,00	178,80	15.376,00	5.148,00
	Сүү	65.570,00	-	0,00	219.928,00	-
	Бусад	6.060,00	-	-	-	-
	Нийт	6.227.874,0	298.570,00	17.338,80	235.304,00	46.536,00
ХАНГАЙ	Ноос, ноолуур	2.950.382,5	168.096,81	5.239,04	6.378,49	35.452,19
	Арьс, шир	213.476,10	37.556,41	-	28.701,20	10.258,96
	Сүү	42.131,47	-	2.031,87	466.784,86	31.952,19
	Бусад	28.294,82	-	-	-	-
	Нийт	3.234.284,86	205.653,23	7.270,92	501.864,54	77.663,35
ТӨВ	Ноос, ноолуур	3.755.923,7	231.927,51	20.742,97	-	20.387,55
	Арьс, шир	284.056,22	40.371,33	931,33	51.447,79	10.838,96
	Сүү	963,86	-	-	94.162,65	13.710,84
	Бусад	1.759,04	-	-	-	-
	Нийт	4.042.702,8	272.298,84	21.674,30	145.610,44	44.937,35
ЗҮҮН	Ноос, ноолуур	3.672.912,0	140.932,80	2.840,00	-	37.088,00
	Арьс, шир	247.596,00	47.362,00	-	93.624,00	31.744,00
	Сүү	4.440,00	-	-	112.564,00	-
	Бусад	32.652,00	-	-	-	-
	Нийт	3.957.600,0	188.294,80	2.840,00	206.188,00	68.832,00
УБ	Ноос, ноолуур	170.120,00	16.600,00	-	0,00	22.872,00
	Арьс, шир	14.920,00	6880,00	-	74.120,00	6.800,00
	Сүү		0,00	-	849.956,00	96.000,00
	Нийт	185040,00	23480,00	-	924.076,00	125.672,00
НИЙТ	Ноос, ноолуур	3.856.984,8	192.282,81	10.933,33	1.524,76	33.083,43
	Арьс, шир	265.418,6	38.490,11	263,43	48.543,33	14.130,38
	Сүү	26.969,05	-	485,71	253.552,67	15.460,95
	Бусад	16.398,1	-	-	-	-
	Нийт	4.165.770,5	230.772,92	11.682,48	303.620,76	62.674,76
	Хувиар	87.3	4.8	0.2	6.4	1.3